



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Одсүрэнгийн НОМИНЧИМЭГ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-44, Факс: 32-70-16
E-mail: nominchimeg@parliament.mn
<http://www.parliament.mn>

2028.09.19 № 442-03/10660
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

О.НОМИНЧИМЭГ
Ж.АЛДАРЖАВХЛАН
О.АЛТАНГЭРЭЛ
Н.АЛТАНХУЯГ
Н.АЛТАНШАГАЙ
Д.АМАРБАЯСГАЛАН
С.АМАРСАЙХАН
О.АМГАЛАНБААТАР
Ч.АНАР
А.АРИУНЗАЯА
Т.АУБАКИР
Х.БААСАНЖАРГАЛ
Ц.БААТАРХҮҮ
М.БАДАМСҮРЭН
Э.БАТ-АМГАЛАН

000121

Б.БАТБААТАР
Д.БАТБАЯР
Р.БАТБОЛД
Ж.БАТЖАРГАЛ
Д.БАТЛУТ
О.БАТНАЙРАМДАЛ
Ж.БАТСУУРЬ
Н.БАТСҮМБЭРЭЛ
Х.БАТТУЛГА
Б.БАТЦЭЦЭГ
П.БАТЧИМЭГ
Э.БАТШУГАР
Б.БАТ-ЭРДЭНЭ
Ж.БАТ-ЭРДЭНЭ
Б.БАЯРБААТАР
Ж.БАЯРМАА
Ж.БАЯСГАЛАН
Б.БЕЙСЕН
Э.БОЛОРМАА
Х.БОЛОРМАА
Х.БУЛГАНТУЯА
Д.БУМ-ОЧИР
Ш.БЯМБАСҮРЭН
С.БЯМБАЦОГТ
Ж.ГАЛБАДРАХ
А.ГАНБААТАР
Г.ГАНБААТАР
Ж.ГАНБААТАР
С.ГАНБААТАР
Д.ГАНБАТ
П.ГАНЗОРИГ
Д.ГАНМАА
Л.ГАНТӨМӨР
Х.ГАНХУЯГ
М.ГАНХҮЛЭГ
Ц.ДАВААСҮРЭН
Г.ДАМДИННЯМ

Т.ДОРЖХАНД
Б.ДЭЛГЭРСАЙХАН
Б.ЖАВХЛАН
Х.ЖАНГАБЫЛ
Б.ЖАРГАЛАН
Д.ЖАРГАЛСАЙХАН
С.ЗАМИРА
Б.ЗАЯАБАЛ
Ж.ЗОЛЖАРГАЛ
С.ЗУЛПХАР
Ц.ИДЭРБАТ
Ч.ЛОДОЙСАМБУУ
Г.ЛУВСАНЖАМЦ
С.ЛҮНДЭГ
М.МАНДХАЙ
Л.МӨНХБААТАР
Ц.МӨНХБАТ
Л.МӨНХБАЯСГАЛАН
Т.МӨНХСАЙХАН
Б.МӨНХСОЁЛ
Л.МӨНХТУЛГА
Б.МӨНХТУЯА
З.МЭНДСАЙХАН
Б.НАЙДАЛАА
Н.НАРАНБААТАР
П.НАРАНБАЯР
М.НАРАНТУЯА-НАРА
Ч.НОМИН
Н.НОМТОЙБАЯР
Э.ОДБАЯР
С.ОДОНТУЯА
У.ОТГОНБАЯР
Г.ОЧИРБАТ
Л.ОЮУН-ЭРДЭНЭ
Б.ПУНСАЛМАА
Д.ПҮРЭВДАВАА
Б.ПҮРЭВДОРЖ

Д.РЭГДЭЛ

П.САЙНЗОРИГ

Ц.САНДАГ-ОЧИР

О.САРАНЧУЛУУН

М.САРНАЙ

Л.СОРОНЗОНБОЛД

Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

Б.ТУЛГА

Б.ТҮВШИН

Х.ТЭМҮҮЖИН

Г.ТЭМҮҮЛЭН

А.УНДРАА

Ч.УНДРАМ

Н.УЧРАЛ

Б.УЯНГА

Г.УЯНГАХИШИГ

Д.ҮҮРИЙНТУЯА

Г.ХОСБАЯР

Б.ХЭРЛЭН

ДАВ.ЦОГТБААТАР

ДАМ.ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ

С.ЦЭНГҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Ө.ШИЖИР

Л.ЭНХ-АМГАЯАН

В.ЭНХБАЯР

Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХНАСАН

Д.ЭНХТУЯА

Д.ЭНХТҮВШИН

М.ЭНХЦЭЦЭГ

С.ЭРДЭНЭБАТ

С.ЭРДЭНЭБОЛД

Р.ЭРДЭНЭБҮРЭН

000121



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БААСАНДОРЖ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Одсүрэнгийн НОМИНЧИМЭГ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-44, Факс: 32-70-16
E-mail: nominchimeg@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.09.17 № 442-03/10576
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.


Хуулийн төсөл, үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох тайланг хавсаргав.

Хавсралт⁴³⁶ хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

О.НОМИНЧИМЭГ



000193



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.НОМИНЧИМЭГ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.07.07 № ХЭГ/1892
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын гишүүдээс санаачлан боловсруулсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

“00255009735

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 3 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“13.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын гишүүдээс санаачлан боловсруулсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нарын гишүүдээс санаачлан боловсруулсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг хууль санаачлагчдад уламжлахаар тогтов:

1.Хуулийн төслийн 6.7.16-д “энэ хуулийн 3.1.1.а, 3.1.1.б, 3.1.1.в-д заасан бүх төрлийн тамхи, цэнэглэх шингэнд үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн” тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхийг хориглохоор тусгажээ.

Үнэр, амт нэмсэн тамхи худалдаалахыг шууд хориглохоос илүүтэйгээр онцгой албан татварын хэмжээг бусад тамхин бүтээгдэхүүнээс өндөр тогтоох нь энэ төрлийн барааны далд эдийн засаг, цахим худалдаа бий болохоос урьдчилан сэргийлэх боломжтойг анхаарах нь зүйтэй байна.

Түүнчлэн, хуулийн төслийн 7.11¹-д “тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих, тамхи импортлох, худалдах, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргаагүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцно” гэж заажээ.

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт эрх бүхий этгээд нь тухайн зөвшөөрлийн хугацаа дуусахаас 45 хоногийн өмнө сунгуулах тухай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэхээр хуульчилсан тул хуулийн төслийн 7.11¹ дэх хэсэгт Зөвшөөрлийн тухай хуулийн холбогдох заалтыг эшлэн өөрчлөлт оруулах нь зүйтэй;

2.Хуулийн төслийн 3 дугаар зүйлд сорж татах, үнэрлэх зориулалттай тамхи, тамхи орлуулагч, амт, үнэр оруулагч, нийлэг аргаар гаргаж авсан никотин, химийн бодис агуулсан бол зөвшөөрөгдөх хэмжээг тодорхойлох, тавих шаардлага болон хориглосон хүнсний нэмэлтийн асуудлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоох талаар тодорхой зохицуулалтыг нэмэх саналтай байна.

Мөн тамхи, тамхин бүтээгдэхүүн, үйлдвэрийн үндсэн түүхий эд нь импортын бүтээгдэхүүн тул хуулийн төсөлд гаалийн байгууллагын эрх үүргийг нэмж тусгах шаардлагатай;


3.Хуулийн төслийг дагалдан боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тамхины нэр төрлөөс хамааран 2025-2030 он хүртэл татварын хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр заасан боловч тамхин бүтээгдэхүүний биет нэгжид ногдуулах онцгой албан татварын хэмжээг тогтоосон үндэслэл, аргачлал тодорхойгүй, энэ талаар холбогдох судалгаанд тусгаагүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 5.1.3-т заасан “шударга байх” зарчимд нийцэж байгаа эсэхийг дахин нягтлах нь зүйтэй байна.

Түүнчлэн, 2030 онд нэг хайрцаг буюу 20 ширхэг янжуур тамхины онцгой албан татвар 10,000 төгрөг, 1 миллилитр электрон тамхины цэнэглэгч шингэн 1,410 төгрөгт хүрэхээр тооцоолсноос үзэхэд тамхины үнэ харилцан адилгүй, ялгаатай тогтоогдох, цаашилбал шингэн тамхины хэрэглээ нэмэгдэхээр байна. Иймд тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлэхдээ тухайн тамхинд агуулагдах никотины хэмжээг харгалзах үзэх нь зүйтэй;

4.Хуулийн төслийн 3 дугаар зүйлээр Тамхины хяналтын тухай хуулийн 9.1.8 дахь заалтыг өөрчлөн найруулахаар тусгасан нь одоо хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй хуулийн заалттай зарим агуулгаараа давхардаж байх тул хуулийн заалтад нэмэлт оруулах байдлаар тусгах;

5.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан арга хэмжээг Биеийн тамир, спортын тухай хуулийн 13.1.8-д “хүн амын нягтаршил, боломж, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн иргэний идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх талаар хариуцсан нэгжтэй байх, стандартын шаардлага хангасан спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх” чиг үүргийн хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулж, шийдвэрлэх боломжтой.

Иймд хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгасан 19.3.8 дахь заалтыг хасах нь зүйтэй байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**
(2025 оны 5 дугаар сарын 31-ний өдөр)

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй,” гэж, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, Монгол Улсын нэгдэн орсон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Тамхины хяналтын суурь Конвенцын 3 дугаар зүйлд “Энэхүү Конвенцын зорилго нь: “Оролцогч улсуудын иргэдийг тамхины хэрэглээ, тамхины утаанд өртөх, түүнчлэн тамхины хэрэглээтэй холбоотой бусад сөрөг нөлөөллөөс хамгаалах,” гэж, 2 дугаар зүйлд “Гишүүн улс орнууд энэхүү Конвенцын зорилгод нийцүүлэн, өөрсдийн үндэсний хууль тогтоомж, олон улсын эрх зүйн үүргийн хүрээнд нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлж болно.” гэж тус тус заажээ.

Түүнчлэн Тамхины хяналтын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь тамхины хэрэглээ, дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хүн амыг хамгаалах зорилго бүхий тамхины хяналтын эрх зүйн үндсийг тодорхойлж...” гэж, Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад “хүн амын эрүүл мэндийг төрийн онцгой анхаарал, ивээлд авах,” гэж, Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад “хүн амын эрүүл мэндийг дэмжих, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бодлого, үйл ажиллагаандаа тусгаж, хэрэгжүүлэх,” гэж, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтад “төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах,” гэж тус тус заажээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-ны 2.2.9-д “Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэрэглээг хязгаарлах, архи, тамхи, эм, чихэрлэг ундааны онцгой албан татварын тодорхой хувийг эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлэх, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг санхүүжүүлнэ.”, мөн 2.2.35-т “хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах

бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, ...” зорилтыг тус тус дэвшүүлсэн байна.

1.2. Практик шаардлага

Монгол Улс анх 1993 онд Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуулийг баталж, үүнээс хойш 2005 онд уг хуулийг шинэчлэн найруулж, одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Тамхины хяналтын тухай хуулийг баталсан¹. Энэхүү хууль нь тухайн үед зах зээлд өргөн тархсан утаат тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, хэрэглээг хязгаарлах, хүн амыг тамхины хор хөнөөлөөс хамгаалах зорилготойгоор баталсан болно.

Тамхины хяналтын тухай хуульд 2012, 2015, 2019, 2022, 2023 онуудад нийт найман удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, олон нийтийн газар тамхи хэрэглэх болон сурталчлах үйл ажиллагааг бүрэн хориглох, боловсролын байгууллагын орчинд тодорхой зайд тамхи худалдаалахыг хязгаарлах, эрүүл мэндийн сэрэмжлүүлгийг олон нийтэд түгээх зэрэг арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж ирсэн. Гэсэн хэдий ч тамхи үйлдвэрлэгчдийн зүгээс электрон болон халаадаг тамхин бүтээгдэхүүн, никотин, никотин бус бодис дамжуулах систем зэрэг зохицуулалтгүй шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, эдгээрийг бусад төрлийн бүтээгдэхүүнтэй андуурагдахуйц, хор хөнөөл багатай, мөн тамхинаас гарахад дэмжлэг үзүүлдэг хэмээн олон нийтэд сурталчилж байна. Гэвч дээрх бүтээгдэхүүний үйлчилгээ, аюулгүй байдлыг нотолсон шинжлэх ухааны үндэслэл хангалтгүй, урт хугацаанд эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл бүрэн тогтоогдоогүй бөгөөд сөрөг нөлөөллийн талаарх судалгаа, бодит тохиолдол нэмэгдсээр байна. Тухайлбал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2021 оны тайланд халаадаг болон электрон тамхин бүтээгдэхүүнд хорт бодис агуулагдаж байгааг онцлон анхааруулсан (WHO, 2021), АНУ-ын Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төвөөс 2019 онд электрон тамхитай холбоотой уушгины хүнд хэлбэрийн гэмтэл (EVALI)-ийн 2,800 гаруй тохиолдол, 60 гаруй нас баралт бүртгэгдсэн тухай мэдээлсэн (CDC, 2020), мөн The Lancet Public Health сэтгүүлд 2022 онд нийтлэгдсэн системчилсэн тойм судалгаагаар эдгээр бүтээгдэхүүн нь зүрх судасны, уушгины болон сэтгэцийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэйг тэмдэглэсэн байна (The Lancet Public Health, 2022).

Тамхи татах нь нийт хүн ам, нэн ялангуяа хөдөлмөрийн насны хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлснээс үүдэн гэр бүлийн эрүүл мэндийн зардал эрс нэмэгдэж, энэ нь эрүүл мэндийн тогтолцоонд асар их ачаалал үзүүлдэг бөгөөд тамхины шалтгаант өвчлөлтэй холбоотой эрүүл мэндийн зардал дээр хөдөлмөрийн насны хүн амын өвчлөл, цаг бус эндэгдэлтэй холбоотой бүтээмжийн алдагдалыг нэмэгдүүлдэг байна. Цаашлаад тамхины хэрэглээ нь эдийн засгийн өсөлтийг удаашруулж, улмаар үндэсний хэмжээнд ядуурал нэмэгдэх, ядуурлын нөлөөлөл нь тамхичдын гэр бүлд ч гэсэн мэдрэгддэг бөгөөд энэ нь зөвхөн тамхи татдаг хувь хүнд хамааралтай асуудал биш тул тамхины хяналтад хөрөнгө оруулах нь ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах, халдварт бус өвчлөлийн тархалттай тэмцэхэд асар чухал² болохыг

¹ Тамхины хяналтын тухай хууль Төрийн мэдээлэл сэтгүүл 2005 он

² Regional action plan for tobacco control in the Western Pacific (2020-2030): working towards a healthy, tobacco-free Region. Manila, Philippines, World Health Organization Regional Office for the Western Pacific. 2020. Лиценз: CC BY-NC-SA 3.0 IGO.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүс нутгийн тамхины хяналтын төлөвлөгөө 2020-2030 онд тодорхой дурдсан байна.

Иймд тамхи, тамхин бүтээгдэхүүний талаарх ойлголтыг шинэчлэх, хяналт, хэрэгжилтийн үр нөлөөтэй тогтолцоо бий болгох, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг үр дагаварууд нь бүрэн илрээгүй байгаа тамхин бүтээгдэхүүний зохицуулалт бий болгох, тамхинд ногдуулах татварын үр нөлөөг нэмэгдүүлэх, тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, тамхидалтыг бууруулахад чиглэсэн цогц зохицуулалт бий болгох, хэрэгжүүлэхийг цаг үе шаардаж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас 2021 онд гаргасан “Электрон тамхи ба эрүүл мэнд”³ тайланд эдгээр бүтээгдэхүүнүүд нь амьсгалын замын үрэвсэл үүсгэх, зүрх судасны системд сөргөөр нөлөөлөх, никотинд донтох эрсдэл өндөртэй болохыг онцолсон. Мөн энэхүү тайланд “электрон тамхи нь тамхинаас гарах хэрэгсэл биш бөгөөд өсвөр үеийнхэн, залууст донтох шинэ зам болж байгааг анхаарах шаардлагатай” хэмээн дурдсан байна.

Монгол Улсын хэмжээнд 13-15 насны сурагчдын 10.8 хувь нь электрон тамхи хэрэглэж байгаа талаар ЭМЯ, ХӨСҮТ-ийн 2019 онд хийсэн Глобал залуучуудын тамхины судалгаагаар (GYTS) тогтоогдсон. Харин 2023 онд 13-17 насны сурагчдын дунд хийсэн судалгаагаар сурагчдын 19.9 хувь нь янжуур тамхи, 24.8 хувь нь электрон тамхи хэрэглэж байгаа дүн гарсан. Хэрэглэгчдийн олонх нь электрон тамхийг “аюулгүй” гэсэн ташаа ойлголтоор хүлээн авч, амт, үнэр, дизайн зэрэг нь хэрэглээг дэмжих хүчин зүйл болсоор байна. Хууль эрх зүйн зохицуулалт дутмаг, хяналт сул байгаагаас шалтгаалан эдгээр бүтээгдэхүүнийг хүүхэд, өсвөр үеийнхэн дэлгүүр, худалдааны төв, цахим худалдаа, сошиал платформоор дамжуулан чөлөөтэй худалдан авч, хэрэглэх боломжтой байгаа нь эрүүл мэндийн хувьд эрсдлийг улам нэмэгдүүлж байна.

2024 оны байдлаар Монгол Улс дахь тамхины хэрэглээ нийт хүн амын 28.4 хувьд хүрсэн нь ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлттэй орны 7 дугаарт орж байна. Монгол Улсад жил бүр тамхинаас шалтгаалсан 4,300 орчим нас баралт бүртгэгдэж⁴, өсвөр насныхны дунд электрон тамхины хэрэглээ уламжлалт тамхины хэрэглээнээс давж гарсан буюу 13-17 насны дөрвөн сурагч тутмын нэг нь электрон тамхи татаж байна гэсэн статистик үзүүлэлт байна⁵.

Судалгаанаас үзэхэд, 2023 оны тамхидалтын тархалтыг 2019 онтой харьцуулахад 10 хувиар нэмэгдсэн, эмэгтэйчүүдийн тамхидалт 4 дахин нэмэгдсэн, тамхи татах нас 3 насаар залуужсан байна. Мөн 3,000 гаруй оюутныг хамруулсан судалгаагаар 14 хувь нь утаат тамхи, 10,9 хувь нь электрон тамхи, 2 хувь нь аль алийг нь татдаг тоо баримтууд гарсан. Түүнчлэн Вашингтоны их сургуулийн эрүүл мэндийн хэмжил зүйн үнэлгээний хүрээлэнтэй хамтран хийсэн судалгаагаар цаг бусын нас

³ WHO REPORT ON THE GLOBAL TOBACCO EPIDEMIC, 2021 Addressing new and emerging products

⁴ ДЭМБ-ын 2021 оны “Монгол Улс дахь тамхины хэрэглээ ба хохирлын үнэлгээ” тайлан.

⁵ Монгол Улсад 2023 онд хийгдсэн Сурагчдын дундах тамхины хэрэглээний үндэсний судалгаа.

баралт, чадвар алдалтад хүргэж буй тэргүүлэх 20 эрсдэлт хүчин зүйлийн 3 дугаарт тамхидалт орж байна⁶.

Олон улс оронд шинэ төрлийн тамхидалтын асуудлыг хуулиар зохицуулж эхлээд байна. Тухайлбал: Австрали Улс электрон тамхийг эмчийн жороор худалдаалдаг, амт оруулагч нэмэлтүүдийг хориглосон, Канад улс өсвөр үеийнхэнд чиглэсэн амт, үнэрийн сурталчилгааг хязгаарласан, никотины агууламжид дээд хязгаар тогтоосон, Европын Холбоо ENDS бүтээгдэхүүний сав баглаа боодлын стандартыг нарийвчлан тогтоож, хаяг, анхааруулга, никотины агууламжийг хатуу хянаж байхад харин Сингапур, Энэтхэг, Тайланд зэрэг орнууд эдгээр бүтээгдэхүүнийг бүрэн хориглосон байна.

Канад⁷, Австрали⁸, Норвеги⁹ зэрэг улс оронд тамхи худалдаалахдаа ил байрлуулахыг хориглож, зөвхөн насанд хүрэгчдэд зориулсан мэдээлэл бүхий жагсаалтаас сонгох хэлбэрийг хуульчилсан. Гэтэл Монгол Улсад тэдгээр бүтээгдэхүүн нь зохицуулалтгүй байгаагаас улсын хилээр зарим төрлийн электрон тамхи нь "цахилгаан хэрэгсэл" гэсэн кодоор нэвтэрч, дэлгүүр, худалдааны төвүүдэд кассын хажууд шилэн хоргонд сонирхол татах өрөлтөөр ил байршуулан чөлөөтэй, ямар нэгэн хориглолт, хязгаарлалтгүй худалдаалагдаж байгаа нь ДЭМБ-ын Тамхины хяналтын тухай суурь конвенцын 13 дугаар зүйлд заасан сурталчилгаа, ивээн тэтгэлтийг хязгаарлах, мөн Тамхи, тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг таслан зогсоох протоколын заалтуудтай зөрчилдөж байгаа тул шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнийг тамхинд хамааруулах хуулийн зохицуулалтыг бий болгох нь Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, өсвөр үе, залуучууд болон нийт хүн амыг никотины хамаарлаас хамгаалахад дэмжлэг үзүүлэх юм.

Тамхины хяналтын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд 2015-2024 оны хооронд Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн нийт 8274 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс 30.3% (2505 зөрчил) нь аймгуудад, 69.6% (5758 зөрчил) нь нийслэлд бүртгэгдсэн байна. Харин дээрх тоо баримтад электрон тамхи болон шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний зөрчилтэй холбоотой тоо баримт ороогүй бөгөөд уг тайланд электрон тамхи болон никотин агуулсан шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнийг хуулийн зохицуулалтад бүрэн хамруулж, үнэр амт, найрлагад хязгаарлалт тогтоох, хяналтын үр дүнтэй механизмыг бий болгох шаардлагатай талаар дурдсан байна¹⁰.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), Тамхины хяналтын тухай суурь конвенц (FCTC)-ийн Нарийн бичгийн дарга нарын газар, Конвенцын талуудын бага хурлаас электрон болон шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн (ENDS/ENNDs) нь никотины хамаарал, эрүүл мэндийн эрсдэлийг нэмэгдүүлж, ялангуяа өсвөр үеийнхэнд ноцтой хор уршиг учруулж буйг онцлон, эдгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, худалдаа, хэрэглээг хязгаарлах буюу хориглох хууль, бодлогын арга хэмжээ авахыг

⁶ Эрүүл мэндийн хэмжил зүйн үнэлгээний хүрээлэн (IHME)-гийн "Дэлхийн өвчлөлийн ачааллын судалгаа 2015" (Global Burden of Disease Study 2015)

⁷ Канад: [Tobacco Control Laws](#)

⁸ Австрали: [NSW Health](#)

⁹ Норвеги: [Tobacco Control Laws](#)

¹⁰ Монгол Улсын парламентын судалгааны хөгжлийн хүрээлэнгээс Тамхины хяналтын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 2025 он

зөвлөсөн, бүх төрлийн амт, үнэр оруулагч нь хүүхэд, залуусын хэрэглээг өдөөж байгааг харгалзан, тэдгээрийг бүрэн хориглох шаардлагатайг анхааруулсан⁶, Тамхины хяналтын суурь конвенцын 8, 9, 10, 11, 13 дугаар зүйлээр тогтоосон шаардлагыг шинэ төрлийн бүтээгдэхүүнд уламжлалт тамхитай ижил түвшинд хэрэгжүүлэх, сурталчилгааг бүрэн хориглох, төөрөгдүүлсэн мэдээлэл, “эрсдэл багатай” гэх хуурамч ойлголтыг хязгаарлах эрх зүйн механизм бүрдүүлэхийг уриалсан, баримт нотолгоонд суурилсан, урьдчилан сэргийлэх суурьтай хууль тогтоомж боловсруулах нь гишүүн орнуудын үндсэн үүрэг болохыг зөвлөмж болгосон байна.

ДЭМБ-аас Тамхины хяналтын суурь конвенцид тусгагдсан тамхины эрэлтийг бууруулах гол арга хэмжээ болох MPOWER арга хэмжээг хэрэгжүүлэхийг гишүүн улс орнуудад даалгадаг бөгөөд уг арга хэмжээнд тамхины хэрэглээний талаар тогтмол анализ хийх тоон мэдээтэй байх, олон нийтийн газарт тамхи татахыг хориглосон хууль тогтоомжийн зохицуулалт бий болгох, тамхинаас гарахад туслах эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, дэмжих, үнэгүй үзүүлэх, тамхин бүтээгдэхүүний сав, баглаа, боодол дээр шалгуур хангасан эрүүл мэндийн анхааруулгатай байхыг шаардах, тамхины зар сурталчилгаа, бүх буюу зарим хэлбэрийн дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглох, тамхины жижиглэнгийн үнийн 75-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний татвартай байх буюу тамхины бүтээгдэхүүний татварыг нэмэгдүүлэх зэрэг багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зааварчилсан байдаг.

Монгол Улсын хувьд тамхин бүтээгдэхүүний онцгой албан татварыг 2017 оноос хойш нэмээгүй бөгөөд хөрш зэргэлдээ улсуудтай харьцуулахад янжуур тамхины худаалдаалагдаж буй үнэ даруй 3-4 дахин хямд байгаа нь хүүхэд залуучуудын дунд тамхидалтыг нэмэгдүүлэх, хэрэглээг гааруулах нөхцөл байдал үүссэн байна.

Тамхины хэрэглээ нь дэлхий даяар нийт хүн амын эрүүл мэндэд тулгамдаж буй томоохон асуудал бөгөөд тодорхой хориглолт, хязгаарлалттай байдгаас энэ төрлийн бүтээгдэхүүний хэрэглээний эргэн тойрон дахь хууль бус худалдаа, хяналтгүй эргэлтийн асуудал нь хүн амын эрүүл мэндийг хохироох, улсын төсвийн орлого төвлөрөлтөд нөлөөлөх төдийгүй хууль тогтоомжоор бий болгосон тамхины хяналтын тогтолцоог сулруулах эрсдэлтэй байдаг. Монгол Улс ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц (WHO FCTC) болон түүний “Хууль бус худалдааг устгах тухай протокол”-д нэгдсэн улсын хувьд тамхины хууль бус худалдаа, хяналтгүй эргэлтээс урьдчилан сэргийлэх талаар үндэсний хууль тогтоомжоо боловсронгуй болгох үүрэг хүлээдэг. Хуулийн төслөөр халаадаг болон электрон тамхийг тамхин бүтээгдэхүүнд тооцох болон бүх төрлийн тамхинд нэмэлт үнэр, амтыг хязгаарлах зохицуулалт тусгагдах нь хууль бус худалдааг нэмэгдүүлэх эрсдэлтэй тул үүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор тамхи үйлдвэрлэгч, импортлогч, худалдагч зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн бүртгэл, тамхин бүтээгдэхүүн бүрийг QR кодоор бүртгэх цахим бүртгэлийн систем нэвтрүүлэх зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Энэ нь тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг таслан зогсоох, үйлдвэрлэлийн эх үүсвэрээс хэрэглэгч хүртэлх бүх шатны хөдөлгөөнийг хянах, хууль бус, хуурамч бараа бүтээгдэхүүн улсын хилээр нэвтрэхээс сэргийлэх, татвараас зугтах боломжийг хязгаарлах, хэрэглэгч бүтээгдэхүүний хууль ёсны байдалд хяналт тавих боломж бүрдэх, төрийн тамхины хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Иймд Монгол Улс электрон тамхи болон шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний талаар зохицуулалтыг бий болгох, Тамхины хяналтын хуулийн хэрэгжилтийг хангахад бүх талуудын оролцоог дэмжих, тамхинаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, тамхины хэрэглээг татвараар дамжуулан хязгаарлах чиглэлд худалдаа, байршил, борлуулалттай холбоотой үйл ажиллагаанд олон улсын стандарт, ДЭМБ-ын зөвлөмж, Тамхины хяналтын суурь конвенц, Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай Протоколын зарчимд нийцүүлэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах практик шаардлага бодитойгоор тулгарч байна.

Хоёр.Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл хэлбэрээр, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тэр дундаа өсвөр үе, хүүхэд, залуучуудыг тамхины хор хөнөөлөөс хамгаалах, тамхины хэрэглээг бууруулах зорилгоор боловсруулна.

Тамхины хяналтын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр халаадаг болон электрон зэрэг шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнийг тамхитай адилтан тодорхойлж, тэдгээрийн үйлдвэрлэл, импорт, худалдаа, хэрэглээ, сурталчилгаа, хяналт, хариуцлагын асуудлыг тамхин бүтээгдэхүүний эрх зүйн зохицуулалтад хамруулна.

Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдийн хамтын ажиллагаа, чиг үүргийн хуваарилалтыг боловсронгуй болгож, тамхидалтыг бууруулах, тамхины хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх нь салбар дундын зохицуулалт бүхий, олон талт харилцаа болохыг илэрхийлэх зохицуулалт тусгана.

Шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнтэй холбоотойгоор бүх төрлийн тамхинд тамхинаас өөр төрлийн амт, үнэр нэмэх, сав баглаа боодол нь бусад энгийн бүтээгдэхүүнтэй андуурагдахуйц, сэтгэл татах өнгө үзэмжтэй байхыг хориглох зохицуулалт тусгана. Түүнчлэн тамхин бүтээгдэхүүнийг худалдаалахдаа худалдааны байгууллагын касс буюу төлбөр төлөх хэсгийн хажууд ил тавьж, өнгө үзэмжтэй өрөлттэйгээр худалдаалж байгааг өөрчлөх, тамхи худалдаалахыг зөвшөөрсөн насанд хүрсэн хүн өөрийн хүсэлтээр, бүтээгдэхүүний нэр, хор хөнөөлийн талаарх мэдээллийг багтаасан жагсаалтаас сонгон худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалт тусгана.

Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр хуульд заасан хориглолт, хязгаарлалт нь тогтмол зөрчигддөг бөгөөд зөрчсөн үйлдэлд хариуцлага оногдуулах буюу хуулийн хэрэгжилтийг хангах тогтолцоо муу ажиллаж байгааг дурдсан. Иймд хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор тамхи худалдаалах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөлтэй болохыг илтгэх тэмдгийг хэрэглэх, тамхины зар сурталчилгаанд хяналт тавих эрх бүхий байгууллагыг тодорхой болгох зохицуулалт тусгагдана.

Тамхины хэрэглээг бууруулахад эдийн засгийн арга болох татварын оновчтой бодлого хэрэгжүүлэхээс гадна тамхинаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэмжих нь хориглолт, хязгаарлалттай энэ зэрэгцэхүйц үр нөлөөтэй тул тамхи татдаг

хүнийг тамхинаас гаргах, никотины хамаарал, хорт зуршлаасаа салах үйл явцыг дэмжих, хөнгөвчлөх зорилготой зөвлөгөө, эмчилгээ, сэтгэлзүйн дэмжлэг, эм бэлдмэл зэргийг багтаасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг төрөөс хөгжүүлэх зохицуулалтыг тусгана. Тамхин бүтээгдэхүүний үнэ манай улсад хэт хямд байгаа нь тамхидалтыг нэмэгдүүлэх нэг нөхцөл болж байгаа бөгөөд нөгөө талаас олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор тамхи, тамхин бүтээгдэхүүнд ногдуулах онцгой албан татварын хувь хэмжээг олон улсын жишигт нийцүүлэн нэмэгдүүлэх зорилгоор холбогдох хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг дагалдуулан боловсруулна. Үүнтэй холбоотойгоор татварын тодорхой хувийг тамхины хор хөнөөлтэй тэмцэх, эрүүл мэндийн боловсролоор дамжуулан урьдчилан сэргийлэх, тамхинаас гаргах эмчилгээ, үйлчилгээг санхүүжүүлэх талаарх зохицуулалтыг тусгана.

Тамхин бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж байгаатай холбоотойгоор хууль бус худалдаа үүсэх эрсдэлтэй тул бүтээгдэхүүн бүрт онцгой албан татварын тэмдэг ашиглан, үйлдвэрлэл болон импортоос эхлэн эцсийн хэрэглэгч хүртэлх бүхий л шатанд хяналт тавих, бүтээгдэхүүний гарал үүсэл, хууль ёсны байдлын талаар мэдээлэл бүхий нэгдсэн сантай байх зохицуулалтыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаарх санал

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар тамхины хяналтыг тогтоож байгаа хамгийн гол зорилго болох тамхины хэрэглээ бууруулах зорилго хангагдахын зэрэгцээ дараах нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах зэрэг үр дагавар үүснэ гэж үзэж байна. Үүнд:

1.Тамхины хяналтын тухай хуульд шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний талаарх зохицуулалт нэмж тусгагдснаар тэдгээр бүтээгдэхүүнд олон нийтийн газар тамхи татахтай холбоотой хуулийн хориглолт, хязгаарлалт шууд үйлчилж эхлэхийн зэрэгцээ чихэр, жимс, гаа зэрэг нэмэлт амт, үнэр бүхий бүтээгдэхүүн импортлох, худалдаалагдах нь хориглогдох, өсвөр үе, залуучуудад хандсан маркетинг, анхаарал татахуйц загвар дизайнтай байгааг тамхины зар сурталчилгааны зохицуулалтаар зохицуулах боломжтой болж тамхидалтын түвшин буурахад мэдэгдэхүйц нөлөө үзүүлнэ. Ялангуяа тамхины хор нөлөөг бүрэн ухамсарлаж амжаагүй байгаа өсвөр насныхан, залуу үеийн тамхидалт буурах, улмаар тэдний бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндийг тамхины хор хөнөөлөөс хамгаалах, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах боломж нэмэгдэнэ;

2.Тамхидалтыг бууруулах зорилгоор гагцхүү тамхи татахыг хориглох бус түүнтэй зэрэгцүүлэн тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээг төр бодлогоор дэмжих, хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлснээр тамхинаас гаргах эмчилгээ, зөвлөгөөний хүртээмж нэмэгдэж, олон мянган хүнийг никотины хамааралтай байдлаас гаргах, амьдралын чанарыг дээшлүүлэх, уушгины хорт хавдар, зүрх судасны өвчин, амьсгалын замын архаг өвчлөл зэрэг халдварт бус өвчлөлийг урьдчилан сэргийлэх боломж нэмэгдэнэ;

3.Хүн амын дундах тамхидалт буурснаар Эрүүл мэндийн даатгалын сан, улсын төсвөөс хорт хавдар, уушиг, зүрх судасны эмгэгийн эмчилгээ, үйлчилгээ, хөдөлмөрийн

чадвар алдалтад олгох эмчилгээний зардал хасагдах, улсын төсвийн ачаалал буурах болон тамхидалтаас үүдэлтэй өрхийн эдийн засагт үзүүлэх дарамт багасгана;

4.Тамхийг ил задгай буюу биет байдлаар дэлгэн худалдаалахыг хязгаарлах нь насанд хүрээгүй хүнд төдийгүй тамхи татдаг хүнд ч тамхи худалдан авах сэдлийг бууруулж, хэрэглээг багасгадаг болох нь Европын холбоо, Англи, Шинэ зеланд улсуудад хийгдсэн судалгаагаар батлагдсан байдаг. Тамхийг дэлгүүр худалдааны төвийн төлбөр тооцоо хийх хэсэгт болон бусад хэсэгт ил задгай дэлгэн худалдаалахгүй байх зохицуулалт тусгагдснаар тамхи татах шийдвэр гаргаагүй байгаа хүн /насанд хүрээгүй хүн/ тамхи худалдан авах нь боломжтой бөгөөд тамхи татах нь эерэг гэсэн хандлагыг бууруулж, тамхины хүртээмжийг багасган, тамхины хэрэглээний эхлэлд хяналт тавих боломж бүрдэхийн зэрэгцээ нийгмийн дунд тамхины хэрэглээг “хэвийн” үзэгдэл мэтээр хүлээн зөвшөөрөх байдлыг халахад дэмжлэг үзүүлнэ;

5.Тамхины хяналтад оролцогч төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох, Тамхины хяналтын хуулийн үндсэн зорилго болох тамхины хэрэглээг бууруулах зарчимтай уялдуулах нь давхардал, хийдэл, хариуцлагагүй байдал буурах, хуулийн хэрэгжилт хангагдахад бодит үр нөлөө үзүүлнэ;

6.Тамхидалт буурснаар үр дүн нь зөвхөн өнөөдөр маргаашаар хязгаарлагдах бус ирээдүйд тамхинаас үүдэлтэй нас баралт, хорт хавдар, бусад өмчлөл багасах, үүнийг дагалдан эдийн засгийн хувьд улс орны болоод айл өрхийн төсөвт ирэх дарамтыг бууруулах ач холбогдолтой;

7.Тамхи, тамхин бүтээгдэхүүний эргэлтэд хяналт тавих зорилготой, тамхи импортлох, үйлдвэрлэх тусгай болон энгийн зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэл, холбогдох бусад мэдээллийг агуулсан мэдээллийн цахим сантай болно. Монгол Улсад үйлдвэрлэсэн, импортолсон бүх төрлийн тамхийг үйлдвэрлэл, импорт, борлуулалтын үе шат бүрээр эцсийн хэрэглэгч хүртэл олон улсын стандартад нийцсэн дахин давтагдашгүй, цахим өгөгдөл бүхий код ашиглана. Энэхүү кодыг цахим төлбөрийн баримт, гаалийн мэдүүлэгт үндэслэн татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ. Ингэснээр энэхүү тогтолцоо нь тамхины хууль бус худалдаа үүсэхээс урьдчилан сэргийлж, эргэлтэд бүрэн хяналт тавих боломжийг бүрдүүлнэ;

8.Монгол Улс нь ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц (FCTC)-ын хэрэгжилтийг хангаж, олон улсын эрүүл мэндийн хэм хэмжээ, стандартад нийцсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх замаар олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлнэ;

9.Цаашлаад урт хугацаандаа тамхинаас үүдэлтэй өвчлөл, нас баралтын улмаас жил бүр алдаж буй эдийн засгийн боломжийг бууруулж, эдийн засгийн өсөлтийг дэмжих идэвхтэй хүн амын тоо өсөх боломж бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төслийг дагалдуулан Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл болон "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг тус тус боловсруулна.

-----oOo-----

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тамхины хяналтын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслийн талаар

Тамхины хэрэглээг бууруулах, тамхины хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгын хүрээнд Тамхины хяналтын тухай хуулийн зорилго, зарчим, үзэл баримтлалд нийцүүлэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

Хуулийн төсөлд Засгийн газрын санал дүгнэлт авахаар хүргүүлснийг 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн үзэл баримтлалын хувьд дэмжиж, холбогдох санал дүгнэлт гаргасанг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны 7 дугаар 07-ны өдрийн ХЭГ/1892 дугаар албан бичгээр хууль санаачлагчид ирүүлсэн болно.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэхээр боловсруулсан бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын D.PARLIAMENT.MN цахим сүлжээнд байршуулсан бөгөөд 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн байдлаар нийт 466 санал ирүүлсэн. Мөн хуулийн төслийг боловсруулах явцад олон улсын хэлэлцүүлэг, зөвлөгөөн 1 удаа, холбогдох төрийн байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг 2 удаа тус тус зохион байгууллаа. Түүнчлэн хуулийн төсөлтэй холбогдуулан нийт 15 байгууллагаас албан бичиг болон цахим шуудангаар санал ирүүлсэн. Хуулийн төсөлтэй холбогдуулан ирүүлсэн нийт саналыг нэгтгэн хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх саналын товъёог бэлтгэн хуулийн төсөлд хавсаргалаа.

Тамхины хэрэглээг хуулиар зохицуулах нь хүний болон нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, өсвөр үе, залуучуудыг хорт зуршлаас сэргийлэх зорилготой. Тамхи нь эрүүл мэндэд ноцтой хор хөнөөл учруулж, нас баралтын шалтгаан болдог тул олон улсад хууль, олон улсын гэрээний хүрээнд зохицуулалт хийж иржээ. Монгол Улсад тамхины хяналтын хууль анх 1993 онд батлагдсан бөгөөд 2005 оноос шинэчлэгдэж, нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Гэвч сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд шинэ төрлийн электрон тамхины хэрэглээ эрс нэмэгдэж, ялангуяа өсвөр үе, залуучуудын дунд түгээмэл хэрэглэгдэх болсон байна.

Манай улсад тамхины үнэ хямд, татварын хэмжээ ДЭМБ-ын зөвлөмжөөс доогуур байгаа нь хэрэглээг бууруулахад саад болж байгаа бөгөөд тамхины татвар нэмэгдэхэд хэрэглээ багасдаг болох нь олон улсын туршлагаар нотлогдож байна.

Тамхины хяналтын тухай хуульд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр хуулийн хэрэгжилт хангалтгүй, хяналт сул, хууль бус худалдаа ихэссэн, хяналтын байгууллагуудын уялдаа холбоо муу байгаагаас өсвөр үе, залуучуудын дунд тамхины хэрэглээ өсөж, эрүүл мэнд, сэтгэлзүйд сөргөөр нөлөөлж байгаа талаар дурджээ. Монгол Улсад тамхинаас шалтгаалсан нас баралт жилд ойролцоогоор 4300 болж, эдийн засгийн алдагдал 801 тэрбум төгрөгт хүрсэн байна. Иймээс тамхины хэрэглээг бууруулахын тулд онцгой татварыг нэмэгдүүлэх, электрон тамхийг хуульчилж зохицуулах шаардлагатай болсон байна.

Олон улсад электрон тамхи, шинэ төрлийн тамхины хэрэглээг хязгаарлах хатуу хууль, эрх зүйн зохицуулалт амжилттай хэрэгжиж байгаа туршлагууд бий болсоор байна. Жишээ нь, насанд хүрээгүй хүнд тамхи, шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнийг худалдахыг хориглох, амт үнэр болон сурталчилгаа, сав баглаа боодолд хязгаарлалт тогтоох, татвар ногдуулах зэргээр хуульчилсан байна. Тодруулбал, Австрали, АНУ, Их Британи, Шинэ Зеланд, Канад зэрэг улс орнууд электрон тамхийг бүртгэж, хатуу хяналт тавьж байна. ДЭМБ-гаас ч мөн ийм зохицуулалтыг хуульчлахыг зөвлөдөг бөгөөд Монгол Улс ч энэ жишигт нийцсэн хууль эрх зүйн шинэчлэл хийх шаардлагатай болсон байна.

Иймд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгалаа. Үүнд: тамхины төрөлд электрон, халаадаг, усан, наадаг г.м бүх төрлийг оруулах, хүүхэд, залуучуудыг хамгаалж амт үнэр нэмэхийг хориглох, тамхинаас гарах тусламж үйлчилгээг дэмжих, спорт, залуучуудын үйл ажиллагаанд санхүүжилт өгөх, хяналтын байгууллагуудын чиг үүргийг тодорхойлох, савлагаа, никотины хэмжээг хязгаарлах, тамхины татварыг үе шаттай нэмэгдүүлэх, татварын орлогыг эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлж зарцуулах, хуулийн зөрчлийг системчлэх зохицуулалтыг тус тус тусгалаа. Үүнд:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр олон улсын зөвлөмж, шилдэг туршлагад нийцүүлэн тамхи болон никотины хамаарлаас урьдчилан сэргийлэх, гарахад дэмжлэг үзүүлэх зорилгоор бүтээгдэхүүнд амт, үнэр оруулагч бодис хэрэглэхийг хориглох, борлуулалтын цэгт ил байршуулалтыг хязгаарлах, тамхи худалдахыг илтгэх тэмдгийг ил байршуулах, тамхи татахыг хориглосон орчныг өргөтгөх, никотины хамаарлаас гарахад чиглэсэн зөвлөгөө, эмчилгээ, сэтгэлзүйн дэмжлэг бүхий тусламж, үйлчилгээг төрийн бодлогоор дэмжих зохицуулалтыг нэмж тусгалаа.

Төслийн 2 дугаар зүйлээр тамхины урамшуулалт худалдаа, үнэгүй тараалт, хөнгөлөлт зэрэг шууд болон шууд бус сурталчилгааг хориглож, импортын хяналтын шаардлагыг өргөжүүлэн нарийвчилж, тамхины компанийн хандив, ивээн тэтгэлтийг нийтийн спорт, урлаг, улс төрийн үйл ажиллагаа зэрэгт хориглох зохицуулалтыг тусган, хүүхэд, өсвөр үеийг хамгаалах, хүн амын эрүүл мэндийг дэмжих зорилгыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Төслийн 3 дугаар зүйлээр “тамхин бүтээгдэхүүн”-ий тодорхойлолтод бүх төрлийн шинэ бүтээгдэхүүнийг хамруулах, бодлого, зохицуулалтыг Эрүүл мэндийн яаманд төвлөрүүлж, хамтын хяналтын тогтолцоо бүрдүүлэх, анхааруулга, савлагааны шаардлагыг чангатгах, электрон тамхины агууламж, багтаамжид дээд хязгаар тогтоох, хүүхдийн орчныг хамгаалах зохицуулалтыг өөрчлөн найруулсан.

Төслийн 4 дүгээр зүйлээр хуулийн үг, өгүүлбэр өөрчлөх өөрчлөлтийг, 5, 6 дугаар зүйлээр “утаат тамхи” гэх хязгаарлагдмал ойлголтыг хүчингүй болгож, бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнд ижил зохицуулалт үйлчлэх нөхцөл бүрдүүлэн, ил дэлгэн тавихтай холбоотой зарим зохицуулалтыг шинэ хоригтой уялдуулан хүчингүй болголоо.

Төслийн 7 дугаар зүйлээр энэхүү хуулийг дагаж мөрдөх хугацааг хуульчилсан.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай уялдуулан дараах хууль, тогтоолын төслийг боловсрууллаа. Үүнд:

1.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр тамхинаас гаргах эм, бүтээгдэхүүнийг даатгалаар санхүүжүүлэх зохицуулалт бүрдүүлж, иргэдэд дэмжлэг үзүүлнэ. Энэ хүрээнд “даатгалаар хариуцах үйлчилгээний багц” болон эмийн жагсаалтад “тамхинаас гаргах эм, бүтээгдэхүүн”-ийг нэмж тусгасан. Ингэснээр тамхинаас гарах боломж нэмэгдэж, өвчлөл, зардал буурна.

2.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр тамхины татварын орлогоос төвлөрсөн хөрөнгийг ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын үдийн хоолны шим тэжээлийг дээшлүүлэх арга хэмжээ, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг эрүүл, аюулгүй, идэвхтэй өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, тамхинаас урьдчилан сэргийлэх болон гаргах тусламж, үйлчилгээ зэрэгт зориулах замаар хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулах, иргэдэд шаардлагатай тусламжийг хүртээмжтэй хүргэх, эмнэлгийн зардлыг хэмнэх, нийгмийн эрүүл мэндийн бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэв.

3.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний хэрэглээ өсөж, инфляцын нөлөөгөөр эрүүл мэндийн зардал нэмэгдэж буй энэ үед эдгээр бүтээгдэхүүнд онцгой албан татварыг 2025–2030 оны хооронд үе шаттайгаар нэмэгдүүлэх, татварын орлогыг тамхинаас урьдчилан сэргийлэх, гаргах эмчилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд чиглүүлэх замаар хэрэглээг бууруулж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэхийг зорьсон болно.

4.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр тамхи, ялангуяа электрон болон халаадаг тамхины хэрэглээ өсөж байгаа тул тамхи үйлдвэрлэл, тамхины ургамал тарих, импорт болон худалдах тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамжийг эрс нэмэгдүүлж, хяналт, санхүүгийн хариуцлагыг чангатгав. Ингэснээр тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаанд тавих хяналт сайжирч, хүн амын эрүүл мэндийг хамгаалах төрийн бодлого үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

5.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдэж, хяналт, зохицуулалт сул байгаатай уялдуулан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй худалдаа эрхлэгчдэд оногдуулах хариуцлагыг ялгамжтай тогтоох, хууль бус үйлдвэрлэл, худалдаа, сурталчилгаанд тавих хяналтыг сайжруулах, хариуцлагыг чангатгах, өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлэхээр тусгалаа.

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг тодорхой болгох шаардлага үүссэн. Иймд тус хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.16 дахь хэсгийн “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “6.3,” гэдэг үгийг нэмснээр шинээр туссан хяналт, хариуцлагын зохицуулалтыг мөрдөх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

7.Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөөр тамхи нь онцгой албан татварын тэмдэг хэрэглэдэг бүтээгдэхүүн болохын хувьд тэмдгийг дахин ашиглагдахгүй байхаар байршуулах шаардлагатай бөгөөд энэ нь хууль бус тамхины хэрэглээг хязгаарлах зорилготой байдаг тул тамхины хайрцаг, сав, баглаа боодолд онцгой албан татварын тэмдэг байршуулах шаардлагыг нэмж тусгалаа.

8.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслөөр Тамхины хяналтын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, иргэн, хуулийн этгээдийн бэлтгэлийг хангах зорилгоор журмын хуулийн төсөл боловсруулав. Ингэснээр хууль хэрэгжих нөхцөл, бэлтгэлийг хангах, хууль хэрэгжиж эхлэхэд холбогдох төрийн болон бусад байгууллага, иргэн, хуулийн этгээд хуулийн талаар мэдээлэлтэй болсон байх, хууль нэг мөр хэрэгжих нөхцөл хангагдах юм.

8.Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөлд электрон тамхи, халаадаг тамхи зэрэг шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн, цэнэглэгч шингэн болон тэдгээрийн эд анги, хэрэгслийг гаалийн барааны жагсаалтад тусгай ангилал, кодоор нарийвчлан нэрлэж, одоогийн мөрдөж буй 5–20 хувийн гаалийн татварыг 30 хувь болгон нэмэгдүүлэв. Ингэснээр импортын хэт хямд үнийг хязгаарлаж, хэрэглээг бууруулах, өсвөр үе, залуучуудыг хорт зуршлаас сэргийлэх, нэмэгдсэн татварын орлогыг урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилтэд чиглүүлэх боломж бүрдэнэ.

-----oOo-----

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Тамхины хяналтын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслийн талаар

Тамхины хэрэглээг хуулиар зохицуулах нь зөвхөн нэг хүний сонголтыг хязгаарлах бус, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, эдийн засгийн өсөлтийг дэмжих, залуу үеийг хорт зуршилд татагдахаас сэргийлэх, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах зэрэг өргөн цар хүрээтэй зорилгоос үүдэн бий болдог. Тамхи нь хүний эрүүл мэндэд ноцтой хор хохирол учруулж, улмаар нас баралтад хүргэдэг томоохон шалтгаануудын нэг төдийгүй байгаль орчин, эдийн засагт ихээхэн дарамт үзүүлдэг болох нь олон төрлийн судалгаагаар нэгэнт батлагдсан. Иймд улс орон бүр тамхины хэрэглээг дотоодын хууль тогтоомжоор зохицуулахын зэрэгцээ олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох замаар энэ төрлийн хэм хэмжээг бий болгож, даган мөрддөг.

Монгол Улсын хувьд тамхины хэрэглээг бууруулах зорилгоор анх 1993 онд Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуулийг баталж, улмаар 2005 онд уг хуулийг шинэчлэн найруулснаар одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Тамхины хяналтын тухай хууль батлагдаж байв. Энэ хуульд 2012, 2015, 2019, 2022, 2023 онуудад нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт орсноос хоёр удаагийн нэмэлт, өөрчлөлт нь хуульд зарчмын шинжтэй өөрчлөлт орсон бол бусад нэмэлт, өөрчлөлт нь өөр хуулийг дагалдан нэр томьёо өөрчлөх, жигдлэх зорилготой байсан байна.

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд тамхи үйлдвэрлэгчид шинэ төрлийн электрон тамхин бүтээгдэхүүн (жишээлбэл, цахим тамхи (e-cigarette), vape, heated tobacco)-ийг зах зээлд нэвтрүүлж, уламжлалт тамхины “эрүүл” хувилбар мэтээр сурталчилж байна. Тэд өнгөлөг дизайн бүхий савлагаа, жимс, ментол, амттан зэрэг үнэр, амт оруулах химийн нэмэлт бодис, мөн нийгмийн сүлжээ болон инфлюенсер маркетингийг ашиглан хэрэглэгчдийг татах стратеги хэрэгжүүлснээр электрон тамхины хэрэглээ олон улсын түвшинд хурдацтай өсөхөд нөлөөлж байна. Ийм нөхцөл байдал нь тодорхой хууль, бодлогын зохицуулалт хангалтгүй байсан улс орнуудад өсвөр насныхан, залуучуудын дунд хэрэглээ огцом нэмэгдэхэд хүргэж, никотиний хамааралд оруулах, улмаар эрүүл мэндэд ноцтой эрсдэл учруулах сөрөг үр дагаврыг бий болгосоор байна. Энэхүү үзэгдэл нь олон улсын байгууллагууд болон улс орнуудын хувьд эрүүл мэндийн, хууль эрх зүйн, нийгмийн болон эдийн засгийн олон талын шинэ сорилтыг бий болгож байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (цаашид “ДЭМБ” гэх) болон улс орнуудын зүгээс хурдацтайгаар түгэн дэлгэрч байгаа шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах зорилгоор бүрэн болон хэсэгчилсэн хориглолт, хязгаарлалт тогтоосон хууль, дүрэм журам батлан мөрдүүлж эхлээд байна.

Монгол Улсын хувьд уламжлалт болон шинэ төрлийн тамхины хэрэглээ тогтмол өсөн нэмэгдэж 2019 онд 13-15 насны сурагчдын 14 хувь нь утаат тамхи, 3,5 хувь нь электрон тамхи хэрэглэдэг байсан бол 2023 онд энэ үзүүлэлт 19,9 хувь, 24,8 хувь болж огцом өссөн дүнтэй байгаа нь бүх төрлийн тамхины хор хөнөөлөөс өсвөр, залуу үеийг хамгаалах зайлшгүй шаардлага тулгарсан байгааг илтгэж байна.

Тамхины хэрэглээ тогтмол өсч байгаа шалтгааны нэг нь Монгол Улсад тамхин бүтээгдэхүүн маш хямд үнэтэй байдаг явдал юм. ДЭМБ-ын зүгээс тамхины

хэрэглээг бууруулах хамгийн үр дүнтэй бодлогын нэг нь тамхинд ногдуулах татварыг нэмэгдүүлэх гэж үздэг бөгөөд энэ нь 2003 онд батлагдсан “Тамхины хяналтын суурь конвенц” болон холбогдох бусад баримт бичгүүдээр баталгаажсан байдаг. ДЭМБ-ын судалгаагаар тамхины үнийг 10%-аар нэмэхэд хэрэглээ хамгийн багадаа 4%, хөгжиж буй орнуудад 5%–7% буурдаг бөгөөд ялангуяа өсвөр насныхан, бага орлоготой бүлэг нь тамхинаас илүү амархан татгалздаг гэжээ. Түүнчлэн ДЭМБ-аас тамхины жижиглэнгийн үнийн хамгийн багадаа 75%-ийг бүх төрлийн татвар (онцгой, гаалийн, НӨАТ г.м) бүрдүүлэх ёстой гэж зөвлөдөг. Монгол Улсын хувьд тамхин бүтээгдэхүүний дундаж үнэ 3850 төгрөг байгаа бөгөөд үүнийн 40 орчим хувийг татвар эзэлж байгаа нь дэлхийн хамгийн хямд тамхитай улсын жагсаалтад багтах, улмаар тамхины хэрэглээг дэмжих нөхцөлийг бүрдүүлж байна.

Өөрөөр хэлбэл, тамхины татвар болон тамхины хэрэглээ нь урвуу хамааралтай бөгөөд тамхины үнийн өсөлт нь өсвөр насныхан болон бага орлоготой иргэдийг тамхинаас татгалзахад ихээхэн нөлөө үзүүлсэн бусад улсуудын туршлага байна. Нөгөөтэйгүүр тамхины татвар нь зөвхөн төсвийн орлого бүрдүүлэх хэрэгсэл биш бөгөөд, хамгийн үр дүнтэй эрүүл мэндийн бодлого гэж үздэг болно. Иймд манай улсын хувьд бүх төрлийн тамхины онцгой болон импортын татварыг ДЭМБ-аас санал болгодог босго түвшин хүртэл нэмэгдүүлэх замаар тамхины хэрэглээг бууруулах хэрэгсэл болгон ашиглах шаардлагатай юм.

Монгол Улс 2020 оноос хойш тамхин бүтээгдэхүүний онцгой албан татварын хувь хэмжээг нэмээгүй бөгөөд электрон тамхины хувьд тамхин бүтээгдэхүүнд тооцогдохгүй байгаагаас онцгой албан татваргүй ба зөвхөн импортлох тоо хэмжээ нэмэгдсэнээс татварын дүн өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1.Импортын сигар, янжуур тамхинд ногдуулсан албан татварын хэмжээ 2020-2024 он /сая.төгрөг/

Он	Тоо хэмжээ мян.ш	Үнийн дүн (сая.ам.дол)	Гаалийн албан татвар (сая.төг)	Онцгой албан татвар (сая.төг)	НӨАТ (сая.төг)	Нийт татвар (сая.төг)
2020	2,933,613.14	56.87	48,364.45	122,625.03	33,135.09	204,124.57
2021	3,081,898.64	60.48	52,095.38	128,823.36	35,325.06	216,243.80
2022	3,345,958.07	69.41	65,042.93	139,780.37	42,122.16	246,945.47
2023	3,489,971.80	63.90	66,359.02	145,880.82	43,343.66	255,583.50
2024	3,493,985.37	66.69	67,795.58	146,048.59	43,982.94	257,827.11

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 2.Электрон тамхи, цэнэглэгч шингэн болон төхөөрөмжид ногдуулсан татварын хэмжээ 2020-2024

Он	Үнийн дүн (сая.ам.дол)	Гаалийн албан татвар (сая.төг)	НӨАТ (сая.төг)	Нийт татвар (сая.төг)
2020	0.00116	0.17	0.35	0.51
2021	6.54	975.94	1,961.39	2,937.33
2022	14.52	2,273.40	4,773.89	7,047.29
2023	13.29	2,300.58	4,831.22	7,131.80
2024	22.58	3,824.23	8,030.64	11,854.87

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Парламентийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хэрэгжилтийг үр дагаврын үнэлгээгээр уг хууль дахь дараах зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай талаар дүгнэлт гарсан байна. Үүнд¹:

“1.Тамхинд ногдуулах онцгой албан татварын хэмжээ ДЭМБ-ын зөвлөмжид хүрэхгүй, харьцангуй бага түвшинд байгаа нь тамхины хэт хүртээмжтэй байдлыг бий болгож, хэрэглээг бууруулахад хангалттай үр дүнг үзүүлж чадахгүй байна.

2.Нийтийн эзэмшлийн зарим газарт зориулалтын тамхи татах цэг байгуулаагүйгээс иргэд хууль зөрчих эрсдэлд өртөж байна.

3.21 насанд хүрээгүй хүний тамхи худалдан авах боломж хяналтгүй хэвээр байна.

4.Тамхи худалдаалагчид худалдан авагчийн насыг шалгахгүйгээр тамхи худалдаж байгаа нь ширхэглэн зарах худалдааны далд сүлжээг тэлж, өсвөр үеийнхний хэрэглээг нэмэгдүүлэх шалтгаан болсон байна.

5.Зөвшөөрснөөс бусад газарт тамхи худалдах зөрчил нийт зөрчлийн 83.3%-ийг эзэлж байгаа нь хууль бус худалдаа далд хэлбэрт шилжиж, хяналтгүйгээр өргөжин тэлсэн байна.

6.Хуулийн хэрэгжилтийг хангах хяналтын тогтолцоо сул, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо хангалтгүй, хариуцлага тооцох механизм бүрхэг байгаа нь хэрэгжилтийг үр дүнгүй болгож байна. Үүрэг, хариуцлагын хуваарилалт тодорхойгүй, хяналт хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагаа сул байгаагаас үүдэн бүх ачаалал Цагдаагийн байгууллагад төвлөрч, тэдний ажиллах чадавх, үр нөлөөнд сөргөөр нөлөөлж байна.” гэжээ

Мөн дээрх тайланд дурдсан үр дүнгээс үзэхэд, тамхины хэрэглээ, тэр дундаа электрон тамхины худалдааны хүртээмж сурагч, оюутнуудын дунд өндөр байгааг тоо баримтаар дурдаад сурагчдын 24.4 хувь нь ямар нэгэн байдлаар тамхи худалдан авч чадсан, оюутан, залуучуудын 57.7 хувь нь нас харгалзахгүйгээр, 82.9 хувь нь хүнсний дэлгүүр болон ТҮЦ-ээс тамхи худалдаж авсан хэмээн мэдээлсэн нь хуулийн хэрэгжилтэд анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай болсныг харуулж байна².

Олон улсын эрүүл мэндийн байгууллагууд, тэр дундаа ДЭМБ болон АНУ-ын Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх төв (CDC) электрон тамхи болон никотин агуулсан бүтээгдэхүүнүүд нь хүүхэд, өсвөр насныхны тархины хөгжилд сөргөөр нөлөөлж, суралцах чадвар, сэтгэлзүйн байдалд муугаар нөлөөлдөг болохыг анхааруулдаг. Дээрх байгууллагуудын мэдээлснээр, никотин нь тархины анхаарал төвлөрөл, суралцах чадвар, сэтгэл хөдлөлийг удирдах үйл ажиллагаанд хортой нөлөө үзүүлдэг бөгөөд өсвөр насны хүүхдийн тархи 25 нас хүртэл хөгжиж байдаг

¹ Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн “Тамхины хяналтын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан” 2025 он

² Мөн тэнд


тул энэ хугацаанд никотин хэрэглэх нь урт хугацаандаа эрүүл мэндийн сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлтэйг онцолсон байна.

Электрон тамхи хэрэглэдэг өсвөр насныхны дунд сэтгэл гутрал, түгшүүр, анхаарал төвлөрөл, ой тогтоолт, өөрийгөө хянах чадвар буурах зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн асуудлууд илүүтэй ажиглагдаж байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд, электрон тамхи болон шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний хэрэглээ нь хүүхэд, өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэнд, суралцах чадварт ноцтой сөрөг нөлөө үзүүлж байгааг нотолж байна.³

Цагдаагийн байгууллагаас гаргасан мэдээллээр 2015–2024 оны хооронд Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэгт заасан зохицуулалтыг зөрчсөн нийт 6,831 зөрчил улсын хэмжээнд бүртгэгдсэнээс 28.8 хувь буюу 1,970 зөрчил нь аймгуудад, 71.1 хувь буюу 4,860 нь зөрчил нийслэлд гарсан байна.⁴ Гэвч энэхүү статистик мэдээлэлд электрон тамхи болон шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнтэй холбоотой зөрчлүүд тусгагдаагүй нь уг төрлийн бүтээгдэхүүнд хамаарах тодорхой эрх зүйн зохицуулалт байхгүйтэй холбоотой бөгөөд энэ нь хууль хяналтын байгууллагын бүртгэл, хяналтын үр нөлөөг бодитой илэрхийлж чадахгүйд хүргэж байна.

ДЭМБ-ын 2022 оны тооцооллоор Монгол Улсад тамхины хэрэглээ 28.4 хувьд хүрч, Номхон далайн баруун бүсийн орнуудын дунд хамгийн өндөр тархалттай орны 7 дугаарт жагсаж байна. Энэ нь Монгол Улс 2030 он гэхэд тамхины хэрэглээг 30 хувиар бууруулах зорилтоо биелүүлэхэд хүндрэл учруулах нөхцөл байдлыг бүрдүүлж байна.

Зураг 3. Монгол Улсын 15-69 насны хүн амын тамхины хэрэглээний тархалт



Эх сурвалж: ЭМЯ, ДЭМБ-ын "Тамхи тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад саад болж байна" тайлан, 2023 он

Монгол Улсад тамхинаас шалтгаалсан нас баралт нийт нас баралтын 17 хувийг эзэлж, жил бүр ойролцоогоор 4300 хүн тамхины хэрэглээтэй холбоотой нас барж байна. Тамхины хэрэглээний эдийн засгийн зардлыг тооцохдоо тамхинаас үүдэлтэй өвчний эмчилгээнд шаардагдах эрүүл мэндийн өртөг, тамхинаас үүдэлтэй өвчлөл, нас баралтын улмаас алдагдаж буй хүний нөөцийг оруулж тооцдог бөгөөд тамхины хэрэглээнээс шалтгаалсан эдийн засгийн алдагдал жил бүр 801 тэрбум төгрөгт хүрч, ДНБ-ний 2.1 хувийг эзэлж байна.⁵

³ Мөн тэнд

⁴ Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн "Тамхины хяналтын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан" 2025 он

⁵ Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 110 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн тайлан 2025 он


Улсын хэмжээнд 2024 оны байдлаар тамхи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуйн нэгж, тамхи импортлох тусгай зөвшөөрөлтэй 19 аж ахуйн нэгж байгаа бөгөөд 2024 онд импортолсон 3.5 тэрбум ширхэг янжуур тамхийг нийт хүн амын тоонд харьцуулахад нэг хүнд жилд дунджаар 1000 ширхэг янжуур тамхи буюу 50 хайрцаг янжуур тамхи ногдож байна.

Харин 2025 оны байдлаар улсын хэмжээнд тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй нийт 4743 иргэн, хуулийн этгээд байгаагаас Улаанбаатар хотод 1406, аймгуудад 3337 иргэн, хуулийн этгээд тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байна.⁶

Дэлхийн улс орнууд тамхины хэрэглээг хязгаарлах, эрсдэлийг бууруулах зорилгоор бодлогын олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг бөгөөд үүний нэг нь гааль, татварын бодлогын хүрээнд зохицуулах арга хэрэгсэл юм.

Гаалийн ерөнхий газраас гаргасан статистик мэдээллээс үзэхэд, 2024 онд импортолсон янжуур тамхины хэмжээ 2020 оноос 1,1 дахин өссөн, электрон тамхины шингэн болон төхөөрөмжийн хэмжээ 2021 оноос 4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 2. Сигар, янжуур тамхи болон электрон тамхины импортын хэмжээ 2020-2024 он



Хүснэгт 1. Янжуур тамхи болон электрон тамхины импортын хэмжээ 2020-2024 он

Он	Сигар, янжуур тамхи		Электрон тамхи болон цэнэглэгч шингэн		Электрон тамхины төхөөрөмж	
	мян.ш	үнийн дүн, мян.ам.дол	мян.ш	Үнийн дүн, мян. ам.дол	мян.ш	Үнийн дүн, мян.ам.дол
2020	2,933,613.14	56,870.76	-	-	0.047	1.16
2021	3,081,898.64	60,483.16	589.11	1,682.35	1,199.17	4,859.61
2022	3,345,958.07	69,414.32	4,754.48	11,960.81	334.29	2,554.86
2023	3,489,971.80	63,895.07	5,453.80	12,303.39	165.47	987.30
2024	3,493,985.37	66,687.16	6,919.23	19,173.01	852.84	3,409.60

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тамхины хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д "тамхин бүтээгдэхүүн" гэж татах, үнэрлэх, зажлах зорилгоор тамхины навчийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн хэрэглээний бүтээгдэхүүнийг, 3.1.2-т "утаат тамхи" гэж үйлдвэрийн болон гар аргаар ороож бэлтгэсэн, татах зориулалттай янжуур, навчин тамхи, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг хэлнэ гэж тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, эдгээр тодорхойлолтод электрон

⁶ Мөн тэнд

тамхи хамаардаггүй буюу электрон тамхи нь Тамхины хяналтын тухай хуулийн үйлчлэлд хамаараахгүй өдийг хүрсэн байна.⁷

Олон улсын туршлагаас үзэхэд, шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний хэрэглээ, тархалтыг хязгаарлах, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн хатуу зохицуулалтыг олон улс орон амжилттай хэрэгжүүлж байна. Тухайлбал, электрон тамхи болон никотин агуулсан тамхин бүтээгдэхүүнийг тусгай зөвшөөрөлөөр борлуулах, бүртгэлийн тогтолцоо нэвтрүүлэх, насанд хүрээгүй хүмүүст худалдаалахыг хориглох, олон нийтийн газар хэрэглэхийг хязгаарлах, амт, үнэрийг хориглох, сав баглаа боодол болон сурталчилгааг хязгаарлах, стандарт тогтоох, татвар ногдуулах зэргээр эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Электрон тамхийг утаат тамхитай адилтган зохицуулдаг 54 улс байна. Үүнд: Аргентин, Австри, Азербайжан, Бахрейн, Бразил, Бруней Даруссалам, Болгар, Колумб, Коста Рика, Хорват, Эквадор, Эстони, Финланд, Гүрж, Герман, Грек, Гондурас, Индонез, Иран, Итали, Латви, Литва, Мальдив, Мальта, Маврикий, Мексик, Молдав, Балба, Нидерланд, Шинэ Зеланд, Никарагуа, Норвег, Палау, Панам, Парагвай, Польш, Румын, Сенегал, Сейшелийн арлууд, Сингапур, Словак, Словени, Өмнөд Солонгос, Испани, Швед, Тажикистан, Тайланд, Того, Турк, Туркменистан, Их Британи, АНУ, Венесуэл, Вьетнам зэрэг болно.

Мөн дээрх улс орнуудаас электрон тамхины бүрэлдэхүүн хэсэг буюу никотины агууламж, тодорхой амт зэргийг хязгаарладаг дараах 36 улс байна. Үүнд: Бельги, Болгар, Канад, Хорват, Кипр, Чех, Дани, Эстони, Финланд, Франц, Герман, Грек, Исланд, Ирланд, Израиль, Итали, Ямайк, Япон, Латви, Литва, Люксембург, Австрали, Австри, Мальта, Молдав, Нидерланд, Саудын Араб, Польш, Португал, Румын, Словак, Словени, Испани, Швед, Швейцарь, Их Британи⁸.

Австрали улс 2024 оны 03 дугаар сараас эхлэн эмчийн жороор электрон тамхи худалдах бөгөөд жоргүйгээр худалдаж авсан болон хил гаалиар оруулсан тохиолдолд "шар түүхтэй эрүүгийн зөрчил" (yellow card offence) гэж тооцохоос гадна амт, үнэр бүхий электрон тамхи, загварлаг дизайнтай бүтээгдэхүүнийг бүрэн хориглосон.⁹

АНУ-ын Хүнс, эмийн захиргаа (FDA) 2020 оноос эхлэн өсвөр насныхны хэрэглээг өдөөж буй хүчин зүйл хэмээн үзэж, жимс, амттан зэрэг амт, үнэр бүхий электрон тамхины бүтээгдэхүүнийг зах зээлээс татан авч эхэлсэн. Судалгааны үр дүнгээс харахад, амттай электрон тамхины бүтээгдэхүүн нь өсвөр үеийнхний хэрэглээг нэмэгдүүлдэг болохыг FDA тогтоосон тул дээрх бүтээгдэхүүнд хатуу хяналт тавьж, зөвшөөрөлгүй борлуулалтыг зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.¹⁰

Их Британийн Засгийн газар 2023 онд электрон тамхины хэрэглээг, ялангуяа хүүхэд, өсвөр насныхны дунд хязгаарлах зорилгоор амт, үнэр бүхий электрон тамхины сурталчилгаа, өнгөлөг, анхаарал татахуйц сав, баглаа боодол, маркетинг

⁷ Мөн тэнд

⁸ Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн "Тамхины хяналтын зарим асуудлаарх гадаад улсуудын туршлага" 2025 он

⁹ Australian Government, Department of Health and Aged Care. (2024). *Vaping reforms to protect young people*. Retrieved from: <https://www.health.gov.au>

¹⁰ U.S. Food & Drug Administration (FDA). (2020). *FDA finalizes enforcement policy on unauthorized flavored cartridge-based e-cigarettes*. Retrieved from: <https://www.fda.gov>

явуулахыг хориглож, зөрчсөн тохиолдолд өндөр хэмжээний мөнгөн торгууль ногдуулах, бүтээгдэхүүнийг худалдаалах зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэг арга хэмжээг авахаар хуульчилж, хэрэгжилтэд хатуу хяналт тавин ажиллаж байна.¹¹

Шинэ Зеландын Засгийн газар Утаагүй орчин ба зохицуулалттай бүтээгдэхүүний тухай хууль (Smokefree Environments and Regulated Products Act 1990)-д нэмэлт, өөрчлөлт оруулж, электрон тамхи болон түүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд гаргахаас өмнө тухайн бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгүүлж, тогтоосон стандартыг хангах шаардлагатай болгосон байна. Ингэснээр стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг худалдаанд гаргахыг хориглож, хэрэглэгчдийн эрүүл мэндийг хамгаалах, бүтээгдэхүүний чанарт хяналт тавих тогтолцоог бүрдүүлсэн.¹²

Канад улс 2018 онд баталсан Тамхи болон утаагүй бүтээгдэхүүний тухай хууль (Tobacco and Vaping Products Act)-аар бүх төрлийн электрон тамхи, вэйп бүтээгдэхүүнд хорт бодисын найрлага, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар анхааруулга бүхий шошгыг заавал байршуулахыг хуульчилсан. Түүнчлэн уг хуульд сурталчилгаа хийх, хөнгөлөлт үзүүлэх, үнэгүй дээж тараах зэрэг борлуулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн маркетингийн бүх хэлбэрийг хатуу хориглосон. Энэ нь ялангуяа өсвөр насныхны хэрэглээг бууруулах, хэрэглэгчдийг мэдээлэлтэй сонголт хийхэд чиглэсэн зохицуулалт болсон байна.¹³

ДЭМБ нь гишүүн орнуудад электрон тамхи болон шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнээс хүүхэд, өсвөр насныхныг хамгаалах зорилгоор тусгай зохицуулалт хийх, сурталчилгаа болон амт оруулагч бодисыг хориглох, зах зээлийн бүртгэл, стандарт болон бүтээгдэхүүний мэдээллийг хангах, хяналт тавих, мөн онцгой албан татвар ногдуулах зэрэг хатуу зохицуулалт хийхийг зөвлөсөн.¹⁴

Монгол Улс ч мөн адил шинэ нөхцөл байдалд тохирсон олон улсын жишигт нийцэхуйц хууль, эрх зүйн зохицуулалтыг яаралтай боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд дээр дурдсан нөхцөл байдал, судалгааны дүн, Монгол Улсын эрх зүйн үндсэн зарчим, олон улсын сайн туршлага, ДЭМБ-ын зөвлөмж, “Тамхины хяналтын суурь конвенц”, “Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай протокол”-ын зарчмуудтай нийцүүлэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 7 зүйлтэй хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл болон түүнийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалт тусгалаа. Үүнд:

- Тамхин бүтээгдэхүүний тодорхойлолтыг өөрчлөн найруулж, электрон тамхи, халаадаг тамхи, усан тамхи, наадаг тамхи зэрэг одоо хэрэглээнд нэвтрээд байгаа бүх төрлийн тамхийг тамхин бүтээгдэхүүнд хамааруулсан байдлаар нэр

¹¹ GOV.UK (2023). Youth vaping: government crackdown to protect children. Retrieved from: <https://www.gov.uk/government/news/youth-vaping-government-crackdown-to-protect-children>

¹² New Zealand Ministry of Health. (2023). Vaping regulation. Retrieved from: <https://www.health.govt.nz/our-work/regulation-health-and-disability-system/regulation-vaping>

¹³ Government of Canada. (2018). Tobacco and Vaping Products Act. Retrieved from: <https://www.canada.ca/en/health-canada/services/smoking-tobacco/vaping.html>

¹⁴ WHO (2021). WHO technical note on the regulation of electronic nicotine and non-nicotine delivery systems. Retrieved from: <https://www.who.int/publications/i/item/9789240034467>

томъёоны тодорхойлолтыг өөрчлөн найруулахаар тусгалаа. Ингэснээр уламжлалт тамхинд үйлчилж байгаа импортлох, худалдаалах, хэрэглэх, сурталчилах, хязгаарлах болон хориглохтой холбоотой бүх зохицуулалт шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнд нэгэн адил хамааралтай болно;

- Хүүхэд, залуучуудыг тамхины хэрэглээнээс хамгаалах зорилгоор бүх төрлийн тамхинд амт, үнэр оруулагч нэмэлт химийн бодис нэмэхийг хориглох зохицуулалт тусгалаа. Ингэснээр үнэр, амт, өнгө, дизайнд татагдан тамхи хэрэглэж байгааг бууруулах юм;

- Тамхи, никотины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээг төрийн бодлогоор хөгжүүлэх, дэмжих зорилго бүхий зохицуулалт тусгаснаар зөвхөн хориглолт, хязгаарлалт нь үр дүнтэй хэрэгжих нөхцөл бололцоо нэмэгдэнэ;

- Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг идэвхитэй өнгөрүүлэх зориулалттай нийтийн спортын байгууламж шинээр барих, өргөтгөх, засварлах, спортын дугуйлангийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлэх хөтөлбөрийг дэмжих, тамхины татвараас бий болсон орлогын тодорхой хувийг дээрх үйл ажиллагааг санхүүжүүлэх чиглэлийн зохицуулалт;

- Хуулийн хэрэгжилтийг сайжруулах, салбар хоорондын уялдаа холбоо сайжруулах зорилгоор энэ чиглэлд үүрэг хариуцлага хүлээн ажилладаг байгууллагуудын чиг үүргийг давхардалгүй, тодорхой болгох зохицуулалт;

- Тамхин бүтээгдэхүүний савлагааны хэмжээ, нэг савлагаан дахь никотоны хэмжээний хязгаарыг тогтоох, зарим байршилд тамхи татахыг хориглох зохицуулалт;

- Дагалдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийн бүх төрлийн тамхин бүтээгдэхүүний онцгой албан татварыг үе шаттайгаар нэмэгдүүлж, 2030 онд ДЭМБ-аас санал болгож буй босгод хүргэх зохицуулалт;

- Тамхины онцгой албан татварын орлогын тодорхой хувийг тамхинаас гаргах тусламж үйлчилгээ, спортын байгууламж, хүүхэд залуучуудад тамхины хор хөнөөлийг сурталчлан таниулах чиглэлд хяналттайгаар зарцуулах зохицуулалт;

- Тамхины хяналтын хуулийн зөрчлийг системчлэх зохицуулалт тус тус тусгалаа.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийн зохицуулалтыг зүйл тус бүрээр дэлгэрүүлэн дор тодруулав.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр Тамхины хяналтын тухай хуульд дараах агуулга бүхий зүйл, хэсэг, заалт нэмлээ.

- Хуулийн төслийн 3.1.12, 3.1.13, 3.1.14 дэх заалтаар тамхин бүтээгдэхүүнийг хэрэглэхэд ашиглагддаг татах төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, эд ангийг нэр томъёоны тодорхойлолтоор тусгалаа. Ингэснээр, тамхины хэрэглээний шинэ төрлүүдэд хэрэглэгдэж буй цахилгаан, дулаан, механик болон электроны энергиэр ажилладаг татах төхөөрөмж, түүнтэй хамт хэрэглэгдэх бөгөөд дангаар ашиглах боломжгүй дагалдах хэрэгсэл, хэрэглээний явцад солигддог эд ангийг хууль зүйн зохицуулалтад хамруулсан бөгөөд энэ нь хууль хэрэгжих явцад хяналт, хариуцлагын тогтолцоог нарийвчлан тодорхой болгох, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, худалдаа, хэрэглээний цар хүрээг илүү тодорхой болгож, хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлнэ.

- ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцын 9-11 дүгээр зүйлд тамхин бүтээгдэхүүнд амт, үнэр оруулагч бодисыг хязгаарлах, хэрэглэгчийг татахуйц сав,

баглаа боодлыг хориглохыг гишүүн орнуудад зөвлөсөн байдаг тул Тамхины хяналтын тухай хууль /цаашид “хууль” гэх/-д 6.7.16, 6.7.17 дахь заалтаар утаат тамхи, татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн эд ангид тамхинаас өөр төрлийн үнэр, амт оруулагч бодис, бэлдмэл нэмэх болон тамхины хайрцаг, сав, баглаа боодлыг хүний анхаарал татахуйц байдлаар үйлдвэрлэхийг тус тус хориглосон зохицуулалтыг нэмж тусгалаа.

- Манай улсад тамхи болон шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнийг дэлгүүр, худалдааны төвийн кассын дэргэд шилэн хоргонд ил байршуулан худалдаалж байгааг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж “борлуулалтын цэг дэх ил байршуулалтыг хориглох - point-of-sale display ban” зохицуулалтыг тусгалаа. Өөрөөр хэлбэл, хуульд эдгээр бүтээгдэхүүнийг биетээр дэлгэн үзүүлэхийг хориглож, зөвхөн 21-ээс дээш насанд хүрсэн хүний хүсэлтээр нэр, үнийн мэдээллийг тусгасан жагсаалтаас сонгон худалдан авах зохицуулалтыг тусгасан. Мөн дэлгүүр, худалдааны төв нь тамхи худалдах зөвшөөрөлтэй болохыг илтгэх тэмдгийг хэрэглэгч, худалдан авагчид харагдахуйцаар ил тод байршуулах бөгөөд энэ тэмдэгт маркетинг, сурталчилгаа, гэрэлтүүлэг, хөдөлгөөнт элемент, брэндийн уриа агуулахгүй байх болон тамхи худалдах зөвшөөрөлтэй болохыг илтгэх тэмдгийн загварыг өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн Стандартчиллын үндэсний зөвлөл батлах зохицуулалтыг тус тус тусгаж өглөө. Ингэснээр өсвөр үе, залуучуудын анхаарлыг татах, тамхины хэрэглээг өдөөх эрсдэлийг бууруулах, зөвшөөрөлгүй этгээд тамхи худалдаалахыг зогсоох ач холбогдолтой гэж үзлээ.

-Тамхины хяналтын тухай хуульд тамхи үйлдвэрлэх, импортлох, худалдах зөвшөөрлийн талаар зохицуулсан бөгөөд хуулийн төсөлд шинээр татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, эд ангийг зохицуулж байгаатай холбоотойгоор 7^{2.3} дахь хэсгээр “Тамхи татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, эд анги үйлдвэрлэх, худалдах, импортлоход тус хуулийн 7, 7¹, 7² дугаар зүйл нь нэгэн адил үйлчилэх талаар зааж өглөө. Өөрөөр хэлбэл, уламжлалт тамхины үйлдвэрлэл, тамхины ургамал тарих, импортлох, худалдах үйл ажиллагааг эрхэлхэд авдаг тусгай болон энгийн зөвшөөрөл, түүнийг сонгон шалгаруулах журам нь тамхи татах төхөөрөмж, түүний эд анги, дагалдах хэрэгсэлд ч адил хэрэглэгдэх нөхцөл бүрдэнэ.

- ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцын 14 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах зорилгоор тамхины хамаарлаас гаргах зөвлөгөө, эмчилгээ, сэтгэлзүйн дэмжлэг зэрэг шинжлэх ухааны үндэслэлтэй, стандартын шаардлага хангасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг төрийн бодлогоор дэмжих зохицуулалтыг шинээр тусгалаа. Түүнчлэн энэхүү тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сан болон хөнгөлөлттэй эмийн жагсаалтад хамруулах замаар санхүүжүүлэх бөгөөд үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг дагалдуулан боловсрууллаа.

-Тамхи үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн бүртгэл, холбогдох мэдээллийг нэгтгэсэн цахим сан байгуулах зохицуулалтыг хуулийн 11¹ дүгээр зүйлээр шинээр тусгалаа. Цахим сан нь татвар, мэдээллийн нэгдсэн сан, гаалийн мэдээллийн сантай холбогдож, Монгол Улсад үйлдвэрлэсэн, импортолсон бүх төрлийн тамхийг үйлдвэрлэл, импорт, борлуулалтын үе шат бүрээр эцсийн хэрэглэгч хүртэл олон улсын стандартад нийцсэн дахин давтагдашгүй кодтой цахим өгөгдөл ашиглан бүртгэнэ. Бүртгэлд бүтээгдэхүүний нэр, барааны код, үйлдвэрлэгч, импортлогчийн нэр, үйлдвэрлэсэн улс, огноо, тоо хэмжээ, гаалийн бүрдүүлэлт, төлсөн онцгой албан татварын дүн зэрэг мэдээллийг багтаах бөгөөд эцсийн

хэрэглэгч цахим төлбөрийн баримтаар дамжуулан холбогдох мэдээлэлтэй танилцах боломжийг бүрдүүлсэн. Харин цахим санг бүрдүүлэх, ашиглах үйл ажиллагааг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлж, холбогдох харилцааг тусгай журмаар зохицуулна. Ингэснээр, тамхин бүтээгдэхүүний эргэлтэд ил тод хяналт тогтоож, татварын бүртгэлтэй уялдуулан үйлдвэрлэл, импорт, худалдааны бүртгэл, мэдээллийг нэгтгэх, эцсийн хэрэглэгч хүртэл хяналт тавих боломжийг бүрдүүлнэ гэж үзлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлээр Тамхины хяналтын тухай хуулийн холбогдох заалтад дараах нэмэлт орууллаа.

- Тамхины борлуулалтыг нэмэгдүүлэх зорилготой урамшуулалт арга хэмжээ нь ялангуяа залуучууд болон бага орлоготой бүлгийн тамхины хэрэглээг өдөөх нөлөөтэй болох нь олон улсын судалгаагаар нотлогдсон. Иймд ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцын 13 дугаар зүйлийн тайлбар зөвлөмжид үндэслэн, хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.10-т Тамхины борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа зохион байгуулах, сугалаа гаргах гэсний дараа “үнэгүй тараах, бэлэглэх, хөнгөлөлт үзүүлэх, эд зүйлсээр арилжаалах” гэсэн шууд болон шууд бус сурталчилгааны хэлбэрүүдийг хориглохоор нэмж тусгасан.

- Хуулийн 7².2.11-д “эрүүл ахуйн” гэж заасны дараа “болон энэ хуульд заасан бусад” гэж нэмснээр зөвхөн эрүүл ахуйн шаардлага төдийгүй Тамхины хяналтын тухай хуульд заасан бусад зохицуулалтууд болох сав, баглаа боодол, шошго, найрлага, насны хязгаарлалт, сурталчилгааны хориг зэрэг шаардлагуудыг хамруулах эрх зүйн үндэс бүрдэнэ. Ингэснээр импортын шатанд бүтээгдэхүүний хяналт илүү өргөн хүрээнд цогцоор хэрэгжих боломжтой болж, тус хуулийн гол зорилго болох нийгмийн эрүүл мэнд, тэр дундаа хүүхэд, өсвөр үеийг тамхины хорт нөлөөнөөс хамгаалах, тамхины хэрэглээг бууруулах нөхцөл бүрэн хангагдана.

- Хуулийн 9 дүгээр зүйлийн тамхи татахыг хориглосон газрын 9.1.8-д “хүүхдийн асрамжийн газар, хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх газар, явган хүний зам дагуу, спортын байгууламж”-ийг нэмж оруулсан. Ингэснээр хүүхэд, өсвөр үеийнхнийг дам тамхидалтын сөрөг нөлөөллөөс хамгаалах, тэдний сурч боловсрох, хүмүүжих, тоглох, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчныг эрүүл, аюулгүй байлгах, түүнчлэн олон нийтийн эрүүл мэндийг хамгаалахад ач холбогдолтой зохицуулалт болно. Монгол Улсад хүүхдийн асрамжийн газар, цэцэрлэг, сургууль, спортын байгууламж зэрэг олон нийтийн газарт насанд хүрэгчид тамхи хэрэглэх нь хүүхэд, залуучуудыг тамхинд татагдах сэдэлд хүргэж, дам тамхидалтад өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг. ДЭМБ-ын судалгаагаар тамхи татах орчинд өссөн хүүхдүүдийн гуравны нэг нь цаашид өөрсдөө тамхи татах магадлал өндөртэй байдаг нь нотлогдсон. Иймд олон нийтийн байнга үйлчлүүлдэг, хүүхэд, залуучууд тогтмол цуглардаг газарт тамхи татахыг хориглосноор хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, дам тамхидалтаас урьдчилан сэргийлэх, нийтийн соёл, эрүүл ахуйн орчныг дээшлүүлэх, олон улсын сайн туршлагад нийцсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Мөн гудамжинд алхаж явах үедээ тамхи татах нь 10 метрийн радиуст байгаа бусад хүмүүс дам тамхидалтад өртөж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг гэсэн судалгаа байна. Өөрөөр хэлбэл, гудамж бол хүн амын хамгийн өргөн хэрэглэдэг нийтийн орон зай бөгөөд олон хүн цугларсан, ойрхон зөрөх нөхцөлд тамхины утаанд бусад иргэд өртөх эрсдэл өндөр байдаг. Иймээс гудамжинд буюу явган хүний зам дагуу алхангаа тамхи татахыг хязгаарлаж, олон нийтэд эрүүл, цэвэр орчныг

бүрдүүлснээр дам тамхидалтад өртөхөөс иргэдийг хамгаалах, нийтийн соёл, олон нийтийн газар биеэ зөв авч явах дадлыг хэвшүүлэх, тамхины хэрэглээг аажим бууруулах, олон улсын сайн туршлагад нийцсэн зохицуулалт бий болгох үүднээс хуулийн тайлбарыг оруулж өглөө.

Төслийн 3 дугаар зүйлээр Тамхины хяналтын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг дараах агуулгаар өөрчлөн найруулав.

- Хуулийн төсөлд тамхин бүтээгдэхүүний тодорхойлолтыг өргөтгөн шинэчилсэн. Өмнөх хуульд зөвхөн уламжлалт тамхин бүтээгдэхүүнийг хамарч байсан бол энэ удаагийн өөрчлөлтөөр тамхины навч болон ургамлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн боловсруулсан, нийлэг аргаар гарган авсан никотин болон түүний уламжлал дагавар бодис, амт, үнэр оруулагч болон бусад нэмэлт химийн бодис нэмсэн, эсхүл нэмээгүй, татах, үнэрлэх, сорох, зажлах, аманд уусгах, биед наах зэрэг янз бүрийн аргаар хэрэглэх боломжтой бүтээгдэхүүн болон дагалдах хэрэгсэл бүхий төхөөрөмжийг ашиглан хэрэглэх электрон болон халаадаг тамхи, тэдгээрийн цэнэглэгч шингэн, бусад тэдгээртэй адилтгах тамхин бүтээгдэхүүнийг хамруулахаар хүрээг өргөтгөсөн.

Тамхийг адилтгах хэв шинжээр нь таван төрлөөр тодорхойлсноор шинэ төрлийн зарим бүтээгдэхүүнийг тамхинд хамааруулах боломж бүрдэнэ.

- Одоогийн хууль тогтоомжид салбар хоорондын уялдааг хангах, хариуцах байгууллагын чиг үүрэг тодорхойгүйгээс хэрэгжилт хангалтгүй байна гэж Тамхины хяналтын тухай хуульд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд дурдагдсан байна. Иймээс хуулийн төслөөр тамхины хяналтын бодлого, зохицуулалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад төвлөрүүлэн, салбар хоорондын уялдааг хангах зохицуулалтыг тусгалаа.

Мөн тамхины хяналтыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэн, хуулийн этгээд, үйлдвэрлэгч, импортлогчийн оролцоо, үүргийг нарийвчлан тодорхойлж, давхардлыг арилган, хамтын ажиллагааг сайжруулах зохицуулалтыг тусгасан. Ингэснээр тамхины хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх, олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах бодлогыг шинжлэх ухаанд суурилсан, уялдаа холбоотой, олон улсын чиг хандлагад нийцүүлэн хэрэгжүүлэх боломж бүрдэх бөгөөд бодлого, арга хэмжээний зөрчил, давхардлыг арилгаж, нэгдсэн удирдлагатай, хариуцлагатай тогтолцоо бий болох нөхцөл бүрдүүлж байна.

- Хуулийн 6.4.1 дэх заалтыг ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц, түүний Сав баглаа боодол, шошгожуулалтын удирдамж болон олон улсын туршлага, жишигт нийцүүлэн “зурагт анхааруулга нь утаат тамхины хайрцаг, сав, баглаа боодлын нүүр болон ар талын талбайн хэсгийн гадаргуугийн талбайн 70-аас багагүй хувийг эзэлсэн байх” гэж өөрчиллөө.

- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.2-т уламжлалт тамхин бүтээгдэхүүний савлагааны дээд хэмжээг тогтоосон байх тул энэ хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан электрон тамхины шингэний савлагаа, цэнэглэгч болон никотины агууламжийн дээд хэмжээ тогтоох зохицуулалтыг нэмж тусгалаа. Тус зохицуулалт нь өндөр агууламжтай, хэт их багтаамжтай бүтээгдэхүүний нийлүүлэлтээр дамжуулан тамхины хэрэглээ нэмэгдэхээс сэргийлэх, хэрэглээг

бууруулах, эрсдэлийг хязгаарлах зорилготой бөгөөд олон улсын жишигт нийцсэн зохицуулалт болно.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлээр Тамхины хяналтын тухай хуулийн 8 дугаар зүйлээр тамхи сурталчилахад хориглох зохицуулалтыг тусгасан бөгөөд мөн зүйлийн 8.4 дэх хэсэгт тамхи үйлдвэрлэгч нь зарим төрлийн үйл ажиллагааг нийгмийн хариуцлага нэрийн дор ивээн тэтгэхийг хориглосон байдаг. Үүн дээр үйлдвэрлэгчээс гадна импортлогчийг ижил статустай гэж үзэн нэмэлтээр оруулж, ивээн тэтгэх байгууллага, үйл ажиллагааг “боловсрол, төрийн болон төрийн бус байгууллага, нийтийн биеийн тамир, спорт, урлагийн арга хэмжээ, сонгуульд нэр дэвшигч, улс төрийн намын үйл ажиллагаанд” гэж нэмлээ. Ингэснээр тамхины хэт хэрэглээг хязгаарлах, Тамхины хяналтын хуульд заасан тамхины талаар баримтлах төрийн бодлого нь тамхи үйлдвэрлэгч, импортлогчоос ангид байх зарчим бэхжих юм. Тамхины хяналтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд утаат тамхи татахыг хориглох байршил, газрыг зааж өгсөн боловч зүйлийн гарчгийн нэр нь тамхи татахыг хориглож байгаа байдлаар нэрлэгдсэн байгааг найруулгыг сайжруулах болон “утаат” тамхинаас гадна зарим төрлийн бусад тамхинд уг зохицуулалт нь нэгэн адил хамаарч байгаа тул зүйлийн гарчгийг “Тамхи татахыг хориглох орчин” болгох өөрчлөлтийг тусгалаа.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлээр Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр “утаат тамхи” гэсэн нэр томъёог өөрчилж байгаатай холбоотойгоор хуульд хэрэглэсэн “утаат” гэсэн үгийг хасахаар тусгав.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлээр Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “тамхин бүтээгдэхүүн”-ний нэр томъёоны тодорхойлолтыг өөрчилж байгаатай холбоотойгоор 3.1.2 дахь заалтад тусгагдсан “утаат тамхи” гэсэн нэр томъёоны тодорхойлолт болон тамхин бүтээгдэхүүнийг тамхи худалдаалах цэгт ил, биет байдлаар дэлгэн худалдаалахыг хориглож байгаатай холбоотойгоор Тамхины хяналтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг тус тус хүчингүй болгохоор тусгалаа.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлээр хуулийг дагаж мөрдөх хугацааг тогтоолоо.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн бөгөөд хууль хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор хуулийн төсөлтэй холбогдуулан дараах хуулийн болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулсан болно. Үүнд:

1.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Энэхүү хуулийн төслийн зорилго нь тамхинаас гаргах эмчилгээний эм, бүтээгдэхүүнийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих боломжийг бүрдүүлж, тамхинаас гаргах үйл явцад иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, улмаар хүн амын эрүүл мэндийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино.

Тамхи, түүнийг орлуулах бүтээгдэхүүнээс үүдэлтэй өвчлөл, нас баралт нь Монгол Улсын хүн амын эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байгаа бөгөөд тамхидалттай холбоотой эмнэлгийн зардал жил бүр өсөн нэмэгдэж байна.

Тамхинаас гаргах эмчилгээ нь урьдчилан сэргийлэх, архаг өвчний ачааллыг бууруулахад үр дүнтэй хэмээн олон улсын судалгаагаар нотлогдсон боловч эдгээр эм, бүтээгдэхүүний өртөг өндөр, иргэд өөрсдийн зардлаар худалдан авах боломж хязгаарлагдмал байгаагаас хэрэглээний хүртээмж муу байна.

Тамхины хяналтын тухай хууль болон ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцоор тамхинаас гарахад дэмжлэг үзүүлэх нь төрийн бодлогын тэргүүлэх чиглэл гэж заасан тул энэхүү нэмэлт, өөрчлөлт нь олон улсын хэм хэмжээнд нийцсэн, бодит дэмжлэг үзүүлэх боломжийг бий болгоно гэж үзлээ.

Иймд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц"-ын хүрээнд "тамхинаас гаргах эмчилгээний эм, бүтээгдэхүүн" гэж, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтад тус багцын тодорхойлолтод "тамхинаас гаргах эм, бүтээгдэхүүн"-ийг тус тус нэмэж тусгалаа. Ингэж тусгаснаар мөн хуулийн 14.9.10 дахь заалтын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь үнийн хөнгөлөлт эдлэх зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад "тамхинаас гаргах эм, бүтээгдэхүүн"-ийг оруулж, тамхинд хамааралтай иргэд эдгээрийг даатгалын хөнгөлөлттэй нөхцөлөөр авах боломж бүрдэнэ.

Энэхүү хууль хэрэгжсэнээр тамхинаас гарахыг хүссэн иргэдэд эмчилгээний бүтээгдэхүүнийг даатгалаар олгох боломж бүрдэж, тамхинаас гарах хандлага нэмэгдэх, тамхидалтаас шалтгаалсан өвчлөл, нас баралт буурах, эрүүл мэндийн салбарын урт хугацааны зардал хэмнэгдэх зэрэг үр дүнг бий болгоно. Мөн нийгмийн эрүүл мэндийн бодлого илүү уялдаа холбоотой, үр дүнтэй болно.

2.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Тамхинаас шалтгаалсан өвчлөл, ялангуяа хорт хавдрын тархалт нэмэгдэж, нийгмийн эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байгаа тул эрсдэлийг бууруулахын тулд урьдчилан сэргийлэх мэдээлэл, боловсрол, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, тамхинаас гаргахад чиглэсэн эмчилгээ, зөвлөгөө, сэтгэлзүйн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох шаардлага нэн тулгамдсан асуудал болоод байна. Гэвч эдгээр арга хэмжээг тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлэхэд санхүүгийн тогтвортой эх үүсвэр дутмаг, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.

Иймд уг хуулийн төслөөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, бүх төрлийн тамхинаас урьдчилан сэргийлэх болон гаргах чиглэлийн арга хэмжээ, мөн эдгээртэй шууд хамаарал бүхий эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийг дэмжих бодлого, хөтөлбөрт тусгай сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэхээр тусгалаа. Үүнд:

-ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын үдийн хоолны шим тэжээлийг дээшлүүлэх арга хэмжээ;

-хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг эрүүл, аюулгүй, идэвхтэй өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор спортын зориулалттай байгууламжийг шинээр

барих, өргөтгөх, засварлах, зориулалтыг нь өөрчлөн тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, үйл ажиллагааг нь дэмжих арга хэмжээ;

-тамхинаас гарах, никотины хамаарлыг бууруулахад чиглэсэн эмчилгээ, зөвлөгөө, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмчилгээ, түүний хүртээмжийг дэмжих арга хэмжээ.

Хуулийн төслийг баталснаар тамхинаас урьдчилан сэргийлэх, гаргах бодитой, тогтвортой арга хэмжээг санхүүгийн эх үүсвэрээр хангах эрх зүйн орчин бүрдэх, өсвөр үе, залуучуудын дунд тамхины хэрэглээг бууруулах, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, тамхинаас үүдэлтэй өвчлөл, тэр дундаа хорт хавдрын улмаас үүсэх нийгэм, эдийн засгийн хохирлыг бууруулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах нөхцөл бүрдэнэ.

Энэ хуулийн төсөл нь Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль болон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр, ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцын үзэл баримтлалтай уялдаж байгаа болно.

3.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Монгол Улсын хил, гаалиар “цахилгаан хэрэгсэл” гэсэн ангиллаар 2014 оноос хойш нэвтэрч эхэлсэн электрон тамхи, халаадаг тамхи, тэдгээрийн төхөөрөмж, шингэн зэрэг шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний хэрэглээ эрчимтэй нэмэгдэж, ялангуяа өсвөр үе, залуучуудын дунд өргөн тархаж байна. Эдгээр бүтээгдэхүүн нь уламжлалт тамхитай ижил донтуулах, хүний эрүүл мэндэд хортой нөлөөтэй хэдий ч онцгой албан татвар ногдуулах эрх зүйн зохицуулалт тодорхой бус байсаар ирсэн.

Иймд тамхины хэрэглээг бууруулах, өсвөр үе, залуусын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнд шат дараалсан өсөлт бүхий онцгой албан татвар ногдуулах хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Хуулийн төслөөр Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтэд электрон тамхины шингэн, бүх төрлийн тамхины төхөөрөмж, дагалдах эд ангийг шинээр нэмж, янжуур тамхинд ногдуулах хэмжээг “100 ширхэг” гэснийг “20 ширхэг” болгон өөрчилж, хэрэглээний бодит хэмжээнд ойртуулж, онцгой албан татварын хэмжээг 2025–2030 оны хооронд үе шаттайгаар өсгөх зохицуулалтыг тусгалаа.

Энэ хууль батлагдсанаар шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнд хяналт тогтоох, хэрэглээг бууруулах бодлого үр дүнтэй хэрэгжиж, татварын орлого нэмэгдэж, эрүүл мэндэд хортой бүтээгдэхүүний хүртээмж багасах эерэг үр нөлөөтэй. Мөн тус хууль нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомж, ДЭМБ-ын зөвлөмж, олон улсын жишигтэй нийцэж байна.

4.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Манай улсад тамхи, ялангуяа шинэ төрлийн электрон болон халаадаг тамхины хэрэглээ өсөж, түүний импорт нэмэгдэж байгаа нь эрүүл мэндийн болон татвар, хураамжийн зохицуулалтад шинэ шаардлага үүсэж байна. Тамхины

бизнесийн цар хүрээ өргөжихийн хэрээр тусгай зөвшөөрөл, хяналтын тогтолцоо, санхүүгийн хариуцлагыг чангатгах бодлого шаардлагатай болсон.

Иймд энэхүү хуулийн төслөөр тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих тусгай зөвшөөрөл олгох хураамжийг зохистой түвшинд нэмэгдүүлэн "7,500,000 төгрөг" гэснийг "25,000,000 төгрөг", түүний хугацааг сунгуулахад "4,500,000 төгрөг" гэснийг "15,000,000 төгрөг" гэж, тамхи импортлох тусгай зөвшөөрөл олгох, сунгахад улсын тэмдэгтийн хураамж "14,000,000 төгрөг" гэснийг "50,000,000 төгрөг", худалдах зөвшөөрөл олгоход "100,000-500,000 төгрөг" гэснийг "500,000–1,000,000 төгрөг" болгон тус тус нэмэгдүүлж байна.

Уг хуулийн төсөл батлагдсанаар тамхи, тамхин бүтээгдэхүүний импорт, худалдаанд тавих санхүүгийн хяналт сайжирч, улсын төсөвт төвлөрөх тэмдэгтийн хураамжийн орлого нэмэгдэнэ. Мөн төрийн зохицуулалтын үүрэг, эрүүл мэндийг хамгаалах төрийн бодлого үр нөлөөтэй хэрэгжинэ.

5. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Сүүлийн жилүүдэд шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн болох электрон тамхи, халааж хэрэглэх тамхи (ЕНТР), никотин агуулсан бусад бүтээгдэхүүн өргөн тархаж, хэрэглээ хурдацтай нэмэгдэж байна. Үүнийг даган эдгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, худалдаа, сурталчилгаа зэрэг бүхий л шатанд тавих хяналт сул, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа нь иргэдийн, ялангуяа өсвөр үеийнхний эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөө үзүүлж байна.

Хэрэглээ хязгаарлах бодлогын хүрээнд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаатай уялдуулан Зөрчлийн тухай хуульд мөн нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага тулгарч байна. Одоогийн хууль зөрчигчдөд ногдуулах торгуулийн хэмжээ нь хангалтгүй, хариуцлагын механизм сул байгаа нь хууль бус үйл ажиллагааг өөгшүүлж буй тул энэ төслөөр дараах зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

-Тамхины сурталчилгаа, ивээн тэтгэлтэд хориг тавих хүрээг өргөтгөж, импортлогч, улс төрийн нам, төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд хориг тавих эрх зүйн үндсийг тодорхой болгох;

-Тамхины худалдаа, үйлдвэрлэл, импорт, экспортод тавигдах шаардлагыг зөрчсөн тохиолдолд зөрчил үйлдэхэд ашигласан эд хөрөнгө, хууль бусаар олсон орлого, хөрөнгийг хураах, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, хүн, хуулийн этгээдэд торгууль ногдуулах;

-Зөвхөн "утаат тамхи"-д хамаарах байсан хуучин заалтыг хүчингүй болгож, бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнд (уламжлалт болон шинэ хэлбэрүүдэд) хамаарах уялдаа бүхий зохицуулалт бий болголоо.

Хуулийн төсөл батлагдсанаар тамхины хууль бус үйлдвэрлэл, худалдаа, сурталчилгаанд тавих хяналт сайжирч, зөрчил гаргасан этгээдэд оногдуулах хариуцлага чангарах, хууль сахиулах орчин сайжирч, иргэд, ялангуяа өсвөр үеийнхний эрүүл мэндийг хамгаалах эрх зүйн баталгаа нэмэгдэхэд чухал үр нөлөө үзүүлнэ.

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор тамхин бүтээгдэхүүнийг хуульд заасан хориглосон хэлбэрээр сурталчилсан зөрчилд шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагыг тодорхой болгох зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын эрх бүхий байцаагчийг Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрхтэй байхаар нэмэлт тусгалаа.

Ингэснээр Тамхины хяналтын тухай хуулиар хориглосон хэлбэрээр тамхийг сурталчилсан болон дэлгэцийн бүтээлд дүрсэлсэн зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанг тодорхой болгох шаардлагын дагуу чиг үүргийн хувьд зар сурталчилгааны асуудал нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт /Монополийн эсрэг газар/ хамаарах тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.16 дахь хэсэгт Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын хяналтын байцаагчийн шалган шийдвэрлэх зөрчлийн хэрэгт Тамхины хяналтын тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг нэмж тусгах зохицуулалт тусгав.

7.Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулиар согтууруулах ундаа болон тамхи нь онцгой албан татварын тэмдэг хэрэглэдэг бүтээгдэхүүний бөгөөд уг хуулиар тэмдгийг олгох, хэрэглэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан болно.

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт согтууруулах ундаанд онцгой албан татварын тэмдгийг хэрхэн нааж, бэхлэх талаар тусгасан байдаг боловч тамхи, тамхин бүтээгдэхүүнд тэмдгийг хэрхэн нааж бэхлэх зохицуулалт тусгагдаагүй болно.

Онцгой албан татварын тэмдгийн зорилго нь тухай бүтээгдэхүүнийг нээх үед тэмдэг дахин ашиглах боломжгүйгээр гэмтдэг байх нь хууль бус бүтээгдэхүүн худалдах, нэг тэмдгийг хэд хэдэн бүтээгдэхүүнд дахин ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой юм. Иймд тэмдгийн энэ чанарыг хангах зорилгоор Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт тамхин бүтээгдэхүүнд тэмдгийг хэрхэн нааж бэхлэх талаарх зохицуулалтыг тусгалаа.

8.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийгдагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн захиргааны болон хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, хуулийн хэрэгжилтэд шаардагдах бэлтгэл ажлыг хангах, тамхи үйлдвэрлэх, импортлох, худалдах, хэрэглээтэй холбоотой иргэн, хуулийн этгээдийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгох зорилгоор дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Энэхүү журмын хуулиар Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжиж эхлэхтэй зэрэгцэн төрийн байгууллагуудын зохион

байгуулалт, бүртгэл, мэдээллийн сангийн уялдаа, хяналт шалгалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, иргэн, хуулийн этгээд хуулийн хэрэгжилтэд бэлтгэлтэй оролцох нөхцөлийг хангах зохицуулалт тусгагдсан. Ийнхүү дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталснаар Тамхины хяналтын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн хэрэгжилт нэг мөр болж, төрийн байгууллагын үйл ажиллагааны уялдаа, олон нийтийн эрх ашиг хамгаалагдах нөхцөл бүрдэнэ.

9.Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл.

Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” тогтоолын хавсралтад шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн болон тэдгээрийн эд анги, хэрэгслийг тодорхой ангилан нэрлээгүй, мөн импортын гаалийн албан татварын хувь хэмжээ тодорхой тусгагдаагүй байгаа нь бодлогын болон хуулийн хийдэл үүсгэж байна. Үүний улмаас шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний импортын өсөлтийг хязгаарлах боломжгүйд хүрч, хэт хямд үнээр зах зээлд нийлүүлэгдэх нөхцөл бүрдэж, хэрэглээг өдөөх, эрүүл мэндэд учрах сөрөг нөлөөг нэмэгдүүлэх зэрэг бодит эрсдэл бий болоод байна.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хуулийн төсөлтэй уялдуулж Улсын Их Хурлын дээрх тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулснаар нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, ялангуяа өсвөр үе, залуучуудыг хорт зуршлаас сэргийлэх, мөн татварын бодлогыг нийгмийн хариуцлагатай байдлаар хэрэгжүүлэх боломжтой болно.

Иймд уг тогтоолын төслөөр Гаалийн татвар ногдуулах барааны жагсаалтын 24, 85, 96 дугаар бүлэгт шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн, тэдгээрийн эд анги, дагалдах хэрэгслийн гаалийн код, нэршил, ангилал, татварын хувь хэмжээг шинээр тодорхойлж, гаалийн албан татварын хэмжээг 30 хувь байхаар тогтоох, 24 дүгээр бүлгийн одоо хүчин төгөлдөр мөрдөж буй “янжуур үйлдвэрлэх зориулалттай тамхи”, “нэгэн төрлийн болгосон тамхи, эсхүл сэлбэгдсэн тамхи”, “бусад” зэрэг нэр төрөлд ногдуулж буй 5-20 хувийн татварыг 30 хувь болгон нэмэгдүүлэхээр тусгалаа.

Тогтоолд энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулснаар шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний импортыг хязгаарлах замаар хэрэглээг бууруулах, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, ялангуяа өсвөр үе, залуучуудын дундах хэрэглээний өсөлтийг сааруулах, улсын төсвийн татварын орлогыг нэмэгдүүлэх замаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх бодлогыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлнэ.

Иймд Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, дээрх зохицуулалтыг тусгах нь хууль зүйн болон бодлогын үндэслэлтэй, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн алхам болно.

-----oOo-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тамхины хяналтын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.12, 3.1.13, 3.1.14 дэх заалт:

“3.1.12.”татах төхөөрөмж” гэж тамхин бүтээгдэхүүнийг хэрэглэх зориулалттай үйлдвэрлэгдсэн, цахилгаан, дулаан, механик, электроны энергиэр ажилладаг тоног хэрэгслийг;

3.1.13.”дагалдах хэрэгсэл” гэж татах төхөөрөмжийн үйл ажиллагаа, тамхин бүтээгдэхүүнийг дэмжихэд зориулагдсан, дангаар ашиглах боломжгүй хэрэгслийг;

3.1.14.”татах төхөөрөмжийн эд анги” гэж хэрэглээний явцад хэрэглэх боломжгүй болсноос сольж, татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэлд суурилуулж хэрэглэдэг хэсгийг.”

2/6 дугаар зүйлийн 6.7.16, 6.7.17 дахь заалт:

”6.7.16.тамхи, татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн эд ангид тамхи болон гаанаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх;

6.7.17.тамхи, татах төхөөрөмжийн хайрцаг, сав, баглаа боодол нь өнгө, дүрслэл, хэлбэр хийцлэл, материал болон бусад гадаад шинж чанараараа бусад эд зүйлстэй андуурагдахаар байх.”

3/6 дугаар зүйлийн 6.8.3, 6.8.4 дэх заалт:

“6.8.3.тамхи худалдаалах цэгт тамхины нэр, үнийн мэдээлэл агуулсан жагсаалт байрлуулж, тамхин бүтээгдэхүүнийг биетээр дэлгэн худалдаалахгүй байх;

6.8.4.тамхи худалдах зөвшөөрөлтэй болохыг илтгэх тэмдгийг худалдан авагч олж харахуйц ил байрлалд байршуулах.”

4/6 дугаар зүйлийн 6.8¹ дэх хэсэг:

“6.8¹.Энэ зүйлийн 6.8.4-т заасан тэмдэг нь тамхи худалдаалах зөвшөөрөлтэй худалдааны цэгийг онцгойлон сурталчлах, хэрэглээг өдөөх, маркетингийн зорилгоор ашиглагдаж болохуйц гэрэлтүүлэг, дуу, хөдөлгөөнт элемент, брэндийн дүрслэл, уриа үг агуулаагүй байна. Тэмдгийн загварыг өрсөлдөөний асуудал

эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн Стандартчиллын Үндэсний зөвлөл батална.”

5/7² дугаар зүйлийн 7^{2.3} дахь хэсэг:

“7^{2.3}.Тамхи татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, татах төхөөрөмжийн эд анги үйлдвэрлэх, худалдах, импортлоход энэ хуулийн 7, 7¹, 7² дугаар зүйл нь нэгэн адил үйлчилнэ.”

6/9¹ дүгээр зүйл:

9¹ дүгээр зүйл.Тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

9^{1.1}.Тамхи татдаг хүнийг тамхинаас гаргах, никотины хамаарал, хорт зуршлаасаа салах үйл явцыг дэмжих, хөнгөвчлөх зорилготой зөвлөгөө, эмчилгээ, сэтгэлзүйн дэмжлэг, эм бэлдмэл зэргийг багтаасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ. Тусламж үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

- 9^{1.1.1}.сэтгэлзүйн эмчилгээ;
- 9^{1.1.2}.никотин орлуулах эмчилгээ;
- 9^{1.1.3}.эмийн эмчилгээ;
- 9^{1.1.4}.тусгай утасны зөвлөгөө, мэдээллийн тусламж үйлчилгээ.

9^{1.2}.Энэ хуулийн 9^{1.1}-д заасан тусламж үйлчилгээ нь үр нөлөөтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй, холбогдох стандартын шаардлага хангасан байх ба тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан үзүүлнэ.

9^{1.3}.Энэ хуулийн 9^{1.1}-д заасан тусламж үйлчилгээг төрөөс дэмжих, бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх бөгөөд тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сан болон хөнгөлөлттэй эмийн жагсаалтад хамруулах замаар санхүүжүүлнэ. Үүнтэй холбогдсон харилцааг Эрүүл мэндийн тухай хуулиар нарийвчлан зохицуулна.

9^{1.4}.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас энэ хуулийн 9^{1.1}-д заасан тусламж үйлчилгээний үр нөлөө, чанар, хүртээмжийн талаар тогтмол судалгаа, үнэлгээ хийнэ.”

7/11¹ дүгээр зүйл:

“11¹ дүгээр зүйл.Тамхин бүтээгдэхүүний эргэлтэд хяналт тавих

11^{1.1}.Тамхин бүтээгдэхүүний эргэлтэд хяналт тавих зорилготой, тамхи үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай болон энгийн зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэл, холбогдох бусад мэдээллийг агуулсан мэдээллийн цахим сантай байна.

11^{1.2}.Мэдээллийн цахим сан нь татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, гаалийн үйл ажиллагааны мэдээллийн сантай холбогдсон байна.

11^{1.3}.Монгол Улсад үйлдвэрлэсэн, импортолсон бүх төрлийн тамхийг үйлдвэрлэл, импорт, борлуулалтын үе шат бүрээр эцсийн хэрэглэгч хүртэл олон улсын стандартад нийцсэн дахин давтагдашгүй, цахим өгөгдөл бүхий код ашиглан цахим

төлбөрийн баримт, гаалийн мэдүүлэгт үндэслэн татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

11¹.4.Энэ хуулийн 11¹.3-т заасан санд дараах мэдээллийг бүртгэнэ:

- 11¹.4.1.бүтээгдэхүүний нэр, барааны код;
- 11¹.4.2.үйлдвэрлэгч, импортлогч хуулийн этгээдийн нэр;
- 11¹.4.3.бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улсын нэр;
- 11¹.4.4.үйлдвэрлэсэн болон импортолсон огноо, тоо хэмжээ;
- 11¹.4.5.импортолсон тохиолдолд гаалийн бүрдүүлэлт хийсэн огноо;
- 11¹.4.6.төлсөн онцгой албан татварын дүн.

11¹.5.Энэ хуулийн 11¹.4-т заасан мэдээллийг тамхи худалдан авсан этгээд өөрийн ашигладаг цахим төлбөрийн баримтын системээр дамжуулан танилцах боломжтой байна.

11¹.6.Энэ хуулийн 11¹.1-д заасан цахим санг бүрдүүлэх, ашиглах үйл ажиллагааг үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлнэ.

11¹.7.Энэ хуулийн 11¹.1-д заасан цахим санг бүрдүүлэх, ашиглах, баяжуулах харилцааг Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 38.7-д заасан журмаар зохицуулна.”

2 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.10 дахь заалтын “сугалаа гаргах” гэсний дараа “, үнэгүй тараах, бэлэглэх, хөнгөлөлт үзүүлэх, эд зүйлсээр арилжаалах” гэж, 7² дугаар зүйлийн 7².2.11 дэх заалтын “эрүүл ахуйн” гэсний дараа “болон энэ хуульд заасан бусад” гэж, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “үйлдвэрлэгч” гэсний дараа “, импортлогч” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.8 дахь заалтын “дотуур байр” гэсний дараа “хүүхдийн асрамжийн газар, хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх газар,” гэж, мөн заалтын “цэцэрлэгт хүрээлэн,” гэсний дараа “, явган хүний зам дагуу, спортын байгууламж” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт:

“3.1.1.“тамхин бүтээгдэхүүн” /цаашид “тамхи” гэх/ гэж тамхины навч, ургамлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн болон нийлэг аргаар гаргаж авсан никотин, түүний уламжлал дагавар бодис, бохь, химийн бодис агуулсан, амт, үнэр оруулагч нэмсэн, эсхүл нэмээгүй, татах, үнэрлэх, сорох, зажлах, аманд уусгах, биед наах, эсхүл бусад аргаар, дагалдах хэрэгсэл бүхий төхөөрөмжийг ашиглаж болон ашиглахгүйгээр хэрэглэх зориулалттай, хууль тогтоомжид заасны дагуу эмийн бүртгэлд бүртгэгдсэн тамхинаас гаргах эмээс бусад дараах бүтээгдэхүүнийг:

3.1.1.а.тамхины түүхий эд, задгай тамхи, татаж хэрэглэх зориулалттай навчин, дүнсэн, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи;

3.1.1.б.цахилгаан халаагч болон бусад арга, хэрэгслээр асаахгүйгээр сорж татах зориулалттай бүх төрлийн халаадаг тамхи;

3.1.1.в.никотин, никотин давс, амт, үнэр оруулагч болон бусад химийн бодис агуулсан, эсхүл агуулаагүй шингэнийг цахилгаан хэрэгслээр ууршуулан татах, эсхүл түүнтэй адилтгах аргаар хэрэглэх зориулалттай электрон тамхи;

3.1.1.г.усан хоолойгоор татах зориулалттай тамхи, тамхи орлуулагч, амт, үнэр оруулагч бүтээгдэхүүн;

3.1.1.д.үнэрлэх, сорох, зажлах, аманд уусгах, биед наах болон татахаас бусад аргаар хэрэглэх зориулалттай, никотин агуулсан, эсхүл агуулаагүй химийн бодис, амт, үнэр оруулагч бүтээгдэхүүн."

2/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт:

"3.1.11."тамхи татах зөвшөөрөгдсөн цэг" гэж энэ зүйлийн 3.1.1.д-д зааснаас бусад тамхийг энэ зүйлийн 3.1.3-т заасан дам тамхидалт бий болгохгүйгээр татах зориулалтаар тусгайлан бэлтгэсэн талбай, агааржуулалтын тоног төхөөрөмжөөр тоноглож тусгаарласан өрөөг."

3/5 дугаар зүйл:

"5 дугаар зүйл.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар салбар хоорондын хамтын ажиллагаа, төр, иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоо

5.1.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллага дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

5.1.1.нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, олон нийтийн боловсрол олгох чиглэлээр тамхи үйлдвэрлэгч, эсхүл түүний ашиг сонирхлын төлөө ажиллаж байгаа хуулийн этгээд, иргэдтэй хамтран ажиллахаас татгалзах;

5.1.2.тамхины хяналтын тухай хууль тогтоомж боловсруулах явцад ашиг сонирхлын зөрчил байгаа гэж үзсэн тохиолдолд тамхи үйлдвэрлэгчээс тавьсан саналыг хүлээн авахаас татгалзах;

5.1.3.тамхины хяналтын талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа төрийн албан хаагч, бусад ажилтны ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг шийдвэрлэж, хамтран ажиллахаас татгалзах.

5.2.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

5.2.1.тамхины хэрэглээг бууруулах, тамхинаас үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаарх улсын нэгдсэн бодлого боловсруулах, Засгийн газраар батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

5.2.2.энэ зүйлийн 5.2.1-д заасан бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн бүх шатны болон нутгийн өөрөө удирдах байгууллагатай хамтран ажиллах, салбар хоорондын уялдааг хангах;

5.2.3.тамхины хэрэглээ, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх мэдээлэл цуглуулах, нэгдсэн статистик хөтлөх, түүнд дүн шинжилгээ хийх;

5.2.4.тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэмжих, хөгжүүлэх.

5.3.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

5.3.1.ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт тамхины хор уршиг, насанд хүрээгүй иргэнийг тамхинд орохоос урьдчилан сэргийлэх агуулга тусгах;

5.3.2.бүх шатны сургуулийн орчинд тамхи худалдах, хэрэглэхийг хориглох, зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэх, хамтран ажиллах;

5.3.3.бүх шатны сургуулийн орчин дахь тамхидалт, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагааны талаар нэгдсэн тоо мэдээлэл хөтлөх, насанд хүрээгүй иргэний тамхи татах болсон шалтгаан, нөхцөлд судалгаа, үнэлгээ хийх;

5.3.4.бүх шатны боловсролын байгууллагыг тамхи импортлогч, экспортлогч, үйлдвэрлэгч, худалдаа эрхлэгчээс хандив, тусламж, дэмжлэг авахгүй байх талаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

5.4.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

5.4.1.энэ хуулийг зөрчсөн зөрчилд оногдуулсан шийтгэлийн төрлийн үр нөлөөтэй байдалд дүн шинжилгээ хийх;

5.4.2.энэ хуулийн 9.1-д заасан хориглосон газарт тамхи татсан, тамхи худалдсантай холбоотой гарсан зөрчлийг шийдвэрлэх болон зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийг соён гэгээрүүлэхэд цагдаагийн байгууллагад бодлогын дэмжлэг үзүүлэх;

5.4.3.энэ хуулийг зөрчсөн зөрчлийн талаарх мэдээллийг иргэдээс хүлээн авах үр дүнтэй зөрчил мэдээлэх тогтолцоо бий болгоход дэмжлэг үзүүлэх.

5.5.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

5.5.1.энэ хуулийн 4.1.1-д заасан тамхины татварын талаар баримтлах зарчмыг хэрэгжүүлэх, татвараас бий болсон орлогыг хүн амын эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг тогтвортой санхүүжүүлэх арга хэмжээ авах;

5.5.2.тамхины импорт, экспорт, үйлдвэрлэл, худалдаанд гааль, татварын бодлогыг хэрэгжүүлэх замаар хяналт тавих, дүн шинжилгээ хийх;

5.5.3.энэ хуулийн 4.1.6-д заасныг хэрэгжүүлэх.

5.6.Тамхины хяналтын талаар хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ:

5.6.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тариалах хувь хэмжээг тамхины хэрэглээг бууруулах зарчимтай уялдуулах;

5.6.2.энэ хуулийн 4.1.6-д заасныг хэрэгжүүлэх;

5.6.3.энэ хуулийн 11¹.1-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэл, мэдээллийн цахим сан бүрдүүлэх.

5.7.Тамхины хяналтын талаар бүх шатны Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.7.1.харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд тамхины хяналтыг зохион байгуулах;

5.7.2.тамхины эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулан ажиллах;

5.7.3.энэ хуулийн 9.1.1, 9.1.2, 9.1.3, 9.1.4, 9.1.7, 9.1.8-д заасан хориглосон газраас бусад нийтийн эдэлбэр газарт байгуулах тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийн байршлыг тогтоох;

5.7.4.тамхи худалдаалах зөвшөөрөл олгох цэгийн тоо байршлыг тогтоохдоо энэ хуульд заасан зарчим, хязгаарлалтыг хангах, тамхи худалдаалах зөвшөөрөлтэй цэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих;

5.7.5.тамхи татах зөвшөөрөгдсөн цэгт тамхи татахыг зөвшөөрсөн анхааруулах тэмдэг байрлуулах;

5.7.6.орон нутгийн хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах.

5.8.Тамхины хяналтын талаар иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:

5.8.1.тамхины хяналтыг хэрэгжүүлэх, дам тамхидалтаас сэргийлэх арга хэмжээ авах;

5.8.2.насанд хүрээгүй иргэнд тамхи татахыг санал болгох болон тамхи олж авах, хэрэглэхэд дэмжлэг үзүүлэхгүй байх;

5.8.3.тамхи үйлдвэрлэгч, импортлогчоос хандив, тусламж, тэтгэлэг хүлээн авахаас татгалзах;

5.8.4.энэ хуулийн 9.1.5, 9.1.6-д заасан газарт тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг 300м²-аас доошгүй талбай бүхий барилга байгууламжид нэгээс илүүгүй байхаар тухайн хуулийн этгээд байгуулах, тамхи татах зөвшөөрөгдсөн цэгт анхааруулах тэмдэг байрлуулах.

5.9.Тамхины хяналтын талаар тамхи үйлдвэрлэгч, импортлогч хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:

5.9.1.хуулийн этгээдийн 20-оос дээш хувийн хувьцаа эзэмшигчийн нэр, хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа, тамхины үйлдвэрлэл, импорттой холбоотой бусад мэдээллийг өөрийн цахим хуудаст байрлуулан нийтэд ил тод байлгах;

5.9.2.энэ хууль болон эрх бүхий байгууллагаас баталсан тамхины найрлага, тамхины хайрцаг, сав, баглаа боодолд тавигдах стандартыг хангах;

5.9.3.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.”

4/6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт:

“6.4.1.зурагт анхааруулга нь 3.1.1.а, 3.1.1.б, 3.1.1.в-д заасан тамхины хайрцаг, сав, баглаа боодлын нүүр болон ар талын талбайн хэсгийн гадаргуугийн талбайн 70-аас багагүй хувийг эзэлсэн байх;”

5/6 дугаар зүйлийн 6.7.2 дахь заалт:

“6.7.2.энэ хуулийн 3.1.1.а, 3.1.1.б-д заасан тамхийг нэг хайрцагт 20 ширхгээс цөөн тоогоор, эсхүл дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг 200 граммаас багаар савлах, энэ хуулийн 3.1.1.в-д заасан электрон тамхины шингэний хэмжээг 2 миллилитрээс, цэнэглэгч шингэнийг 10 миллилитрээс ихээр савлах, шингэн дэх никотины агууламж 20 миллиграмм/миллилитрээс их байх;”

4 дүгээр зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн “байгууллагад” гэснийг “, боловсрол, төрийн болон төрийн бус байгууллага, нийтийн биеийн тамир, спорт, урлагийн арга хэмжээ, сонгуульд нэр дэвшигч, улс төрийн намын үйл ажиллагаанд” гэж, 9 дүгээр зүйлийн гарчгийн “Утаат тамхи татахыг хориглох” гэснийг “Тамхи татахыг хориглох орчин” гэж, мөн зүйлийн 9.1 дэх хэсгийн “утаат” гэснийг “энэ хуулийн 3.1.1.г, 3.1.1.д-д зааснаас бусад” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, мөн зүйлийн 9.1.6 дахь заалтын “утаат” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.1.16 дахь заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.1.16 дахь заалт:

“9.1.16.тамхинаас гаргах эмчилгээний эм, бүтээгдэхүүн.”

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “хөнгөвчлөх” гэсний дараа “, тамхинаас гаргах эмчилгээний эм, бүтээгдэхүүн” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.15 дахь заалтын “шинжилгээ.” гэснийг “шинжилгээ,” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газрын тухай сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/19 дүгээр зүйлийн 19.3.7-19.3.9 дэх заалт:

"19.3.7.ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын үдийн хоолны шим тэжээлийг дээшлүүлэх арга хэмжээ;

19.3.8.хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг эрүүл, идэвхтэй өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийтийн зориулалттай спортын байгууламж шинээр барих, өргөтгөх, засварлах, аймаг нийслэлээс спортын дугуйлангийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлэх хөтөлбөрийг санхүүжүүлэх;

19.3.9.тамхинаас гаргах, никотины хамаарал, хорт зуршлаас салгах эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх, хамрагдах этгээдийг нэмэгдүүлэх арга хэмжээ."

2/19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсэг:

"19.6.Засгийн газар энэ хуулийн 19.5-д заасан журмыг батлахдаа энэ хуулийн 19.2.3-т заасан эх үүсвэрээс бий болсон хөрөнгийг энэ зүйлийн 19.3.7, 19.3.8, 19.3.9-д заасан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулж байхаар зохицуулна."

2 дугаар зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.3 дахь заалтын "2" гэснийг "50" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Онцгой албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Онцгой албан татвар ногдуулах биет нэгж
8	Бүх төрлийн тамхины шингэн	1 миллилитр
9	Бүх төрлийн тамхины татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл	1 ширхэг

2/6.1².энэ хуулийн 4.1.2-т заасан барааны тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгж	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/					
			2025 он	2026 он	2027 он	2028 он	2029 он	2030 он
1	Татаж хэрэглэх зориулалттай навчин, халаадаг, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи	20 ширхэг	836	2,000	4,000	6,000	8,000	10,000

2	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи	200 грамм	626	1500	3000	4500	6000	7500
3	Бүх төрлийн тамхины шингэн	1 миллилитр	0	1,000	2,000	3,000	4,000	5,000
4	Электрон тамхи төхөөрөмжийн хамт	1 миллилитр	0	1,000	2,000	3,000	4,000	5,000
		1 ширхэг	0	5,000	10,000	15,000	20,000	25,000
5	Бүх төрлийн тамхины татах төхөөрөмж, дагалдах хэрэгсэл	1 ширхэг	0	5,000	10,000	15,000	20,000	25,000

2 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 2 дахь мөрийн “Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи” гэснийг “Татаж хэрэглэх зориулалттай навчин, халаадаг, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи” гэж, “100 ширхэг” гэснийг “20 ширхэг”, мөн хэсэг дэх хүснэгтийн 3 дахь мөрийн “1 килограмм” гэснийг “200 грамм” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “4.1.2” гэснийг, мөн хэсгийн хүснэгтийн 6, 7 дахь мөрийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалтын "14.000.000" гэснийг "50.000.000" гэж, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын "7.500.000" гэснийг "25.000.000" гэж, мөн заалтын "4.500.000" гэснийг "15.000.000" гэж, 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтын "100.000 - 500.000" гэснийг "500.000 - 1.000.000" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “үйлдвэрлэгч” гэсний дараа “, импортлогч” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдснаар өөрчлөн найруулсугай:

1/6.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи:

2.1.худалдахад тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.2.зөвшөөрөлгүй, хориглосон хэлбэрээр худалдсан бол зөрчилтэй эд юмс, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.3.импортлох, экспортлох, үйлдвэрлэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд хөрөнгө, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “байгууллагад” гэснийг “, боловсрол, төрийн болон төрийн бус байгууллага, нийтийн биеийн тамир, спорт, урлагийн арга хэмжээ, сонгуульд нэр дэвшигч, улс төрийн намын үйл ажиллагаанд” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 3 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтын “утаат” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.16 дахь хэсгийн “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “6.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тэмдгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсгийн “Согтууруулах ундааны” гэсний дараа “болон тамхины” гэж, мөн хэсгийн “бэхэлсэн” гэсний дараа “тамхины сав, баглаа боодол нь нэг талаараа онгойдог, бүтээгдэхүүнийг нээх үед онцгой албан татварын тэмдэг нь дахин ашиглагдахгүй байхаар наагдсан” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтын 24, 85, 96 дугаар бүлэгт доор дурдсан агуулгатай 24.04, 85.43, 96.14 дүгээр зүйл тус тус нэмсүгэй.

Бүлэг	Зүйл	Үндэсний код	Барааны бичиглэл	Албан татварын хувь, хэмжээ
24	24.04		Тамхи, дахин боловсруулсан тамхи, никотин агуулсан эсвэл тамхи, никотин орлуулагч агуулсан, асаахгүйгээр сорж татах зориулалттай бүтээгдэхүүн; хүний биед никотин өгөх зориулалттай, никотин агуулсан бусад бүтээгдэхүүн.	
			Асаахгүйгээр сорж татах зориулалттай бүтээгдэхүүн:	
		2404.11	Тамхи эсвэл дахин боловсруулсан тамхи агуулсан:	
		2404.11.10	Цахилгаан халаагч хэрэгслээр татах, янжууртай адилтгах тамхи (ЕНТР)	30
		2404.11.90	Бусад	30
		2404.12.00	Никотин агуулсан бусад: - Нэг удаагийн электрон тамхи; - Цэнэглэгч шингэн.	30 30
		2404.19.00	Бусад /никотин агуулаагүй/: - Нэг удаагийн электрон тамхи;	30

			- Цэнэглэгч шингэн.	30
			Бусад:	
		2404.91.00	Амаар хэрэглэх зориулалттай	30
		2404.92.00	Арьсанд нааж хэрэглэх зориулалттай	30
		2404.99.00	Бусад /амаар болон арьсанд наахаас бусад аргаар хэрэглэх зориулалттай/	30
85	85.43	8543.40.00	Электрон тамхи болон түүнтэй төстэй цахилгаанаар ажилладаг ууршуулж татах хэрэгсэл, эд анги: - Электрон тамхины хэрэгсэл шингэний хамт; - Тамхины цахилгаан халаагч хэрэгсэл /ЕНТР device/; - Бусад.	30 30 30
		8543.90.00	Дагалдах хэрэгсэл, эд анги	30
96	96.14	9614.00.00	Бүх төрлийн тамхи татах цахилгаан бус хэрэгсэл, эд анги (усан хоолойгоор татах хэрэгсэл хамаарна)	30

2."Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтын 24 дүгээр бүлгийн Янжуур үйлдвэрлэх зориулалттай тамхи "5" гэснийг "30" гэж, мөн бүлгийн "Нэгэн төрлийн болгосон" эсвэл "сэлбэгдсэн тамхи" "20" гэснийг "30" гэж, мөн бүлгийн Бусад "20" гэснийг "30" гэж тус тус өөрчилсүгэй.

3.Энэ тогтоолыг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ
ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд төрийн байгууллагууд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1.1. Тамхины хяналтын тухай хуулиар стандарт, хэм хэмжээний акт батлах эрх олгосон Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагууд, Стандартчиллын Үндэсний зөвлөл тус хуульд нийцүүлэн холбогдох дүрэм, журам, стандарт, загварыг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө шинэчлэн баталж, мөрдүүлэх бэлтгэл ажлыг хангах;

1.2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах арга хэмжээг авах:

1.2.1. тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төлөвлөгөөг 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө боловсруулж, эмчилгээ үйлчилгээг хэвийн явуулах, хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авах;

1.2.2. олон нийтэд 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг таниулах, мэдээлэл, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулах;

1.2.3. Хууль тогтоомжийн тухай хуулийн 49.2-т заасны дагуу Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3-т заасан хугацаанд хийж байх, 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийн талаар Засгийн газарт 2027 оны 01 дүгээр сард багтаан танилцуулах;

1.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах арга хэмжээг авах:

1.3.1. Гаалийн ерөнхий газарт 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан тамхин бүтээгдэхүүн, түүний орц найрлагыг таних, шалгах зориулалтын лабораторийн тоног

төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, албан хаагчдад хууль хэрэглээний талаар сургалт, мэргэжил, арга зүйгээр хангах;

1.3.2. 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан тамхин бүтээгдэхүүнд Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд заасан тэмдэг олгох, хэрэглэхэд бэлтгэх, мэдээллийн санд бүртгэх;

1.4.Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах арга хэмжээг авах:

1.4.1. 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхэд тамхин бүтээгдэхүүнд тооцогдох зарим төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох зорилго бүхий хуулийн этгээдэд хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл олгох, эсэх асуудлыг шийдвэрлэх;

1.4.2.тамхи үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаарх 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасан мэдээллийн нэгдсэн санг бий болгох, уг мэдээллийн санг холбогдох бусад мэдээллийн сантай мэдээлэл солилцдог байх чиглэлд төрийн байгууллагуудтай хамтран ажиллах;

1.5.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусгагдсан тамхи болон тамхин бүтээгдэхүүний хор уршгийн талаарх агуулгыг батгаан шинэчлэх, бүх шатны сургуулийн дотоод журмыг хуульд нийцүүлэн тамхи, тамхин бүтээгдэхүүнийг хориглох заалт тусгах, хууль, дотоод журмын талаар суралцагчдад таниулан сурталчилж, хэрэгжилтийг хангах;

1.6.Монополын эсрэг газар нь 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө мөн хуулиар тамхин бүтээгдэхүүнд тооцсон шинэ төрлийн тамхийг Тамхины хяналтын тухай хуулиар хориглосон байдлаар сурталчилсан зар сурталчилгааг хуульд нийцүүлэх арга хэмжээ авах, тамхи үйлдвэрлэх, импорлох, худалдаалахад зүй ёсны монопол болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгч байгаа эсэхийг тогтоох;

1.7.Цагдаагийн ерөнхий газар нь Тамхины хяналтын тухай хууль болон 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар тамхин бүтээгдэхүүний хүрээ өргөжсөнтэй холбоотойгоор зөвшөөрөлгүйгээр тамхи худалдаалахгүй байх, хориглосон газар тамхи татаж хэрэглэхгүй байх талаар олон нийтийг мэдээллээр хангах, хуулийн хэрэгжилтийг хангах.

2 дугаар зүйл.Тамхины импорт, экспорт, үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

2.1.2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өдрөөс өмнө халаадаг, электрон бусад тамхин бүтээгдэхүүнд Тамхины хяналтын тухай хуульд заасан тусгай болон энгийн зөвшөөрлийг холбогдох журмын дагуу авах;

2.2.Энэ хуулийн 2.1-д заасан тусгай болон энгийн зөвшөөрөл авсан тамхин бүтээгдэхүүний сав, баглаа, боодлыг Тамхины хяналтын тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэх, зурагт анхааруулга байршуулах арга хэмжээ авах;

3 дугаар зүйл.Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс 2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд мөн хуульд заасны дагуу тамхин бүтээгдэхүүнд тооцогдох халаадаг болон электрон тамхи, дагалдах хэрэгсэл, тэдгээрийн эд ангийг улсын хилээр нэвтрүүлэхгүй.

Гарын үсэг

ХУУЛЬ ТОГТОМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ

Захиалагч: Эрүүл мэндийн яам

Гүйцэтгэсэн: Судлаач Л.Мөнхцэцэг

УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

АГУУЛГА

Нэг.Ерөнхий мэдээлэл

Хоёр.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар иргэнд үүсэх зардлын тооцоо:

2.1.Шууд зардлыг тооцоолох

Гурав.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо:

3.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;

3.2.Нэг бүрийн зардлыг тооцох;

3.3.Тоон үзүүлэлтийг тооцох;

3.4.Нийт зардлын дүнг тооцож гаргах;

3.5.Хялбарчлах боломжийг шалгах;

3.6.Нэмэлт зардлыг тооцох.

Дөрөв. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо:

4.1.Төрд үүсэх шууд зардлыг тооцоолох.

4.2.

4.3.

4.4.

4.5

Тав.Дүгнэлт

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

/Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл/

Нэг.Ерөнхий мэдээлэл

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх үүрэг болон тэдгээрийг дагалдан гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог хийнэ.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлангийн зорилго чиглэгдэх болно.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчаас хүлээн авч, зохицуулалтыг судлан үзэхэд хуулийн төсөл батлагдсанаар зардал тээгч хуулийн этгээд болон төрийн байгууллагад тодорхой төрлийн зардал үүсгэхээр байна.

Хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлохдоо уг хуулийн төсөл нь “нэмэлт, өөрчлөлт” хэлбэрээр бичигдэж байгаа буюу тамхины хяналтай холбоотой харилцааг зохицуулсан хуультай, түүний дагуу холбогдох иргэн, хуулийн этгээд, байгууллага хуулийг дагаж биелүүлж байгаа тул зөвхөн нэмэлт, өөрчлөлт орж байгаа хуулийн төслөөр шинээр бий болгохоор заасан болон өмнө гүйцэтгэж байсан үүргийг өргөжүүлсэнтэй холбоотой үүсэх зардлыг тооцоолсон болно.

Хуулийн төслөөр шинээр бий болж буй үүрэгт зардал тооцогдож байгаа тул зарим үүрэгтэй холбоотой бодит статистик болон зарцуулах хугацааг тооцоолоход шууд ашиглах тоо баримт байхгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн бусад адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, түүнд үндэслэн баримжаалах, салбарын мэргэжилтнүүдээс санал авах, ярилцлага зохион байгуулах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

¹ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

ХУУЛИЙН ЭТГЭЭД:

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр “тамхи” гэсэн нэр томъёог өөрчлөн найруулж, түүний хүрээг өргөжүүлэн электрон тамхи, усан тамхи, халаадаг, наадаг зэрэг хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүнийг шинээр тамхи гэх ойлголтод хамруулахаар тусгасан байна. Үүнд:

3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт:

“3.1.1. “тамхин бүтээгдэхүүн” (цаашид “тамхи” гэх) гэж тамхины навч, ургамлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн болон нийлэг аргаар гаргаж авсан никотин, түүний уламжлал дагавар бодис, бохь, химийн бодис агуулсан, амт, үнэр оруулагч нэмсэн, эсхүл нэмээгүй, татах, үнэрлэх, сорох, зажлах, аманд уусгах, биед наах, эсхүл бусад аргаар, дагалдах хэрэгсэл бүхий төхөөрөмжийг ашиглаж болон ашиглахгүйгээр хэрэглэх зориулалттай, хууль тогтоомжид заасны дагуу эмийн бүртгэлд бүртгэгдсэн тамхинаас гаргах эмээс бусад дараах бүтээгдэхүүнийг:

3.1.1.а. тамхины түүхий эд, задгай тамхи, татаж хэрэглэх зориулалттай навчин, дүнсэн, шүүлтүүртэй, шүүлтүүргүй янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи;

3.1.1.б. цахилгаан халаагч хэрэгслээр асаахгүйгээр сорж татах зориулалттай бүх төрлийн халаадаг тамхи болон цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн эд анги, дагалдах хэрэгсэл;

3.1.1.в. никотин, никотин орлуулагч, бохь, химийн бодис, амт, үнэр оруулагч агуулсан, эсхүл агуулаагүй шингэнийг цахилгаан хэрэгслээр ууршуулж татах болон бусад аргаар хэрэглэх зориулалттай электрон тамхи болон цэнэглэгч шингэн, дагалдах хэрэгсэл;

3.1.1.г. усан хоолойгоор татах зориулалттай тамхи, эсхүл тамхи орлуулагч бүтээгдэхүүн, татах төхөөрөмж, түүний эд анги, дагалдах хэрэгсэл;

3.1.1.д. үнэрлэх, сорох, зажлах, аманд уусгах, биед наах болон татахаас бусад аргаар хэрэглэдэг никотин, эсхүл никотин орлуулагч, химийн бодис, амт, үнэр оруулагч бүтээгдэхүүн;”

Ингэснээр одоо эдгээр бүтээгдэхүүнийг импортлох, худалдах аж ахуйн нэгжийн хувьд Тамхины хяналтын тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл авах шаардлагатай болох юм. Иймд тамхи импортлох, худалдаалах тусгай зөвшөөрөл авахтай холбоотой зардлыг тооцоолох шаардлагатай.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА:

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр улсын төсөвт шинээр зардал үүсгэж болзошгүй болон уг хуулийн хэрэгжилтийг хангах зарим төрийн байгууллагад шинээр бий болгож байгаа зарим чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холботой зардал, ачааллыг тооцоолох юм.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

5/9¹ дүгээр зүйл:

“9¹ дүгээр зүйл. Тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

9¹.1. Тамхи татдаг хүнийг тамхинаас гаргах, никотины хамаарал, хорт зуршлаасаа салах үйл явцыг дэмжих, хөнгөвчлөх зорилготой зөвлөгөө, эмчилгээ, сэтгэлзүйн дэмжлэг, эм бэлдмэл зэргийг багтаасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ байна. Тусламж үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

9¹.1.1. сэтгэлзүйн эмчилгээ;

9¹.1.2. никотин орлуулах эмчилгээ;

9¹.1.3. эмийн эмчилгээ;

9¹.1.4. тусгай утасны зөвлөгөө, мэдээллийн тусламж үйлчилгээ.

9¹.2. Энэ зүйлийн 9¹.1-т заасан тусламж үйлчилгээ нь үр нөлөөтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй, холбогдох стандартын шаардлага хангасан байна. Тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан үзүүлнэ.

9¹.3. Энэ зүйлийн 9¹.1-т заасан тусламж үйлчилгээг төрөөс дэмжих, бэхжүүлэх бодлого хэрэгжүүлнэ. Үүнтэй холбоотой харилцааг холбогдох хуулиар нарийвчлан зохицуулна.

9¹.4. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас энэ зүйлийн 9¹.1-т заасан тусламж үйлчилгээ үр нөлөө, чанар, хүртээмжийн талаар тогтмол судалгаа, үнэлгээ хийнэ.”

Дээрх зохицуулалттай холбоотойгоор улсын төсөвт үүсэх ачааллыг тооцоолоно.

УЛСЫН ТӨСӨВТ НЭМЭГДЭХ ОРЛОГО:

Хуулийн төслийг дагалдуулан Онцгой албан татварын тухай болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсруулсан байна. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь тамхины онцгой болон гаалийн албан татвар нэмэгдэх, зарим төрлийн зөвшөөрөлтэй холбоотой улсын тэмдэгтийн хураамж нэмэгдэхээр байна.

Иймд эдгээр өөрчлөлтийн дагуу улсын төсөвт орж ирэх орлогыг урьдчилсан байдлаар тооцоолох юм.

ГУРАВ.ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ хэсэгт Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн төслийн үйлчлэлд хамаарахаар заасан хуулийн этгээдүүд тамхи импортлох, худалдаалах зөвшөөрлийг шинээр авахад буюу одоо зөвшөөрөлтэй эрхлэхээр заагаагүй боловч хуулийн төслийн өөрчлөлтийн улмаас зайлшгүй зөвшөөрөл авахаар болж байгаа хуулийн этгээд уг үүргийг хэрэгжүүлэхэд тэдэнд үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана.

Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- нэг бүрийн зардлыг тооцох;
- тоон үзүүлэлтийг тооцох;
- нийт зардлын дүнг тооцож гаргах;
- хялбарчлах боломжийг шалгах;
- нэмэлт зардлыг тооцох.

3.1.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ:

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр дээрх хуульд өмнө нь байгаагүй шинээр хуулийн этгээдэд ногдуулж байгаа болон өмнө нь хуулийн этгээд гүйцэтгэдэг байсан боловч уг үүргийг биелүүлэх этгээдийн хүрээг өргөжүүлсэн, нэмэгдүүлсэн үүрэгтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх болно.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шинэ төрлийн бүтээгдэхүүнийг тамхинд хамруулж байгаагаас зарим хуулийн этгээд тамхи импортлох, худалдах тусгай зөвшөөрлийг авах шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл электрон тамхи борлуулж байгаа болон улсын хилээр орж ирж байгаа хуулийн этгээд нь энэхүү үйл ажиллагаагаа цааш үргэлжлүүлэх тохиолдолд тусгай зөвшөөрөл авах шаардлагатай юм. Энэ нь одоо тусгай зөвшөөрөлтэйгөөр тамхи импортолдог болон худалдаалдаг этгээдийн хувьд хамааралгүй бөгөөд харин электрон тамхи, халаадаг тамхийг тусгай зөвшөөрөлгүйгээр ил нэвтрүүлж, худалдаалж байгаа этгээдийн хувьд энэ үйл ажиллагаагаа үргэлжүүлэн эрхлэх тохиолдолд шинээр зөвшөөрөл авах үүрэг, үйл явцад хамааралтай тооцоолол болно.

Хүснэгт 5

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга
1	Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр орж байгаа нэмэлт, өөрчлөлтийн дагуу зарим хуулийн этгээдэд Тамхины хяналтын тухай хуулийн холбогдох заалта хамааралтай болох юм.	7.1.Тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тамхи импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар олгож, хүчингүй болгоно. 7.9.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч олгоно.

3.2.НЭГ БҮРИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Энэ шатанд өмнөх шатанд тодорхойлсон хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд нэг хуулийн этгээдээс зарцуулах мөнгөн зардлыг тооцоолон гаргана. Ингэхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:



Стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтад заасан хугацааг харгалзан үзэхийн хамт хуулийн этгээдийн ажилтантай уулзалт ярилцлага хийх дүнд бий болсон үр дүнг ашигласан болно.

Хүснэгт 6

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
1	Тамхи импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв	7 ² .2.1.тусгай зөвшөөрлийн хүсэлт;	Хүсэлт боловсруулах	15 мин
			Хянах нягтлах	5 мин
			Хүсэлтийг илгээх	5 мин
		7 ² .2.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;	УБГ-г хуулбарлах	5 мин
		7 ² .2.3.татварын албаны санал, тодорхойлолт;	Цахим татварын системээс тодорхойлолт авах	5 мин

**Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг
дагалдан гарах зардлын тооцооны тайлан**

байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар олгож, хүчингүй болгоно.	7 ² .2.4.тохирлын гэрчилгээний хуулбар;	Тохирлын гэрчилгээг хуулбарлах	5 мин
	7 ² .2.5.тамхи худалдан авах гэрээ;	Гэрээний хуулбарыг бэлтгэх	5 мин
	7 ² .2.6.импортлох тамхийг үйлдвэрлэсэн болон экспортолсон улс орны чанар, стандартын шаардлага хангаж байгааг тодорхойлсон гэрчилгээ, баримт бичиг;	Холбогдох баримт бичгийг харилцагчаас авах	60 мин
		Баримт бичгийн хуулбарлан олшруулах	10 мин
	7 ² .2.7.импортолсон бүтээгдэхүүнээ хадгалах агуулахын талаарх мэдээлэл;	Агуулахын талаарх мэдээлэл боловсруулах	30 мин
		Мэдээллийг нягтлах	5 мин
	7 ² .2.8.импортын тамхи хадгалах барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулсан талаарх цагдаагийн байгууллагын санал;	Дүрс бичлэгийн техник хэрэгслийн талаар судлах	60 мин
		Дүрс бичлэгийн техник хэрэгслийг суурилуулах	120 мин
		Дүрс бичлэгийн техник суурилуулсныг нотлох санал авахаар цагдаагийн байгууллагад хандах	30 мин
	7 ² .2.9.аймаг, нийслэлийн Засаг даргын санал;	Аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг авах зорилгоор баримт бичиг боловсруулах	120 мин
		Баримт бичгийг нягталж, хүргүүлэх	20 мин
		Шаардлагатай бол нэмэлт материал бэлтгэж өгөх	60 мин
	7 ² .2.10.энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан импортлох тамхины төрөл тус бүрийн эрүүл ахуйн нөхцөл, тамхин дахь хорт бодисын агууламжийн талаарх дүгнэлт;	Импортлох тамхины эрүүл ахуйн нөхцөл, тамхин дахь хорт бодисын агууламжийн талаар дүгнэлт авахаар ЭМЯ-д баримт бичиг боловсруулж хүргүүлэх	120 мин
		Шаардлагатай тохиолдолд ЭМЯ-д нэмэлт материал өгөх	60 мин

**Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг
дагалдан гарах зардлын тооцооны тайлан**

		7 ² .2.11.импортлох тамхины дээжийг гаалийн байгууллагын урьдчилсан шинжилгээнд хамруулж, эрүүл ахуйн болон энэ хуульд заасан бусад шаардлага хангасан талаарх баримт	Гаалийн байгууллагад урьдчилсан шинжилгээнд хамруулахаар дээж, албан хүсэлт боловсруулж өгөх	60 мин
			Шаардлагатай тохиолдолд Гаалийн байгууллагын шаардсан бусад мэдээлэл бэлтгэх	20 мин
		Нийт хугацаа		820 мин

Хүснэгт 2

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
2	7.9.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч олгоно.	7.10.1.тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг /оноосон нэр, байрлах хаяг, харилцах утсыг тодорхой дурдах/;	Хүсэлт боловсруулах	15 мин
			Хянах нягтлах	5 мин
			Хүсэлтийг илгээх	5 мин
		7.10.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;	УБГ-г хуулбарлах	5 мин
		7.10.3.хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас тухайн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагааг эрхлэх талаар гаргасан улсын байцаагчийн болон ажлын байрны дүгнэлт;	Ажлын байрны дүгнэлт гаргуулах тухай хүсэлт боловсруулах	30 мин
			Шаардлагатай нэмэлт мэдээлэл боловсруулж өгөх	30 мин
			Эрх бүхий байгууллагаас ажлын байрыг шалгах	90 мин
		7.10.4.худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартын шаардлагыг дүгнэсэн стандартын хуудасны хуулбар;	Шалгалтын дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт хийх.	90 мин
			Дүгнэлтийн хуулбарлан олшруулах	5 мин
		7.10.5.тухайн үйл ажиллагааг эрхлэх байранд хийгдсэн онцгой байдлын асуудал	Ажлын байрны дүгнэлт гаргуулах тухай хүсэлт боловсруулах	30 мин

**Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг
дагалдан гарах зардлын тооцооны тайлан**

		Хариуцсан төрийн захиргааны байгууллагын галын дүгнэлт.	Шаардлагатай нэмэлт мэдээлэл боловсруулж өгөх	30 мин
			Эрх бүхий байгууллагаас ажлын байрны галын аюулгүй байдлыг шалгах	90 мин
			Шалгалтын дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт хийх.	90 мин
Нийт хугацаа			515 мин	

Хуулийн этгээдэд үүсч байгаа хоёр төрлийн үүргийг хэрэгжүүлэхийн тулд үйлдэлд суурилсан арга ашиглан, Зардлын тооцоо бодох аргачлалд заасан үйлдэл бүрт зарцуулах хугацааг удирдлага болгон нийт зарцуулах хугацааг үүрэг тус бүрээр гаргав.

Ажлын хөлсийг тооцож гаргахдаа дундаж ажилтанд олгох сарын үндсэн цалинг Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг ажилтны ажиллах цагийн горимоор тогтоосон хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цаг, минутаар гаргана.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар² “2024 оны 4 дүгээр улирлын байдлаар бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын ажиллагсдын сарын цалин 2.104.300 төгрөг байгааг судалгаанд дурдсан байх тул уг тоог үндсэн суурь болгон ашиглана.

Ажиллах хугацааг Хөдөлмөрийн тухай хуульд³ заасан ажлын цагийг баримтлав.

Хүснэгт 7

Ажлын хөлс = Үндсэн цалинг : ажиллах хугацаа
$2.104.300 : 22 \text{ өдөр} : 8 \text{ цаг} = 11.956,2 \text{ төгрөг /нэг цагийн ажлын дундаж хөлс/}$
$11.956,25 : 60 \text{ минут} = 200 \text{ төгрөг /нэг минутын цалин/}$

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд нэг хуулийн этгээдэд үүсгэж байгаа зардлыг үйл ажиллагаанд буюу үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлдэлд зарцуулж буй хугацааг ажлын хөлсөөр үржүүлэх замаар тооцоолох юм.

² http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=average_wage_2017.pdf&ln=Mn /Үндэсний статистикийн хорооны албан ёсны веб хуудаст байршуулсан цалин хөлсний талаарх судалгаа

³ Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүлийн 1999 оны №25 дугаарт хэвлэгдсэн.

Хүснэгт 8

д/д	Гүйцэтгэх үүрэг	Зарцуулах хугацаа	Ажлын хөлс	Нэг бүрийн зардал
1	Тамхи импортлох тусгай зөвшөөрөл авах	820 мин	200 төгрөг	164,000 төгрөг
2	Тамхи худалдах энгийн зөвшөөрөл авах	515 мин	200 төгрөг	103,000 төгрөг

3.3.ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ:

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тогтоосон үүргийг хэдэн хуулийн этгээд, жилд хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргах юм.

Гаалийн ерөнхий газраас гаргасан мэдээгээр 2024 онд 7 иргэн, 71 аж ахуйн нэгж байгууллага электрон тамхи, цэнэглэгч шингэн, түүний дагалдах хэрэгслийг импортлосон байна. Энэ тоог суурь болгон дээрх этгээдүүд электрон тамхи нь тамхин бүтээгдэхүүнд хамаарч байгаатай холбоотойгоор тамхи импортлох тусгай зөвшөөрөл авах шаардлагатай гэж үзэж тоон үзүүлэлтийг тогтооно.

Харин тамхи худалдах зөвшөөрлийн хувьд 2025 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд 4743 хуулийн этгээд тамхи худалдаалах зөвшөөрөлтэй бөгөөд хууль хүчин төгөлдөр үйлчилснээс хойш жилд дундажаар 237 аж ахуйн нэгжид тамхи худалдаалах зөвшөөрөл олгосон байгааг суурь тоо болгон ашиглана.

Энэ үзүүлэлтийг гаргахын тулд **тохиолдлын тоо**⁴ болон **давтамжийг**⁵ холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр “тоон үзүүлэлт” нь илэрхийлэгдэх юм. Давтамжийн хувьд Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт зааснаар тамхи импортлох зөвшөөрлийг 3 жилээр олгох тул давтамж нь 0,3, тамхи худалдах зөвшөөрлийн тухайд Тамхины хяналтын тухай хуульд тусгайлсан хугацаа заагаагүй бөгөөд Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг таван жилээс доошгүй, энгийн зөвшөөрлийг гурван жилээс доошгүй хугацаагаар олгоно.” Гэж заасан тул гурван жилийн хугацаагаар олгож байгаа гэж үзвэл давтамж нь мөн 0,3 юм.

ТОХИОЛДЛЫН ТОО х ДАВТАМЖ = ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Дээрх томъёог ашиглан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар шинээр хоёр төрлийн зөвшөөрөл авах үүргийн тоон үзүүлэлтийг тогтооё.

Хүснэгт 9

⁴ “Тохиолдлын тоо” гэдэг нь тухайн шинээр бий болж байгаа үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлэх тоог ойлгоно.

⁵ “Давтамж” гэдэг нь тухайн үүргийг биелүүлэх хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж байгууллагууд үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэхийг илэрхийлэх тоо юм.

**Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг
дагалдан гарах зардлын тооцооны тайлан**

д/д	Гүйцэтгэх үүрэг	Тохиолдлын тоо	х	Давтамж	=	Тоон үзүүлэлт
1	Тамхи импортлох тусгай зөвшөөрөл авах	78 ⁶	х	0,3 ⁷	=	23,4
2	Тамхи худалдах энгийн зөвшөөрөл авах	237 ⁸	х	0,3 ⁹	=	71,1

3.4.НИЙТ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ДУНГ ТООЦОЖ ГАРГАХ:

Энэ үе шатанд өмнөх үе шатанд гаргасан үүргийн нийт зардлыг “тоон үзүүлэлт”-ээр үржүүлснээр гаргах юм.

НЭГ БҮРИЙН ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ х ТООН ҮЗҮҮЛЭЛТ = НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт 10						
д/д	Гүйцэтгэх үүрэг	Нэг бүрийн зардал	х	Тоон үзүүлэлт	=	Нийт зардал ¹⁰
1	Тамхи импортлох тусгай зөвшөөрөл авах	164,000 төг	х	23,4	=	3.837.600 төг
2	Тамхи худалдах энгийн зөвшөөрөл авах	103,000 төг	х	71,1	=	7.323.300 төг

3.5.ХУВИЛБАРЫГ НЯГТАЛЖ, ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙН ТАЛААР:

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалтаар шинэ төрлийн үүрэг хариуцлагыг хуулийн этгээдэд оногдуулаагүй боловч зарим төрлийн бүтээгдэхүүнийг “тамхин бүтээгдэхүүн”-д хамруулж байгаа тул шинэ төрлийн тамхи нь хуулийн дагуу “тамхи”-нд тооцогдохоор байна.

Ингэснээр одоо хүчин төгөлдөр хуулиар үйлчилж байгаа тамхинд тавигддаг хориглолт, хязгаарлалт, зөвшөөрлөл нь шинэ төрлийн электрон тамхинд нэгэн адил

⁶ Гаалийн мэдээгээр 2024 онд электрон тамхи импортоор оруулж ирсэн этгээдийн тоо

⁷ Тамхины хяналтын тухай хуульд зааснаар импортлох тусгай зөвшөөрлийг гурван жилээр олгох тул давтамжийн тоо 0,3 болох юм.

⁸ Жилд олгож буй тамхи худалдаалах зөвшөөрлийн тоо

⁹ Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар энгийн зөвшөөрлийг гурван жилээс доошгүй хугацаагаар олгох тул тамхи худалдаалах зөвшөөрөл авах үүргийг гүйцэтгэх давтамж 0,3 юм.

¹⁰ “Нийт зардал” гэдэг нь уг хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн төсөлд тусгагдсан үүргийг биелүүлэх нийт хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал юм.

хамраарах юм. Иймд одоо тусгай болон энгийн зөвшөөрөлгүйгээр электрон тамхи импортолж байгаа болон худалдаалж байгаа хуулийн этгээдийн хувьд Тамхины хяналтын тухай хуульд зааснаар зөвшөөрөл авах шаардлагатай болж байгаатай холбоотой үүргийг уг аж ахуйн нэгж байгууллага гүйцэтгэхэд ямар хэмжээний зардал гарахыг өмнөх шатанд үйлдэлд суурилсан өртөг тооцох аргачлалын дагуу тооцоолсон болно.

Энэ үүргийг хялбарчлах болон хөнгөвчлөх, бусад үүрэгтэй хавсаргах боломжгүй бөгөөд тамхин бүтээгдэхүүн импортлох, худалдаалах зөвшөөрлийн асуудал нь Тамхины хяналтын тухай болон Зөвшөөрлийн тухай хуулиар нэгэнт зохицуулагдсан байна. Түүнчлэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тамхи импортлох, худалдаалах зөвшөөрлийг хүндрүүлэх ямар нэг зохицуулалт агуулаагүй тул хуулийн төслийн зохицуулалтын дагуу үүсэх үүргийн хуулийн этгээдэд үүсэх зардал нь боломжит хэмжээнд байна гэж дүгнэж байна.

3.6.НЭМЭЛТ ЗАРДЛЫГ ТООЦОХ:

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хуулийн этгээдээс хуульд заасан үүргийг биелүүлэхийн тулд зайлшгүй төлөхөөр хуулиар тогтоосон төлбөр хураамж, тоног төхөөрөмж, материал зэргийг нэмэлт зардал гэсэн ойлголтод хамруулж ойлгох бөгөөд дараах нэмэлт зардал гарна. Үүнд:

- Зөвшөөрөл авах улсын тэмдэгтийн хураамжийн зардал
- Бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулах үйлчилгээний хураамж;
- Хяналтын зорилгоор дүрс бичлэгийн төхөөрөмж суурилуулахтай холбоотой зардал;
- Импортоор оруулж ирэхэд гаалийн болон онцгой албан татвар.

Тамхи нь хүний эрүүл мэндэд ноцтой хохирол учруулдаг, улмаар өрх гэр төдийгүй эрүүл мэндийн тогтолцоонд тамхины хэрэглээнээс үүдсэн өвчин эмгэгээс үүдэлтэйгээр ихээхэн санхүүгийн дарамт учруулдаг тул улс бүр тамхины хэрэглээг нэг хүний сонголтын асуудал гэж үзэлгүй хуулиар зохицуулдаг бөгөөд хуулийн зохицуулалт нь тамхины хэрэглээг бууруулах зорилготой байдаг.

Хуулийн этгээдэд гарч байгаа нэмэлт зардал нь бүх төрлийн татвартай холбоотой зардал байх тул зардлыг хор уршигтайгаа харьцуулахад хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнд байна гэж үзлээ.

ДӨРӨВ.ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БУЮУ УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хуулийг хэрэгжүүлэх төрийн байгууллагад шинэ төрлийн чиг үүргийг нэмэгдүүлээгүй боловч Тамхины хяналтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “тамхины хэрэглээ, дам тамхидалтын улмаас хүний эрүүл мэнд, эдийн засаг, байгаль орчинд учруулах сөрөг үр дагаврын талаархи шинжлэх ухааны үндэслэлтэй, бодит мэдээлэл, сургалт, сурталчилгаа болон тамхинаас гаргах эмчилгээг хүртээмжтэй болгох.” зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор “Тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” гэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрлийг тодорхой болгон хуулийн төсөлд тусгасан байна.

Ийнхүү нэг төрлийн эмчилгээ байх бөгөөд түүний төрлийг хуульчлан тусгаж байгаа тул хуулийн төсөл батлагдснаар энэ төрлийн тусламж үйлчилгээг үзүүлэх шаардлагатай болох тул үүнтэй холбоотой зардлыг тооцоолох шаардлагатай юм.

Хуулийн төсөлд дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:

“9¹ дүгээр зүйл.Тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

9¹.1.Тамхи татдаг хүнийг тамхинаас гаргах, никотины хамаарал, хорт зуршлаасаа салах үйл явцыг дэмжих, хөнгөвчлөх зорилготой зөвлөгөө, эмчилгээ, сэтгэлзүйн дэмжлэг, эм бэлдмэл зэргийг багтаасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ. Тусламж үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

- 9¹.1.1.сэтгэлзүйн эмчилгээ;
- 9¹.1.2.никотин орлуулах эмчилгээ;
- 9¹.1.3.эмийн эмчилгээ;
- 9¹.1.4.тусгай утасны зөвлөгөө, мэдээллийн тусламж үйлчилгээ.

9¹.2.Энэ хуулийн 9¹.1-д заасан тусламж үйлчилгээ нь үр нөлөөтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй, холбогдох стандартын шаардлага хангасан байх ба тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан үзүүлнэ.

9¹.3.Энэ хуулийн 9¹.1-т заасан тусламж үйлчилгээг төрөөс дэмжих, бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх бөгөөд тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сан болон хөнгөлөлттэй эмийн жагсаалтад хамруулах замаар санхүүжүүлнэ. Үүнтэй холбогдсон харилцааг холбогдох хуулиар нарийвчлан зохицуулна.

9¹.4.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас энэ хуулийн 9¹.1-т заасан тусламж үйлчилгээний үр нөлөө, чанар, хүртээмжийн талаар тогтмол судалгаа, үнэлгээ хийнэ.” Гэжээ.

Түүнчлэн хуулийн төслийг дагалдуулан Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, тамхинаас гаргах эмчилгээний эм, бүтээгдэхүүнийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр тусгасан байна.

ТАВ.УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРӨХ ОНЦГОЙ БОЛОН ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫН НӨЛӨӨЛӨЛ

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

д/д	Хуулийн төсөлд нэмэхээр заасан гадаадын иргэдэд үзүүлэх үйлчилгээ	2018 онд үзүүлсэн нийт үйлчилгээ ¹¹	Уг үйлчилгээнээс 2018 онд улсын төсөвт төлсөн нийт хураамж	Хуулийн төслийн дагуу нэмэгдэх хэмжээ
1	Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд оршин суух үнэмлэх олгох, солих	15367 ¹²	15367 х 7.200 = 110.642.400 төг	230.136.192
2	Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгох	357 ¹³	357 х 1.000 = 357.000	3.570.000 төгрөг
3	Гадаадын иргэнд нэг удаагийн орох болон гарах-орох виз олгох	20132 ¹⁴ +204.000 ¹⁵ = 225.132	226.132 х 54.000 төг = 12.211.128.000 төгрөг	25.643.368.800 төгрөг
4	Хоёр удаагийн орох виз олгох	154 ¹⁶ + 7000 ¹⁷ = 7154	7154 х 81.000 = 579.474.000 төгрөг	1.072.026.900 төгрөг
5	Зургаан сарын олон удаагийн виз олгох	4008 ¹⁸ + 2250 ¹⁹ = 6658	6658 х 126.000 = 838.908.000 төг	1.560.368.880 төгрөг
6	Нэг жилийн олон удаагийн виз олгох	5981 ²⁰ + 1150 ²¹ = 7131	7131 х 252.000 = 1.797.012.000 төг	3.270.561.840 төгрөг

¹¹ Хүснэгтэд дурдсан үйлчилгээг Гадаад харилцааны яам болон Гадаадын иргэн, харьяатын газар нь гадаадын иргэдэд үзүүлэхээр хууль тусгагдсан тул үйлчилгээ үзүүлсэн тоог гаргахдаа дээрх хоёр байгууллагын статистикийг нэгтгэх замаар гаргасан болно.

¹² Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 оны үйл ажиллагааны тоон статистик

¹³ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилгыг Гадаадын иргэн, харьяатын гауар олгож байгаа тул тус байгууллагын 2018 оны тоон статистикийг ашиглав.

¹⁴ Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 онд олгосон нэг удаагийн виз

¹⁵ Гадаад харилцааны яам буюу хилийн чанад дахь ДТГ-уудын 2018 онд олгосон нэг удаагийн виз

¹⁶ ГИХГ-ын 2018 онд олгосон хоёр удаагийн виз

¹⁷ Гадаад харилцааны яам буюу хилийн чанад дахь ДТГ-уудын 2018 онд олгосон хоёр удаагийн виз

¹⁸ Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 онд олгосон 6 сарын олон удаагийн виз

¹⁹ Гадаад харилцааны яам буюу хилийн чанад дахь ДТГ-уудын 2018 онд олгосон зургаан сарын олон удаагийн виз

²⁰ Гадаадын иргэн, харьяатын газрын 2018 онд олгосон нэг жилийн хугацаатай олон удаагийн виз

²¹ Гадаад харилцааны яам буюу хилийн чанад дахь ДТГ-уудын 2018 онд олгосон нэг жилийн олон удаагийн виз

7	Нийт	15.537.521.400 төгрөг	31.780.032.712 төгрөг
---	------	--------------------------	--------------------------

ТАВ.ДҮГНЭЛТ

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдан гарах зардлын тооцоог Засгийн газрын 2015 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу хийв. Хуулийн төсөл нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад тодорхой зардал үүсгэхээр байна. Гэвч иргэн болон төрийн байгууллагад шинэ төрлийн үүрэг хүлээлгээгүй тул захиргааны зардал үүсгэхгүй “нэмэлт буюу шууд зардал” үүсгэхээр зохицуулалт тусгагдсан байна.

Иргэнд үүсэх зардлын тухайд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр гадаадын иргэдэд үзүүлж буй виз, бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээний жураамжийг нэмэгдүүлэхээр тусгасан нь иргэнд үүсэх шууд зардлыг нэмэгдүүлсэн байна. Энэ нь гадаадын иргэдэд хамааралтай зохицуулалт тул нөгөө талдаа Монгол Улсын төсөвт орлого болж тооцогдох юм. Хуулийн төслөөр гадаадын иргэдэд үзүүлэх 6 төрлийн үйлчилгээний хураамжийг нэмэгдүүлснээр улсын төсвийн орлого дараах байдлаар нэмэгдэхээр байна.

Хүснэгт 13

Дээрхээс харахад хуулийн төсөл батлагдвал гадаадын иргэдэд үзүүлэх зарим төрлийн үйлчилгээний хураамжийг нэмэгдүүлснээр энэ төрлийн үйлчилгээнээс улсын төсөвт орох орлого хамгийн багадаа 2,1 дахин нэмэгдэх төлөвтэй байна. Түүнэчлэн гарах-орох виз гэсэн зориулалтын визийг хүчингүй болгож байгаа бөгөөд энэ зориулалтын визийг 2018 онд 18920 гадаадын иргэнд олгож, 2.500.000.000 гаруй төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн бөгөөд хуулийг төсөл батлагдвал энэ зориулалтын визээс улсын төсөвт орж байсан орлого орохгүй юм.

Төрийн байгууллагын хувьд шинэ чиг үүрэг нэмэгдээгүй тул хүний нөөцийн болон материаллаг зардал үүсэхгүй бөгөөд бие хүний давхцахгүй өгөгдлөөр гадаадын иргэдийг хилийн боомт дээр бүртгэхтэй холбоотой техник хэрэгсэл, программ хангамжийг шинээр бий болгоход чиглэсэн шууд зардал үүсэхийг урьдчилсан байдлаар тооцон гаргасан болно.

Дүгнэвэл хуулийн төслийн зардал нь үр өгөөжтэйгээ харьцуулвал үр өгөөж нь өндөр байна.

**Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг
дагалдан гарах зардлын тооцооны тайлан**

-----oOo-----

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР
НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**2025 ОН
УЛААНБААТАР ХОТ**

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйл болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д заасны дагуу хуулийн төслийн зүйл, заалтын харилцан уялдаа, практикт хэрэгжих боломж, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, улмаар хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төрлөөр боловсруулагдсан болно.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг дараахь үе шаттайгаар хийлээ:

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудлыг харгалзан 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо:

1. зорилгод хүрэх байдал;
2. ойлгомжтой байдал;
3. хүлээн зөвшөөрөгдөх байдал;
4. харилцан уялдаа.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор сонгов.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, хувь хүнд ойлгомжтой тодорхой байх, хуулийн төслийн бичвэр нь нэр томъёо, хэл зүй, найруулгын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төсөл боловсруулах аргачлал”-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах үүднээс сонголоо.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, хүлээн зөвшөөрөгдөх эсэхийг өөрөөр хэлбэл, тухайн зохицуулалтаар иргэдийн эрх чөлөөг хязгаарлаж байгаа эсэх, аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэхийг шалгахар сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээний холбогдох заалтад нийцэж байгаа эсэх, хуулийн төслийн зүйл, заалт хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг шалган тогтоож, улмаар хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах үүднээс сонгосон болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор хуулийн төслийн 3 дугаар зүйлд өөрчлөн найруулахаар заасан 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.5.1 дэх заалт, 1 дүгээр зүйлд хуульд нэмэхээр заасан 6 дугаар зүйлийн 6.8.3 дахь заалт, 4 дүгээр зүйлд өөрчлөлт оруулахаар заасан 9.1 дэх хэсгийг үнэлгээ хийхээр тус тус сонгож авлаа.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд үнэлгээ хийхээр хуулийн төслийн 3 дугаар зүйлд өөрчлөн найруулахаар заасан 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, мөн зүйлийн 5.7.1 дэх заалтыг сонгож авлаа.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь, дагалдах хуулийн төслүүдийн хамт сонгон авлаа.

/Хуулийн төсөл 6 зүйлтэй, дагалдах 5 хуулийн төсөл, 1 тогтоолын төсөлтэй/

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгах үүднээс хуулийн төслийг бүхэлд, дагалдах хуулийн төслүүдийн хамт авч үзэхээр тооцлоо.

/Хуулийн төсөл 6 зүйлтэй, дагалдах 5 хуулийн төсөл, 1 тогтоолын төсөлтэй/

ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараахь байдлаар авч үзэв.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 3 дугаар зүйлд өөрчлөн найруулахаар заасан 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.5.1 дэх заалтууд, 1 дүгээр зүйлд хуульд нэмэхээр заасан 6 дугаар зүйлийн 6.8.3 дахь заалт, 4 дүгээр зүйлд өөрчлөлт оруулахаар заасан 9.1 дэх хэсэг.	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ, дагалдах хуулийн төслүүд	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29-32 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгах байдлаар ойлгомжтой байдлыг шалгах.
3	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, 5.7.1 дэх заалт	Хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, хүлээн зөвшөөрөгдөх эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ, дагалдах хуулийн төслүүд	Аргачлалын стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараахь байдлаар үнэллээ.

1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хуулийн төслийн үзэл баримтлалд “хуулийн төслийг .. хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тэр дундаа өсвөр үе, хүүхэд, залуучуудыг тамхины хор хөнөөлөөс хамгаалах, тамхины хэрэглээг бууруулах зорилгоор боловсруулна” гэжээ.

Хуулийн төсөлд тамхин бүтээгдэхүүнд хамаарах ойлголтыг өргөтгөн шинэчилж, уламжлалт тамхинаас гадна сүүлийн үед хэрэглээ нь нэмэгдэж буй электрон, халаадаг болон усан тамхи, никотин агуулсан шингэн, үнэрлэх, сорох, зажлах, биед наах зэргээр хэрэглэх бүх төрлийн бүтээгдэхүүн, тэдгээрийн дагалдах хэрэгслийг хамруулан авч үзэх, тэдгээртэй холбоотой асуудлыг зохицуулах, хяналт

тавих асуудлыг тусгасан байна. Ингэснээр хуулийн төслийн үзэл баримтлал болон тухайн хуулийн зорилгод нийцсэн нөхцөл, журмыг тогтоосон байна.

Тамхины хяналтын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь тамхины хэрэглээ, дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хүн амыг хамгаалах зорилго бүхий тамхины хяналтын эрх зүйн үндсийг тодорхойлж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэж хуулийн зорилтыг тодорхойлсон.

1/ / Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийхээр хуулийн төслийн 3 дугаар зүйлд өөрчлөн найруулахаар заасан 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.5.1 дэх заалтыг сонгосон.

Хүснэгт-2

5 дугаар зүйл. Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар салбар хоорондын хамтын ажиллагаа, төр, иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоо

5.1.4. импортлох тамхины хэмжээ, нэр төрлийн талаар энэ хуульд заасан тамхины хэрэглээг бууруулах зарчимтай уялдуулан нэгдсэн бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

5.5.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тариалах хувь хэмжээ, нэр төрөл нь хүн амд аюул учруулахгүй түвшинд байлгах, тамхины хэрэглээг бууруулах зарчимтай уялдуулсан бодлого, зарчим баримтлах;

/Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс/

Одоо даган мөрдөж байгаа Тамхины хяналтын тухай хуульд тусгасан Тамхины хяналтын талаар төрөөс баримтлах бодлогын тухай 4 дүгээр зүйлийн 4.1.1-д ...тамхины хэрэглээг бууруулах зарчим барихаар заасантай хуулийн төслийн 3 дугаар зүйлд өөрчлөн найруулахаар заасан 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.5.1 дэх заалтууд нийцэж байна.

Хуулийн төсөлд өөрчлөн найруулахаар заасан 5 дугаар зүйлийн холбогдох зохицуулалтын зорилгодоо хүрэх байдлыг тодорхойлохын тулд хуулийн холбогдох заалттай харьцуулж үзэх нь зүйтэй юм.

Хүснэгт-3

Тамхины хяналтын тухай хуулийн	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн
5 дугаар зүйл. Тамхины хяналтын талаар төр, иргэн, хуулийн этгээдийн хүлээх нийтлэг үүрэг	5 дугаар зүйл. Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар салбар хоорондын хамтын ажиллагаа, төр, иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоо

5.1.Тамхины хяналтын талаар төрийн байгууллага дараахь үүрэг хүлээнэ: 5.1.1.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тамхины хяналтын талаар төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрийн бус байгууллагын санаачлага, оролцоог дэмжих, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах; 5.1.2.төрийн бүх шатны болон нутгийн өөрөө удирдах байгууллага нь бүрэн эрхийнхээ дагуу хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлогын хүрээнд дангаар буюу холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах.	5.1.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ: 5.1.4.импортлох тамхины хэмжээ, нэр төрлийн талаар энэ хуульд заасан тамхины хэрэглээг бууруулах зарчимтай уялдуулан нэгдсэн бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих; 5.5.Тамхины хяналтын талаар хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ; 5.5.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тариалах хувь хэмжээ, нэр төрөл нь хүн амд аюул учруулахгүй түвшинд байлгах, тамхины хэрэглээг бууруулах зарчимтай уялдуулсан бодлого, зарчим баримтлах;
---	--

Тамхины хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлд байгууллагын хүлээх үүргийг ерөнхий байдлаар бүгдэд нь нийтлэгээр тусгасан бол хуулийн төсөлд тэдний хүлээх үүргийг тус бүрт нь тодорхой зохицуулж тусгасан.

Тамхины хяналтын тухай хуульд тамхины хэрэглээг бууруулахыг зөвхөн зарчим болгон заасан бол хуулийн төсөлд тухайн асуудлыг хариуцсан холбогдох төрийн захиргааны төв байгууллагад үүрэг болгон заасан ба импортлох тамхины хэмжээ, нэр төрлийг бууруулах, тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тариалах хувь хэмжээ, нэр төрлийг бууруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлж ажиллахаар зохицуулсан байна. Хуулийн төслийн 5.1.4, 5.5.1-дахь заалт нь үзэл баримтлалд тамхины хэрэглээг бууруулна гэж тавьсан зорилгод хүрэх боломжтой.

2/ Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийхээр хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.8.3 дахь заалтыг сонгосон:

Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлд тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд тавих шаардлагын талаар тусгасан ба энэ зүйлд нэмэлт болгон оруулж байгаа 6.8.3-т “тамхийг худалдахдаа далд байршуулж, хэрэглэгч бүтээгдэхүүнийг сурталчилгааны шинж чанар агуулаагүй жагсаалтаас сонгон худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх” хэмээн тусгасан.Уг заалтад хийсэн тайлбарт “далд байршуулах” гэдгийг хэрэглэгч бүтээгдэхүүнийг шууд харах боломжгүй, бүрэн хаалттай хайрцаг, шүүгээнд байршуулж, хэрэглэгчийн хүсэлтээр түр хугацаанд нээж үзүүлэх боломжтой байдлаар худалдахыг ойлгоно” гэжээ.

6 дугаар зүйл. Тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд тавих шаардлага

6.8.3. тамхийг худалдахдаа далд байршуулж, хэрэглэгч бүтээгдэхүүнийг сурталчилгааны шинж чанар агуулаагүй жагсаалтаас сонгон худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх

/Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс/

Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.8.3 дахь заалт нь үзэл баримтлалд тодорхойлсон өсвөр үе, хүүхэд, залуучуудыг тамхины хор хөнөөлөөс хамгаалах, тамхины хэрэглээг бууруулах зорилгод хүрэхэд ач холбогдолтой зохицуулалт болно. Энэхүү зохицуулалт нь шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүн болох электрон тамхийг худалдааны байгууллагын касс төлбөр төлөх хэсгийн хажууд шууд анзаарагдахаар ил тавьж, өсвөр үе, залуучуудын анхаарлыг татах, шохоорхлыг төрүүлэх, тамхины хэрэглээг өдөөх эрсдэл үүсгэж байгааг багасгана. Мөн үзэл баримтлалд “Тамхины хяналтын тухай хуульд шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний талаарх зохицуулалт нэмж тусгагдсанаар өсвөр үе, залуучуудад хандсан маркетинг, анхаарал татахуйц загвар дизайнтай байгааг зохицуулах боломжтой болсноор тамхины хор нөлөөг бүрэн ухамсарлаж амжаагүй байгаа залуу үеийг тамхины хор хөнөөлөөс хамгаалах, эрүүл мэндэд үзүүлэх эрсдэл буурах боломж нэмэгдэнэ” гэж заасан үр дагавар гарахад эергээр нөлөөлнө.

3/ Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийхээр хуулийн төслийн 4 дүгээр зүйлд өөрчлөлт оруулахаар заасан 9.1 дэх хэсгийг сонгосон:

4 дүгээр зүйл. Тамхины хяналтын тухай хуулийн ...зүйлийн 9.1 дэх хэсгийн “утаат” гэснийг “энэ хуулийн 3.1.1-д зааснаас бусад” гэж тус тус өөрчилсүгэй.

/Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс/

Тамхины хяналтын тухай хуулийн “9.1. Дараах газарт утаат тамхи татахыг хориглоно” гэсэн хэсгийг дээр дурдсаны дагуу “утаат” гэснийг “3.1.1-д зааснаас бусад” гэж өөрчлөхөд “9.1. Дараах газарт энэ хуулийн 3.1.1-д зааснаас бусад тамхи татахын хориглоно” гэж агуулга нь өөрчлөгдөж байна.

Энэхүү өөрчлөлтийн агуулгыг үзэхэд 9.1-д нэрлэн заасан 9 газарт хуулийн төслийн 3.1.1-д заасан бүх төрлийн тамхийг татаж болохоор харин 3.1.1-д зааснаас бусад буюу 3.1.1-д хамаарахгүй тамхийг татаж болохгүй гэж тодорхойлсон байна.

Хуулиар тамхи татахыг хориглож байсан газар хуулийн төслөөр бүх төрлийн тамхи татахыг зөвшөөрч байгаа 9.1 дэх хэсэг нь “Тамхи татахыг хориглох” гэсэн 9 дүгээр зүйлийн гарчигтай нийцэхгүй байгаа нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.2.1-д “зүйл нь хоорондоо уялдаа холбоо бүхий, дэс дараалал бүхий агуулгыг товч илэрхийлсэн гарчиг, нэгдсэн дугаартай байх” гэж заасныг зөрчсөн байна.

Хуулийн төслийн 9.1 дэх хэсэг нь “Хуулийн төслийн үзэл баримтлалд “хуулийн төслийг .. хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тэр дундаа өсвөр үе, хүүхэд, залуучуудыг тамхины хор хөнөөлөөс хамгаалах, тамхины хэрэглээг бууруулах зорилгоор боловсруулна” гэж, “Тамхины хяналтын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь тамхины хэрэглээ, дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хүн амыг хамгаалах зорилго бүхий тамхины хяналтын эрх зүйн үндсийг тодорхойлж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэж заасантай болон хуулийн бусад заалттай тус тус зөрчилдөж байгаа тул зорилгодоо хүрэх боломжгүй гэж үзэж байна.

2."Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хуулийн төслийн үзэл баримтлалд “Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдийн хамтын ажиллагаа, үүргийг дахин боловсруулж, тамхины хор хөнөөлөөс сэргийлэх нь салбар дундын зохицуулалт бүхий, олон талт харилцаа болохыг илэрхийлэх зохицуулалт тусгана” гэж заажээ.

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоож, тухайн зохицуулалтаар иргэдийн эрхийг хязгаарлаж байгаа эсэх, байгууллагад шинээр үүрэг хүлээлгэсэн эсэхийг судлах зорилгоор хуулийн төслийн зарим зүйлийг сонгож үнэлгээ хийлээ.

1/Хуулийн төслийн 3 дугаар зүйлд өөрчлөн найруулахаар заасан 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, мөн зүйлийн 5.7.1 дэх заалтыг үнэлгээ хийхээр сонгож, зохицуулалтын хувьд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагад нийцэх эсэх, хуулийн төслийн зорилтыг хангах боломжтой эсэхийг шалгалаа.

Хүснэгт-6

3 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"5 дугаар зүйл.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар салбар дундын хамтын ажиллагаа, төр, иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоо

5.3.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ;

5.3.1.энэ хуулийг зөрчсөн зөрчлийн шийтгэлийн хэрэгжилтэд хяналт тавих, шийтгэлийн төрлийн үр нөлөөтэй байдалд үнэлэлт, дүгнэлт, судалгаа хийх;

5.3.2.энэ хуулийн 9.1-д заасан хориглосон газарт тамхи татсан, тамхи худалдахтай холбоотой зөрчлийг Цагдаагийн байгууллагаар дамжуулан шийдвэрлэх, хуулийн хэрэгжилтийг хангах;

5.3.3.энэ хуулийг зөрчсөн зөрчлийн талаарх мэдээллийг иргэдээс хүлээн авах үр дүнтэй зөрчил мэдээллэх тогтолцоо бий болгох....

/Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс/

Дээр дурдсан зүйлийн 5.3.1-д хуулийг зөрчсөн зөрчлийн шийтгэлийн хэрэгжилтэд хяналт тавих, шийтгэлийн төрлийн үр нөлөөтэй байдалд үнэлэлт, дүгнэлт, судалгаа хийх үүргийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Хууль зүй, дотоод хэргийн яам хэрэгжүүлэхээр заасан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн “138.2.Зөрчлийн хэргийн талаархи шийдвэрийг шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтан, хэрэв шүүх гаргасан бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэнэ” гэж, Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Мөн зүйлийн “5.3.2.энэ хуулийн 9.1-д заасан хориглосон газарт тамхи татсан, тамхи худалдахтай холбоотой зөрчлийг Цагдаагийн байгууллагаар дамжуулан шийдвэрлэх, хуулийн хэрэгжилтийг хангах”-ыг, “5.3.3.энэ хуулийг зөрчсөн зөрчлийн талаарх мэдээллийг иргэдээс хүлээн авах үр дүнтэй зөрчил мэдээллэх тогтолцоо бий болгох”-ыг Хууль зүй, дотоод хэргийн яам хэрэгжүүлэхээр үүрэг болгон тус тус заасан нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.6-д олон нийтийн цагдаа Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт, мөн зүйлийн 6.8-д цагдаагийн байгууллагын эрх бүхий абан хаагч Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 1,2,4 дэх хэсэгт, мөн зүйлийн 6.11-д гаалийн улсын байцаагч 6.3 дугаар зүйлийн 2.1, 2.2. дахь заалтад, 6.14-т оюуны өмчийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт, 6.54-т Хүнсний чанар, стандартын хяналтын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 2.3, 2.4 дэх заалтад тус тус заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулна гэж заасантай нийцэхгүй байна.

Хүснэгт-7

6.3 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хууль зөрчих

1.Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Монгол Улсын нутаг дэвсгэрт утаат тамхи:

2.1.импортлох;

2.2.экспортлох;

2.3.үйлдвэрлэх;

2.4.худалдах;

2.5.хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг

хүчингүй болгож хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Хуулиар хориглосон хэлбэрээр утаат тамхийг сурталчилсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Тамхи үйлдвэрлэгч шууд, эсхүл өөр байгууллагаар дамжуулан нийгмийн хариуцлага нэрийн доор нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, байгаль орчныг хамгаалах байгууллагад:

4.1.санхүүгийн, эсхүл эд материалын хандив, тусламж үзүүлсэн;

4.2.бусдад дэмжлэг үзүүлсэн;

4.3.ивээн тэтгэх үйл ажиллагаа явуулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

/Зөрчлийн тухай хуулиас/

Иймээс хуулийн төслийн 5.3-т “Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүлээлгэхээр заасан үүрэг нь тухайн байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй холбогдох хуулийн дагуу бусад байгууллагад харьяалагдахаар байх тул хүлээн зөвшөөрөгдөхгүй болно.

2/ Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийхээр хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.7.1 дэх заалтыг сонгосон:

Хүснэгт-8

3 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

”5 дугаар зүйл.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар салбар дундын хамтын ажиллагаа, төр, иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоо

5.7.Тамхины хяналтын талаар иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:

5.7.1.энэ хуулийн хэрэгжилтийг гэр бүл, ажлын байрны орчинд хангаж ажиллах.

/Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс/

Дээр дурдсан 5.7.1-д энэ хуулийн хэрэгжилтийг гэр бүлийн...орчинд хангаж ажиллахыг иргэнд үүрэг болгосон байна. Иргэнд хуулиар үүрэг хүлээлгэсэн бол үүргийн хэрэгжилтийг хэн хянах, үүргийг биелүүлэхгүй, зөрчсөн тохиолдолд хэн ямар хариуцлага хүлээлгэх вэ гэсэн асуудлууд гарна. Хуулийн алдаатай заалтаас болж, алдаатай зохицуулалт бий болж давхар, давхар алдаа зөрчил үүсэх эрсдэлтэй байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.7.1 дэх заалт нь Гэр бүлийн тухай хуулийн 3.1.2-т “гэр бүл” гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг ойлгоно” гэж,, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/-т “.. өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх,. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно....” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 17 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно” гэж, мөн Пактын 23 дугаар зүйлд “Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй” гэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Орон байр халдашгүй байна” гэж тус тус заасныг анхаарна уу.

Иймээс хуулийн төслийн 5.7.1-д “энэ хуулийн хэрэгжилтийг гэр бүлийн ..орчинд хангаж ажиллах”-аар заасан нь холбогдох хуулийн заалтад нийцэхгүй, иргэдийн хувийн амьдралд хяналт тавих эрсдэлтэй болох тул хүлээн зөвшөөрөгдөхгүй гэж үзэж байна.

3.“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

1/Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь, дагалдах хуулийн төслүүдийн хамт Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, 31 дүгээр зүйлд заасан хуулийн төсөлд товчлол хэрэглэх, 32 дугаар зүйлд заасан хуулийн төсөлд эшлэл хэрэглэх шаардлагад нийцүүлсэн эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталж боловсруулсан эсэхийг шалгалаа.

Хүснэгт-9

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: “2/эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан болон олон улсын гэрээ, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Хуулийн төсөлд тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг тусгасан.

29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Тусгаагүй.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Тусгаагүй.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Хуулийн төслийн заалт нь хуулийн заалттай зөрчилдсөн. Хуулийн төслийн 6.7.2-т "...энэ хуулийн 3.1.1.в-д заасан электрон тамхины шингэний хэмжээг 2 миллилитрээс, цэнэглэгчийг 10 миллилитрээс ихээр савлах, электрон тамхины шингэн дэх никотины агууламж 20 миллиграмм/миллилитрээс их байх гэж тусгасан нь Тамхины хяналтын тухай хуулийн 6.3-т Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэх, худалдах, импортлох, экспортлох тамхинд агуулагдах бохь, никотин, бусад хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд тавих стандартыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Стандартчиллын Үндэсний зөвлөл батлахаар заасантай зөрчилдөж байна.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Тусгаагүй.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	1/Хуулийн төсөлд бусад хуулиас эшлэл хийгээгүй. Харин хуулийн төслийн заалт хооронд эшлэл хийхдээ /төслийн 6.8.5-д/ буруу хийсэн байна. 2/Дагалдах Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 19.6-д эш татахдаа хуульд байхгүй хэсгийг буюу "19.5" гэж эшилсэн.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг,	Тусгасан.

эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт боловсруулах шаардлагатай.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төслийг дагалдах 5 хуулийн төсөл, нэг УИХ-ын тогтоолын төсөл боловсруулсан.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Хуулийн төсөл нь нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тул хуулийн зорилго гэсэн зүйлгүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Хуулийн төслийн 5.1.1-д “улсын нэгдсэн бодлого” гэсэн нэр томъёо хэрэглэсэн. Мөн Тамхины хяналтын тухай хуулийн 8.1.2-т “өөгшүүлэх” гэсэн ярианы үг хэллэг хэрэглэснийг хуулийн төсөлд залруулаагүй.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	1/Дагалдах хуулийн төсөл болох Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд “19.3.6 дахь заалтын “тэтгэмж.” гэснийг “тэтгэмж,” гэж тус тус өөрчилсүгэй.гэсэн нь ойлгомжгүй. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн “19.3.6.тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөлт нь хуульд заасан хугацааг хангаагүй амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох нэг удаагийн тэтгэмж” гэснийг анхаарна уу: 3/Дагалдах Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.15 дахь заалтын “шинжилгээ.” гэснийг “шинжилгээ,” гэж өөрчилсүгэй гэсэн нь ойлгомжгүй. “9.1.15.шүүх эмнэлгийн

	цогцост хийх шинжилгээ” гэснийг анхаарна уу. 3/Дагалдах Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2.1-д заасан худалдахад тавигдах шаардлагыг зөрчихдөө ашигласан эд зүйл, хэрэгсэлд юу хамаарах, 2.3-т заасан импортлох, экспортлох, үйлдвэрлэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд хөрөнгө, гэдэгт юу хамаарах нь ойлгомжгүй тул засах эсхүл тайлбар хийх.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн: 1/Хуулийн төслийн 6.7.17-д “дизайн” гэж тусгасан нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд “монгол хэлэнд тохирох үг байгаа тохиолдолд гадаад хэлний нэр томьёо хэрэглэхгүй” гэж заасныг зөрчсөн байна. 2/Мөн хуулийн төслийн 6.7.17-д “гүйцэтгэл” гэсэн нэр томьёо хэрэглэсэн нь уг заалтынхаа агуулгатай нийцээгүй байна.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Хуулийн төслийн 6.8.5-д “зөвхөн” гэсэн хүч оруулсан нэр томьёо хэрэглэсэн.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Хэрэглээгүй.

4.“Хуулийн төслийн харилцан уялдааг шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

1.Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалын 4.10-т заасан дараахь 16 стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь дагалдах хуулийн төслүүдийн хамт шалгахыг зорилоо.

Хүснэгт-10

Д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа.

2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл тул заах шаардлагагүй.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	“Дөрөв”-ийн 3-т дурдсан.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	1/ Дагалдах Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээний тухай 26 дугаар зүйлд “26.1.10.тамхи импортлох тусгай зөвшөөрлийг олгох, сунгахад 50.000.000 төгрөг.” гэж нэмэхээр заасан нь Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлд 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, мөн зүйлийн 7.2 дахь хэсэг, 7.6 дахь хэсэг, 7.7 дахь хэсэг, 7².2 дахь хэсэг дэх “үйлдвэр, худалдааны” гэснийг “эрүүл мэндийн” гэж өөрчлөхөөр заасантай нийцэхгүй байна. 2/ Хуулийн төслийн 5 дугаар зүйлд “Тамхины хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “утаат”, 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.5, 9.1.6 дахь заалтын “утаат” гэснийг тус тус хүчингүй болгосугай” гэсэн нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.8 дугаар зүйлийн 28.8.4-т “хуулийн зарим үг, өгүүлбэрийг хасах”, 28.8.5-д “зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох” гэж заасантай нийцээгүй. 3/ Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд “9 дүгээр зүйлийн гарчгийн “Утаат тамхи” гэснийг “Тамхи” гэж .. өөрчилсүгэй” гэсэн нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.8.4-т “хуулийн зарим үг, өгүүлбэрийг хасах” гэж заасантай нийцээгүй.

		4/ Дагалдах Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2/-т тусгасан 19.6 дахь хэсгийн тухай 1 дүгээр зүйлд заагаагүй нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.8-тай нийцээгүй. 5/ Дагалдах Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлд “Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “утаат”, 6.20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтын “утаат” гэснийг тус тус хүчингүй болсонд тооцсугай” гэсэн нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.8 дугаар зүйлийн 28.8.4-т “хуулийн зарим үг, өгүүлбэрийг хасах”, 28.8.5-д “зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох” гэж заасантай нийцээгүй.. Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “утаат” гэж хэвээр үлдсэн байгааг анхаарна уу.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагалдах “Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1-д Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19.3-т заасан эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг санхүүжүүлэх арга хэмжээнд “19.3.8.. тамхинаас үүдэлтэй хорт хавдрын эмчилгээ.” гэж нэмэхээр заасан нь Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай хуулийн даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай 9 дүгээр зүйлийн 9.1-д Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад хамаарах тусламж, үйлчилгээнд “9.1.10.хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээ” хамаарахаар заасантай давхардаж байна.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тусгасан.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Хуулийн төслийн 9.1.8 дахь хэсэгт “тэдгээрийн гаднах орчин” гэсэн үгийг орхигдуулсан.

8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.3-т заасан байгууллагад бусад байгууллагад хамаарах үүргийг давхардуулан хүлээлгэсэн.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Хуулийн төсөлд энэ тухай заалт байхгүй.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамжийн хэмжээг тогтоогсогүй. Дагалдах хуулийн төсөлд тогтоосон.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд тусгай зөвшөөрлийн асуудлыг тусгасан нь Зөвшөөрлийн тухай хуультай уялдсан.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Тусгаагүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Тусгаагүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлд хариуцлагын асуудал тусгаагүй.

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэх ажиллагааг хийлээ. Үнэлгээ хийхдээ хуулийн төслийн зарим зүйл, заалтын зохицуулалтын практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож шинжилгээ хийх, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийг батлан хэрэгжүүлснээр үүсэж болзошгүй, урьдчилан тооцоогүй үр дагаврыг тодорхойлох, хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, хуулийн төслийн чанарыг сайжруулахад анхаарсан болно.

Зөвлөмж

1.Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага буюу үзэл баримтлалаар тодорхойлсон зорилготой нийцэж томъёологдсон боловч үзэл баримтлалд хуулийн төслийг нийцүүлэхэд голлон анхаарснаас тухайн зохицуулалтын мөн чанар, бусад хуулийн заалттай хэрхэн уялдаж байгааг судалж тооцоогүй байдлаас болж хуулийн төслийн зарим заалт алдаатай болсныг анхаарч засах.

2.Хуулийн төслийн зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг бүтэц, хэлбэрийн болон агуулгын хувьд хангасан байна. Бичвэрийн хувьд зарим зүйл заалтад давхардал, нийцэл, үг хэллэг, нэр томъёоны алдаа гарсан нь хуулийн төслийн боловсруулалтад анхаарах шаардлагатайг харуулж байна.

3.Хуулийн төсөлд шинэчлэн найруулж, эсхүл нэмж байгаа заалтыг хэрэгжүүлэх нөхцөлийг судалсны үндсэн дээр хуулийн төсөлд тусгахыг анхаарах.

4.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн гарчгийг "5 дугаар зүйл.Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар салбар хоорондын хамтын ажиллагаа, төр, иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоо" гэж өөрчилсөн боловч, салбар хоорондын хамтын ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхойлоогүй байгааг анхаарах.

5.Дагалдах хуулийн төслүүдийг Тамхины хяналтын тухай хуулийн төслийн холбогдох заалт болон бусад хуулийн заалттай нийцүүлэх.

---ooOoo---

Ашигласан материал:

- 1.Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
- 2.Тамхины хяналтын тухай хууль
- 3.Монгол Улсын Засгийн газрын тухай хууль 19993 он
- 4.Зөвшөөрлийн тухай хууль 2022 он
- 5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль 2017 он
- 6.Зөрчлийн тухай хууль 2017 он
- 7.Гэр бүлийн тухай хууль 1999 он
- 8.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 2020 он
- 9.Засгийн газрын тусгай сангийн тухай хууль 2019 он
- 10.Зөвшөөрлийн тухай хууль 2022 он
- 11.Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 2015 он
- 12.Онцгой албан татварын тухай хууль 2006 он
- 13.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль 2010 он
- 14.Хууль тогтоомжийн тухай хууль 2016 он
- 15.Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт
- 16.Тамхины хяналтын тухай суурь конвенц
- 17.Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан.
- 18.Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2, 3 дугаар хавсралт
- 19.Засгийн газрын 2013 оны 191 дүгээр тогтоол



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Судалгааны төрөл:
Судалгааны код:
Хугацаа:

Хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ
ХҮДҮ-25/01
2025.02.24

Захиалагч:

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг

Хянасан:

ПСХХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт

Судалгаа удирдсан:

ПСХХ-ийн Судалгааны хэлтсийн зөвлөх Г.Билгээ

Судлаач:

Г.Билгээ, О.Нарантуяа, Ц.Ариунаа

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	2
Зургийн жагсаалт	3
Товчилсон үгийн жагсаалт	4
Нэг. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	5
1.1. Үнэлгээ хийх үндэслэл	5
1.2. Үнэлгээ хийх хүрээ	5
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт	7
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	7
1.5. Үнэлгээний мэдээлэл цуглуулсан талаар	8
1.5.1. Тоон судалгааны арга	8
1.5.1. Чанарын судалгааны арга	8
Хоёр. ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ	11
2.1. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт	11
2.1.1. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн тоо	11
2.1.2. Ярилцлагад оролцогчдын төсөөлөл	13
2.2. Тамхи худалдахад тавигдах шаардлага, түүний хэрэгжилт	15
2.2.1. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн тоо	15
2.2.2. 21 насанд хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр худалдуулах	18
2.2.3. Тамхийг ширхэглэн худалдах	23
2.2.4. Зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхи худалдах	26
2.2.5. Сургуулийн ойр орчинд тамхи худалдах	29
2.2.6. Хууль зөрчигчид тооцох хариуцлагын тохиромжтой эсэх үнэлгээ	32
2.3. Зарим газар тамхи татахыг хориглосон заалт, түүний хэрэгжилт	35
2.3.1. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн тоо	35
2.3.2. Хориглосон газар утаат тамхи татах	36
2.3.3. Хууль зөрчигчид тооцох хариуцлагын тохиромжтой эсэх үнэлгээ	38
2.4. Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт	40
2.4.1. Хуулийн хэрэгжилтэд тавих төрийн хяналт	41
2.4.2. Хуулийн хэрэгжилтэд тавих олон нийтийн хяналт	43
2.4.3. Хуулийн хэрэгжилтэд тавих ААН-ийн хяналт	45
Гурав. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	47
3.1. Дүгнэлт	47
3.2. Зөвлөмж	49
Ашигласан материал	51
Дөрөв. ХАВСРАЛТУУД	52
Хавсралт 1. САНАЛ АСУУЛГА	52
Хавсралт 2. САНАЛ АСУУЛГЫН ДҮН	55
Хавсралт 2. ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ	60

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Улсын хэмжээнд бүртгэгдсэн зөрчлийн тоо, эзлэх хувь (2015-2024 онд)	11
Хүснэгт 2. Тамхитай холбоотой үйл ажиллагаанд тавих шаардлагыг зөрчсөн тоо, эзлэх хувь (2015-2024 онд).....	16
Хүснэгт 3. Тамхитай холбоотой үйл ажиллагаанд тавих зарим шаардлагыг зөрчсөн тоо, эзлэх хувь (2015-2017 онд).....	17
Хүснэгт 4. Санал асуулгын дүн: ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн дотор утаат тамхи худалдах зөрчил гардаг шалтгаан.....	30
Хүснэгт 5. Утаат тамхи татахыг хориглосон газар тамхи татсан зөрчлийн тоо, эзлэх хувь (2015-2024 онд).....	36
Хүснэгт 6. Санал асуулгын дүн: Хууль тогтоомжийн хэрэгжилтэд төрийн хяналт тавих заалтын хэрэгжилт	41
Хүснэгт 7. Санал асуулгын дүн: Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд тавих төрийн хяналт яагаад хэрэгждэггүй вэ?	41
Хүснэгт 8. Санал асуулгын дүн: Хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих заалтын хэрэгжилт	44
Хүснэгт 9. Санал асуулгын дүн: Хэрэв хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ энэ хуулийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих заалт хяналт яагаад хэрэгждэггүй вэ?.....	44
Хүснэгт 10. Санал асуулгын дүн: Хууль тогтоомжийн хэрэгжилтэд ААН, байгууллагын хяналт тавих заалтын хэрэгжилт	45
Хүснэгт 11. Санал асуулгын дүн: Санал асуулгын дүн: Хэрэв хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ энэ хуулийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих заалт хяналт яагаад хэрэгждэггүй вэ?.....	45

Зургийн жагсаалт

Зураг 1. Санал асуулгын дүн: 21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах тохиолдол.....	20
Зураг 2. Санал асуулгын дүн: 21 нас хүрээгүй хүнээр тамхи худалдуулах тохиолдол.....	21
Зураг 3. Санал асуулгын дүн: Утаат тамхийг ширхэглэх худалдах тохиолдол.....	24
Зураг 4. Санал асуулгын дүн: Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины үйлдвэрлэсэн боодлыг задалж буюу ороож худалдаалах тохиолдол.....	25
Зураг 5. Санал асуулгын дүн: Утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах тохиолдол.....	27
Зураг 6. Санал асуулгын дүн: ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн дотор утаат тамхи худалдах тохиолдол.....	30
Зураг 7. Санал асуулгын дүн: Хувь хүнд тооцох хариуцлагын тохиромжтой эсэх үнэлгээ.....	32
Зураг 8. Санал асуулгын дүн: Хуулийн этгээдэд тооцох хариуцлагын тохиромжтой эсэх үнэлгээ.....	33
Зураг 9. Санал асуулгын дүн: Утаат тамхи татахыг хориглосон газар тамхи татах тохиолдол.....	36
Зураг 10. Санал асуулгын дүн: Хориглосон газар утаат тамхи татсан хувь хүнд ногдуулах торгуулийн хэмжээний үнэлгээ.....	38
Зураг 11. Санал асуулгын дүн: Хориглосон газар утаат тамхи татсан хуулийн этгээдэд ногдуулах торгуулийн хэмжээний үнэлгээ.....	39

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуй нэгж
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НСАУСИ ТББ	Нотолгоонд суурилсан анагаах ухааны судалгааны институт ТББ
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
ТҮЦ	Түргэн үйлчилгээний цэг
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

Нэг. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

1.1. Үнэлгээ хийх үндэслэл

Захиалагч Улсын Их Хурлын даргын 2024 оны 110 дугаар захирамжаар байгуулагдсан “Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, электрон тамхи, түүнтэй холбоотой асуудлаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг судлан, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагын хүрээнд тус хуулийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийлгэхээр захиалга өгсөн.

2005 онд батлагдсан Тамхины хяналтын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт зааснаар хуулийн зорилт нь тамхины хэрэглээ, дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хүн амыг хамгаалах зорилго бүхий тамхины хяналтын эрх зүйн үндсийг тодорхойлж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон төр, иргэн, ААН, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Тус хуульд нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт орсон.¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд 51.3 дахь хэсэгт зааснаар хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ. Харин Тамхины хяналтын тухай хуульд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг өнөөг хүртэл хийгээгүй нь тус судалгааг хийх шаардлагатай болохыг харуулж байна.

Өмнө нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газар чиг үүргийнхээ хүрээнд Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтад 21 аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон 396 албан байгууллага хамрагдсан. Мөн тамхи худалдаалагч 1303 ААН, байгууллага, 131 бөөний худалдаа, 1114 жижиглэнгийн худалдаа, 262 ил задгай худалдаа эрхлэгчид, нийт 3000 гаруй ААН, байгууллага, иргэд оролцжээ.²

Тус шалгалтын үр дүнгээс үзэхэд, тамхины үйлдвэрлэл, хайрцаг, сав, баглаа боодол, хаяг, шошго, санамж анхааруулга, тамхины сурталчилгаатай холбоотой зөрчил илрээгүй байна. Харин тамхийг ширхэглэн худалдаалах, тусгай зөвшөөрөлгүй, хориглосон бүсэд худалдаалах, ААН, байгууллага хуулийн хүрээнд байгууллагынхаа хөдөлмөрийн дотоод журамд тусгаж хэрэгжүүлээгүй зөрчлүүд гарчээ. Эдгээр зөрчлүүд нь захиалагчийн зүгээс ирүүлсэн үнэлгээ хийх хүрээнд хамаарч байна.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7, 6.7.8, 6.7.12, 6.7.14 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийг сонгож үнэлгээний хүрээг тогтоосон болно.

¹ Тус хуульд 2012, 2015 (3 удаа), 2019, 2022 (2 удаа), 2023 онд нэмэлт, өөрчлөлт орсон.

² ЗГХЭГ. 2017.05.30-ний өдрийн ХЭГ/909 тоот албан бичгийн хавсралт. 2017 онд УИХ-ын гишүүн Н.Учралаас “Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх заалтын хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариу.

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ (2005.07.01)

6 дугаар зүйл. Тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд тавих шаардлага

/Энэ зүйлийн гарчигт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

6.7. Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд дараахь зүйлийг хориглоно:

/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтад 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

6.7.7.21 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулах;

/Энэ заалтад 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

6.7.8. тамхийг ширхэглэн худалдах, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины үйлдвэрлэсэн боодлыг задалж буюу ороож худалдах;

6.7.12. зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхи худалдах.

/Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/

6.7.14. ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдах;

/Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/

9 дүгээр зүйл. Утаат тамхи татахыг хориглох

9.1. Дараах газар утаат тамхи татахыг хориглоно:

9.1.1. бүх төрлийн нийтийн тээврийн хэрэгсэл;

9.1.2. олон нийтийн үзвэр, үйлчилгээний газар;

9.1.3. шатахуун түгээгүүрийн газар, шатах, тослох, тэсэрч, дэлбэрэх бодис, материалын үйлдвэр, түүний нөөцийн агуулах;

9.1.4. зорчигч тээврийн буудал, зочид буудлын нийтийн танхим, тамхи татахыг хориглосон өрөө;

9.1.5. нийтийн хоол, худалдаа, баар, цэнгээний газрын утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгээс бусад орчин;

/Энэ заалтыг 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

9.1.6. аж ахуйн нэгж, байгууллагын утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгээс бусад ажлын байрын дотоод орчин;

/Энэ заалтыг 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

9.1.7. агаарын хөлөг, зорчигч тээврийн галт тэрэг;

9.1.8. цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувилал, тэдгээрийн гаднах орчин, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орц, шат, цахилгаан шат, хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн.

/Энэ заалтад 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

11 дугаар зүйл. Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих

11.1. Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.

/Энэ хэсэгт 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

11.2. Аж ахуй нэгж, байгууллага, тэдгээрийн салбар нэгжийн удирдлага энэ хуульд заасан өөрийн эрх хэмжээний хүрээнд тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина.

11.3. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавьж болно.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс Тамхины хяналтын тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлоход чиглэгдсэн дараах шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1) Хүлээн зөвшөөрөгдсөн байдал – иргэд, хуулийн этгээдээс хуулийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр шалгана.

- *Таны бодлоор иргэд, эсхүл аж ахуйн нэгж, байгууллагууд дараах хуулийн зүйл заалтыг хэр зэрэг биелүүлдэг гэж бодож байна вэ?*

2) Практикт нийцэж байгаа байдал – тухайн хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

- *Таны бодлоор Тамхины хяналтын тухай хууль хэрэгжиж эхэлснээр эерэг, эсхүл сөрөг үр дагавар гарсан уу?*
- *Эерэг үр дүн гарсан бол ямар?*
- *Сөрөг үр дүн гарсан бол ямар?*
- *Таны бодлоор дараах хуулийн зүйл заалтыг хэрэгжүүлэхэд ямар байсан бэ? (маш хялбар, огт биелэгдэхгүй)*
- *Тухайн хуулийн зүйл, заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байсан бол ямар хүндрэлүүд гарч байсан бэ?*

3) Бусад үр дагавар – урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй ямар үр дагавар байж болохыг тооцоолно.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Тамхины хяналтын тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт нь хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд үзүүлсэн эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.5-д заасан үнэлгээний харьцуулах хэлбэрээс “байх ёстой болон одоо байгаа” харьцуулах хэлбэрийг сонгосон.

Энэ хэлбэрийг ашиглан хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар буюу одоо байгаа нөхцөл байдлыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно.

1.5. Үнэлгээний мэдээлэл цуглуулсан талаар

Үнэлгээний мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргаар цуглуулна.

1.5.1. Тоон судалгааны арга

Тамхины хяналтын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээ хийх ажлын хүрээнд санал асуулга болон ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан.

1) Санал асуулга: Тамхины хяналтын тухай хуулийн 11.1-д заасны дагуу тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга болон бусад албан тушаалтнууд хяналт, шалгалтыг хэрэгжүүлнэ.

Үнэлгээний ажлын хүрээнд Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн хамгийн олон гардаг зөрчлийн төрөл, хуулийг хэрэгжүүлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээл зэрэг асуудлыг тодорхойлох зорилгоор 21 аймаг, 330 сум, нийслэлийн 9 дүүргийн Засаг дарга, эсхүл Засаг даргын орлогч нараас Google Forms ашиглан санал асуулга авахаар албан тоот хүргүүлсэн.

Санал асуулгад нийт 2134 албан хаагч оролцов. Үүнд:

- аймгийн удирдлага (Засаг дарга, түүний орлогч, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга) – 8 хүн;
- дүүргийн удирдлага – 3 хүн;
- сумын удирдлага – 136 хүн;
- хорооны удирдлага - 100 хүн;
- Засаг даргын Тамгын газрын албан хаагч – 55 хүн;
- бусад төрийн албан хаагч – 1831 хүн хамрагдсан.

Оролцогчдын байршлаар нь авч үзвэл, хөдөө, орон нутгаас – 1970 хүн (65.9%), нийслэлээс – 164 хүн (34.1%) хамрагдав.

2) Ганцаарчилсан ярилцлага: Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн түгээмэл зөрчлүүд, хуулийг хэрэгжүүлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор нийслэлийн төвийн 5 дүүрэгт дараах бүлгүүдээс ярилцлага авсан. Үүнд:

- хуулийн хэрэгжилтэд өртөж буй этгээд –
 - байрны дунд, эсхүл доор байрлах хүнсний дэлгүүрийн 2 худалдагч, түргэн үйлчилгээний цэг (цаашид “ТҮЦ”)-ийн 3 худалдагч;
 - ерөнхий боловсролын сургууль (цаашид “ЕБС”)-ийн 5 нийгмийн ажилтан;
- хууль хэрэгжилтэд хяналт тавьж буй албан хаагч –
 - цагдаагийн 6 албан хаагч хамрагдсан.

1.5.1. Чанарын судалгааны арга

Тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, холбогдох судалгааны тайлан, статистик мэдээлэл зэрэг эх сурвалжуудыг болон

төрийн болон холбогдох бусад байгууллагаас цуглуулсан баримт бичгүүдэд контент анализ хийсэн болно.

Тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад хууль тогтоомж, стандарт:

- Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйл (2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр батлагдаж, мөн оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн);
- Зөвшөөрлийн тухай хууль (2022 оны 6 сарын 17 өдөр батлагдаж, 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн);
- Тамхи үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам (Засгийн газрын 2013 оны 191 дүгээр тогтоол);
- “Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/987 дугаар захирамж;
- “Янжуур тамхи техникийн ерөнхий шаардлага” MNS 5042:2013 стандарт зэрэг хамаарна.

Хуулийн хэрэгжилттэй холбоотой судалгааны тайлан, статистик мэдээлэл:

- 2017 онд Улсын Их Хурал (цаашид “УИХ”)-ын гишүүн Н.Учралаас “Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх заалтын хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан **асуулгын хариу** албан бичиг³, түүний хавсралтын баримт бичгүүдийг үнэлгээний тайланд эх сурвалж болгон ашигласан болно.
- Тамхины хяналтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу цагдаагийн байгууллага нь эрх хэмжээнийхээ хүрээнд тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд төрийн хяналтыг хэрэгжүүлдэг. Тайланд Цагдаагийн ерөнхий газар (цаашид “ЦЕГ”)-т бүртгэгдсэн Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн **зөрчлийн тоон мэдээллийг** дараах эх сурвалжаас авч нэгтгэсэн болно:
 - **2015 оны 7 дугаар сараас 2017 оны 5 дугаар сарын хооронд ЦЕГ-т бүртгэгдсэн зөрчил⁴:** 2017 оны 7 дугаар сараас өмнөх бүртгэл бөгөөд тухайн үед Тамхины хяналтын тухай хуулийн тодорхой зүйл, заалтын зөрчлийг нарийвчлан ангилж бүртгэж байсан. Ингэж ангилсан бүртгэл нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг бодитой үнэлэх, хяналтыг сайжруулах зэрэг олон талын ач холбогдолтой;
 - **2017-2024 оны хооронд ЦЕГ-т бүртгэгдсэн зөрчил:** 2017 оны 7 дугаар сараас хойш Зөрчлийн тухай хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээр ЦЕГ-ын Хэрэг бүртгэх алба нь Тамхины хяналтын тухай хуулийн зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйл болон 6.3.1, 6.3.2, 6.3.4 дэх заалтын дагуу нэгтгэж бүртгэдэг болсон. Үүний улмаас

³ ЗГХЭГ. 2017.05.30-ний өдрийн ХЭГ/909 тоот албан бичгийн хавсралт. 2017 онд УИХ-ын гишүүн Н.Учралаас “Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх заалтын хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариу.

⁴ Мөн тэнд.

зөрчлийн мэдээллийг тусгайлан ангилж бүртгэх боломж хязгаарлагдаж, Тамхины хяналтын тухай хуулийн тодорхой зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврыг нарийвчлан үнэлэх боломжгүй болсон.

- Нотолгоонд суурилсан анагаах ухааны судалгааны институт ТББ-ын 2024 онд хийсэн “Өсвөр үе, залуу иргэдийн тамхины хэрэглээ, төрлүүд, никотин хамааралт байдал, нөлөөлж буй сэтгэц, нийгмийн зарим үзэгдлүүд судалгааны тайлан”;
- ЭМЯ, НЭМҮТ, ДЭМБ-ын хамтран 2023 онд хийсэн “Тамхи тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад саад болж байна” судалгааны тайлан;
- НХХЯ, ЭМЯ, БШУЯ-ны хамтран 2024 онд хийсэн “Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн судалгаа”-ны тайлан;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2023 онд Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөний “Эрүүл оюутан” дэд хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгааны тайлан.

Хоёр. ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

2.1.Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт

2.1.1.Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн тоо

2015-2024 оны хооронд Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн нийт 8274 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс 30.3% (2505 зөрчил) нь аймгуудад, 69.6% (5758 зөрчил) нь нийслэлд бүртгэгдсэн байна. Улсын хэмжээнд:

- 2015-2017 онд 4206 зөрчил бүртгэгдсэнээс 26% (1095) нь аймгуудад, 74% (3111) нь нийслэлд гарсан байна;
- 2017-2024 онд 4068 зөрчил бүртгэгдсэнээс 34.7% (1410) нь аймгуудад, 65.1% (2647) буюу мөн л дийлэнх нь нийслэлд гарсан байна.

Хүснэгт 1. Улсын хэмжээнд бүртгэгдсэн зөрчлийн тоо, эзлэх хувь (2015-2024 онд)

	Тамхины хяналтын тухай хуулийн дагуу бүртгэгсэн зөрчлийн тоо (2015-2017 он)				Зөрчлийн тухай хуулийн дагуу бүртгэгсэн зөрчлийн тоо (2017-2024 он)									Бүгд
	2015 ¹	2016	2017 ²	Нийт	2017 ³	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Нийт	
Улсын дүн	1175	2283	748	4206	324	587	897	688	636	318	358	260	4068	8274
Аймгуудын дүн	383	514	198	1095	144	282	261	158	194	167	114	90	1410	2505
-Улсын дүнд эзлэх хувь	32.6	22.5	26.5	26.0	44.4	48.0	29.1	23.0	30.5	52.5	31.8	34.6	34.7	30.3
Дүүргүүдийн дүн	792	1769	550	3111	175	305	634	530	442	148	243	170	2647	5758
-Улсын дүнд эзлэх хувь	67.4	77.5	73.5	74.0	54.0	52.0	70.7	77.0	69.5	46.5	67.9	65.4	65.1	69.6
Бусад нэгж ⁴	-	-	-	-	5	-	2	-	-	3	1	-	11	11
-Улсын дүнд эзлэх хувь	-	-	-	-	1.5	-	0.2	-	-	0.9	0.3	-	0.3	0.1

Тайлбар: 1. 2015 оны сүүлийн 6 сарын хугацаа хамаарна.
2. 2017 оны эхний 5 сарын хугацаа хамаарна.
3. 2017 оны сүүлийн 6 сарын хугацаа хамаарна.
4. "Бусад нэгж" гэдэг нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэс буюу аймаг, дүүргийн цагдаагийн байгууллагаас бусад алба, нэгжүүд хамаарна. Тухайлбал, Тээврийн цагдаагийн алба, Төмөр замын цагдаагийн газар, Иргэний агаарын тээврийн хяналт, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх нэгж зэрэг болно.

Эх сурвалж: ЦЕГ, 2017; 2025.

2015-2024 оны онцлох үзүүлэлтүүд:

- 2016 онд хамгийн олон буюу 2283 зөрчил бүртгэгдсэнээс нийслэлд 1769 зөрчил бүртгэгдсэн нь улсын дүнгийн 77.5%-ийг эзэлж байна;
- 2024 онд улсын дүн хамгийн бага буюу 260 зөрчил бүртгэгдсэн;

- 2022 онд аймгуудад бүртгэгдсэн зөрчлийн эзлэх хувь 52.5% болж өссөн бол 2024 онд 34.6% болж буурсан байна;
- нийслэлд зөрчлийн эзлэх хувь ихэвчлэн 50%-иас дээш байгаа нь зөрчил Улаанбаатар хотод илүү их бүртгэгддэгийг харуулж байна.

Аймгууд болон дүүргүүдийн зөрчлийн түвшин хүн амын тооноос хамааралтай байгааг статистик үзүүлэлтүүд харуулж байна. Тухайлбал, зөрчлийн түвшин доогуур байгаа Говьсүмбэр (18.0 мянга), Дундговь (46.1 мянга), Говь-Алтай (56.7 мянга) зэрэг аймгууд хүн ам багатай байна. Зөрчлийн түвшин өндөр Дархан-Уул (109.2 мянга), Баян-Өлгий (116.6 мянга), Увс (83.9 мянга) зэрэг аймгууд нь олон хүн амтай.⁵

Дүүргүүдийн хувьд, хүн амын тоо цөөнтэй захын дүүргүүд болох Багахангай (4.4 мянга), Багануур (28.9 мянга), Налайх (40.2 мянга) зэрэгт зөрчлийн түвшин тогтвортой бага түвшинд байна. Хүн амын төвлөрөл ихтэй Баянзүрх (436.8 мянга), Сонгинохайрхан (341.4 мянга) дүүргүүдэд зөрчлийн түвшин хамгийн өндөр байна.⁶

Зөрчлийн тоо 2019 онд 897 болж өссөн боловч 2024 онд 260 болж 71%-иар буурсан байна. 2022 оноос эхэлж зөрчлийн тоо тогтвортой буурсан бөгөөд тухайн онд 318 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 50%-иар буурсан үзүүлэлт юм.

Зөрчлийн тоо буурахад нөлөөлсөн нэг хүчин зүйл нь Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/987 дугаар захирамж⁷ байж болзошгүй байна. Уг захирамжийн 1 дүгээр зүйлд “Хуулиар нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл авахыг шаардсанаас бусад бүх төрлийн аж ахуйн үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт, шаардлагад нийцүүлэн, зөвхөн татварын албанд бүртгүүлсний үндсэн дээр нийслэлийн нутаг дэвсгэрт чөлөөтэй эрхлэх нөхцөл боломжийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн бүрдүүлэхийг нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллага, албан хаагчдад үүрэг болгосугай.”⁸ гэж заасан байна. Энэхүү зохицуулалт нь зарим худалдаа, үйлчилгээний газруудын хяналтад нөлөөлсөн байж болзошгүй.

2024 онд бүртгэгдсэн зөрчлийн тоо:

- аймаг, дүүргүүдэд зөрчлийн тоо буурч, улсын дүн хамгийн бага түвшинд хүрч 260 болсон;
- Дундговь, Завхан, Говь-Алтай аймагт, мөн Багахангай дүүрэгт хууль зөрчсөн тохиолдол бүртгэгдээгүй;
- Архангай, Булган, Дархан-Уул, Дорнод, Увс, Ховд, Хөвсгөл зэрэг аймгуудад зөрчлийн тоо нэг болж буурсан;
- Сонгинохайрхан дүүрэгт хамгийн олон буюу 62 зөрчил, дараа нь Баянзүрх дүүрэгт 46 зөрчил бүртгэгдсэн байна.

⁵ Үндэсний статистикийн хороо. 1212 статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Хүн амын тоо, 2023 он. Хандах: https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_004V1 Хандсан огноо: 2025-02-17.

⁶ Нийслэлийн статистикийн газар. Улаанбаатар хотын хүн амын тоо, 2023 он. Хандах: <http://ubstat.mn/StatTable=20> Хандсан огноо: 2025-02-17.

⁷ Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/987 дугаар захирамж. Хандах: <https://n9.cl/l3snkm>

⁸ Мөн тэнд. §1.

2.1.2.Ярилцлагад оролцогчдын төсөөлөл

Үнэлгээний ажлын хүрээнд Улаанбаатар хотын төвийн 5 дүүрэгт байрлах хүнсний дэлгүүр, ТҮЦ-ийн худалдагчид, ЕБС-ийн нийгмийн ажилтнууд, цагдаагийн албан хаагчидтай Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийн талаар ганцаарчилсан ярилцлага хийж, тэдний байр суурийг тодрууллаа.

Худалдагчдын үзэж байгаагаар тамхи худалдаалахыг хориглосон хуулийн зохицуулалт тодорхой хэмжээнд хэрэгжиж байгаа. Ялангуяа сургуулиас 500 метрийн дотор тамхи худалдахгүй байх шаардлага тавигдаж, хяналт шалгалт тогтмол хийгдэж байдаг. Гэсэн хэдий ч олон нийтийн газар тамхи татах явдал төдийлөн буураагүй, хяналт сул хэвээр байгааг онцолсон.

Шигтгээ.

- Энэ хууль хүүхдийн сургууль, цэцэрлэгийн орчинд хэрэгжиж байгаа гэж бодож байна. (Худалдагч, ТҮЦ-3)
- Хуулийн хэрэгжилт тааруухан шүү дээ. Яагаад гэвэл гадуур гудамжаар хаа сайгүй л татаад байна шүү дээ. (Худалдагч, Хүнсний дэлгүүр-2)

ЕБС-ийн нийгмийн ажилтнууд Тамхины хяналтын тухай хуулийг сургуулийн орчныг тамхигүй байлгах чухал бодлогын хэрэгсэл гэж үзэж байна. Гэвч сургуулиас 500 метрийн дотор тамхи худалдаалах болон хэрэглэхийг хязгаарлах зохицуулалт бодит байдал дээр бүрэн хэрэгжихэд хүндрэлтэй хэвээр байгааг онцолсон. Түүнчлэн, олон нийтийн мэдлэг, мэдээлэл хангалтгүй, ухамсарт нөлөөлөх ажлууд дутмаг байгаагаас хориглосон бүсэд тамхи татах зөрчил түгээмэл гарч буйг тэмдэглэжээ.

Шигтгээ.

- Сургууль орчмын 500 метр гэдэг зохицуулалт бол үндсэндээ хэрэгжихгүй байна. (Нийгмийн ажилтан, ЕБС-2)
- Энд тамхи татаж болохгүй гээд сануулга тавьчихсан байхад хүмүүс үүнийг уншдаггүй. Иргэд, олон нийт тамхины хуулийн талаар мэдлэг, мэдээлэл муу байна. Цаашид сургууль орчмын бүсийг "Тамхигүй бүс" болгох хэрэгтэй. Үүнд бүх төрлийн тамхи хамаарна. (Нийгмийн ажилтан, ЕБС-4)
- Хуулийн хэрэгжилт муу байна. Хүмүүс хаа сайгүй л тамхи татаж байна. Хүүхдээ хүлээх хоорондоо сургуулийн гадаа эцэг, эхчүүд өөрсдөө ч тамхи татаад зогсож л байдаг. (Нийгмийн ажилтан, ЕБС-5)

Цагдаагийн албан хаагчдын үзэж байгаагаар Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт анхны жилүүдэд харьцангуй сайн байсан ч, сүүлийн жилүүдэд зарим газарт хяналт суларч, хэрэгжилтэд хүндрэл үүссэн байна.

Шигтгээ.

- Анх хууль батлагдсаны дараа хэрэгжилт сайн байсан. Харин одоо зарим талаар хэрэгжилт буурсан. Тухайлбал, ТҮЦ-үүд сургуулийн орчим хууль зөрчин тамхи нууцаар зардаг нь үнэн. Тэгээд бид нэр арга хэмжээг нь аваад явдаг. Бараг 70% нь зөвшөөрөлгүй явуулж байгаа гэж ойлгож болно шүү. (Цагдаагийн албан хаагч-1)

Шигтгээ.

- Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт 50%-тай гэж үзэж байна, 100% хэрэгжихгүй байгаа. 1-рт, 2022 оноос Нийслэлийн ЗД-ын зарим төрлийн худалдаа, аж ахуйн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтгүйгээр эрхлэх шийдвэр хэрэгжиж эхэлсэн. Тэрэгнэй холбоотойгоор ААН рүү шууд орж шалгалт хийхээ больсон. Тухайн ААН дээр ямар нэгэн гэмт хэрэг, зөрчил гарсан тохиолдолд шууд орж шалгаж байгаа болохоос биш эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаад шалгахаа больсон. 2-рт, цагдаагийн албан хаагчид их ачаалалтай ажиллаж байгаа. Хүний нөөц хүрэлцэхгүй байна. Тиймээс жишээлбэл, гудамжинд тамхи татаж байгаа хүнийг хараад "Энд автобусны буудал дээр тамхи татаж болохгүй" гэж хэлээд зогсоох боломжгүй болсон. Өмнө нь ийм хяналт тавьдаг байсан, одоо байхгүй болсон. (Цагдаагийн албан хаагч-3)

Албан хаагчдаас тус хуультай холбоотой **"түгээмэл гардаг зөрчил"**-ийг тодруулж асуухад, тамхи ширхэглэн худалдах тохиолдол их байна. Үүнд, ТҮЦ, хүнсний дэлгүүр болон орон сууцны доорх жижиг дэлгүүрүүд ихэвчлэн хамрагддаг. Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй газрууд болон сургуулиас 500 метрийн дотор тамхи худалдахыг хориглосон заалт хамгийн их зөрчигддөг. Мөн тамхи татахыг хориглосон газар тамхи татах зөрчил түгээмэл гардаг, үүнийг дагаад Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан олон нийтийн газар, авто зам, орон сууцны орчны газар, гудамж, талбайд тамхины иш хаях зөрчил гардаг.

Цагдаагийн байгууллагын албан хаагчдаас хамгийн түгээмэл гардаг зөрчлүүдийг тодруулахад, хүнсний жижиг дэлгүүр, ТҮЦ-үүдэд тамхийг ширхэглэн худалдаалах явдал хамгийн түгээмэл байдаг. Мөн худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй газруудад тамхи худалдаалах, сургуулиас 500 метрийн дотор тамхи худалдахыг хориглосон заалтыг зөрчих тохиолдол хамгийн их гарч байна. Үүнээс гадна, тамхи татахыг хориглосон газарт тамхи татах зөрчил түгээмэл бөгөөд үүнтэй холбоотойгоор Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан олон нийтийн газар, авто зам, орон сууцны орчин, гудамж, талбайд тамхины иш хаях зөрчил ихээр гардаг байна.

Хэдийгээр цагдаагийн байгууллагаас хяналт тавьж, гомдлын мөрөөр шалгадаг ч хяналтыг хангалттай тавьж чадахгүй байна. Зөрчил гарах шалтгаанууд:

- тамхи татах хэрэгцээ, эрэлт өндөр хэвээр байна;
- худалдаа эрхлэгчид орлогоо нэмэгдүүлэхийн тулд хууль зөрчиж байна;
- цагдаагийн албан хаагчид ачаалал ихтэй, хүний нөөц дутагдалтай;
- сум, дүүргийн Засаг дарга нар, ААН-үүд хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байна;
- тамхи татах зориулалтын цэг хангалтгүй байна.

Эдгээрээс гадна бодлогын түвшинд Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/987 дугаар захирамжийн⁹ дагуу ААН-үүдийг шууд шалгах боломжгүй нөхцөл байдал үүссэн. Тус захирамжийн дагуу нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа зарим төрлийн худалдаа, үйлчилгээнд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл шаардахгүй болсон нь хяналт сулрахад нөлөөлсөн байна.

⁹ Мөн тэнд. §1.

Хуулийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлс:

- олон нийтийн хуулийн талаарх мэдлэг, ойлголт дутмаг;
- зөрчил шийдвэрлэх ажиллагаа, тухайлбал, хууль зөрчсөн иргэдийг торгох процесс нь шат дамжлага ихтэй байдаг.

Мөн цагдаагийн албан хаагчдын үзэж байгаагаар зарим хууль, зохицуулалт бодит байдалтай нийцэхгүй байгаа нь хэрэгжилтэд хүндрэл учруулж байна. Тухайлбал:

- ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдахыг хориглох - энэхүү зохицуулалт нь хот төлөвлөлттэй уялдахгүй, бодит хэрэгжилтэд хүндрэл учруулж байгаа тул далд худалдаа гарч байна;
- хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих – цагдаагийн байгууллагаас хяналт тавьж, гомдлын мөрөөр шалгаж, шаардлага тавьж, зөвлөмж хүргүүлдэг боловч иргэд амьдралын тааруу нөхцөлөөс шалтгаалан хууль зөрчиж, ашиг олохын тулд шаардлага, зөвлөмжийг биелүүлдэггүй;
- Тамхи татах цэг хангалтгүй тул иргэд цэцэрлэг, сургуулийн орчим, тоглоомын талбай, автобусны буудал зэрэг газарт тамхи татах зөрчил гаргасаар байна."
- утаат тамхи татахыг хориглосон газруудад тамхи татах – тамхи татах цэг хангалттай байдаггүйгээс болж хүүхдээ авч байгаа, тоглуулж байгаа эцэг хангалтгүй тул иргэд цэцэрлэг, сургуулийн орчим, тоглоомын талбай, зорчигч тээврийн (автобусны) буудал зэрэг газарт тамхи татах зөрчил гаргасаар байна.

Үнэлгээний тайлангийн 2.1.1 дэх хэсэгт дурдсан зөрчлийн тоон үзүүлэлт болон ярилцлагын үр дүнгээс үзэхэд, цагдаагийн байгууллага Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа хэдий ч хүний нөөцийн хомсдол, ажлын ачаалал ихсэх, зөрчил шийдвэрлэх ажиллагааны олон шат дамжлага зэргээс хуулийн хэрэгжилт хангалтгүй, үр нөлөөг бууруулж байна.

ААН-үүдийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас зөрчлийн бүртгэл буурсан мэт харагдаж байгаа боловч бодит байдал дээр тамхины хууль бус худалдаа далд хэлбэрт шилжсэн байж болзошгүй..

2.2.Тамхи худалдахад тавигдах шаардлага, түүний хэрэгжилт

2.2.1.Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн тоо

2015-2024 оны хооронд Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэгт заасан шаардлагыг зөрчсөн нийт 6831 зөрчил улсын хэмжээнд бүртгэгдсэн байна. Үүнээс 28.8% (1970 зөрчил) нь аймгуудад, 71.1% (4860 зөрчил) нь нийслэлд бүртгэгджээ. Улсын хэмжээнд:

- 2015-2017 онд 3956 зөрчил бүртгэгдсэнээс 25.4% (1004) нь аймгуудад, 74.6% (2952) нь нийслэлд гарсан байна;
- 2017-2024 онд 2875 зөрчил бүртгэгдсэнээс 33.6% (966) нь аймгуудад, 66.4% (1908) буюу дийлэнх нь мөн л нийслэлд гарсан байна.

2015-2024 оны онцлох үзүүлэлтүүд:

- 2016 онд хамгийн олон буюу 2139 зөрчил бүртгэгдсэн бөгөөд нийслэлд 1676 (78.4%), аймгуудад 463 (21.6%) тохиолдол гарсан байна;
- 2022 онд аймгуудад бүртгэгдсэн зөрчлийн эзлэх хувь 62.6%-д хүрч хамгийн өндөр үзүүлэлттэй байсан бол 2024 онд 37.9% болж буурсан;
- 2016 онд нийслэлд бүртгэгдсэн зөрчлийн эзлэх хувь 78.4%-тай байсан бол 2022 онд 37.4% хүртэл буурч, 2024 онд 62.1% болж дахин өссөн байна;
- зөрчлийн тоо 2019 онд 582 байсан бол 2024 онд 227 болж 61%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2. Тамхитай холбоотой үйл ажиллагаанд тавих шаардлагыг зөрчсөн тоо, эзлэх хувь (2015-2024 онд)

	Тамхины хяналтын тухай хуулийн дагуу бүртгэгдсэн зөрчлийн тоо (2015-2017 он)				Зөрчлийн тухай хуулийн дагуу бүртгэгдсэн зөрчлийн тоо (2017-2024 он)									Бүгд
	2015 ¹	2016	2017 ²	Нийт	2017 ³	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Нийт	
Улсын дүн	1110	2139	707	3956	161	383	582	558	475	198	291	227	2875	6831
Аймгуудын дүн	370	463	171	1004	52	160	173	128	143	124	100	86	966	1970
-Улсын дүнд эзлэх хувь	33.3	21.6	24.2	25.4	32.3	41.8	29.7	22.9	30.1	62.6	34.4	37.9	33.6	28.8
Дүүргүүдийн дүн	740	1676	536	2952	108	223	409	430	332	74	191	141	1908	4860
-Улсын дүнд эзлэх хувь	66.7	78.4	75.8	74.6	67.1	58.2	70.3	77.1	69.9	37.4	65.6	62.1	66.4	71.1
Бусад нэгж ⁴	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	1	1
-Улсын дүнд эзлэх хувь	-	-	-	-	0.6	-	-	-	-	-	-	-	0.0	0.0
Тайлбар: 1. 2015 оны сүүлийн 6 сарын хугацаа хамаарна. 2. 2017 оны эхний 5 сарын хугацаа хамаарна. 3. 2017 оны сүүлийн 6 сарын хугацаа хамаарна. 4. "Бусад нэгж" гэдэг нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэс буюу аймаг, дүүргийн цагдаагийн байгууллагаас бусад алба, нэгжүүд хамаарна. Тухайлбал, Тээврийн цагдаагийн алба, Төмөр замын цагдаагийн газар, Иргэний агаарын тээврийн хяналт, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх нэгж зэрэг болно.														

Эх сурвалж: ЦЕГ, 2017; 2025.

Өмнө нь дурдаж байсанчлан 2015 оны 7 дугаар сараас 2017 оны 5 дугаар сарын хооронд ЦЕГ-т Тамхины хяналтын тухай хуулийн тодорхой зүйл, заалтын зөрчлийг ангилан бүртгэж байсан.¹⁰ Тус бүртгэлээс үзэхэд, 2015-2017 оны хооронд Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7, 6.7.8, 6.7.12, 6.7.14 дэх заалтуудыг

¹⁰ ЗГХЭГ. 2017.05.30-ний өдрийн ХЭГ/909 тоот албан бичгийн хавсралт. 2017 онд УИХ-ын гишүүн Н.Учралаас "Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх заалтын хэрэгжилтийн талаар" Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариу.

зөрчсөн 3955 зөрчил улсын хэмжээнд бүртгэгджээ. Үүнээс 25.4% (1003) нь аймгуудад, 74.6% (2952) нь нийслэлд гарсан байна.

Тамхины хяналтын тухай хуулийн 6.7 дугаар зүйлийн дараах заалтууд хамгийн түгээмэл зөрчигдсөн байна:

- 21 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулах (§6.7.7) –
 - улсын хэмжээнд 42 зөрчил бүртгэгдсэнээс 71.4% (30) нь аймгуудад гарсан байна;
- тамхийг ширхэглэн худалдах, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины үйлдвэрлэсэн боодлыг задалж буюу ороож худалдах (§6.7.8) –
 - улсын хэмжээнд 463 зөрчил бүртгэгдсэнээс 88.1% (408) нь нийслэлд гарсан байна;
- зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхи худалдах (§6.7.12) –
 - улсын хэмжээнд 3295 зөрчил бүртгэгдсэнээс 73.8% (2431) нь нийслэлд гарсан байна;
 - энэ төрлийн зөрчил нийт зөрчлийн дийлэнх буюу 83.3%-ийг эзэлж байна;
- ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдах (§6.7.14):
 - улсын хэмжээнд 155 зөрчил бүртгэгдсэнээс 65.2% (101) нь мөн нийслэлд гарсан байна.

Хүснэгт 3. Тамхитай холбоотой үйл ажиллагаанд тавих зарим шаардлагыг зөрчсөн тоо, эзлэх хувь (2015-2017 онд)

	Тамхины хяналтын тухай хуулийн				Нийт
	§6.7.7	§6.7.8	§6.7.12	§6.7.14	
Улсын дүн	42	463	3295	155	3955
Аймгуудын дүн	30	55	864	54	1003
-Улсын дүнд эзлэх хувь	71.4	11.9	26.2	34.8	25.4
Дүүргүүдийн дүн	12	408	2431	101	2952
-Улсын дүнд эзлэх хувь	28.6	88.1	73.8	65.2	74.6

Эх сурвалж: ЦЕГ, 2017.

Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэгт заасан тамхитай холбоотой үйл ажиллагааны бусад шаардлагын хэрэгжилтийг авч үзвэл:

- 6.7.15-т заасан шаардлагыг зөрчсөн тохиолдол 2015 онд орон нутгийн хэмжээнд нэг удаа бүртгэгдсэн байна;
- 6.7.6, 6.7.9, 6.7.10, 6.7.11, 6.7.13-д заасан шаардлагыг зөрчсөн тохиолдол 2015-2024 оны хооронд бүртгэгдээгүй байна.

2017-2024 онд ЦЕГ-т Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэгт заасан **тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагын** зөрчлүүдийг Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтын хүрээнд нэгтгэн бүртгэж байна. Гэвч зөрчлийн төрөл тус

бүрийг нарийвчлан ангилахгүй бүртгэж байгаа нь зөрчлийн давтамж, тархалтын нарийвчилсан дүн шинжилгээ хийх боломж хязгаарлагдмал байна.

2017-2024 онд Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэгт тусгасан тамхитай холбоотой үйл ажиллагаанд тавигдах шаардлагын зөрчил улсын хэмжээнд 2875 бүртгэгдсэн бөгөөд үүнээс 66.4% (1908) нь нийслэлд, 33.6% (966) нь аймгуудад гарсан байна. Тодруулбал:

- 2019 онд улсын хэмжээнд хамгийн олон буюу 582 зөрчил бүртгэгдсэн байна;
- 2024 онд зөрчлийн тоо 2019 онтой харьцуулахад 61%-иар буурсан ч нийслэлд илүүтэй давамгайлсан хэвээр байна;
- аймгуудад 2019 онд хамгийн олон буюу 173 зөрчил бүртгэгдсэн бол 2024 онд 86 болж 50%-иар буурсан байна;
- нийслэлд хамгийн олон буюу 409 зөрчил 2019 онд бүртгэгдсэн бол 2022 онд хамгийн бага буюу 74 зөрчил болж буурсан байна.

2.2.2.21 насанд хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр худалдуулах

Үнэлэх хэсэг:

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

6.7.Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд дараахь зүйлийг хориглоно:

/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтад 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

6.7.7.21 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулах;

/Энэ заалтад 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7 дахь хэсэгт 21 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, тэднээр тамхи худалдаалуулахыг хориглосон. Үүнийг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдийг Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 6.3.2 дахь хэсгийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Үүнд, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, хувь хүнийг 100 нэгжтэй, хуулийн этгээдийг 3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох арга хэмжээ багтана.

2015 оны 7 дугаар сараас 2017 оны 5 дугаар сарын хооронд цагдаагийн байгууллагад Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7 дахь хэсгийн зөрчил 42 бүртгэгдсэн бөгөөд үүнээс аймгуудад 30, нийслэлд 12 бүртгэгджээ.¹¹ Харин 2017 оны 7 дугаар сараас хойш энэ төрлийн зөрчлийн нарийвчилсан тоон мэдээлэл байхгүй. Учир нь уг зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн дагуу бусад зөрчлийн хамт нэгтгэн бүртгэж байгаа юм.

¹¹ Мөн тэнд.

А) 21 насанд хүрээгүй хүнд тамхи худалдах:

Монгол Улсад 21 нас хүрээгүй иргэнд тамхи худалдахыг Тамхины хяналтын тухай хуулиар хориглосон боловч хэрэгжилт нь хангалтгүй байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд, оюутан, сурагчдын тамхины хэрэглээ нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд худалдагчид насны хязгаарлалтыг тогтвортой мөрдөхгүй, хяналт шалгалт хангалтгүй хэвээр байна. Мөн тамхи худалддаг ААН-үүд оюутан, сурагчдад тамхи худалдах зөрчил нас ахих тусам нэмэгдэж байгааг судалгааны дүн харуулж байна (НСАУСИ ТББ, 2024, р. 23):


- *оюутан, сурагчдын тамхины хэрэглээ* –
 - 2019 оны судалгаагаар 13-15 насны сурагчдын 14% нь тамхи татаж байна (НСАУСИ ТББ, 2024, хууд. 9);
 - 2023 онд сурагчдын 11.1% нь сүүлийн 30 хоногт дор хаяж нэг удаа тамхи татсан гэж хариулсан нь 2013 оны 9.4%-тай харьцуулахад өссөн үзүүлэлт юм (НХХЯ, ЭМЯ, БШУЯ, 2024, хууд. 42);
 - 17-19 настай оюутнуудын 17%, 20-24 настай оюутнуудын 30.4% нь сүүлийн 7 хоногт тамхи, тамхин бүтээгдэхүүн хэрэглэсэн байна (Ерөнхийлөгчийн Тамгын газар, 2023, хууд. 43);
 - оюутнуудын тамхины хэрэглээнд нас, хүйс, цахим орчинд өнгөрүүлж буй хугацаа болон архины хэрэглээ зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. (Ерөнхийлөгчийн Тамгын газар, 2023, хууд. 73);
- *оюутан, сурагчдад тамхи худалдах зөрчил* –
 - 13-15 насны сурагчдын 75.6% нь насанд хүрээгүй тул тамхи худалдаж авч чадаагүй ч үлдсэн 24.4% нь ямар нэгэн байдлаар тамхи худалдан авсан байна (НСАУСИ ТББ, 2024, хууд. 22);
 - өөр нэгэн судалгаагаар, сурагчдын 38.2% нь насны хязгаарлалтаас болж татгалзсан хариу авсан боловч үлдсэн 61.8% нь тамхи худалдан авч чадсан байна (НХХЯ, ЭМЯ, БШУЯ, 2024, хууд. 44)
 - 16-24 насны залуучуудын 57.7%-д нь нас харгалзахгүйгээр тамхи худалдсан байна (НСАУСИ ТББ, 2024, хууд. 23);
 - судалгааны дүнгээс харахад, тамхи татдаг сурагчдын 82.9% нь хүнсний дэлгүүр, супермаркет, ТҮЦ-ээс тамхи худалдан авдаг бол 40.7% нь ямар нэгэн саадгүйгээр тамхи худалдан авч чадна гэж хариулжээ (ЭМЯ, НЭМҮТ, ДЭМБ, 2023, хууд. 6).

Санал асуулгын дүн:

Бүс нутгийн харьцуулалтаас үзэхэд, 21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах тохиолдол сумын төвд хамгийн өндөр (35.8%) “гардаг” гэсэн нь улсын дунджаас өндөр үзүүлэлттэй байна. Харин аймгийн төв (27.4%) болон нийслэлд (27.4%) харьцангуй бага хувьтай байгаа нь Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7 дахь хэсгийн хэрэгжилт, хяналт сумын төвд сул байгааг харуулж байна.

Мөн санал асуулгад оролцогчдын 10.5% нь энэ асуудлын талаар "хэлж мэдэхгүй" гэж хариулсан нь тамхи худалдах хяналтын бодлогын талаарх олон нийтийн мэдээлэл дутмаг байгааг илтгэж байна. Энэ нь хууль тогтоомжийн хэрэгжилт нь зөвхөн хяналт шалгалтаас гадна, олон нийтийн мэдлэг, мэдээллийн хүртээмжтэй байдал чухал үүрэгтэй болохыг харуулж байна.

Зураг 1. Санал асуулгын дүн: 21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах тохиолдол



Ярилцлагын үр дүн:

Хүнсний дэлгүүр, ТҮЦ-ийн худалдагчдын зарим нь 21 насанд хүрээгүй хүнд утаат тамхи худалдаггүй гэсэн бол зарим нь орлогоо нэмэгдүүлэх үүднээс тамхи нууцаар худалдах тохиолдол түгээмэл байдгийг хүлээн зөвшөөрсөн.

Шигтгээ.

- Ер нь хүнийг 21 нас хүрсэн эсэхийг шууд хараад мэдэхгүй шүү дээ. (Худалдагч, ТҮЦ-3)
- Ер нь зардаг. ТҮЦ-ээ ажиллуулж, амьдралаа залгуулж байгаа болохоор хүмүүс юм авахаар өгөөд л явуулна. (Худалдагч, ТҮЦ-4)

ЕБС-ийн нийгмийн ажилтнууд "зах, худалдааны төв, хүнсний дэлгүүрүүд оюутан, сурагчдад тамхи худалддаггүй гэдэг ч бодит байдал дээр ААН-үүд тэдэнд тамхи нууцаар худалддаг" гэж үзэж байна.

Шигтгээ.

- Хүүхдүүд тамхийг хаанаас олж аваад байна гэвэл дэлгүүр, ТҮЦ, хүнсний дэлгүүрүүдээс л олж авч байна шүү дээ. ТҮЦ-ээр амьдралаа залгуулдаг хүмүүсийн хувьд зарж болно, гэхдээ хуулиа дагаад 21 нас хүрээгүй хүүхдэд зарахгүй байх нь чухал байна. (Нийгмийн ажилтан, ЕБС-2)
- Тамхийг хаа сайгүй л зарж байна. Зах, худалдааны төвүүд нас харгалзахгүй л зарж байна. (Нийгмийн ажилтан, ЕБС-5)

Цагдаагийн албан хаагчийн ажиглалтаар, хяналтын камераар хүний насыг шууд тогтоох боломжгүй бөгөөд ТҮЦ, дэлгүүрүүдэд байнгын хяналт тавихад хүндрэлтэй байдаг. Үүний улмаас 21 нас хүрээгүй хүүхдүүд том хүнээр дамжуулан, хуурамч бичиг

баримт ашиглаж, эсхүл дэлгүүрийн хяналт сул байдлыг далимдуулан тамхи худалдан авч байна.

Шигтгээ.

- Цагдаагийн албан хаагч хяналтын камер шүүж үзэхэд тухайн хүн нь 21 насанд хүрч үү хүрээгүй юу гэдгийг нь шууд тогтоох боломжгүй болоод байна. Мөн албан хаагчид ТҮЦ, хүнсний дэлгүүр дээр байнга хяналт тавиад байх боломжгүй. Харин гудамж, талбай дээр 21 насанд хүрээгүй хүн тамхи татаад байна гэдэг чинь тамхи бас худалдаж аваад л байна гэсэн үг. (Цагдаагийн албан хаагч-2)
- Дэлгүүр бүр хяналтгүй зараад байдаггүй. 1-рт, 21 насанд хүрээгүй хүүхдүүд тамхи авахдаа том хүнээр дамжуулж тамхи авч байна. Тэд хэрэв өөрт нь зарахгүй байгаа бол гудамжинд таврсан хүнээсээ гуйгаад, мөнгө төгрөгийг нь өгөөд дамжуулж авч байна. 2-рт, хуурамч бичиг баримтаар, оноо худлаа хэлж авч байна, ахынхаа ч юм уу үнэмлэхийн зургийг харуулж байгаад тамхи худалдаж аваад байна. Зарим тохиолдолд дэлгүүр өөрсдөө хяналтаа тавихгүй бичиг баримтыг нь шалгахгүйгээр зарж байгаа тохиолдол өрөнхийдөө гарч байна. (Цагдаагийн албан хаагч-4)

Б) 21 насанд хүрээгүй хүнээр тамхи худалдуулах

“Өсвөр үе, залуу иргэдийн тамхины хэрэглээ, төрлүүд, никотин хамааралт байдал, нөлөөлж буй сэтгэц, нийгмийн зарим үзүүлэлт” судалгаанаас үзэхэд, тамхины никотин хувьд судалгаанд оролцогчид ажил, гэр, сургуулийн эргэн тойронд 100 метр дотор бүхий л төрлийн тамхи худалдан авах боломжтой байдаг (НСАУСИ ТББ, 2024, р. 47)

Санал асуулгын дүн:

Бүс нутгийн хэмжээнд тамхи худалдаалах зөрчлийн түвшин харилцан адилгүй байна. Тухайлбал, аймгийн төвд 21 нас хүрээгүй хүнд тамхи худалдаалах тохиолдол 42.9% нь "хааяа гардаг", 39.7% нь "гардаг" гэж хариулсан нь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Улаанбаатар хотод 29.1% нь "гардаг", 27.4% нь "хааяа гардаг" гэж хариулсан бол 25.6% нь "гардаггүй" гэж үзсэн байна. Харин сумын төвд "гардаггүй" (30.7%) болон "хааяа гардаг" (32.1%) гэсэн хариулсан байна.

Улсын дунджаар "хааяа гардаг" (30.9%) болон "гардаггүй" (28.3%) гэсэн үзүүлэлт давамгайлж байгаа нь зөрчлийн илрэл болон хяналтын түвшин бүс нутгаас хамааран ялгаатай байгааг харуулж байна.

Зураг 2. Санал асуулгын дүн: 21 нас хүрээгүй хүнээр тамхи худалдуулах тохиолдол



Ярилцлагын үр дүн:

Хүнсний дэлгүүр, ТҮЦ-ийн худалдагчид болон ЕБС-ийн нийгмийн ажилтнуудын үзэж байгаагаар ихэнх хүнсний дэлгүүр, ТҮЦ-ийн худалдагчид өөрсдөө ажиллуулдаг тул 21 насанд хүрээгүй хүнээр тамхи худалдуулах асуудал харьцангуй бага болсон.

Шигтгээ.

- Тэгж их гардаггүй шүү дээ. Яагаад гэвэл 21 хүрээгүй хүн дэлгүүрт ажиллаад байдаггүй. (Худалдагч, Хүнсний дэлгүүр-1)
- Ер нь насанд хүрсэн хүмүүс л сууж байгаа харагддаг. (Нийгмийн ажилтан, ЕБС-3)

Цагдаагийн албан хаагчдын ажиглалтаар, архи худалдаалдаг дэлгүүрүүд тамхи худалдаалахдаа насны хязгаарлалтыг мөрдөх шаардлагатай байдаг тул насанд хүрсэн хүмүүс ажиллаж, энэ төрлийн зөрчил харьцангуй бага бүртгэгдэж байна. Харин гэр бүлийн жижиг дэлгүүрүүдэд хүүхэд, залуучууд худалдаа эрхэлдэг нь эцэг, эх, иргэдийн хуулийн мэдлэг дутмаг байгаатай холбоотойгоор зөрчил гарах нөхцөл бүрдүүлж байна.

Шигтгээ.

- Архи зардаг дэлгүүрүүдэд бас тамхи зарж байгаа. Архи борлуулахад мөн 21-ээс дээш нас гээд заагаад өгчихсөн байдаг учраас тэр дэлгүүрт насанд насанд хүрсэн хүмүүс суудаг тул энэ төрлийн зөрчил гараагүй байна. (Цагдаагийн албан хаагч-4)
- Мөн л гардаг зөрчил. Ихэвчлэн гэрийнхээ ажиллуулдаг дэлгүүрт суугаад худалдаа хийж байгаа хүүхэд, залуучууд байдаг. Энэ нь мөн л эцэг, эхийн, иргэдийн хуулийн мэдлэг дутмаг байгаатай л холбоотой. (Цагдаагийн албан хаагч-5)

2.2.3. Тамхийг ширхэглэн худалдах

Үнэлэх хэсэг:

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

6.7. Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд дараахь зүйлийг хориглоно:

/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтад 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

6.7.8. тамхийг ширхэглэн худалдах, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины үйлдвэрлэсэн боодлыг задалж буюу ороож худалдах;

“Өсвөр үе, залуучуудын тамхины хэрэглээ, төрлүүд, никотин хамааралт байдал, нөлөөлж буй сэтгэц, нийгмийн зарим үзэгдлүүд” судалгааны дүнгээс харахад, 13-15 насны сурагчдын 64.7% нь тамхийг хайрцгаар, 17.6% нь ширхгээр худалдан авсан бол өөрөө тамхи ороож хэрэглэсэн тохиолдол нэг бүртгэгджээ. Харин 16-24 насны залуусын 56.3% нь хайрцгаар, 36.1% нь ширхгээр, 5.1% нь боодлоор, 2.5% нь өөрөө ороож хэрэглэсэн байна (НСАУСИ ТББ, 2024, хууд. 22-23).

Эдгээр үр дүн нь өсвөр үе, залуучуудын дунд тамхийг ширхэглэн худалдаж авах хандлага түгээмэл байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь хяналт сул, насанд хүрээгүй иргэд тамхийг хялбархан хандаж авах боломжтой байгааг илтгэж байна (НСАУСИ ТББ, 2024, хууд. 22-23).

Санал асуулгын дүн:

Улсын хэмжээнд судалгаанд оролцогчдын 48.1% нь утаат тамхийг ширхэглэн худалдах тохиолдол “гардаггүй” гэж хариулсан бөгөөд энэ үзүүлэлт сумын төвд хамгийн өндөр буюу 62.7%, аймгийн төвд 42.9%, харин Улаанбаатар хотод хамгийн бага буюу 22.2% байна.

Харин эсрэгээрээ, Улаанбаатар хотод ийм зөрчил “гардаг” гэсэн хариулт хамгийн өндөр буюу 41.0%, аймгийн төвд 28.6% байгаа нь улсын дунджаас өндөр (23.9%) байна. Харин сумын төвд энэ үзүүлэлт хамгийн бага (14.2%) “гардаг” гэсэн нь утаат тамхины ширхэглэн худалдаах явдал бүс нутгийн түвшинд харилцан адилгүй байгааг илтгэж байна.

Зураг 3. Санал асуулгын дүн: Утаат тамхийг ширхэглэх худалдах тохиолдол




Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины боодлыг задалж, ороож худалдаалах зөрчил аймгийн төвд хамгийн өндөр түвшинд байна. Судалгаанд оролцогчдын 42.9% нь “хааяа гардаг”, 35.7% “гардаг” гэж хариулсан нь улсын дунджаас (30.9%, 25.4%) өндөр үзүүлэлттэй байна.

Харин “гардаггүй” гэсэн хариулт сумын төвд хамгийн өндөр (30.7%), улсын дунджаар 28.3%, Улаанбаатар хотод 25.6%, аймгийн төвд хамгийн бага (14.3%) байна.

Мөн “хэлж мэдэхгүй” гэсэн хариултын хувь 7.1-17.9% хооронд хэлбэлзэж, хамгийн өндөр нь Улаанбаатар хотод, хамгийн бага нь аймгийн төвд байна. Энэ нь нийслэлд олон нийтийн мэдээлэл, ойлголт харьцангуй сул байгааг илтгэж байна.

Зураг 4. Санал асуулгын дүн: Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины үйлдвэрлэсэн боодлыг задалж буюу ороож худалдаалах тохиолдол



Ярилцлагын үр дүн:

Хүнсний дэлгүүр, ТҮЦ-ийн худалдагчид орлогоо бодоод тамхийг ширхэглэн худалдаж байгаагаа хүлээн зөвшөөрсөн.

Шигтгээ.

- Зарим газар орлогоо бодоод зардаг. (Худалдагч, Хүнсний дэлгүүр-1)

ЕБС-ийн нийгмийн ажилтнуудын хэлснээр төвийн сургуулиас 500 метрийн дотор тамхи ширхэглэн худалддаггүй, харин хотын төвөөс холдох тусам ширхэглэн худалдаалах явдал их байдаг ажээ. Тухайлбал, хүнсний дэлгүүр, ТҮЦ, автобусны буудал дээр байрладаг ТҮЦ-үүд тамхийг нууцаар ширхэглэн худалдах явдал түгээмэл байгааг дурдсан.

Шигтгээ.

- ЕБС-ийн хүүхдүүд чинь ширхгээр л авна. Тэд нар өөрсдийнхөө эдийн засагт тохируулж байна. Хоёрт ээж, аавдаа баригдахгүй тулд ширхэглэж авдаг. (Нийгмийн ажилтан, ЕБС-3)
- Хүүхдүүд татаад байна гэдэг чинь зарж байгаа газар нь өгөөд л байна гэсэн үг. Бид үе үе сургуулийн ойр орчмын гадаад, дотоод орчны урьдчилан сэргийлэх үнэлгээ хийгээд явахад тамхи ширхэглэн зарж байгаа дэлгүүрүүд маш их байдаг. Яг үнэндээ үйлдэл дээр нь л харахгүй бол зарж байгаа нь ч тэр, авч байгаа нь ч тэр хэлэхгүй. (Нийгмийн ажилтан, ЕБС-5)

Цагдаагийн албан хаагчдын хариултуудыг нэгтгэн дүгнэхэд, сүүлийн үед тамхи ширхэглэн худалдах зөрчил буурсан ч, амьжиргаагаа залгуулах зорилгоор, ялангуяа ахмад настнууд тамхи нууцаар ширхэглэн худалдах тохиолдол хэвээр байна. Энэ төрлийн зөрчил ихэвчлэн ТҮЦ, автобусны буудал, үйлчилгээний төвүүдийн орчимд түгээмэл байдаг.

Нэг талаас, худалдагчид орлогоо нэмэгдүүлэхийн тулд тамхи ширхэглэн худалдаж байгаа бол, нөгөө талаас, худалдан авагчид хайрцагаар авах санхүүгийн

боломжгүй байдал, цаг хугацааны хязгаарлалт, хуулийн мэдлэг дутмаг байдлаас шалтгаалан тамхи ширхэглэн худалдан авч байна.

Шигтгээ.

- ТҮЦ-ийн иргэд амжиргаагаа бодоод, ашгаа бодоод тамхиыг ширхгээр нь зарж байна. (Цагдаагийн албан хаагч-2)
- Ширхэглэн худалдах асуудал бол ерөнхийдөө ТҮЦ-үүд дээр, автобусны буудал дээр байдаг. Ширхэглэн худалдах гэдэг нь төлбөрийн боломжоос шалтгаалж байна, бүтэн хайрцагаар нь авах боломжгүй тохиолдолд ширхгээр худалдаж авч байна. (Цагдаагийн албан хаагч-5)

2.2.4.Зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхи худалдах

Үнэлэх хэсэг:

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

6.7.Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд дараахь зүйлийг хориглоно:

/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтад 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

6.7.12.зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхи худалдах.

/Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/

Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 8.2.11-д **тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг** тухайн сум, дүүргийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч олгохоор заасан.

2017 онд УИХ-ын гишүүн Н.Учралаас Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариу албан бичигт дурдсанаар, 2017 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 4059 ААН тамхи худалдах үйл ажиллагаа эрхэлж байжээ (ЕБС-иас 500 метрээс гадна). Нэгдсэн дүнгээс харахад, нэг сургууль тойроод дунджаар 6.3 ААН тамхи худалдах үйл ажиллагаа эрхэлж байжээ.¹²

2015-2017 оны хооронд Тамхины хяналтын тухай хуулийн тодорхой зүйл, заалтын зөрчлийг ангилан бүртгэсэн мэдээллээс үзэхэд, зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхи худалдах зөрчил улсын хэмжээнд нийт 3295 тохиолдол бүртгэгдсэн байна.

Энэ үзүүлэлт нь 2015-2017 онд улсын хэмжээнд Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7, 6.7.8, 6.7.12, 6.7.14 дэх заалтыг зөрчсөн нийт 3955 зөрчлийн 83%-ийг эзэлж, хамгийн өндөр хувьтай зөрчилд тооцогдож байна.

¹² Мөн тэнд.

Мөн зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхи худалдсан нийт 3295 зөрчлийн 73.8% (2431) нь Улаанбаатар хотод бүргэгдсэн¹³ нь энэ төрлийн зөрчил нийслэлд илүү түгээмэл байгааг харуулж байна.


Санал асуулгын дүн:

Судалгааны дүнгээс харахад, улсын хэмжээнд 42.0% нь зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхи худалдах тохиолдол “гардаг” гэж хариулсан нь энэ төрлийн зөрчил Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд түгээмэл байгааг харуулж байна. Тухайлбал, аймгийн төвд 42.9%, сумын төвд 42.5%, Улаанбаатар хот 41.0% байна.

“Хааяа гардаг” гэсэн хариулт Улаанбаатар (31.6%), сумын төвд (31.1%) хамгийн өндөр, харин аймгийн төвд (14.3%) хамгийн бага байна.

“Гардаггүй” гэсэн хариулт аймгийн төвд хамгийн өндөр (35.7%), харин нийслэлд (19.7%) хамгийн бага үзүүлэлттэй байгаа нь хууль зөрчсөн худалдаа нийслэлд илүү түгээмэл байгааг илтгэж байна.

Зураг 5. Санал асуулгын дүн: Утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах тохиолдол



Ярилцлагын үр дүн:

Хүнсний дэлгүүр, ТҮЦ-ийн худалдагч нарын үзэж байгаагаар, тамхины худалдаанд тавих хяналт сул байдаг тул зөвшөөрөлгүй газруудад нууцаар худалдсаар байгаа бөгөөд тэр дундаа шөнө, оройн цагаар ямар ч хяналт байдаггүй байна.

Шигтгээ.

- Энэ зохицуулалт нэг их хэрэгждэггүй байхаа. Нууж хаагаад л зараад байх шиг байдаг. (Худалдагч, ТҮЦ-4)

ЕБС-ийн нийгмийн ажилтнуудын ажиглалтаар, байрны дунд байрладаг хүнсний жижиг дэлгүүр, ТҮЦ, худалдааны төвүүд бол тамхи худалдаалдаг гол цэгүүд бөгөөд хуулийн энэ заалт бодит байдал дээр хэрэгжихгүй байна.

¹³ Мөн тэнд.

Шигтгээ.

- Энэ хэвиар ТҮЦ-үүд бол гайгүй. СУ, ойрхон Марс худалдааны төв болон хүнсний дэлгүүрүүд 200 гаруй мөрт байдаг юм. Бид нар энэ дээр нэлээн хяналт тавиад албан тоотууд жил болгон өгөөд хамтраад явчихдаг. Бид нар уг нь тийм шаардлага тавих эрхгүй ч гэсэн захирлын албан тоот бичиг өгч хамтарч ажилладаг. (Нийгмийн ажилтан, ЕБС-1)
- Сургуулийн хажуугийн дэлгүүрүүд орлогоо бодоод нууцаар зардаг. Ил өлгөхгүйгээр нууцаар лангуун дороосоо гаргаж ирж зардаг. Манай ойрхон Бөмбөгөр худалдааны төв байдаг болохоор хүүхдүүд тэндээс бас авчихдаг. (Нийгмийн ажилтан, ЕБС-4)

Цагдаагийн албан хаагчдын хариултуудыг нэгтгэн үзэхэд, тамхи зөвшөөрөлгүй худалдах зөрчил сүүлийн жилүүдэд багассан ч өндөр настнууд ихэвчлэн энэ төрлийн зөрчлийг гаргадаг. Автобусны буудал, ТҮЦ, үйлчилгээний төвүүдийн орчинд ийм зөрчил ихэвчлэн илэрдэг.

Шигтгээ.

- Зөвшөөрөгдсөн цэг нь Улаанбаатар хотод 30% байдаг гэж үзвэл манайд бараг 100% зөвшөөрөл байхгүй. Бүгд л нууцаар зардаг, хадгалдаг. Жишээ нь ТҮЦ-д зөвшөөрөл гаргахад больчихсон, тусгай зөвшөөрөл байхгүй, үйл ажиллагааны зөвшөөрөл гэж байхгүй. Тийм учраас бүгд тамхи нууцаар зараад байдаг юм уу даа. Яагаад нууцаар зараад байгаа юм гэж асуухаар тэд амь зуудаг гол орлого гэдэг юм. (Цагдаагийн албан хаагч-1)
- Сургуулиас 500 метрийн дотор ихэвчлэн хүнсний дэлгүүр, ТҮЦ тамхи зараад байна. Эд нар дээр дандаа тамхийг нууцаар зарж байгаад баригдаж, торгуулийн арга хэмжээ авагдаж байдаг. Тэгээд дэлгүүрүүд юу гэж яриад байна вэ гэвэл бид тамхи зарахгүй бол орлогогүй байна, тийм болохоор бид торгуулаар ч хамаагүй тамхиа нуугаад ч хамаагүй зарахаас өөр аргагүй байна. (Цагдаагийн албан хаагч-4)
- Жишээлбэл, хэдэн жилийн өмнө сургууль, цэцэрлэгийн орчим 500 метрийн радиуст тамхи худалдаалахыг хориглосон. Гэхдээ сургуулиуд шинээр баригдахад өмнө нь зөвшөөрөлтэй байсан дэлгүүрүүд үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байдаг. Сургууль баригдсан гэж үндэслэн тухайн ААН-ийн зөвшөөрлийг цуцалж байгаа тохиолдол гараагүй. Энэ нь хууль, эрх зүйн уялдаа холбоогүй байгаагийн нэг илрэл гэж харж байна. (Цагдаагийн албан хаагч-4)

Судалгааны дүнгээс үзэхэд, зөвшөөрөлгүй цэгт тамхи худалдах зөрчлийн түвшин нь 2015-2017 оны цагдаагийн байгууллагын бүртгэлд өндөр байсны зэрэгцээ, энэхүү үнэлгээний хүрээнд явуулсан санал асуулгын дүнгээр ч өндөр үзүүлэлттэй хэвээр байна.

Мөн ярилцлагын үр дүнгээс үзэхэд, нэг талаас ААН, худалдаа эрхлэгчид ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд, хувь хүн, өндөр настнууд амьжиргаагаа залгуулахын тулд зөвшөөрөлгүй газарт тамхи худалдаалсаар байгаа бол, нөгөө талаас тамхины эрэлт хэрэгцээ буурахгүй хэвээр байгаагаас энэ төрлийн зөрчил тасрахгүй байна.

2.2.5.Сургуулийн ойр орчинд тамхи худалдах

Үнэлэх хэсэг:

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

6.7.Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд дараахь зүйлийг хориглоно:

/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтад 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

6.7.14.ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдах;

/Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/

2012 оны 10 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувийн хэргээс үзэхэд, энэ заалтыг хэлэлцүүлгийн явцад шинээр нэмж оруулсан (УИХ-ын Тамгын газрын архив, 2012).

Тус заалтыг "...бие бялдар, оюун санааны өсөлт, хөгжлийн онцлог үедээ байгаа хүүхэд, өсвөр үеийнхнийг хорт хавдар, зүрх судасны өвчин, амьсгалын замын өвчлөл зэрэг 400 гаруй өвчний шалтгаан болсон тамхины хорт утаанд нэрвэгдэх хор хөнөөлөөс сэргийлэх, суралцагчдын эрүүл мэндэд ээлтэй, цэвэр цэмцгэр эрүүл орчныг сургуулийн орчинд бүрдүүлэх, хүүхэд, өсвөр үеийнхнийг тамхины худалдан авагч болж, донтохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх..." зорилготой хуульд нэмж оруулсан байна.¹⁴

УИХ-ын гишүүн Н.Учралаас Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариу албан бичгийн хавсралтаар ирүүлсэн ЦЕГ-ын албан бичигт "Зарим сумын төвийн нутаг дэвсгэр бүхэлдээ ЕБС-ийн 500 метр радиуст багтаж, тамхи худалдаалах зөвшөөрөл олгогддоггүй нь бодит амьдралд нийцэхгүй, тамхины худалдаа далд байдалд орох нөхцөлийг бүрдүүлж, иргэд цагдаагийн ажилтны хооронд үл ойлголцол үүсэх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна." гэж дурджээ.¹⁵

Мөн албан бичгийн хавсралтаар ирүүлсэн Мэргэжлийн хяналтын байгууллагын 2016 онд хийсэн тандалт, судалгаанаас үзэхэд, улсын хэмжээнд давхардсан тоогоор нийт 116 зөрчил илэрсэн ба үүний 33 нь сургуулиас 500 метрийн дотор болон тусгай зөвшөөрөлгүйгээр тамхин бүтээгдэхүүн худалдсан зөрчил эзэлсэн байна.¹⁶

Судалгаанаас үзэхэд, оюутан, сурагчдын тамхины хэрэглээ өсөх хандлагатай, худалдагчид насны хязгаарлалтыг тогтвортой мөрдөхгүйн дээр хяналт шалгалт дутмаг байна. Мөн тамхи худалддаг ААН-үүдийн зүгээс оюутан, сурагчдад тамхи худалдах зөрчил нас ахих тусам нэмэгддэг нь судалгаагаар нотлогдож байна (НСАУСИ ТББ, 2024, хууд. 23).

(Дэлгэрэнгүйг Үнэлгээний тайлангийн 19 дүгээр хуудаснаас үзнэ үү.)

¹⁴ Мөн тэнд.

¹⁵ Мөн тэнд.


¹⁶ Мөн тэнд.

Санал асуулгын дүн:

ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн дотор утаат тамхи худалдах тохиолдол “гардаггүй” гэж хариулсан иргэдийн хувь аймгийн төвд хамгийн өндөр (42.9%), харин сумын төвд хамгийн бага (31.6%) байна.

Энэ төрлийн зөрчил “гардаг” гэсэн хариултын хувь сумын төвд хамгийн өндөр (35.8%), харин аймгийн төвд хамгийн бага (28.6%) байна. “Хааяа гардаг” гэсэн хариулт Улаанбаатар хотод хамгийн өндөр (28.2%), аймгийн төвд хамгийн бага (14.3%) байна.

Зураг 6. Санал асуулгын дүн: ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн дотор утаат тамхи худалдах тохиолдол



Санал асуулгаар “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн дотор утаат тамхи худалдах зөрчил яагаад гардаг?” талаар тодруулж асуухад 40.2% нь тамхи худалдаж байгаа цэг нь сургуулиас 500 метрийн дотор байдаг гэж хариулсан бол 36.7% нь хууль хэрэгждэггүй, хяналт, хариуцлагын асуудал сул байна гэж хариулсан байна.

Хүснэгт 4. Санал асуулгын дүн: ЕБС-ийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн дотор утаат тамхи худалдах зөрчил гардаг шалтгаан

№	Шалтгаан	Улсын дундаж
1	ЕБС-ийн орчинд байрладаг учраас	40.2%
2	Хууль ер нь хэрэгждэггүй	18.8%
3	Хяналт, хариуцлага сул	17.9%
4	Ашиг олох зорилготой	9.8%
5	Зөвшөөрөлтэй учир	4.5%
6	Хэрэглэгч байгаа учир	2.7%
7	Шинэ нөхцөл үүссэн	2.7%
8	Хуулийг сайжруулах шаардлагатай	1.8%
9	Иргэдийн хуулийн мэдлэг тааруу	0.9%
10	Бусад	0.9%

Ярилцлагын үр дүн:

Хүнсний дэлгүүр, ТҮЦ-ийн худалдагчдын үзэж байгаагаар, зарим газарт цагдаагийн байгууллага хяналт тавьдаг ч нийтэд нь авч үзвэл хяналт хангалтгүй байна.

Шигтгээ.

- Хориглосон болохоор зардаггүй. (Худалдагч, Хүнсний дэлгүүр-1)
- Гайгүй байгаа. Яг тийм сургуулийн ойр газруудад тамхи зардаггүй шүү дээ. (Худалдагч, ТҮЦ-5)

ЕБС-ийн нийгмийн ажилтнуудын үзэж байгаагаар хотын зохион байгуулалт, төлөвлөлтөөс шалтгаалан хуульд заасан 500 метрийн хязгаарлалт бодит байдал дээр хэрэгжих боломжгүй байна. Тухайлбал, зах, худалдааны төвүүд сургуулиас 100 метрийн дотор үйл ажиллагаа явуулж байгаа нь уг заалтыг амьдралд нийцэхгүй болгож байна.

Шигтгээ.

- Хүүхдэд тамхи зарах бол их байна. Жишээлбэл, энэ түцүүд, автобусны буудлуудын жижиг дэлгүүр байна. Сургуулийн урд 2 буудал байна. Одоо автобусны буудал нь эндээс хэдхэн метрт байна. 300 метр хүрэхгүй. Тэгэхлээр нөгөө 500 метр гэдэг бол ерөөсөө л болохгүй байгаан. Гэхдээ 500 метр байлаа гээд татахаа хүрэл хавна ч байсан олоод л татна шүү дээ. (Нийгмийн ажилтан, ЕБС-2)
- Тэгэхлээр 500 метр дотор бол худлаа байна. Бүх газар л 500 метр дотор байгаад байна бүгд л зарж байна шүү дээ. Одоо ингээд л 500 метр явахгүй 200 метр яваад л бөмбөгөр худалдааны төвд л гэхэд худалдаж байна. (Нийгмийн ажилтан, ЕБС-4)

Цагдаагийн албан хаагчид мөн л сургуулийн 500 метрийн радиуст тамхи худалдаахыг хориглосон заалт хэрэгжихэд хүндрэлтэй бөгөөд энэ нь зарим талаараа хот төлөвлөлттэй холбоотой гэж үзсэн байна. Тухайлбал, зарим хорооны нутаг дэвсгэр ойролцоогоор 4 км² байдаг ч тус хороонд 3-4 сургууль байрлаж байгаа нь уг хязгаарлалтыг амьдралд нийцэхгүй болгож байна. Өөр нэг асуудал бол зөвшөөрөлтэй дэлгүүрийн орчинд сургууль шинээр ашиглалтад орсон, эсхүл зөвшөөрөл авсан дэлгүүр сургуулиас хязгаарласан бүсэд нүүж ирсэн бол нөгөө зөвшөөрлийг хэрхэн зохицуулах талаар эрх зүйн тодорхой зохицуулалт байхгүй байна. Энэ нь хууль, эрх зүйн уялдаа холбоо хангалтгүй байгааг харуулж байна.

Шигтгээ.

- Сургуулийн орчим 500 метрийн радиуст тамхи худалдаахыг хориглодог. Энэ заалт хэрэгжихэд хүндрэлтэй. Манай хорооны нутаг дэвсгэрийн хэмжээ хаашаа хаашаага 2 км ч хүрэхгүй, гэтэл манай хороонд 4, 5 сургууль байдаг, тэгээд зөвшөөрөлтэй дэлгүүр бараг байхгүй. Дэлгүүрүүд бүгд нууцаар зарж байна. Биднийг очиход тамхи байхгүй, харин гэнэдүүлээд ч юм уу, шалгаад үзвэл тамхи байж байдаг. Жишээ нь, дэлгүүрийн хойд талын өрөөнд тамхи байгаа тохиолдолд тамхийг зарсан гэж үзэхэд бас хэцүү. Хадгалж байгаа тамхийг нь бид нар аваад хуулийн дагуу арга хэмжээ авъя гэхэд бас өөр. Баримт нь тамхин дээр угаасаа гарахгүй учраас зарсан гэж нотлох боломжгүй. Тэр 500 метрээс жишээ нь 100 метр болговол илүү хэрэгжих боломжтой. (Цагдаагийн албан хаагч-1)

Шигтгээ.

- Сургуулиас 500 метрийн дотор тамхи худалдахыг хориглосон цэгүүдэд л, тийм бүсэд байршиж байгаа хүнсний дэлгүүр, ТҮЦ л тамхийг нууж зарж байна. Яагаад зараад байгаа гэхээр нэгөө л орлоготой холбоотой байдэг. (Цэгдвээгийн албан хаагч-4)
- Хэдэн жилийн өмнө сургуулийн орчим 500 метрийн радиуст тамхи худалдаалахыг хориглосон. Гэхдээ сургуулиуд шинээр баригдахад өмнө нь зөвшөөрөлтэй байсан дэлгүүрүүд үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байдаг. Сургууль баригдсан гэж үндэслэн тухайн ААН-ийн зөвшөөрлийг цуцалж байгаа тохиолдол гараагүй. Энэ нь хууль, эрх зүйн уялдаа холбоогүй байгаагийн нэг илрэл гэж харж байна. (Цэгдвээгийн албан хаагч-5)

2.2.6.Хууль зөрчигчид тооцох хариуцлагын тохиромжтой эсэх үнэлгээ

Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 6.3.2 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт утаат тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 3000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Санал асуулгын дүн:

Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн түгээмэл зөрчил, хуулийг хэрэгжүүлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор зорилгоор авсан санал асуулгын үеэр Зөрчлийн тухай хуулийн 6.3.2-т заасан утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд тооцох хариуцлагын зохицуулалтын талаар асуусан асуултын хариултуудыг авч үзье.

А) Хувь хүнд тооцох хариуцлагын тохиромжтой эсэх үнэлгээ

Судалгаанд оролцогчдын 46.4% нь торгуулийн хэмжээг тохиромжтой гэж үзсэн байна. Улаанбаатар хотын оролцогчдын 47.0% нь мөн адил тохиромжтой гэж үзсэн бол 23.1% нь торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай гэж хариулсан нь аймаг, сумын төвийн оролцогчидтой харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Эдгээр үр дүн нь нийслэлд торгуулийн үр нөлөө хангалтгүй байгааг илтгэж байна. .

Зураг 7. Санал асуулгын дүн: Хувь хүнд тооцох хариуцлагын тохиромжтой эсэх үнэлгээ



“Хэлж мэдэхгүй” гэсэн хариултын хувь аймгийн төвд хамгийн өндөр (21.4%) байгаа нь тус бүсэд мэдээллийн хүртээмж сул байгааг харуулж болзошгүй.

Б) Хуулийн этгээдэд тооцох хариуцлагын тохиромжтой эсэх үнэлгээ

Судалгаанд оролцогчдын 45.5% нь торгуулийн хэмжээг тохиромжтой гэж үзсэн байна. Аймгийн төвд 28.6% нь энэ хэмжээг тохиромжтой гэж үзсэн нь бусад оролцогчдоос хамгийн бага хувь юм. Аймгийн төвийн иргэдийн дийлэнх нь (71.4%) торгуулийн хэмжээнд ямар нэгэн өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзэж байгаа нь анхаарал татахуйц үзүүлэлт юм.

Торгуулийн хэмжээг нэмэгдүүлэхийг дэмжигчид аймгийн төвд 21.4%, Улаанбаатарт 14.5%, байгаа нь хууль зөрчсөн байгууллагуудад ногдуулах хариуцлагыг чангатгах хэрэгтэй гэж үзэж буй иргэдийн санаа бодлыг илэрхийлж байна.

Зарим иргэд зөвхөн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээг илүү оновчтой гэж үзэж байгаа нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд торгуулийн үр нөлөө хэрхэн нөлөөлж байгааг дахин нягтлан судлах шаардлагатайг харуулж байна.

Зураг 8. Санал асуулгын дүн: Хуулийн этгээдэд тооцох хариуцлагын тохиромжтой эсэх үнэлгээ



Ярилцлагын үр дүн:

Хүнсний дэлгүүр, ТҮЦ-ийн худалдагчид торгуулийн хэмжээг өндөр байна, ялангуяа бөгөөд уян хатан зохицуулах хэрэгтэй гэж үзсэн байна.

Шигтгээ.

- Яг одоо бол тохирохгүй байгаа, хүмүүс хая сайгүй л тамхи татаад явж байдаг. Зарим нь торгуулна, зарим нь боломжгүй. Тэгэхээр хэнийг нь торгоод, хэнийг нь үлдээх вэ дээ? (Худалдагч, Хүнсний дэлгүүр-2)
- 300 мянга гэдэг чинь их мөнгө шүү дээ. Яг хэд байвал болохыг мэдэхгүй, гэхдээ 300 мянга нь бол өндөр байна. 3 сая төгрөгөөр торгох арай л үнэтэй байна, 300 мянга л байвал болох байх. (Худалдагч, ТҮЦ-1)
- Тохиромжгүй. Өнөөдөр гэр хорооллын ТҮЦ тамхи ширхгээр зарж байж л орлогоо олж байна. Хэрэв заруулахгүй л гэдэг хууль байгаа юм чинь заруулахгүй л байх ёстой. (Худалдагч, ТҮЦ-3)

Нийгмийн ажилтнуудын хувьд торгуулийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл хангалтгүй байгааг онцолсон. Түүнчлэн, тэд хүүхдүүдийг тамхинаас урьдчилан сэргийлэхэд илүүтэй анхаарах шаардлагатайг дурдсан бөгөөд хууль бус худалдааг таслан зогсоохын тулд илүү хатуу бодлого хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Шигтгээ.

- Сайн мэдэхгүй байна. Ер нь зарж байвал хуравдаг байх шүү. (Нийгмийн ажилтан, ЕБС-1)
- Манай энэ чинь бас хотын төв бүс шүү дээ тэ? Өчнөөн баар сав, хоолны газрууд гээд л бодвол тэр дотроо тамхи зардаг л юм байна лээ. Бидний хувьд хүүхдүүдийг тамхи татуулахгүй байхад л чиглэж ажилладаг. (Нийгмийн ажилтан, ЕБС-2)
- Тамхийг нууж худалддаг, хурааж авч байгаагүй. (Нийгмийн ажилтан, ЕБС-3)

Цагдаагийн албан хаагчдын үзэж байгаагаар, хуульд заасан торгуулийн хэмжээ одоогийн байдлаар тохиромжтой боловч, цаашид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан өөрчлөх боломжтой гэж үзэж байна.

Тэдэнд тулгарч байгаа томоохон хүндрэл нь хууль бусаар олсон орлогыг нотлох асуудал бөгөөд энэ нь дансны гүйлгээний ил тод байдал, татварын баримттай холбоотой. Мөн зөрчлийн шалган шийдвэрлэх үйл явцын хүрээнд зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах нь хууль хэрэгжүүлэх гол механизм болох ёстой ч, сүүлийн үед энэхүү зохицуулалт практик дээр бүрэн хэрэгжихгүй байгаа нь ажиглагдаж байна.

Шигтгээ.

- Одоогийн байдлаар энэ хариуцлагын хэмжээ нь тохиромжтой гэж бодож байна. Харин цаашид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан өөрчлөх боломжтой. (Цагдаагийн албан хаагч-1)
- Хүндрэлтэй асуудал нь олсон орлогыг нотлох явдал. Тэд дан ганц тамхиа зараад байдаггүй, бусад бараагаа бас зардаг. Тэгэхээр нөгөө хүний дансыг нь, байгууллагын дансыг нь шалгаад үзээд ч нотолж чадахгүй. (Цагдаагийн албан хаагч-3)
- Эд хөрөнгийг хураах явдал сүүлийн үед ховор болсон. Олсон орлогыг нь, мөнгө төгрөгийг нь хураах тохиолдол бараг байхгүй болсон. (Цагдаагийн албан хаагч-6)

2.3.Зарим газар тамхи татахыг хориглосон заалт, түүний хэрэгжилт

Үнэлэх хэсэг:

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН §9.1.

9 дүгээр зүйл.Утаат тамхи татахыг хориглох

9.1.Дараах газар утаат тамхи татахыг хориглоно:

9.1.1.бүх төрлийн нийтийн тээврийн хэрэгсэл;

9.1.2.олон нийтийн үзвэр, үйлчилгээний газар;

9.1.3.шатахуун түгээгүүрийн газар, шатах, тослох, тэсэрч, дэлбэрэх бодис, материалын үйлдвэр, түүний нөөцийн агуулах;

9.1.4.зорчигч тээврийн буудал, зочид буудлын нийтийн танхим, тамхи татахыг хориглосон өрөө;

9.1.5.нийтийн хоол, худалдаа, баар, цэнгээний газрын утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгээс бусад орчин;

/Энэ заалтыг 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

9.1.6.аж ахуйн нэгж, байгууллагын утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгээс бусад ажлын байрын дотоод орчин;

/Энэ заалтыг 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

9.1.7.агаарын хөлөг, зорчигч тээврийн галт тэрэг;

9.1.8.цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувилал, тэдгээрийн гаднах орчин, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орц, шат, цахилгаан шат, хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн.

/Энэ заалтыг 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2.3.1.Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн тоо

2015-2024 оны хооронд Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэгт утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан нийт 1361 зөрчил бүртгэгдсэн бөгөөд үүнээс 37.0% (503 зөрчил) нь аймгуудад, 62.2% (697 зөрчил) нь нийслэлд бүртгэгдсэн байна. Улсын хэмжээнд:

- 2015-2017 онд 241 зөрчил бүртгэгдсэнээс 39.9% (89) нь аймгуудад, 63.1% (152) нь нийслэлд гарсан байна;
- 2017-2024 онд 1120 зөрчил бүртгэгдсэнээс 37.0% (414) нь аймгуудад, 62.2% (697) нь буюу мөн л дийлэнх нь нийслэлд гарчээ.

2015-2024 оны онцлох үзүүлэлтүүд:

- 2019 онд хамгийн олон буюу 299 зөрчил бүртгэгдсэн бөгөөд үүнээс 72.2% (216) нь нийслэлд, 27.4% (82) нь аймгуудад гарсан байна;
- 2019 оноос хойш зөрчлийн тоо тогтвортой буурч, 2024 онд хамгийн бага түвшинд буюу 33 болж, 2019 онтой харьцуулахад 90%-иар буурсан байна;
- аймгуудын зөрчлийн эзлэх хувь 2018 онд хамгийн өндөр буюу 61.7%-д хүрч, түүнээс хойш тогтмол 36%-иас бага үзүүлэлттэй байна;

- дүүргүүдийн зөрчлийн эзлэх хувь 2019 оноос хойш тогтмол 60%-иас дээш байсан бөгөөд 2024 онд хамгийн өндөр буюу 88%-д хүрсэн байна.

Хүснэгт 5. Утаат тамхи татахыг хориглосон газар тамхи татсан зөрчлийн тоо, эзлэх хувь (2015-2024 онд)

	2015-2017 онд				2017-2024 онд								
	2015	2016	2017	Нийт	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Нийт
Улсын дүн	57	143	41	241	160	183	299	118	148	114	65	33	1120
Аймгуудын дүн	11	51	27	89	90	113	82	26	44	41	14	4	414
-Улсын дүнд эзлэх хувь	19.3	35.7	65.9	36.9	56.3	61.7	27.4	22.0	29.7	36.0	21.5	12.1	37.0
Дүүргүүдийн дүн	46	92	14	152	66	70	216	92	104	70	50	29	697
-Улсын дүнд эзлэх хувь	80.7	64.3	34.1	63.1	41.3	38.3	72.2	78.0	70.3	61.4	76.9	87.9	62.2
Бусад нэгж ¹⁷				-	4		1			3	1		9
Тайлбар: 1. 2015 оны сүүлийн 6 сар; 2. 2017 оны эхний 5 сар; 3. 2017 оны сүүлийн 6 сар.													

Эх сурвалж: ЦЕГ, 2017; 2025.

2.3.2.Хориглосон газар утаат тамхи татах

Санал асуулгын дүн:

Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах зөрчил улсын хэмжээнд өргөн тархалттай байгааг судалгааны дүн харуулж байна: аймгийн төвд хамгийн өндөр (50.0%), Улаанбаатар хот (49.6%), сумын төв (41.0%) орж байна.

“Хааяа гардаг” гэсэн хариултын хувь сумын төвд хамгийн өндөр (32.1%), Улаанбаатар хотод 29.1%, аймгийн төвд хамгийн бага (28.6%) байна. Аймгийн төв болон нийслэлд зөрчил хамгийн түгээмэл байгааг иргэдийн үнэлгээ харуулж байна.

Зураг 9. Санал асуулгын дүн: Утаат тамхи татахыг хориглосон газар тамхи татах тохиолдол



¹⁷ “Бусад нэгж” гэдэг нь нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэс буюу аймаг, дүүргийн цагдаагийн байгууллагаас бусад харьяа алба, нэгжүүдийг хэлнэ. Үүнд, Тээврийн цагдаагийн алба, Төмөр замын цагдаагийн газар, Иргэний агаарын тээврийн хяналт, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх нэгж зэрэг багтана.

“Гардаггүй” гэж хариулсан иргэдийн хувь аймгийн төвд хамгийн өндөр (21.4%), сумын төвд (18.4%), улсын дунджаар (18.1%), харин Улаанбаатар хотод хамгийн бага (17.1%) байна.

Ярилцлагын үр дүн:

Хүнсний дэлгүүр, ТҮЦ-ийн худалдагчдын үзэж байгаагаар, олон нийтийн газар, ялангуяа автобусны буудал, явган хүний зам дээр хүмүүс хаа сайгүй утаат тамхи татдаг бөгөөд тамхи татах зориулалтын цэг зөвхөн томоохон байгууллагуудын гадна байдаг. Түүнчлэн, олон нийтийн газар тамхи татаж буй хүмүүсийн утаанд хүүхдүүд өртөх нь дам тамхидалтад өртөх эрсдэлийг нэмэгдүүлж буйг онцолж, олон нийтийн газар тавих хяналтыг чангатгах шаардлагатай гэж үзсэн байна.

Шигтгээ.

- Явган хүний замаар татаад л тэр нь ам хамар руу ороод л хүүхдүүд ард нь яваад л байдаг. Томоохон байгууллага л зөвшөөрсөн цэг гаргадаг байх. Жижиг газрууд бол гадаа, хаа сайгүй л татаж харагддаг. (Худалдагч ТҮЦ-4)

ЕБС-ийн нийгмийн ажилтнуудын ажиглалтаар, хүмүүс сургуулийн орчинд шууд тамхи татахгүй ч эцэг, эхчүүд хүүхдээ хүргэж, авах үед тамхи татах тохиолдол гардаг. Мөн хотын зохион байгуулалтын онцлогоос шалтгаалан сургуулийн хашааны ойролцоо баар, ресторан, зочид буудал, зах, худалдааны төвүүд байрладаг тул эдгээр аж ахуйн нэгжүүдийн гаднах тамхины цэгүүд хүүхдүүдийн нүдэнд ил байх асуудал үүсэж байна. Үүнээс гадна, тамхи татсан хүмүүс ишээ дуртай газраа хаядаг нь орчны бохирдлыг нэмэгдүүлж буйг онцолжээ. Ерөнхийдөө, олон нийтийн газар тамхи татах хяналт сул байгааг тэд анхааруулсан байна.

Шигтгээ.

- Сургууль орчимд тамхи татах нь ер нь гайгүй болчихсон. Тамхи татах цэгүүд ч цөөрсөн байна. Сургуулийн орчин болон хашаанд зарим эцэг эхчүүд тамхи татах гээд байгаа бол сургуулийн орчин тул хашаанаас гараад татаарай гэж хэлээд гаргадаг. Тэгээд хашааны гадна гараад л татна. Жишээлбэл, энэ яг урд талд байр байгаа байхгүй манайхтай залгаа л дээ. Энд тамхи татах тамхины цэг, сандал байдаг. Тэнд татаад л байж байдаг. (Нийгмийн ажилтан, ЕБС-3)
- Нэг үеэ бодвол хүмүүс чинь соёлтой болчихлоо шүү дээ. Тамхи татах цэгтэй болчихсон. Харин сургуулийн хашаагаар дамжиж өнгөрч байгаа хүмүүс тамхи татаж явах тохиолдол бол байдаг. Тэр тохиолдолд сургуулийн ойр орчмоор тамхи татаж болохгүй гэж хэлээд хэлдэг байсан одоо ч хэлэхээ больж байна өө. (Нийгмийн ажилтан, ЕБС-4)

Цагдаагийн албан хаагчдын хариултыг нэгтгэн дүгнэхэд, утаат тамхи татахыг хориглосон газруудад, тэр дундаа гудамж, талбайд тамхи татах зөрчил түгээмэл гарч байна. Энэхүү зөрчил нь иргэдийн ухамсар, хандлагатай холбоотой бөгөөд хуулийн хэрэгжилтэд хүндрэл учруулж байгаа гэж үзжээ. Тамхи татах зориулалттай цэгүүдийн тоо хязгаарлагдмал тул хүмүүс ихэвчлэн нууцаар татаж, зөрчил гаргадаг, иймд ийм зөрчлийг газар дээр нь илрүүлж, шууд хариуцлага тооцох нь хүндрэлтэй байдаг.

Шигтгээ.

- Утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газар татахыг хориглочихсон байгаа шүү дээ. Хуулийн наад заалт хэрэгжихэд бас хэцүү. Тамхи татаж байгаа үйлдлийг нь яа газар дээр нь таарч байж л хуулийн хариуцлага хүлээлгэнэ. Насанд хүрсэн хүн ч байдаг, насанд хүрээгүй хүүхэд ч байдаг тамхиа нуугдаж байгаад татдаг. (Цагдаагийн албан хаагч-3)
- Зөрчлийн ихэнх хувь нь гудамж, талбайд гарч байна. Өөрөөр бол, утаат тамхийг хориглосон газар татаж байна. Гудамж, талбайд татсан тамхиныхаа ишийг хогийн саванд биш, гудамж, талбайд хаяж байна. Энэ зөрчлүүд нь ерөнхийдөө бол манай гудамж, талбайн зөрчлийн ихэнх хувийг эзэлж байгаа юм. Тэгээд энэ чинь эргээд нөгөө тамхи татах зориулалтын цэгтэйгээ холбоотой байгаад байна. (Цагдаагийн албан хаагч-5)

2.3.3.Хууль зөрчигчид тооцох хариуцлагын тохиромжтой эсэх үнэлгээ

Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэгт зааснаар утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.


Санал асуулгын дүн:

Санал асуулгын хүрээнд Зөрчлийн тухай хуулийн 6.3.1-т заасан утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон зөрчил гаргасан хувь хүн, хуулийн этгээдэд тооцох хариуцлагын зохицуулалтын судалгаанд оролцогчдоос авсан хариултуудыг авч үзье.

А) Хувь хүнд ногдуулах торгуулийн хэмжээний үнэлгээ

Судалгаанд оролцогчдын 46.4% нь торгуулийн хэмжээг энэ хэвээр байлгах нь тохиромжтой гэж үзсэн бөгөөд энэ үзүүлэлт Улаанбаатар хотод 47.0%, аймгийн төвд 28.6% байна.

Зураг 10. Санал асуулгын дүн: Хориглосон газар утаат тамхи татсан хувь хүнд ногдуулах торгуулийн хэмжээний үнэлгээ



Торгуулийн хэмжээг нэмэхийг дэмжигчид улсын дунджаар 18.1% байгаа бол Улаанбаатарт хамгийн өндөр (22.2%) байгаа нь нийслэлд хууль зөрчсөн тохиолдол их байгаатай холбоотой байж болох юм.

Судалгаанд оролцогчдын 35.4% нь торгуулийн хэмжээг “тохиромжгүй”, нэмэгдүүлэх шаардлагатай, эсхүл нийгэмд тустай ажил хийлгэх, албадан сургалтад хамруулах зэрэг бусад төрлийн хариуцлагыг оновчтой гэж хариулсан байна.

Аймгийн төвд “хэлж мэдэхгүй” гэсэн хариултын хувь хамгийн өндөр (21.4%) байгаа нь тухайн бүсэд мэдээллийн хүртээмж сул байгааг илтгэж байж болзошгүй.

Б) Хуулийн этгээдэд ногдуулах торгуулийн хэмжээний үнэлгээ


Судалгаанд оролцогчдын 45.5% нь хуулийн этгээдэд ногдуулах торгуулийн хэмжээг одоогийн байдлаар тохиромжтой гэж үзсэн бөгөөд энэ үзүүлэлт аймгийн төвд хамгийн бага (28.6%) байна.

Аймгийн төвийн иргэдийн 71.4% нь торгуулийн хэмжээнд өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн байна. Түүнчлэн торгуулийн хэмжээг нэмэгдүүлэхийг дэмжигчдийн хувь 21.4% байгаа нь нийслэл (14.5%) болон сумын төв (8.0%)-ийн үзүүлэлтээс өндөр байгаа нь анхаарал татахуйц үзүүлэлт юм.

Мөн “хэлж мэдэхгүй” гэсэн хариултын хувь аймгийн төвд хамгийн өндөр (28.6%) байгаа нь тухайн бүсэд мэдээлэл хангалтгүй байгааг илтгэж байна.

Зарим оролцогчид торгуулиас гадна тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах нь илүү оновчтой шийтгэл гэж үзсэн бөгөөд энэ үзүүлэлт улсын дунджаар 4.1% байна. Энэ нь бизнес эрхлэгчдийн хувьд торгуулийн үр нөлөө, дарамтын асуудлыг дахин нягтлах шаардлагатай болохыг харуулж байна.

Зураг 11. Санал асуулгын дүн: Хориглосон газар утаат тамхи татсан хуулийн этгээдэд ногдуулах торгуулийн хэмжээний үнэлгээ



Ярилцлагын үр дүн:

Хүнсний дэлгүүр, ТҮЦ-ийн худалдагчдын нэг хэсэг нь торгуулийн хэмжээг тохиромжтой гэхдээ уян хатан зохицуулалт шаардлагатай гэж, нөгөө хэсэг нь торгуулийн хэмжээ хэт өндөр гэж үзэж байна.

Шигтгээ.

- Тохиромжгүй юм биш үү, жоохон уян хатан баймаар байна. 3 сая арай өндөр байна 1 сая орчим байвал. (Худалдагч Хүнсний дэлгүүр-1)
- Яг одоо бол тохирохгүй байгаа, хүмүүс хаа сайгүй л тамхи татаад явж байдаг. Зарим нь торгуулна зарим нь боломжгүй. Тэгэхээр хэнийг нь торгоод, хэнийг нь торгохгүй үлдээх вэ. (Худалдагч Хүнсний дэлгүүр-2)
- Арай л өндөр дүнтэй байна. 300 мянга гэдэг чинь их мөнгө шүү. Яг хэд байвал болохыг мэдэхгүй л байна. Энэ 300 мянга нь бол өндөр байна. (Худалдагч ТҮЦ-3)

ЕБС-ийн нийгмийн ажилтнуудын үзэж байгаагаар, цагдаагийн албан хаагчдын ажлын ачаалал их байгаагаас шалтгаалан зөрчлийг хянан шийдвэрлэх үйл явц удааширч, хяналт сул байна. Тэдний хувьд торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх нь хуулийн хэрэгжилтийг сайжруулах нэг арга гэж дүгнэсэн байна.

Цагдаагийн албан хаагчдын хувьд, хариуцлагын арга хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд торгуулийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоох нь зүйтэй гэжээ.

Шигтгээ.

- Жишээ нь Ялалтын талбай дээр тамхи татаад зогсож байгаа иргэнийг би "та энд тамхи татаж болохгүй" гэхэд "яхавараа болдоггүй юм, би хогийн цэгний хажууд татаж байна" гэдэг. Хогийн цэг чинь тамхины цэг биш байхгүй юу. Хүмүүс хогийн цэгийн хажууд татахаар тамхины цэг гэж ойлгоод байдаг. Ийм тохиолдолд би арга хэмжээг нь авахад нэг иргэн надад гомдол гаргаж байсан. Харин шүүх дээр нөгөө хүн маань унаж байсан. (Цагдаагийн албан хаагч-1)
- Хариуцлага нэлээн өндөр байлгаж байж л энэ бүхнийг зохицуулахгүй бол, хариуцлага нь бага байхавар л хүмүүс тоохгүй байна шүү дээ. (Цагдаагийн албан хаагч-3)

2.4.Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт

Тамхины хяналтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн дагуу тус хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг төрийн, ААН-ийн болон төрийн бус байгууллага буюу олон нийтийн хяналт гэсэн гурван субъект өөрсдийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ.

2.4.1.Хуулийн хэрэгжилтэд тавих төрийн хяналт

Үнэлэх хэсэг:

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН §11.

11 дугаар зүйл. Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих

11.1. Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.

/Энэ хэсэгт 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

Засгийн газрын 2013 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Тамхи үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам”-ын 6.2-т зааснаар бүр шатны Засаг дарга нараас гадна иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (цаашид “ИТХ”) харьяалах нутаг дэвсгэртээ тамхины худалдаа, үйлчилгээнд хяналт тавьж, зөрчил арилгуулах арга хэмжээ авч, хяналтын байгууллагад хагас, бүтэн жил тутам тайлагнах үүрэгтэй. Мөн журмын 6.3-т мэргэжлийн хяналт мэргэжлийн хяналтын байгууллага, цагдаа, татварын байгууллагууд тамхины тусгай зөвшөөрөл, эрүүл мэндийн дүгнэлт, шошгоны стандарт, татвар төлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилт зэргийг хянах үүрэгтэй.

Санал асуулгын дүн:

Судалгаанд оролцогчдын 50.4% нь хуулийн хэрэгжилтэд тавих төрийн хяналтыг “дунд зэрэг” гэж үнэлсэн байна: нийслэлд (53.0%), сумын төвд (50.0%) “дунд зэрэг” гэж үнэлсэн байна. Харин аймгийн төвд 35.7% нь “дунд зэрэг” гэж, 36% нь “сайн” гэж үнэлжээ.

Хүснэгт 6. Санал асуулгын дүн: Хууль тогтоомжийн хэрэгжилтэд төрийн хяналт тавих заалтын хэрэгжилт

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Муу	18.1%	17.9%	21.4%	17.9%
Дунд зэрэг	50.4%	53.0%	35.7%	50.0%
Сайн	26.2%	26.5%	35.7%	25.5%
Хэлж мэдэхгүй	5.2%	2.6%	7.1%	6.6%

Хуулийн хэрэгжилтэд тавих төрийн хяналт хэрэгждэггүй шалтгаануудад Улаанбаатар хотод хариуцлага хүлээлгэх субъект байхгүй (42.9%), аймгийн төвд тогтолцоо ойлгомжгүй (33.3%) болон зөвхөн сануулдаг (33.3%), сумын төвд мөн тогтолцоо ойлгомжгүй (29.4%) гэж хариулсан байна.

Хүснэгт 7. Санал асуулгын дүн: Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд тавих төрийн хяналт яагаад хэрэгждэггүй вэ?

	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд	Нийт
Тогтолцоо ойлгомжгүй	9.5%	33.3%	29.4%	22.4%
Хариуцлага хүлээлгэх субъект байхгүй	42.9%		8.8%	20.7%
Зөвхөн сануулаад өнгөрдөг	9.5%	33.3%		5.2%

Муу	28.6%		26.5%	25.9%
Бусад	9.5%	33.3%	35.3%	25.9%

Ярилцлагын үр дүн:

Төрийн байгууллагын хувьд, хорооны цагдаагийн албан хаагчид ЕБС-ийн нийгмийн ажилтантай хамтарч ажилладаг, зарим тохиолдолд хамтарсан баг гарч эргүүл хийдэг талаараа ЕБС-ийн нийгмийн ажилтнууд ярьж байсан.

Шигтгээ.

- Дүүргийн зүгээс дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтсийн байцаагч, хүүхдийн байцаагч нартайгаа бол байнга хамтарч ажилладаг. Улирал тутамд зөвлөгөө хийнэ, асуудалтай хүүхдүүдийг цуглуулж байгаад ч хамаагүй яриа хийдэг. Манай хорооны цагдаагийн хэлтэс бол үнэхээр сайн ажилладаг. (Нийгмийн ажилтан, ЕБС-1)
- Хорооны цагдаа, хүүхэд гэр бүл боловсролын хэлтэстэйгээ л хамтарч ажилладаг. Бас school police хийж байгаа аав, ээж нар сургууль тойрч явна, зам дээр зогсоно, ойр хавийн ТҮЦ-үүдэд хяналт тавина. Хороо, дүүргийн зүгээс чиглэлүүд л өгнө. Заримдаа аян зохион байгуулбал тэр талаарх тайлангаа хороо, дүүрэгтээ хүргүүлдэг. (Нийгмийн ажилтан, ЕБС-2)

Цагдаагийн албан хаагчид Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт болон хяналтын үйл ажиллагаа нь зөвхөн цагдаагийн байгууллагаар хязгаарлагддаггүй, бүх шатны байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжих шаардлагатай гэж үзэж байна. Одоогийн байдлаар Засаг дарга нар нь дүүргийн түвшинд хяналт тавих үүргээ хангалттай биелүүлдэггүй. Энэ хүрээнд холбогдох төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Шигтгээ.

- Засаг дарга нар бараг Тамхины хяналтын тухай хуулиар хяналт тавиад яваад байхгүй. Одоо Засаг дарга нарын хийдэг ажил нь ганцхан хогийн гэрээ болчихоод байна шүү дээ. Энэ дээр Засаг дарга нь өөрөө ороод хамтарсан багаараа хяналт тавья гээд санаачилга гаргаад явж байгаагүй. (Цагдаагийн албан хаагч-1)
- Дүүрэг, хорооны Засаг дарга нартай хамтарч Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор төлөөлөгөөт шалгалтуудыг хийдэг. Ерөнхийдөө хуулийн хэрэгжилтийг хангах гээд арга хэмжээ зохион байгуулаад явдаг. (Цагдаагийн албан хаагч-4)
- Дээр үед бол Мэргэжлийн хяналт гээд нэг байгууллага байсан, тэрийг чинь татан буулгаад хаячихсан. Одоо Тамхины хяналтын тухай хуульд ганцхан цагдаагийн байгууллага л хяналт тавьж байгаа шүү. (Цагдаагийн албан хаагч-3)

Цагдаагийн албан хаагчдад Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавихад хэд хэдэн тулгамдсан асуудлууд байдаг бөгөөд цагдаагийн байгууллагын ажлын ачаалал их, зөрчлийг нотлох асуудал төвөгтэй, хууль эрх зүйн зохицуулалт тодорхой бус байдгаас хяналтын үйл ажиллагаа үр дүн багатай байна. Тухайлбал, зөрчил шалган шийдвэрлэх шалган шийдвэрлэх нь ажиллагаа, цаг хугацаа их шаарддаг, цахим бүртгэлийн сүлжээний тасалдал зэргээс шалтгаалан хяналт хэрэгжүүлэхэд хүндрэл үүсдэг.

Мөн прокурорын байгууллагаас Зөрчлийн тухай хуулийн зөвшөөрөлгүй худалдаа, үйлчилгээ эрхэлсэн заалтыг үндэслэн торгуулийн хэмжээ буурч, хууль зөрчсөн тамхи хураахгүй байх шийдвэр гаргах болсноор хяналтын үр нөлөө буурч байна гэж хариулжээ. Хуульд тамхи татахыг хориглосон байршлуудыг тодорхой болгох, нэг стандарт бүхий тамхи татах цэгүүдийг олшруулах, шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнүүд (электрон тамхи, зажилдаг тамхи гэх мэт)-ийг хуульд тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Шигтгээ.

- Зөрчил шалган шийдвэрлэх процесс нь цагдаагийн албан хаагчийн ажлын ачааллыг их болгодог. Бид өөрсдөө тамхи хурааж авсан тэмдэглэл үйлдэнэ, өөрсдөө баримтжуулна гээд нэг өдөр, маргааш нь өөрсдөө аваад шалгаад тамхийг нь устгуулахаар бол дүүрэг рүү өгнө, хадгалсан гэж үзвэл тамхийг нь буцаагаад эзэнд нь өгнө гээд дахиад нэг өдөр зарцуулна. Тэрийг чинь Цагдаагийн сан, Зөрчлийн сан гээд 2 санд шивж оруулна, газар дээр нь шивнэ гэхээр заримдаа сүлжээгүй болчихдог. Сүлжээгүй болчихсон болохоор хэлтэс рүү очоод шивнэ. Тийм учраас цагдаагийн албан хаагчид чинь ачаалал өгнө гэсэн үг л дээ. Зөрчлийг нотлох асуудал нь тулгамдсан асуудал болоод байна... УЕП-аас цагдаагийн байгууллага руу нэг тоот явуулсан байдаг. Албан бичигт ААН-ийг Зөрчлийн тухай хуулийн 6.3-т заасан "Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн" гэх үндэслэлээр 500 нэгжтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгохгүй, харин 10.4-т заасан "Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих" гэсэн үндэслэлээр хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торго гэсэн зөвлөмж ирсэн. (Цагдаагийн албан хаагч-1)

2.4.2.Хуулийн хэрэгжилтэд тавих олон нийтийн хяналт

Үнэлэх хэсэг:

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН §11.

11 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих

11.3.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад төрийн бус байгууллага тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавьж болно.

Засгийн газрын 2013 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан "Тамхи үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам"-ын 6.3-т зааснаар шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө байгууллага нь төрийн бусад байгууллагуудтай хамтарч тамхины тусгай зөвшөөрөл, эрүүл мэндийн дүгнэлт, шошгоны стандарт, татвар төлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилт зэргийг хянах үүрэгтэй.

Санал асуулгын дүн:

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ-уудын зүгээс хуулийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих байдал улсын хэмжээнд 59.8% нь "дунд зэрэг" гэж үнэлэгдсэн байна. Тухайлбал, Улаанбаатар хотод 62.4%, сумын төвд 59.0%, аймгийн төвд 50.0% нь "дунд зэрэг" гэж хариулжээ. Эдгээр үзүүлэлт нь хуулийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 8. Санал асуулгын дүн: Хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих заалтын хэрэгжилт

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Муу	30.6%	29.1%	35.7%	31.1%
Дунд зэрэг	59.8%	62.4%	50.0%	59.0%
Сайн	0.6%	0.9%	0.0%	0.5%
Хэлж мэдэхгүй	9.0%	7.7%	14.3%	9.4%

Санал асуулгад оролцогчдоос хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ-уудын хуулийн хэрэгжилтэд тавих олон нийтийн хяналт хангалтгүй байгаа шалтгааныг тодруулахад, Улаанбаатар хотод хуулийн хяналт байхгүй (48.5%), аймгийн төвд төрийн болон ТББ-ын уялдаа муу (40%) гэж үзсэн байна.

Харин сумын төвд 24.6% нь хууль ерөнхийдөө хэрэгжихгүй байна гэж хариулсан нь орон нутгийн түвшинд хэрэгжилт сул байгааг илтгэж байна.

Хүснэгт 9. Санал асуулгын дүн: Хэрэв хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ энэ хуулийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих заалт хяналт яагаад хэрэгждэггүй вэ?

	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд	Нийт
Хяналт байхгүй	48.5%		19.7%	28.3%
Хууль сурталчлах, нөлөөлөх ажил хийгдэхгүй байна	12.1%	20.0%	16.4%	15.2%
Хариуцлагагүй	15.2%	20.0%	19.7%	18.2%
Хууль хэрэгжихгүй байна	21.2%		24.6%	22.2%
ТББ, ТБ-ын уялдаа муу	3.0%	40.0%	3.3%	5.1%
Тамхи татах эрэлт байна		20.0%	9.8%	7.1%
ТББ-д урамшуулал байхгүй			6.6%	4.0%

Ярилцлагын үр дүн:

Хүнсний дэлгүүр, ТҮЦ-ийн худалдагчид, ЕБС-ийн нийгмийн ажилтнууд болон цагдаагийн албан хаагчдын хувьд, Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих үүрэгтэй хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллага болон бусад ТББ-уудтай таарч байгаагүй, хамтран ажиллаж байгаагүй байна.

Сургуулиуд дээр хүүхдүүдийн санаачилсан өсвөрийн сэргийлэгч бүлгэм зэрэг цагдаагийн байгууллагын зөвлөмжийн дагуу хүүхдүүдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг байгууллагууд байдаг. Ийм бүлгэм нь сургууль дээрээ хүүхдүүдийн тамхины хэрэглээнд өөрсдийн хэмжээнд хяналт тавьдаг талаар ЕБС-ийн нийгмийн ажилтнууд ярьж байсан.

Шигтгээ.

- ТББ-уудын зүгээс бол нэг их тийм оролцоо байхгүй. (Нийгмийн ажилтан, ЕБС-2)
- ТББ, олон нийтийн байгууллагатай хамтардаг ажил байхгүй дээ. Харин сургууль дээр Өсвөрийн сэргийлэгч бүлгэм ажилладаг. Тэр хүүхдүүд бие биедээ хяналт тавих, нийгмийн ажилтанд мэдээлэл өгөх зэргээр ажилладаг. (Нийгмийн ажилтан, ЕБС-4)

2.4.3.Хуулийн хэрэгжилтэд тавих ААН-ийн хяналт

Үнэлэх хэсэг:

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН §11.

11 дугаар зүйл. Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих

11.2. Аж ахуй нэгж, байгууллага, тэдгээрийн салбар нэгжийн удирдлага энэ хуульд заасан өөрийн эрх хэмжээний хүрээнд тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина.

Санал асуулгын дүн:

Судалгаанд оролцогчдын 45.5% нь ААН, байгууллага болон тэдгээрийн салбар нэгжийн удирдлагын хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын хэрэгжилтийг "дунд зэрэг" гэж үнэлсэн байна. Улсын хэмжээнд авч үзвэл, нийслэлд 45.3%, аймгийн төвд 42.9%, сумын төвд 45.8% нь энэхүү хяналтын хэрэгжилт сул байгааг онцолсон нь хуулийн заалтын бодит хэрэгжилт бүс нутгаас үл хамааран хангалтгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 10. Санал асуулгын дүн: Хууль тогтоомжийн хэрэгжилтэд ААН, байгууллагын хяналт тавих заалтын хэрэгжилт

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Муу	23.9%	23.9%	21.4%	24.1%
Дунд зэрэг	45.5%	45.3%	42.9%	45.8%
Сайн	23.3%	23.9%	35.7%	22.2%
Хэлж мэдэхгүй	7.3%	6.8%	0.0%	8.0%

ААН, байгууллага энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавьдаггүй шалтгааныг авч үзвэл, улсын хэмжээнд хариуцлага, хяналт сул (40.2%), хууль хэрэгждэггүй, тамхи нууцаар худалддаг (29.3%) гэсэн байна.

Улаанбаатар хотод 50.0% нь хариуцлага, хяналт сул гэж үзсэн байна. Харин аймгийн төвд 33.3% нь хууль хэрэгждэггүй, тамхи нууцаар худалддаг, 33.3% нь ухамсрын асуудал гэсэн бол сумын төвд 37.3% нь хариуцлага, 29.3% нь хяналт сул хууль хэрэгждэггүй, тамхи нууцаар худалддаг гэсэн байна.

Хүснэгт 11. Санал асуулгын дүн: Санал асуулгын дүн: Хэрэв хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ энэ хуулийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт тавих заалт хяналт яагаад хэрэгждэггүй вэ?

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Хяналт, хариуцлага сул	40.2%	50.0%	0.0%	37.3%
Хууль хэрэгждэггүй, нууцаар худалддаг	29.3%	28.6%	33.3%	29.4%
Ухамсрын асуудал	9.8%	10.7%	33.3%	7.8%
Ашиг олох зорилгоор худалдаалж буй учир	7.3%	7.1%	0.0%	7.8%
Хэрэглэгч, хэрэглээ байгаа учир	3.7%	0.0%	0.0%	5.9%
ЕБС-ийн ойр байршил, төлөвлөлтэй холбоотой	2.4%	0.0%	0.0%	3.9%

Зөвшөөрөлтэй худалдаалж байна	2.4%	0.0%	33.3%	2.0%
Хуулийн мэдлэг дутмаг	2.4%	3.6%	0.0%	2.0%
Шинэ нөхцөл үүссэн	1.2%	0.0%	0.0%	2.0%
Бусад	1.2%	0.0%	0.0%	2.0%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%

Ярилцлагын үр дүн:

Цагдаагийн алба хаагчид зөрчлийн хяналт, шалгалтыг зохион байгуулж байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангахын тулд зөвхөн цагдаагийн байгууллагаас гадна бусад холбогдох байгууллагуудыг оролцуулж, хяналтыг өргөжүүлэх шаардлагатайг дурдсан.

Шигтгээ.

- Байхгүй. Цагдаагийн байгууллагаас өөр хяналт тавьдаг байгууллага байдаг юм уу? Тамхины хяналтын тухай хуульд заагдсан цагдаагийн байгууллага л хяналт тавьж байгаа шүү. (Цагдаагийн албан хаагч-3)

Гурав. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

3.1.Дүгнэлт

Тамхины хяналтын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилт нь тодорхой үр нөлөө үзүүлж байгаа хэдий ч цогц хяналт, түүнийг хэрэгжүүлэх механизм дутагдалтай байна.

- Төрийн хяналтын хэрэгжилт хангалтгүй, үүрэг хүлээсэн байгууллагуудын уялдаа холбоо алдагдсан (§11.1):

2015-2024 оны хооронд Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн нийт 8274 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс 30.3% (2505 зөрчил) нь аймгуудад, 69.6% (5758 зөрчил) нь нийслэлд бүртгэгдсэн байна.

2016 онд хамгийн олон буюу 2283 зөрчил бүртгэгдсэн бол 2024 онд хамгийн бага буюу 260 зөрчил бүртгэгдсэн байна. 2024 онд зөрчлийн тоо эрс буурсан нь бодит бууралт гэхээс илүүтэй хяналт, илрүүлэлт сул болсонтой холбоотой байж болзошгүй.

- Тамхины хяналтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Засгийн газрын 2013 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Тамхи үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам”-ын 6.2-т заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг дарга болон холбогдох бусад төрийн байгууллагууд хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын үүргээ бүрэн хангахгүй байгаа нь төрийн хяналтын тогтолцоог улам сайжруулах шаардлагатайг харуулж байна.
- Хяналтын гол ачаалал цагдаагийн байгууллагад төвлөрч, хүний нөөцийн хомсдол, ажлын хэт ачаалал зэргээс шалтгаалан хяналтад хүндрэл үүссэн байна. Түүнчлэн цагдаагийн байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх нь ажиллагаа, цаг хугацаа их шаарддаг, цахим бүртгэлийн сүлжээний тасалдал зэргээс шалтгаалан хяналтын үр нөлөөг бууруулж, хэрэгжилтэд хүндрэл учруулж байна.
- Төрийн зарим байгууллагаас ААН-үүдийг дэмжих шийдвэр гаргаж байгаа ч хяналтын тогтолцоог алдагдуулж байна. Тухайлбал, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/987 дугаар захирамжийн дагуу нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа зарим төрлийн худалдаа, үйлчилгээнд зөвшөөрөл шаардахгүй болсон нь хяналтын механизмыг сулруулж, хэрэгжилтэд хүндрэл учрахад нөлөөлсөн байж болзошгүй.
- Санал асуулгад оролцогчдын дийлэнх нь торгуулийн хэмжээг хэвээр хадгалахыг дэмжсэн бол Улаанбаатар хотын оршин суугчдын 23.1% нь торгуулийг нэмэх саналыг илүүтэй дэмжсэн байна. Судалгаанд оролцогчид торгуулийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан нэмэгдүүлэх, боловсрол, соён гэгээрүүлэх бодлоготой хослуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.
- 2017 оноос хойш зөрчил ангилж бүртгэх тогтолцоо байхгүй болсон нь хэрэгжилтийн бодит үр нөлөөг үнэлэх боломжийг бууруулсан.

- **ААН-үүдийн хариуцлага сул, бизнесийн ашиг давамгайлж байна (§11.2):**
 - Тамхи худалдах, хэрэглэхтэй холбоотой хуулийн хэрэгжилтэд аж ахуйн нэгжүүд хяналт тавих үүрэгтэй боловч бодит байдал дээр энэ нь хангалтгүй хэрэгжиж байна.
 - Тамхины хяналтын тухай болон Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулагдсан тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй жижиг хүнсний дэлгүүр, ТҮЦ-үүдийн хувьд тамхи худалдах явдал бүрэн хязгаарлагдаагүй, зарим тохиолдолд далд хэлбэрээр үргэлжилж байна.
- **Олон нийтийн хяналт хангалтгүй байна (§11.3):**
 - Хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллага, бусад ТББ-ууд тамхины хяналтад оролцох эрх зүйн боломжтой боловч бодит байдал дээр хяналт тавьж буй байгууллага байхгүй, төрийн болон ТББ-уудын уялдаа сул байна.
 - Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэл, ухамсар, хандлага хангалтгүй байгаагаас хууль хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.
- **Тамхины үйл ажиллагаанд тавих шаардлага тогтмол зөрчигдөж байна (§6.7):**
 - 2015-2024 онд тамхины үйл ажиллагаанд тавих шаардлагыг зөрчсөн 6831 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд үүнээс 71.1% (4860 зөрчил) нь нийслэлд, 28.8% (1970 зөрчил) нь аймгуудад гарсан байна.
 - 21 нас хүрээгүй иргэдийн тамхи худалдан авах боломж хяналтгүй хэвээр байна. Тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдаалагчид худалдан авагчийн насыг шалгахгүйгээр тамхи худалдаж байгаа нь ширхэглэн худалдааны далд сүлжээг идэвхжүүлсээр байна. (§6.7.7, 6.7.8)
 - Зөвшөөрөгдсөн цэгээс бусад газар тамхи худалдах зөрчил нийт зөрчлийн дийлэнх буюу 83.3%-ийг эзэлж байна. Үүнээс улбаалан тамхи худалдах хууль бус ажиллагаа далд хэлбэрт шилжиж, хяналтгүй худалдаа үргэлжилсээр байна. (§6.7.12)
 - Зөвшөөрөгдсөн цэгээс бусад газар тамхи худалдах зөрчил нийт зөрчлийн дийлэнх хувийг эзэлж байгаа буюу тамхи худалдах хууль бус үйл ажиллагаа далд хэлбэрт шилжиж, хяналтгүй худалдаа газар авсан байна.
 - ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдахыг хориглосон заалт бодит нөхцөл байдалтай нийцэхгүй, хэрэгжилтэд хүндрэл үүсгэж байна. Хот төлөвлөлтийн асуудлаас үүдэн уг хязгаарлалт хэрэгжих боломжгүй байгаа нь хяналт сулрах нэг шалтгаан болж байна. (§6.7.14)
- **Олон нийтийн газар тамхи татах зөрчил өндөр түвшинд хэвээр байна (§9.1):**
 - Судалгааны дүнгээс үзэхэд, энэ төрлийн зөрчил тогтвортой өндөр хувьтай бүртгэгдэж байгаа нь хяналтын тогтолцооны үр дүн хангалтгүй байгааг харуулж байна.
- **Өөрчлөгдөж буй нөхцөл байдал:**
 - Утаат тамхины хэрэглээ буурах хандлагатай байгаа ч цахилгаан тамхины хэрэглээ, ялангуяа өсвөр насныхны дунд огцом нэмэгдэж байна. Цахилгаан тамхины олон төрлийн амт, үнэртэй бүтээгдэхүүн нь залуучууд, өсвөр насныхны сонирхлыг татаж, хэрэглээг эрчимжүүлж байна. Гэвч энэ төрлийн

бүтээгдэхүүнийг зохицуулах хууль, стандарт хангалтгүй байгаа нь хяналтын үр дүнд сөргөөр нөлөөлж, борлуулалт хяналтгүй болж, зохицуулалт шаардлагатай шинэ нөхцөл байдал үүсгэж байна.

3.2.Зөвлөмж

- **Төрийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, үүрэг хүлээсэн байгууллагуудын уялдаа холбоо сайжруулах (§11.1):**
 - орон нутгийн удирдлагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх – аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг дарга нарын хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог сайжруулах;
 - төрийн байгууллагын үүргийг тодорхой болгох – хуулийн хэрэгжилтэд төрийн холбогдох байгууллагуудын үүргийг тодорхой болгож, оролцоог бүрдүүлэх;
 - торгуулийн хэмжээг бодит байдалд нийцүүлэх – торгуулийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах, давтан зөрчил гаргасан тохиолдолд торгуулийн хэмжээг шатлан нэмэгдүүлэх;
 - зөрчлийн мэдээлэл, бүртгэлийг сайжруулах – Тамхины хяналтын зөрчлийг ангилан бүртгэх нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, үүнд хууль зөрчсөн этгээд, давтан зөрчлийн тоог тусгах;
 - цахим бүртгэлийн систем нэвтрүүлэх – зөрчлийг шуурхай бүртгэж, мэдээллийг бодлогын түвшинд ашиглах боломжтой цахим бүртгэлийн тогтолцоо хөгжүүлэх;
 - зөрчлийг олон нийтэд ил тод болгох – торгууль ногдуулсан хуулийн этгээдийн мэдээллийг олон нийтэд мэдээлж, давтан зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх.
- **ААН-үүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх (§11.2):**
 - ААН-үүдийн оролцоог нэмэгдүүлэх – хууль хэрэгжүүлэх үйл явцад аж ахуйн нэгжүүдийн идэвхтэй оролцоог хангах механизмыг бүрдүүлэх;
 - зөвшөөрлийн хяналтыг сайжруулах - давтан зөрчил гаргасан аж ахуйн нэгжийн холбогдох зөвшөөрлийг тодорхой хугацаагаар түр түдгэлзүүлэх зохицуулалт нэвтрүүлэх, зөвшөөрөл олгох журам болон түүнд тавих хяналтыг сайжруулах.
- **Олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх (§11.3):**
 - ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх – хяналтын тогтолцоонд ТББ-уудыг татан оролцуулж, иргэд, мэргэжлийн байгууллагуудын хамтын хяналтын механизмыг бүрдүүлэх;
 - олон нийтийн хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх – олон нийтийн оролцоотой хяналтын механизмыг бий болгож, зөрчлийг мэдээлэх бүх төрлийн платформыг хөгжүүлэх;
 - олон нийтийн орчин дахь хяналтыг сайжруулах – нийтийн тээвэр, цэцэрлэг, сургуулийн орчинд камерын хяналт нэвтрүүлэх.

- **Тамхины үйл ажиллагаанд тавих шаардлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх (§6.7):**
 - 21 нас хүрээгүй хүнд тамхи худалдахад хяналтыг сайжруулах – тамхи худалдан авахад нас шалгах цахим систем нэвтрүүлэхийг хуульчлах, хуулийн зохицуулалтыг мөрдөөгүй тохиолдолд хариуцлага ногдуулах механизмыг чангатгах (§6.7.7);
 - ширхэглэн худалдааг таслан зогсоох хяналтыг эрчимжүүлэх – давтан зөрчил гаргасан тохиолдолд хариуцлагыг шатлалтайгаар нэмэгдүүлэх, торгуулийн хэмжээг өсгөх, дахин зөрчил гаргасан аж ахуйн нэгжийн зөвшөөрлийг цуцлах зохицуулалт нэвтрүүлэх (§6.7.8);
 - ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн хязгаарлалтыг бодитой болгох – хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан энэ хязгаарыг дахин тогтоох, шаардлагатай тохиолдолд уян хатан зохицуулалт хийх (§6.7.14).
- **Олон нийтийн газар тамхи татахыг хориглосон заалт хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх (§9.1):**
 - олон нийтийн орчин дахь хяналтыг сайжруулах - нийтийн тээвэр, цэцэрлэг, сургуулийн орчинд камерын хяналт нэвтрүүлэх, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох механизмыг тодорхой болгох;
 - тамхи татах зөвшөөрөгдсөн бүсийг стандартчилах – тамхи татах цэгийг тодорхой стандарттай болгох, тоог нь нэмэгдүүлэх, тухайн нутаг дэвсгэрт байгаа ААН, байгууллагуудыг үүрэгжүүлэх;
 - олон нийтийн газар тамхи татахыг хянах механизмыг хөгжүүлэх – цагдаагийн байгууллагын хяналтыг нэмэгдүүлж, камерын хяналт болон олон нийтийн мэдээллийн системтэй уялдуулан хяналтын үр дүнг сайжруулах.
- **Шинээр үүсээд байгаа нөхцөл байдлыг зохицуулах:**
 - Цахилгаан тамхи болон никотин агуулсан шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнийг хуулийн зохицуулалтад бүрэн хамруулж, үнэр, амтны найрлагад хязгаарлалт тогтоох, хяналтын үр дүнтэй механизмыг бий болгох шаардлагатай;
 - хуулийн зохицуулалтад бүрэн хамруулах – цахилгаан тамхи болон никотин агуулсан шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнийг хуулиар зохицуулах;
 - шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнд тодорхой хязгаарлалт тогтоох – цахилгаан тамхи, бусад шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүний үнэр, амтны найрлагад тодорхой хязгаарлалт тогтоох;
 - хяналтын үр дүнтэй механизмыг бүрдүүлэх – борлуулалтын зөвшөөрлийн тогтолцоо бий болгох, тусгайсгайлсан шалгалтыг тогтмолжуулах.

Ашигласан материал

- ЭМЯ, НЭМҮТ, ДЭМБ. (2023). *Тамхи тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад саад болж байна.* . Улаанбаатар.
- НХХЯ, ЭМЯ, БШУЯ. (2024). *Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн судалгаа.* Улаанбаатар.
- УИХ-ын Тамгын газрын архив. (2012). “Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн хувийн хэрэг.
- НСАУСИ ТББ. (2024). *Өсвөр үе, залуу иргэдийн тамхины хэрэглээ, төрлүүд, никотин хамааралт байдал, нөлөөлж буй сэтгэц, нийгмийн зарим үзэгдлүүд.* Нотолгоонд суурилсан анагаах ухааны судалгааны институт, ТББ, Улаанбаатар хот.
- Ерөнхийлөгчийн Тамгын газар. (2023). “Эрүүл оюутан” дэд хөтөлбөр.
- ЗГХЭГ. 2017.05.30-ний өдрийн ХЭГ/909 тоот албан бичгийн хавсралт. 2017 онд УИХ-ын гишүүн Н.Учралаас “Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх заалтын хэрэгжилтийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариу.
- Үндэсний статистикийн хороо. 1212 статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Хүн амын тоо, 2023 он. Хандах: https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_004V1.
- Нийслэлийн статистикийн газар. Улаанбаатар хотын хүн амын тоо, 2023 он. Хандах: <http://ubstat.mn/StatTable=20>
- Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/987 дугаар захирамж. Хандах: <https://n9.cl/l3snkm>

Дөрөв. ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. САНАЛ АСУУЛГА

Сайн байна уу? Танд энэ өдрийн мэнд хүргэе. Улсын Их Хурлын даргын 2024 оны 110 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагын хүрээнд Тамхины хяналтын тухай хуулийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийж байгаа тул Та дараах асуултад үнэн зөв хариулж, бидний судалгааны ажилд дэмжлэг үзүүлнэ үү.

ЕРӨНХИЙ АСУУЛГА

1. Аймаг, нийслэл

- | | | |
|---------------|----------------|-----------------|
| 1) Архангай | 9) Дорнод | 17) Төв |
| 2) Баян-Өлгий | 10) Дундговь | 18) Увс |
| 3) Баянхонгор | 11) Завхан | 19) Ховд |
| 4) Булган | 12) Орхон | 20) Хөвсгөл |
| 5) Говь-Алтай | 13) Өвөрхангай | 21) Хэнтий |
| 6) Говьсүмбэр | 14) Өмнөговь | 22) Улаанбаатар |
| 7) Дархан-Уул | 15) Сүхбаатар | |
| 8) Дорноговь | 16) Сэлэнгэ | |

2. Сумын нэр _____

3. Улаанбаатар хот

- | | | |
|---------------|--------------|-------------------|
| 1) Багануур | 4) Баянзүрх | 7) Хан-Уул |
| 2) Багахангай | 5) Чингэлтэй | 8) Налайх |
| 3) Баянгол | 6) Сүхбаатар | 9) Сонгинохайрхан |

4. Хорооны дугаар _____

5. Таны албан тушаал

- | | |
|-----------------------------------|---------------------------------|
| 1) Аймгийн Засаг дарга | 7) Дүүргийн Засаг дарга |
| 2) Аймгийн Засаг даргын орлогч | 8) Дүүргийн Засаг даргын орлогч |
| 3) Сумын Засаг дарга | 9) Хорооны Засаг дарга |
| 4) Сумын Засаг даргын орлогч | 10) Хорооны Засаг даргын орлогч |
| 5) Нийслэлийн Засаг дарга | 11) Бусад _____ |
| 6) Нийслэлийн Засаг даргын орлогч | |

6. Холбоо барих утасны дугаар _____

(Судалгаатай холбоотой тодруулах асуулт гарвал Тантай эргэн холбогдоно.)

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ

1. Таны бодлоор “утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? (§6.7.12)

- | | |
|--------------------|------------------|
| 1) Огт гардаггүй | 4) Ер нь гардаг |
| 2) Ер нь гардаггүй | 5) Байнга гардаг |
| 3) Хааяа гардаг | 6) Хэлж мэдэхгүй |

2. Таны бодлоор “утаат тамхийг ширхэглэн худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? (§6.7.8)

- | | |
|--------------------|------------------|
| 1) Огт гардаггүй | 4) Ер нь гардаг |
| 2) Ер нь гардаггүй | 5) Байнга гардаг |
| 3) Хааяа гардаг | 6) Хэлж мэдэхгүй |

3. Таны бодлоор “дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины үйлдвэрлэсэн боодлыг задалж буюу ороож худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? (§6.7.8)

- | | |
|--------------------|------------------|
| 1) Огт гардаггүй | 4) Ер нь гардаг |
| 2) Ер нь гардаггүй | 5) Байнга гардаг |
| 3) Хааяа гардаг | 6) Хэлж мэдэхгүй |

4. Таны бодлоор “21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? (§6.7.7)
- | | |
|--------------------|------------------|
| 1) Огт гардаггүй | 4) Ер нь гардаг |
| 2) Ер нь гардаггүй | 5) Байнга гардаг |
| 3) Хааяа гардаг | 6) Хэлж мэдэхгүй |
5. Таны бодлоор “21 нас хүрээгүй хүнээр утаат тамхи худалдуулах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? (§6.7.7)
- | | |
|--------------------|------------------|
| 1) Огт гардаггүй | 4) Ер нь гардаг |
| 2) Ер нь гардаггүй | 5) Байнга гардаг |
| 3) Хааяа гардаг | 6) Хэлж мэдэхгүй |
6. Таны бодлоор “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? (§6.7.14)
- | | |
|--------------------|------------------|
| 1) Огт гардаггүй | 4) Ер нь гардаг |
| 2) Ер нь гардаггүй | 5) Байнга гардаг |
| 3) Хааяа гардаг | 6) Хэлж мэдэхгүй |
7. Хэрэв “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах” зөрчил гардаг гэж үзэж байгаа бол Таны бодлоор энэ төрлийн зөрчил яагаад гардаг вэ? (§6.7.14)
(Хэрэв Та 6-р асуултад “Ер нь гардаг”, эсхүл “Байнга гардаг” гэж хариулсан бол энэ асуултад хариулна уу.)
-
8. Таны бодлоор “утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? (§9.1)
- | | |
|--------------------|------------------|
| 1) Огт гардаггүй | 4) Ер нь гардаг |
| 2) Ер нь гардаггүй | 5) Байнга гардаг |
| 3) Хааяа гардаг | 6) Хэлж мэдэхгүй |
9. Хуульд “ААН, байгууллага, тэдгээрийн салбар нэгжийн удирдлага хуульд заасан өөрийн эрх хэмжээний хүрээнд тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина” гэж заасан. Та тус заалтын хэрэгжилтийг хэрхэн үнэлэх вэ? (§11.2)
- | | |
|---------------|------------------|
| 1) Маш муу | 4) Сайн |
| 2) Муу | 5) Маш сайн |
| 3) Дунд зэрэг | 6) Хэлж мэдэхгүй |
10. Хэрэв “ААН, байгууллага тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих” заалт хэрэгждэггүй гэж үзэж байгаа бол Таны бодлоор энэ заалт яагаад хэрэгжихгүй байна вэ? (§11.2)
(Хэрэв Та 9-р асуултад “Маш муу”, эсхүл “Муу” гэж хариулсан бол энэ асуултад хариулна уу.)
-
11. Хуульд “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина” гэж заасан. Та тус заалтын хэрэгжилтийг хэрхэн үнэлэх вэ? (§11.3)
- | | |
|---------------|------------------|
| 1) Маш муу | 4) Сайн |
| 2) Муу | 5) Маш сайн |
| 3) Дунд зэрэг | 6) Хэлж мэдэхгүй |
12. Хэрэв “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих” заалт хэрэгждэггүй гэж үзэж байгаа бол Таны бодлоор энэ заалт яагаад хэрэгжихгүй байна вэ? (§11.3)
(Хэрэв Та 11-р асуултад “Маш муу”, эсхүл “Муу” гэж хариулсан бол энэ асуултад хариулна уу.)
-
13. Хуульд “Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Та тус заалтын хэрэгжилтийг хэрхэн үнэлэх вэ? (§11.1)
- | | |
|------------|---------------|
| 1) Маш муу | 3) Дунд зэрэг |
| 2) Муу | 4) Сайн |

5) Маш сайн

6) Хэлж мэдэхгүй

14. Таны бодлоор “Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналт” яагаад хэрэгждэггүй вэ? (§11.1)
(Хэрэв Та 13-р асуултад “Маш муу”, эсхүл “Муу” гэж хариулсан бол энэ асуултад хариулна уу.)

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 6.3 ДАХЬ ХЭСГИЙН ХЭРЭГЖИЛТ

15. Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? (§6.3.1)

(Зөвхөн нэг хариулт сонгоно уу.)

- 1) Тохиромжгүй. Торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай
- 2) Тохиромжгүй. Зөвхөн албадан сургалтад хамруулах хэрэгтэй
- 3) Тохиромжгүй. Торгуулийн хэмжээг бууруулах шаардлагатай
- 4) Тохиромжгүй. Торгуулийн хэмжээг хэвээр байлгаж, албадан сургалтад хамруулах хэрэгтэй
- 5) Тохиромжгүй. Нийгэмд тустай ажил хийлгэх хэрэгтэй
- 6) Тохиромжтой. Энэ хэвээр байлгасан нь зөв
- 7) Бусад _____
- 8) Хэлж мэдэхгүй

16. Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? (§6.3.1)

(Зөвхөн нэг хариулт сонгоно уу.)

- 1) Тохиромжгүй. Торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай
- 2) Тохиромжгүй. Торгуулийн хэмжээг бууруулах шаардлагатай
- 3) Тохиромжтой. Энэ хэвээр байлгасан нь зөв
- 4) Бусад _____
- 5) Хэлж мэдэхгүй

17. Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? (§6.3.2)

(Зөвхөн нэг хариулт сонгоно уу.)

- 1) Тохиромжгүй. Торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай
- 2) Тохиромжгүй. Торгуулийн хэмжээг бууруулах шаардлагатай
- 3) Тохиромжгүй. Зөвхөн зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах хэрэгтэй
- 4) Тохиромжгүй. Нийгэмд тустай ажил хийлгэх хэрэгтэй
- 5) Тохиромжтой. Энэ хэвээр байлгасан нь зөв
- 6) Бусад _____
- 7) Хэлж мэдэхгүй

18. Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? (§6.3.2)

(Зөвхөн нэг хариулт сонгоно уу.)

- 1) Тохиромжгүй. Торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай
- 2) Тохиромжгүй. Торгуулийн хэмжээг бууруулах шаардлагатай
- 3) Тохиромжгүй. Зөвхөн зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах хэрэгтэй
- 4) Тохиромжгүй. Зөвхөн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хэрэгтэй
- 5) Тохиромжтой. Энэ хэвээр байлгасан нь зөв
- 6) Бусад _____
- 7) Хэлж мэдэхгүй

Хавсралт 2. САНАЛ АСУУЛГЫН ДҮН

ЕРӨНХИЙ АСУУЛГА

1. Аймаг, нийслэл

1.	Архангай	3.2
2.	Баян-Өлгий	1.7
3.	Баянхонгор	4.4
4.	Булган	2.0
5.	Говь-Алтай	4.1
6.	Говьсүмбэр	0.9
7.	Дархан-Уул	0.6
8.	Дорноговь	0.6
9.	Дорнод	4.4
10.	Дундговь	4.1
11.	Завхан	6.4

12.	Орхон	0.3
13.	Өвөрхангай	3.2
14.	Өмнөговь	2.9
15.	Сүхбаатар	2.6
16.	Сэлэнгэ	2.9
17.	Төв	2.3
18.	Увс	4.4
19.	Ховд	3.2
20.	Хөвсгөл	5.8
21.	Хэнтий	5.8
22.	Багануур	1.2

23.	Багахангай	0.6
24.	Баянгол	5.2
25.	Баянзүрх	7.3
26.	Чингэлтэй	4.7
27.	Сүхбаатар	0.3
28.	Хан-Уул	6.4
29.	Налайх	2.6
30.	Сонгинохайрхан	5.8
31.	Нийт	100.0

2. Албан тушаал

1.	Аймгийн удирдлага (Засаг дарга, орлогч, ИТХ)	2.6
2.	Дүүргийн удирдлага (Засаг дарга, орлогч, ИТХ)	0.9
3.	Сумын удирдлага (Засаг дарга, орлогч, ИТХ)	51.3
4.	Хорооны удирдлага (Засаг дарга, орлогч, ИТХ)	29.2
5.	Тамгын газрын ажилтан	16.0
6.	Нийт	100.0

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ

1. Таны бодлоор “утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? (§6.7.12)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Гардаггүй	21.3%	19.7%	35.7%	21.2%
Хааяа гардаг	30.6%	31.6%	14.3%	31.1%
Гардаг	42.0%	41.0%	42.9%	42.5%
Хэлж мэдэхгүй	6.1%	7.7%	7.1%	5.2%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%
Дундаж	3.3	3.3	3.2	3.3

2. Таны бодлоор “утаат тамхийг ширхэглэн худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? (§6.7.8)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Гардаггүй	48.1%	22.2%	42.9%	62.7%
Хааяа гардаг	14.3%	23.1%	14.3%	9.4%
Гардаг	23.9%	41.0%	28.6%	14.2%
Хэлж мэдэхгүй	13.7%	13.7%	14.3%	13.7%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%
Дундаж	2.6	3.3	2.8	2.1

3. Таны бодлоор “дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины үйлдвэрлэсэн боодлыг задалж буюу ороож худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? (§6.7.8)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Гардаггүй	28.3%	25.6%	14.3%	30.7%

Хааяа гардаг	30.9%	27.4%	42.9%	32.1%
Гардаг	25.4%	29.1%	35.7%	22.6%
Хэлж мэдэхгүй	15.5%	17.9%	7.1%	14.6%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%
Дундаж	2.6	3.3	2.8	2.1

4. Таны бодлоор “21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? (§6.7.7)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Гардаггүй	32.4%	32.5%	42.9%	31.6%
Хааяа гардаг	24.5%	28.2%	14.3%	23.1%
Гардаг	32.7%	27.4%	28.6%	35.8%
Хэлж мэдэхгүй	10.5%	12.0%	14.3%	9.4%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%
Дундаж	2.9	2.7	3.0	3.0

5. Таны бодлоор “21 нас хүрээгүй хүнээр утаат тамхи худалдуулах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? (§6.7.7)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Гардаггүй	28.3%	25.6%	14.3%	30.7%
Хааяа гардаг	30.9%	27.4%	42.9%	32.1%
Гардаг	25.4%	29.1%	35.7%	22.6%
Хэлж мэдэхгүй	15.5%	17.9%	7.1%	14.6%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%
Дундаж	3.0	3.3	2.8	2.9

6. Таны бодлоор “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? (§6.7.14)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Гардаггүй	32.4%	32.5%	42.9%	31.6%
Хааяа гардаг	24.5%	28.2%	14.3%	23.1%
Гардаг	32.7%	27.4%	28.6%	35.8%
Хэлж мэдэхгүй	10.5%	12.0%	14.3%	9.4%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%
Дундаж	2.9	2.7	3.0	3.0

7. Хэрэв “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах” зөрчил гардаг гэж үзэж байгаа бол Таны бодлоор энэ төрлийн зөрчил яагаад гардаг вэ? (§6.7.14)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Хэрэглэгч байгаа	2.7%	6.3%	0.0%	1.3%
Ашиг	9.8%	18.8%	0.0%	6.6%
ЕБС-ийн ойр	40.2%	9.4%	75.0%	51.3%
Хууль хэрэгждэггүй	18.8%	31.3%	0.0%	14.5%
Хяналт, хариуцлага сул	17.9%	25.0%	25.0%	14.5%
Зөвшөөрөл	4.5%	3.1%	0.0%	5.3%
Шинэ нөхцөл үүссэн	2.7%	3.1%	0.0%	2.6%
Хууль сайжруулах	1.8%	0.0%	0.0%	2.6%
Хуулийн мэдлэг	0.9%	0.0%	0.0%	1.3%
Бусад	0.9%	3.1%	0.0%	0.0%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%

8. Таны бодлоор “утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? (§9.1)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Гардаггүй	18.1%	17.1%	21.4%	18.4%
Хааяа гардаг	30.9%	29.1%	28.6%	32.1%
Гардаг	44.3%	49.6%	50.0%	41.0%
Хэлж мэдэхгүй	6.7%	4.3%	0.0%	8.5%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%
Дундаж	3.5	3.5	3.4	3.4

9. Хуульд “ААН, байгууллага, тэдгээрийн салбар нэгжийн удирдлага хуульд заасан өөрийн эрх хэмжээний хүрээнд тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавина” гэж заасан. Та тус заалтын хэрэгжилтийг хэрхэн үнэлэх вэ? (§11.2)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Муу	23.9%	23.9%	21.4%	24.1%
Дунд зэрэг	45.5%	45.3%	42.9%	45.8%
Сайн	23.3%	23.9%	35.7%	22.2%
Хэлж мэдэхгүй	7.3%	6.8%	0.0%	8.0%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%
Дундаж	2.9	3.1	2.9	2.9

10. Хэрэв “ААН, байгууллага тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих” заалт хэрэгждэггүй гэж үзэж байгаа бол Таны бодлоор энэ заалт яагаад хэрэгжихгүй байна вэ? (§11.2)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Хяналт, хариуцлага сул	40.2%	50.0%	0.0%	37.3%
Хууль хэрэгждэггүй, нууцаар худалддаг	29.3%	28.6%	33.3%	29.4%
Ухамсрын асуудал	9.8%	10.7%	33.3%	7.8%
Ашиг олох зорилгоор худалдаалж буй учир	7.3%	7.1%	0.0%	7.8%
Хэрэглэгч, хэрэглээ байгаа учир	3.7%	0.0%	0.0%	5.9%
ЕБС-ийн ойр байршил, төлөвлөлтэй холбоотой	2.4%	0.0%	0.0%	3.9%
Зөвшөөрөлтэй худалдаалж байна	2.4%	0.0%	33.3%	2.0%
Хуулийн мэдлэг дутмаг	2.4%	3.6%	0.0%	2.0%
Шинэ нөхцөл үүссэн	1.2%	0.0%	0.0%	2.0%
Бусад	1.2%	0.0%	0.0%	2.0%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%

11. Хуульд “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина” гэж заасан. Та тус заалтын хэрэгжилтийг хэрхэн үнэлэх вэ? (§11.3)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Муу	30.6%	29.1%	35.7%	31.1%
Дунд зэрэг	59.8%	62.4%	50.0%	59.0%
Сайн	0.6%	0.9%	0.0%	0.5%
Хэлж мэдэхгүй	9.0%	7.7%	14.3%	9.4%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%
Дундаж	2.6	2.3	2.6	2.6

12. Хэрэв “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих” заалт хэрэгждэггүй гэж үзэж байгаа бол Таны бодлоор энэ заалт яагаад хэрэгжихгүй байна вэ? (§11.3)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Хяналт байхгүй	28.3%	48.5%	0.0%	19.7%
Хууль хэрэгжихгүй байна	22.2%	21.2%	0.0%	24.6%
Хариуцлаггүй	18.2%	15.2%	20.0%	19.7%

Хууль сурталчлах, нөлөөлөх ажил хийгдэхгүй байна	15.2%	12.1%	20.0%	16.4%
Тамхи татах эрэлт байна	7.1%	0.0%	20.0%	9.8%
ТББ, ТБ-ын үялдаа муу	5.1%	3.0%	40.0%	3.3%
ТББ-д урамшуулал байхгүй	4.0%	0.0%	0.0%	6.6%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%
Шинэ нөхцөл үүссэн	1.2%	0.0%	0.0%	2.0%
Бусад	1.2%	0.0%	0.0%	2.0%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%

13. Хуульд “Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Та тус заалтын хэрэгжилтийг хэрхэн үнэлэх вэ? (§11.1)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Муу	18.1%	17.9%	21.4%	17.9%
Дунд зэрэг	50.4%	53.0%	35.7%	50.0%
Сайн	26.2%	26.5%	35.7%	25.5%
Хэлж мэдэхгүй	5.2%	2.6%	7.1%	6.6%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%
Дундаж	3.1	3.2	3.1	3.1

14. Таны бодлоор “Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналт” яагаад хэрэгждэггүй вэ? (§11.1)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Тогтолцоо ойлгомжгүй	22.4%	9.5%	33.3%	29.4%
Хариуцлага хүлээлгэх субъект байхгүй	20.7%	42.9%	0.0%	8.8%
Зөвхөн сануулдаг	5.2%	9.5%	33.3%	0.0%
Муу	25.9%	28.6%	0.0%	26.5%
Бусад	25.9%	9.5%	33.3%	35.3%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 6.3 ДАХЬ ХЭСГИЙН ХЭРЭГЖИЛТ

15. Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? (§6.3.1) (Зөвхөн нэг хариулт сонгоно уу.)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Тохиромжгүй, торгууль нэмэгдүүлэх шаардлагатай	18.1%	22.2%	21.4%	15.6%
Тохиромжгүй, зөвхөн албадан сургалтад хамруулах шаардлагатай	5.0%	4.3%	7.1%	5.2%
Тохиромжгүй, Торгуулийн хэмжээг бууруулах шаардлагатай	4.1%	0.9%	7.1%	5.7%
Торгуулийн хэмжээг хэвээр байлгаж, албадан сургалтад хамруулах	10.2%	9.4%	7.1%	10.8%
Тохиромжгүй, нийгэмд тустай ажил хийлгэх хэрэгтэй	8.2%	10.3%	21.4%	6.1%
Тохиромжтой, энэ хэвээр байлгасан нь зөв	41.4%	42.7%	28.6%	41.5%
Бусад	2.3%	2.6%	0.0%	2.4%
Хэлж мэдэхгүй	10.8%	7.7%	7.1%	12.7%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%

16. Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? (§6.3.1) (Зөвхөн нэг хариулт сонгоно уу.)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Тохиромжгүй, торгуулийг нэмэх шаардлагатай	17.8%	24.8%	21.4%	13.7%
Тохиромжгүй, торгуулийг бууруулах шаардлагатай	14.0%	9.4%	7.1%	17.0%
Тохиромжтой, энэ хэвээр нь байлгасан нь зөв	50.1%	53.8%	50.0%	48.1%
Бусад	4.4%	2.6%	7.1%	5.2%
Хэлж мэдэхгүй	13.7%	9.4%	14.3%	16.0%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%

17. Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? (§6.3.2) (Зөвхөн нэг хариулт сонгоно уу.)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Тохиромжгүй, торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай	18.4%	23.1%	21.4%	15.6%
Тохиромжгүй, торгуулийн хэмжээг бууруулах шаардлагатай	6.4%	4.3%	21.4%	6.6%
Тохиромжгүй, зөвхөн зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл хэрэгсэл	4.4%	4.3%	0.0%	4.7%
Тохиромжгүй, нийгэмд тустай ажил хийлгэх хэрэгтэй	7.6%	6.8%	0.0%	8.5%
Тохиромжтой, энэ хэвээр байлгасан нь зөв	46.4%	47.0%	35.7%	46.7%
Бусад	3.5%	2.6%	0.0%	4.2%
Хэлж мэдэхгүй	13.4%	12.0%	21.4%	13.7%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%

18. Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? (§6.3.2) (Зөвхөн нэг хариулт сонгоно уу.)

	Улсын дундаж	Улаанбаатар хотод	Аймгийн төвд	Сумын төвд
Тохиромжгүй, торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай	10.8%	14.5%	21.4%	8.0%
Тохиромжгүй, торгуулийн хэмжээг бууруулах шаардлагатай	10.5%	6.0%	7.1%	13.2%
Тохиромжгүй, зөвхөн зөрчил үйлдэхэд ашигласан эд хэрэгсэл хураах	4.1%	4.3%	0.0%	4.2%
Тохиромжгүй, зөвхөн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хэрэгтэй	10.5%	12.8%	14.3%	9.0%
Тохиромжтой, энэ хэвээр нь байлгасан нь зөв	45.5%	47.9%	28.6%	45.3%
Бусад	4.4%	2.6%	0.0%	5.7%
Хэлж мэдэхгүй	14.3%	12.0%	28.6%	14.6%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%

Хавсралт 2. ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

ХҮНСНИЙ ДЭЛГҮҮР, ТҮЦ-ИЙН ХУДАЛДАГЧААС АВСАН ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

1) ХҮНСНИЙ ДЭЛГҮҮРИЙН ХУДАЛДАГЧ – СҮХБААТАР ДҮҮРГИЙН 4 ДҮГЭЭР ХОРОО

Та сайхан өвөлжиж байна уу? Таны ажиллаж байгаа хүнсний дэлгүүр аль дүүргийн хэддүгээр хороонд харьяалагддаг вэ?

– Энэ байршил маань хүнсний дэлгүүр, СБД 4 хороо, 45 дугаар сургуультай ойр байршилтай.

“Тамхины хяналтын тухай хууль”-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– За ер нь хэрэгжиж байгаа гэж боддог. Миний хувьд хэрэгжиж байгаа л гэж боддог.

Таны бодлоор “утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– Гардаг шүү дээ.

Таны бодлоор “утаат тамхийг ширхэглэн худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– Энэ ТҮЦ-д тамхи ширхгээр зараад байдаг.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, модруулбал, “21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Гардаггүй.

“21 нас хүрээгүй хүнээр утаат тамхи худалдуулах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Тэгж аймар гардаггүй ш дэ. Яагаад гэвэл 21 хүрээгүй хүн дэлгүүрт ажиллаад байдаггүй.

Таны бодлоор “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Хориглосон болохоор зардаггүй.

Таны бодлоор “утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Одоо харьцангуй гайгүй болсон татахгүй байгаа ш дэ.

Тамхины хяналтын тухай хуульд “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина” гэж заасан байдга. Сая дурдсан байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– Тийм ирдэг цагдаа ирсэн.

Хуульд “Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засагийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байдга. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Тийм. Манайх тамхи зардаггүй болохоор. Цагдаагаас хорооноос ирж шалгаад байдаг.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Тохиромжтой

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– 500 мянга, арай өндөр байна дүн нь. 300 орчим мянга байвал зүгээр.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Хувь хүнийг юм уу, татах ёсгүй газар татсаныг юм уу, аан за за болно гэж бодож байна.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Тохиромжгүй юм биш үү жоохон уян хатан байвал тэ. 3 сая арай өндөр байна 1 сая орчим байвал.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– Байхгүй ээ. Баярлалаа

2) ХҮНСНИЙ ДЭЛГҮҮРИЙН ХУДАЛДАГЧ – ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 1 ДҮГЗЭР ХОРОО

Та сайхан өвөлжиж байна уу? Энэ ажлыг хийгээд/албан үүргийг гүйцэтгээд хэр удаж байна вэ? Таны ажиллаж байгаа ТҮЦ/хүнсний дэргүүр/хариуцсан хэсэг аль дүүргийн хэддүгээр хороонд харьяалагддаг вэ?

– Энэ байршил маань хүнсний дэлгүүр, ЧД 1 хороо, 23 дугаар сургуультай ойр байршилтай.

“Тамхины хяналтын тухай хууль”-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– За хэрэгждэг манайх зардаггүй ш дэ. Яагаад гэвэл хажууд 23 сургууль байгаа. 20-оос 30 метр зайтай сургуулиас.

Таны бодлоор “утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– Байгаа шүү дэ, яагаад гэвэл хүмүүс хэрэглээ ихтэй юм байна лэ. Гардаг шүү дэ.

Таны бодлоор “утаат тамхийг ширхэглэн худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– Манайх бол ерөөсөө зардаггүй, яагаад гэвэл сургуульд ойр, зөвшөөрөл байхгүй болохоор.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, тодруулбал, “21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Гардаггүй, өгдөггүй.

“21 нас хүрээгүй хүнээр утаат тамхи худалдуулах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Гардаггүй байхаа.

Таны бодлоор “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Ер нь зөвшөөрөлгүй л бол зардаггүй ш дэ.

Таны бодлоор “утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Гадуур хаа сайгүй л хүмүүс татаж байдаг шүү дэ.

Тамхины хяналтын тухай хуульд “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина” гэж заасан байдэг. Сая дурдсан байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– Үгүй таарч байгаагүй.

Хуульд “Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байдэг. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Тийм. Цагдаатай хамт байцаагч явдаг шүү дэ.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Боломжийн шүү дэ, гэхдээ хүмүүс хэрэгжүүлдэггүй л дэ.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Тохирохгүй байхаа, хүмүүс ийм ядуу байхад. Яг нөгөө цэгээ тавиад л Солонгос шиг. Хүмүүс тэнд нь бөөгнөрч татчихаад л яваад байвал ядаг юм гэж бодож байна.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг 500,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Яг одоо бол тохирохгүй байхаа, хүмүүс хаа сайгүй л тамхи татаад явж байдаг. Зарим нь торгуулна зарим нь боломжгүй. Тэгэхээр хэнийг нь торгоод хэнийг нь үлдээх вэ дэ.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Хуулийн этгээдийг 3 саяаар торгож болох байхаа.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– Тамхи заруулахгүй гэдэг сургуулийн орчинд. Тэртээ тэргүй нууцаар зараад л байдаг шүү дэ. Худалдагчид хүүхдээ хараад таньж байгаа юм чинь сургуулийн орчинд байгаа дэлгүүр ТҮЦ-д тамхи зарах зөвшөөрлийг нь өгөөд хүүхдэд л зарахгүй байвал дээр.

3) ТҮЦ-ИЙН ХУДАЛДАГЧ – БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 1 ДҮГЭЭР ХОРОО

Та сайхан өвөлжиж байна уу? Энэ ажлыг хийгээд/албан үүргийг гүйцэтгээд хэр удаж байна вэ? Таны ажиллаж байгаа ТҮЦ аль дүүргийн хэддүгээр хороонд харьяалагддаг вэ?

– Энэ байршил маань ТҮЦ, БГД 1 дүгээр хороонд байдаг.

"Тамхины хяналтын тухай хууль"-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– Ер нь дажгүй хэрэгждэг гэж боддог. Яагаад гэвэл тамхи зарахыг хорьсон газар шалгалт их орж ирдэг юм шиг байна лэ.

Таны бодлоор "утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– Ер нь сургуулийн ойр зарахыг хорьдог.

Таны бодлоор "утаат тамхийг ширхэглэн худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– Энийг ёстой мэдэхгүй байна.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, тодруулбал, "21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Ер нь хүнийг 21 хүрсэн эсэхийг шууд хараад мэдэхгүй ш дэ. Орж ирээд л тамхи авъя гэнэ.

"21 нас хүрээгүй хүнээр утаат тамхи худалдуулах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Ёстой мэдэхгүй.

Таны бодлоор "ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Байхгүй байх гэж бодож байна.

Таны бодлоор "утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Ер нь буруу л да. Татдаггүй хүмүүс зөндөө байгаа шүү дэ. Тэднийгээ хүндлээд зөвшөөрсөн газраа л татах хэрэгтэй.

Тамхины хяналтын тухай хуульд "хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина" гэж заасан байдаг. Сая дурдсан байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– Одоогоор гараагүй л байна.

Хуульд "Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу

хэрэгжүүлнэ" гэж зөвсөн байдга. Хуулийн энэ заалтад зөвсөн төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Цагдаа хааяа орж ирдэг.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Ер нь хориглосон газар татахгүй байх хэрэгтэй л дэ. Зөв гэж бодож байна.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Ер нь хориглосон газар л бол болохгүй дэ. Зөв л гэж бодож байна.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг 500,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Арай л өндөр дүнтэй бн. 300 мянга гэдэг чинь их мөнгө шүү дэ. Яг хэд байвал болохыг мэдэхгүй л байна. Энэ 300 мянга нь бол өндөр байна.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– 3 саяаар торгох арай л үнэтэй байна. 300 мянга л байвал болох байх.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– Байхгүй ээ.

4) ТҮЦ-ИЙН ХУДАЛДАГЧ – БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 14 ДҮГЭЭР ХОРОО

Та сайхан өвөлжиж байна уу? Энэ ажлыг хийгээд/албан үүргийг гүйцэтгээд хэр удаж байна вэ? Таны ажиллаж байгаа ТҮЦ аль дүүргийн хэддүгээр хороонд харьяалагддаг вэ?

– Энэ байршил маань ТҮЦ, БЗД 14 хороонд байршилтай. 5 дахь жилдээ ажиллуулж байна.

"Тамхины хяналтын тухай хууль"-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– Энэ ч тааруухан шүү дэ, яагаад гэвэл тэр хуульд чинь гадуур гудамжаар бас зарим газарт татаж болохгүй гээд байдаг. Харин хаа сайгүй л гудамжинд буудал дээр өмхий үнэртүүлээд татаад байдаг ш дэ.

Таны бодлоор "утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– За энэ чинь бас нээх сайн хэрэгждэггүй байхаа. Нууж хаагаад л зараад байх шиг байдаг да.

Таны бодлоор "утаат тамхийг ширхэглэн худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– Би тэрийг яг сайн хэлж мэдэхгүй байна. Шөнө орой зардаг л байх. Манайх бол зардаггүй л дэ.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, тодруулбал, "21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Ер нь зарна даа. ТҮЦ-ний юмаа зарж байж амьдарч байгаа болохоор хүн юм авахаар хүрээд ирвэл өгөөд л явуулна шүү дэ.

"21 нас хүрээгүй хүнээр утаат тамхи худалдуулах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Ер нь гадуур тэгж зардаг байж магад. Манай ТҮЦ-д хүүхэд суудаггүй би л өөрөө суудаг.

Таны бодлоор "ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Наадахыг чинь эгч нь мэдэхгүй байна. Би өөрөө өөр газар суудаг болохоор.

Таны бодлоор "утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Татахыг хорьсон газарт, би түрүүн хариулчих шиг болсон до. Явган замаар татаад л тэр нь ам хамар руу ороод л хүүхдүүд ард нь яваад л байдаг. Нилээн том байгууллага л зөвшөөрсөн цэг гаргадаг байх. Жижиг газрууд бол гадаа, хаа сайгүй л татаж харагддаг.

Тамхины хяналтын тухай хуульд “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина” гэж заасан байдаг. Сая дурдсан байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– Байдаг байдаг, хүмүүс асуугаад л тийм юм яриад л явдаг. Яг ямар байгууллага гэдгийг санахгүй, мэдэхгүй байна.

Хуульд “Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Аан хийнэ хийнэ, Заримдаа Цагдаа явдаг.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Аан юу юм л да. Хууль байхад хэрэгжүүлэх л хэрэгтэй шүү дэ. Нэг удаа торгууль төлөөд л дараа нь тийм юм хийхгүй тэр хүн. Би тэгж л бодож байна. Зөв зөв.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Одоо хуулиа л хэрэгжүүлмээр байна. Байгууллага үүргээ биелүүлэх ёстой. Ер нь хяналт шалгалт байж хууль хэрэгжих юм байгаа биз дэ. Зөрчсөн бол торгох нь зөвөө.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

За одоо 300 мянгаар торгоод байвал зарах хүн гарахгүй байхаа гэж бодож байна.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

Наадах чинь одоо торгууль нь бүр ихсээд л байна тэ. Одоо ТҮЦ чинь ААН мөн билүү. Их л өндөр санагдаж байна шүү дэ. Ихдээ л 500 мянга байвал, гэхдээ 500 мянга ч өндөр л байна шүү дэ.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

За одоо хаа хаанаа л. Бүх газар бүх хууль хэрэгждэг бол сайхан л байна. Даанч тийм юм байхгүй л байна л да.

5) ТҮЦ-ИЙН ХУДАЛДАГЧ – ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 5 ДУГААР ХОРОО

Та сайхан өвөлжиж байна уу? Энэ ажлыг хийгээд/албан үүргийг гүйцэтгээд хэр удаж байна вэ? Таны ажиллаж байгаа ТҮЦ аль дүүргийн хэддүгээр хороонд харьяалагддаг вэ?

– Би энэ ТҮЦ-ийг 6-7 дахь жилдээ ажиллуулж байна. Энэ байршил ХУД 5 дугаар хороо.

“Тамхины хяналтын тухай хууль”-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– Энэ хууль бол хүүхдийн байгууллагын сургууль, цэцэрлэгийн орчинд хэрэгжиж байгаа гэж бодож байна. Манайх бол сургуулиас 500 метрт байдаг.

Таны бодлоор “утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– За энэ заалт зөрчигдөж байгаа шүү. Зарим нэг дэлгүүр, ТҮЦ орой үдшийн цагаар хүмүүст зарж л байдаг юм билээ. Нууцаар.

Таны бодлоор “утаат тамхийг ширхэглэн худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– Зарим газар орлогоо бодоод зардаг.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, тодруулбал, “21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Зардаг газрууд нь орлогоо бодоод зардаг.

“21 нас хүрээгүй хүнээр утаат тамхи худалдуулах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Манайд бол би өөрөө л суудаг. Хүүхэд суудаггүй. Зарим газарт хүүхдүүд сууж харагддаг. Гэхдээ анзаарч мэдсэн юм алга.

Таны бодлоор “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Гайгүй байхаа. Яг тийм сургуулийн ойр газруудад тамхи зардаггүй шүү.

Таны бодлоор “утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Энд тэнд яваад харж байхад хүмүүс тэр тамхины цэг гэсэн газруудад бөөгнөрсөн татаж харагддаг л юм.

Тамхины хяналтын тухай хуульд “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина” гэж заасан байдаг. Сая дурдсан байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– Байхгүй.

Хуульд “Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Аан хийж байсан, Орж ирж хийж байсан.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Арай л өндөр юм шиг санагдаад байдаг. 20,000 байвал л болно.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Хуулийн этгээд гэхээр одоо... Энэ бас бодомжгүй. Тэр бүр хүнийг дагаад явна гэж байхгүй шүү дэ. 50 60 хүн ажилладаг байгууллага байлаа гэхэд бүгдийг нь татах нь гээд дагаж чадахгүй. Тэгэхээр өндөр байна.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах швардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Тохиромжгүй. Өнөөдөр гэр хорооллын ТҮЦ тамхи ширхгээр зарж байж л орлогоо олж байна. Хэрэв заруулахгүй л гэдэг хууль байгаа юм чинь заруулахгүй л байх ёстой.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах швардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Энэ бол болох юм. Бүхэл бүтэн том байгууллага дэлгүүр мэдээж тамхи авчраад ширхэглээд зарна гэж байхгүй.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– Байхгүй ээ. Баярлалаа

ЕБС-ийн НИЙГМИЙН АЖИЛТНУДААС АВСАН ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

1) ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН

"Тамхины хяналтын тухай хууль"-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– Өмнөх Тамхины тухай хуулийг бодвол одоо мөрдөж буй Тамхины хяналтын тухай хууль нарийсаж гарч ирсэн болохоор бидэнд хүүхдүүд залуучууд руу их чиглэсэн заалтуудтай учраас урьдчилан сэргийлэх алхмуудыг маш сайн оруулсан хууль гэж харж байгаа. Мөн сургуулийн орчинд хориглох, хязгаарлах зүйлүүдийг аягүй сайн гаргаж өгсөн юм болов уу. Тэр утгаараа хүүхэд залуучуудын тамхины хэрэглээг бууруулахад маш үнэ цэнтэй, ач холбогдолтой байна гэж харж байгаа. Их сайн хэрэгжиж байна гэж харж байна.

Ер нь ямар зөрчил ихэвчлэн гардаг вэ? Яагаад?

– Манай сургууль дээр утаат тамхитай холбоотой зөрчил харьцангуй гайгүй шүү. Утаат тамхины асуудал ер нь байхгүй. Нөгөө яриад байгаа шинэ төрлийн л зүйлийг сонирхоод байгаа гэдэг гэхээс биш утаат тамхи миний ажиллаж байгаа үед л лав утаат тамхи татаад аваад яваад байгаа юм ер нь маш бага. За яахав гудамжинд хүүхдүүд, эсхүл нэг танихгүй ах надаар тамхи аваад өг гэсэн ч гэдэг юм уу нэг ийм ойр зуурын асуудал, гомдол, тиймэрхүү юм бол байдаг. Манайд санамж, анхааруулга, зөвлөгөө, урьдчилан сэргийлэх ажлуудыг нэлээн хийсэн. Хийж байгаагийн үр дүнд бол утаат тамхины асуудал бол манай сургууль дээр асар бага гэж хэлж болно. Багш нар, ажилтнууд дээрээ ч гэсэн бид нар маш их хяналт тавьж байгаа.

Тамхины хяналтын тухай хуулийн зүйл, заалтуудаас амьдралд буухгүй, хэрэглэгддэггүй зохицуулалт Таныхаар байна уу?

– Байр, талбай болон тамхи татах бүстэй холбоотой асуудал юмуу. Одоо сургуулийн урдуур хойгуур яваад байгаа ч юм уу хүүхдээ хүлээж байгаа хүмүүс тамхи татах зөрчил ажиглагддаг. Магадгүй тэр цэг нь байхгүй байна уу? Цэгээ бас мэдэхгүй байна уу? Бид ковидийн өмнө сургуулийн орчмын 500 метрийн бүсэд ажиглалт хийж үзэхэд манай тамхи татах цэг бүхий бүс гэвэл сүхбаатарын талбай хамаарч байсан. Сүүлийн үед ямар болж байгааг сайн мэдэхгүй байна. Бас нөгөө электрон тамхитайгаа зууралдаад л байна шүү дээ.

Таны бодлоор "утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– Энэ хавийн ТҮЦ-үүд бол гайгүй. СУ, ойрхон Марс худалдааны төв болон хүнсний дэлгүүрүүд байгаа. 200 жоохон гаран метрт байдаг юм. Бид нар энэ дээр нэлээн хяналт тавиад албан тоотууд жил болгон өгөөд хамтраад явчихдаг. Бид нар уг нь тийм шаардлага тавих эрхгүй ч гэсэн захирлын албан тоот бичиг аваад хяналтын хуулиа яагаад 21-ээс доош насныхан, хүүхдүүд бидний үйлчлүүлэгч нар учраас ойр хавийнхаа хүнсний дэлгүүрүүдийг нэлээн хашраагаад явчихсан. Жаахан дулаан орохоор хүүхдүүд гадуур дотуур явах нь ихэсдэг тиймээс санамж байна уу, хаана байршуулсан бэ? Гээд албан бусаар иргэдийн хяналт байдлаар хянадаг учир гайгүй байдаг. Судалгаад үзэхээр Марсад бол зардаг юм байна лээ. Энэ Чонон бүрдийн цаана дэлгүүрт хүүхдүүд бол зардаггүй. Манайх 21-ээс дээш насны хүнд худалдана гэдэг санамжаа харуулдаг. Манай энэ хорооны цагдаа нар чинь бас их дажгүй ойрхон байдагтай ч холбоотой юм уу хамтраад ажилладаг.

Таны бодлоор "утаат тамхийг ширхэглэн худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– Ширхэглэн зарж байгаа зүйл бол энэ хавьд байхгүй.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, тодруулбал, "21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Манай ойр тойрны дэлгүүрүүд 21 нас хүрээгүй хүүхдүүдэд тамхи зарах асуудал харьцангуй бага байдаг. Бид нар өөрсөө шаардлага сайн тавьж, хяналт тавьдаг болохоор. Заримдаа хорооныхоо цагдаа, хэсгийн байцаагч нартай хамтарсан багаар хяналт тавьдаг.

Таны бодлоор "ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Сургууль орчмоор ерөнхийдөө электрон тамхийг бол татаж явж байгаа харагдаад байгаа болохоос утаат тамхи ер нь харагдахгүй ээ гайгүй шүү байхгүй надтай лав таардаггүй. Багш нар, залуу эцэг эхчүүд ч юм уу манай ажилтнууд хүртэл мэдээлэл өгдөг шүү дээ. Эцэг эхчүүдийн хараа хяналт сайжирсан ч юм уу, бас эцэг эхийн эргүүлүүд бас бид нарт их тустай ажиллаж байгаа.

Тамхины хяналтын тухай хуульд "хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина" гэж заасан байдаг. Сая дурдсан байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– ТББ-тай хамтарч ажилладаг. Манайд өсвөрийн сэргийлэгч бүлгэм гээд хүүхдүүдийн үүсгэл санаачлагын байгууллага. Гол зорилго нь ерөөсөө л хүүхдийг эрсдэл, гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх гэх мэтчилэн

цагдаагийн байгууллагын зөвлөмж чиглэл дор ажилладаг. Тэд нар маань бас эргүүл тойруул хийчихдэг. За тэгээд нөгөө Хар тамхинаас иргэдийг хамгаалах нийгэмлэг гээд Лхагвасүрэн даргатай хамтарч хамгийн сүүлд бид нар Тамхины хяналтын тухай хуулиар сургалт хийгээд сургагч багш, хүүхдүүдэд мэдээлэл хийсэн. Мөн хичээл амрахын өмнө өрхийн эмчтэйгээ электрон тамхины сургалт сурталчилгаа нөлөөллийн ажил хийчихсэн. Одоо бид нар тамхины талаар илтгэгч судлаач Отгонбаяр гээд судлаачтай ирэх 7 хоногийн нэг дэх архи тамхины хор хөнөөлийн талаар сургалт хийнэ. Хүүхдүүдэд давтамжтай ярьж байхгүй бол бусдын нөлөөлөлд орчихдог. Нэг бичлэг үзээд л гоё юм байна гээд л турших гээд л. Энэ бол насны онцлог учраас. Тэгэхээр бид нар урьдчилан сэргийлэх ажил бол миний ажлын 70 гаруй хувийг эзэлж байна. Нөлөөллийн ажлуудаа зөвхөн сургалт гэлтгүй уралдаан тэмцээн, асуулт хариулт, гарын авлага, постор мэдээллүүд, телевизийн шторк, өөрсдийнх нь дунд янз бүрийн хөөрхөн видео контент ч юм уу олон аргыг ашиглаж байна.

Хуульд "Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ" гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Дүүргийн зүгээс дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтсийн байцаагч, хүүхдийн байцаагч нартайгаа бол байнга хамтарч ажилладаг. Улирал тутамд зөвлөгөө хийнэ, асуудалтай хүүхдүүдийг цуглуулж байгаад ч хамаагүй яриа хийдэг. Манай хорооны цагдаагийн хэлтэс бол үнэхээр сайн ажилладаг. Манай 1 дүгээр хорооны цагдаагийн ажилтнууд хороо руугаа өгчихдөг. Цагдаа нь сургуулиудаа ингээд хуваагаад хариуцчихдаг бас хөдөлгөөнт эргүүлүүд хяналт тавьдаг.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Бид нар торгох эрхгүй учраас амаар л торгоно шүү, торгуулдаг шүү гэж л хэлдэг. Би үнэртэж байвал хөөе чи үнэртээд байна шүү дээ тамхи гэхээр үгүй ээ манайд одоо ингээд аав маань татчихсан юм аа машин дотор ингэсэн л гэдэг юм ярина шүү дээ. Жишээ нь тэгэхээр за тэгвэл танай аав чинь одоо торгуульд орох нь байна шүү дээ ч гэж хэлэхээс биш өөрснөө бол торгож чадахгүй, мэдэхгүй, торгож байгаагүй зөндөө л хэлж байсан. Торгуулийн мөнгөө бэлдэнэ шүү та нар л гэдэг. Ямар арга хэмжээ авдгийг хүүхдүүд сонирхоно, зарим нь ч мэдэхгүй. Торгох асуудал бол шөт дараалалтай ч юмуу, биднээс хол байдаг. Хэрэв нийгмийн ажилтанд торгох эрхийг нь өгвөл шууд л хэрэгжинэ. Гэхдээ нийгмийн ажилтан чинь хүүхдээ эрсдэлээс сэргийлдэг, зөвлөн тусалдаг найз нь байх ёстой байтал сургууль дээр цагдаа нарын хүрэлцээгүйгээс болоод заримдаа цагдаа шиг жижиг ажлууд хийх тохиолдол гардаг. Ингээд 2 дүрд орчхож байгаа байхгүй юу.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Бид нар боловсролын хяналтын ажилтнуудруугаа тамхины хуулийг зөрчиж буй үйлдлүүдийг зургаар баталгаажуулаад явуулдаг. Тийм журамтай. Тэгээд тэд нар ирээд шалгачихдаг юм бас цагдаадаа хэлчихдэг.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг 500,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Сайн мэдэхгүй байна. Ер нь зарж байвал хураадаг байх шүү.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– Хүүхдүүдийн хувьд шинэ юмыг л сонирхдог. Одоо цахилгаан дугуй, цахилгаан тамхи ч гэдэг юм уу нөгөө дижитал үеийнхэн гэдгээрээ тэр шинэ трендүүд, дэлхий нийтийн хандлагаа их дагаж л байна. Одоо түүнийг сонирхохгүй байх юм бол бас энэ орчин, хүн биш болчих гээд байгаа л юм шиг өөрөөсөө боддог. Тиймээс бид нарын зүгээс эерэг сурталчилгаануудыг сайн хийж өгөхгүй л бол тэндээс хангалттай мэдээллийн урсгалуудыг аваад байгаа байхгүй юу. Нэг ёсондоо сайн гоё гээд л. Ингээд л нөгөө реппер янз бүрийн шүтэн бишрэгч нар нь хэрэглээд байгаа учраас хүүхдүүд тэрийг хүссэн хүсээгүй хэрэглэх сонирхох, сорж үзэх үзэгдэл их байна. Тэгээд за мэдээж их мөнгөний боломж бололцоо бас энэнд нөлөөлж байгаа. Гэр оронд нь татдаг хүмүүс их байдаг юм байна. Одоо манай ах, эгч, ээж, аав хүртэл татдаг. За тэгээд зарим нь ингээд хураагдаад ирэхээрээ ээжийнхээ аавынх ч гэдэг юм уу, эсхүл эгчийнх гээд, за тэгээд иймэрхүү одоо бид нар амаар л болохгүй, болохгүй, хортой гээд л ингэдэг. Тэгсэн чинь 2024 оны 10 сарын 15-нд сайдын тушаал гарсан нь бид нарт баримжаатай болсон. Тэгээд би нэг хяналтын хуудас гаргаад ажиллаж үзсэн боломжийн байна гэж үзэж байгаа.

Цахилгаан тамхи бол хуульгүй гээд ингээд томроод байгаа. СИ бол худалдан борлуулах, татан авахыг зөвшөөрөө гэсэн зөвшөөрлийн бичгээ үзүүлдэг. Тийм болохоор бид нар яаж болохгүй, гол нь та нар битгий зараарай л гэж хэлдэг дээ. Тэгэхээр бас шинэ тутам байгууллага учраас бас тэр тал дээрээ анхаардаг юм байна л гэж би бодсон шүү дээ. Гэхдээ л зардаг байж магадгүй ээ бид нар ямар байнгын тэд нарыг хараад зогсох юм биш.

2) ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 18 ДУГААР СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН

“Тамхины хяналтын тухай хууль”-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– Сургуулийн орчинд бол 500 метр гэсэн нь үндсэндээ манай энд бол хэрэгжихгүй байна. Жишээлэхэд гадаах түүц, дэлгүүрүүдэд утаат тамхи зарагдаж л байна. Бид нар урьд нь, одоо ч цагдаа нартай шаардлагаа тавьж л байсан. Гэхдээ энэ байдлаа засахгүй ингээд явж л байна. Хүүхдүүд өр нь утаат тамхи харьцангуй гайгүй болсон шүү. Одоо бол нөгөө электрон тамхи гэдэг юм орж ирээд утаат тамхийг хэрэглэх нь нэлээн багассан.

Өр нь ямар зөрчил ихэвчлэн гардаг вэ? Яагаад?

– Хүүхдүүд утаат тамхи татахын тулд энд тэндхийн булан тохойд нуугдаж татдаг. Өдөр “school police”-оор хяналт тавиулна л даа. Хичээл тарах үед хяналт тавиулна. Тэгэхдээ нууцаар тамхи татах тийм сонирхолтой хүүхдүүд бас байна.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, тодруулбал, “21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Хууль хэрэгжихгүй байгаа нэг зүйл нь нөгөө 21 нас хүрээгүй хүнд тамхи зарахгүй байтал тамхи зараад байгаа байхгүй юу. 21 нас хүрээгүй хүнд тамхи зарахгүй гэдэг энийгээ л биелүүлэх ёстой байхгүй юу. Мэдээж эцэг эх нь үр хүүхдэдээ тамхи өгөх юм гэж хэзээ ч байхгүй шүү дээ. Тэд нар хаанаас олж аваад байгаа юм гэвэл дэлгүүр, түүц, хүнсний дэлгүүрүүдээс л олж авч байна шүү дээ. Түүцээр амьдралаа залгуулдаг хүмүүсийн хувьд зарж болно гэхдээ хуулиа дагаад 21 нас хүрээгүй хүүхдэд зарахгүй байх нь чухал байна. Хуучин гар дээрээс ширхгээр зардаг байсан нь байхгүй болсон. Жижиг дэлгүүр, ТҮЦ-үүд байна. Энэ хавьд автобусны буудлууд дээр байгаа ТҮЦ-үүд л насанд хүрээгүй хүүхдэд энэ утаат тамхи зарахаа больчих хэрэгтэй байна. Автобусны буудал дээрх ТҮЦ-үүд бол ширхгээр зараад л явж байна. 10 жилийн хүүхдүүд нэг ширхгээр л авна өө тийм 10 жилийн хүүхдүүд ширхгээр авна.

“21 нас хүрээгүй хүнээр утаат тамхи худалдуулах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Тэр нь бол гайгүй байх аа.

Таны бодлоор “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Хүүхдэд тамхи зарах бол их байна. Жишээлбэл, энэ түүцүүд, зочид буудал, автобусны буудлууд байна. Сургуулийн урд 2 буудал байна. Одоо автобусны буудал нь эндээс хэдхэн метрт байна. 300 метр хүрэхгүй. Тэгэхлээр нөгөө 500 метр гэдэг бол ерөөсөө л болохгүй байгаан. Гэхдээ 500 метр байлаа гээд татахаа хүрвэл хаана ч байсан олоод л татна шүү дээ.

Таны бодлоор “утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Сургууль орчимд тамхи татах нь өр нь гайгүй болчихсон. Тамхи татах цэгүүд ч цөөрсөн байна. Хүүхдүүд бол утаат тамхийг сургууль дээр өр нь татдаггүй. Нуугдмал газар, хүн харахгүй газар л олж нууж л татна. Тэрийг нь хойноос нь хөөж явз олно гэдэг бол худлаа. Хуучин сургууль дээр 00 өрөөнд нууж татдаг байсан явдал бол больсон. Сургуулийн орчин болон хашаанд зарим эцэг эхчүүд тамхи татах гээд байгаа бол сургуулийн орчин тул хашаанаас гараад татаарай гэж хэлээд гаргадаг. Тэгээд хашааны гадаа гараад л татна. Жишээлбэл, энэ яг урд талд байр байгаа байхгүй манайхтай урагшаа залгаа л даа. Энд тамхи татах тамхины цэг, сандал байдаг. Тэнд татаад л байж байдаг. Хэрэв хүүхдүүд утаат тамхи татаж байвал баримтжуулаад авдаг.

Тамхины хяналтын тухай хуульд “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина” гэж заасан байдаг. Сая дурдсан байгууллагуудас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– Төрийн бус байгууллагуудын зүгээс бол нэг их тийм оролцоо байхгүй.

Хуульд “Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Хорооны цагдаа, хүүхэд гэр бүл боловсролын хэлтэстэйгээ л хамтарч ажилладаг. Сургууль дээр өсвөрийн цагдаа гэж байдаг. Тэд нараараа хяналт тавиулнаа бас. Бас school police хийж байгаа аав, ээж нар сургууль тойрч явна, зам дээр зогсоно, ойр хавийн түүцүүдэд хяналт тавьнаа. Хороо, дүүргийн зүгээс чиглэлүүд л өгнө. Заримдаа аян зохион байгуулвал тэр талаарх тайлангаа хороо, дүүрэгтээ хүргүүлдэг. Хорооны сайн

дурын эргүүлүүдтэй сургууль хамтрахдаа хүүхдүүд зам тээврийн осол орох вий, согтууруулах юм уу мансууруулах бодис юу хэрэглэсэн байх вий гэдэг дээр хяналт тавихад хамтардаг. Өглөө бүр орж ирж бидэнд мэдээлэл өгдөг. Жишээлбэл бага ангийн хүүхдүүд ганцаараа явж байна уу гэх мэт.

Хяналт тавихад хуулийн хүрээнд тулгамдсан асуудал байдаг уу?

– Насанд хүрээгүй хүнд тамхи зарахаа болиод түүн дээр маш сайн анхаараад л хяналт тавих хэрэгтэй байна. Хяналт тавих асуудлыг цагдаагийн байгууллага л анхаарах байх. Жишээлэхэд, хүүхдэд тамхи зарчихсан байна гээд очиход ямар нэг арга хэмжээ авах эрх байхгүй. Тэгээд аргаа бараад цагдаад л хэлнэ, хороонд мэдэгдэнэ дээ.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– За одоо бараг хэрэгжихгүй байх аа наадах чинь хэрэгждэггүй байх. Хэцүү шүү дээ наадах чинь. Хэрэв сургууль дээрээ нэг хүүхэд тамхи татаж байгааг бариад авлаа тэрийг 50 мянган төгрөгөөр торгоно гэвэл ёстой худлаа. Ээж аавыг нь дуудна цагдаа сэргийлэх болно. Тэгээд л ямар ч байсан аль болохоор одоо тамхинаас урьдчилан сэргийлэх л юм хийж байгаа байхгүй юу. Тэнд чинь тэ энэ хор ийм хортой шүү юм ужигтай шүү гээд. Гэхдээ нэг ийм бидэнд бас нэг ийм алдаа байна. Байнга энэ тамхи ийм шүү, тийм шүү гээд байх чинь сүүлдээ нөгөө хүүхдүүддээ реклам болчихож байгаан. Буцаагаад ийм сөрөг зүйл болж байна шүү. Нэг хэсэг тамхи бол мансууруулах бодис гээд л битүү сургалтууд явдаг байсан байхгүй юу. Энэ нь сүүлдээ нөгөө хүүхдүүддээ бол сэдэл төрүүлчихсэн.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг 500,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Манай энэ чинь бас хотын төв бүс шүү дээ тэ? Тэгэнгүүт чинь одоо өчнөөн баар сав ингээд л одоо хоолны газар мазрууд гээд л бодвол тэр дотроо тамхи цэг байдаг л юм байна лээ л дээ. Бидний хувьд хүүхдүүдийг л тамхи татуулахгүй байхад л чиглэж ажилладаг.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– Санал бол одоо ерөөсөө л ганцхан санал байна. Энэ электрон тамхийг хилээр оруулж ирэхийг болих хэрэгтэй. Ер нь ахлах ангийн хүүхдүүд их байна. Одоо ингээд хураагаад байж л байна. Хурааж авахаас өөр арга алга байна. Энхийг чинь бас тамхи гэхээр яг Тамхины хяналтын тухай хуулиар торгох юм байхгүй юм байна. Энэ бол хүний биед маш хортой байхгүй юу. Манайх гадаад хэлний сургууль учир гадагшаа нилээд явдаг. Хятадад гэхэд электрон тамхи татахыг хориглочихсон байна. Маш олон улс татгалзаж байна. Зүгээр л оруулж ирэхийг л болих, ирээдүйгээр бодож л байгаа бол зүгээр л хориглох хэрэгтэй. Одоо 5,6 дугаар ангийн хүүхдүүд хүртэл барьчихсан явж байна. Тэгээд асуухаар олсон гэж хэлдэг. Сургуулийн хажуу талын СУ, GS25 бүгд зарж байна. Манай сургуулийн хажууд электрон тамхины том дэлгүүр 100 метр дотор л байна. Насанд хүрээгүй хүүхдүүдэд зараад л байж байна. Цахилгаан тамхины хувьд Тамхины хуулиар зохицуулаагүй учир хэцүү байна. Цахилгаан тамхи бол утаат тамхинаасаа хортой зүйл. Тамхины хяналтын одоогийн хууль бол давгүй хууль. Гол нь хуулиа л сайн хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Насанд хүрээгүй хүүхдэд тамхи зарахгүй байх, тамхи татах цэг зэргийг нь нарийн л хийгээд өгчих хэрэгтэй.

3) ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 21 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН

“Тамхины хяналтын тухай хууль”-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– Хууль хэрэгжилт муутай байна. Олон нийтийн газарт тамхи татахыг хязгаарлах заалт байгаа ч хүмүүс хаа сайгүй тамхи татдаг. Гадаадын зарим оронд тамхи татах тусгай цэгүүддээ л татдаг бол манайд хүүхдээ хүргэж өгч байхдаа хүртэл тамхи татдаг эцэг эх олон. Сургуулийн хичээлийн байрнаас 500 метр гэсэн заалт бол хэрэгжихгүй байна. Өмнө нь гэр хорооллын сургуульд ажиллаж байхад утаат тамхи их байсан. Харин төвийн сургуулиудад утаат тамхи багассан ч электрон тамхи хэрэглээ нь нэмэгдсэн. Хүүхдүүд утаат тамхи татахаа бараг больчихсон, харагдахаа больсон байна.

Тамхины хяналтын тухай хуулийн зүйл, заалтуудаас амьдралд буухгүй, хэрэглэгддэггүй зохицуулалт Таныхаар байна уу?

– Хүүхдүүд электрон тамхийг ихээр хэрэглэж байна. Олонх нь өөр хоорондоо худалдаалж, нэгнээсээ хямд үнээр худалдан авч байна. Энэ нь хууль, хяналтын байгууллагуудаас төдийлөн анхаарагдаагүй асуудал болж байна. Хяналт сул байна. 21 нас хүрээгүй хүүхдүүдэд тамхи худалдаалахыг хуулиар хориглосон ч олон хүн үүнийг зөрчиж байна.

Таны бодлоор "утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– Тамхийг хаа сайгүй л зарж байна штэй. Ер нь тамхи зардаг тусгай цэг буюу нэг цэгийн үйлчилгээ гэдэг шиг цэгтэй байвал зүгээр байх. Зах, худалдааны төвүүд бол насыг нь харгалзахгүй л замбараагүй зарж байна. Манай сургууль захтай ойрхон байдаг тул архи уусан, тамхи татсан хүмүүс хаа сайгүй л байна. Ойр тойрны түц, дэлгүүрүүд бүгд л илээр болон нууцаар зарж байна.

Таны бодлоор "утаат тамхийг ширхэглэн худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– Дэлгүүр, түцүүд, автобусны буудлууд дээр бол ширхгээр л зардаг. Хүүхдүүдийн кармаг нэгжвэл ганц нэг ширхэг л гарч ирдэг.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, тодруулбал, "21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Тамхийг хаа сайгүй л зарж байна. Зах, худалдааны төвүүд бол насыг нь харгалзахгүй л зарж байна. Манай сургууль захтай ойрхон байдаг тул архи уусан, тамхи татсан хүмүүс хаа сайгүй л байна.

"21 нас хүрээгүй хүнээр утаат тамхи худалдуулах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– 21 нас хүрээгүй хүүхдүүд бол нэг их энэ хавиар бол зарах асуудал гайгүй байдаг.

Таны бодлоор "ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Тэгэхээр 500 метр гэдэг бол худлаа шүү дээ. Манай сургуулийн ойрхон 2 зах, худалдааны төв байна, CU, GS байна. Эд нар 100 метр дотор л байна.

Таны бодлоор "утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Хүмүүс чинь ер нь хаа таарсан газраа л тамхи татаж байна штэй. Баар, ресторан, зарим оффисууд гаднаа тамхи татах цэгтэй байна. Тэр торгох процессын асуудал маш асуудалтай. Хориглосон газар тамхи татаж байгаа хүн таарвал цагдаа дуудна, ирэх хүртэл 30 минут болно тэр болтол тэр хүнийг хэрхэн саатуулах уу гээд л асуудал байна.

Тамхины хяналтын тухай хуульд "хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина" гэж заасан байдаг. Сая дурдсан байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– Цагдаагийн хэлтэс, нийслэлийн хүүхэд, залуучуудын газраас тамхины хяналтын тухай хууль болон электрон тамхины асуудлаар сургалт хийдэг.

Хуульд "Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ" гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Хороо, дүүргийнхээ нийгмийн ажилтантай хамтраад хамтарсан багаараа сургалт хийдэг. Бас иргэдийн хурлаас багш, нийгмийн ажилтнуудад чиглэсэн сургалтууд хийдэг. Хорооны нийгмийн ажилтны хувьд хүүхдүүд рүү чиглэсэн сургалтуудыг хийдэг. Улиралдаа нэг удаа ч юмуу.

Хяналт тавихад хуулийн хүрээнд тулгамдсан асуудал байдаг үү?

– Хүүхдийн биед хүрэх, нэгжлэг хийж болохгүй байдаг учраас бидний хувьд төдийлөн нарийн хяналт тавьж чаддаггүй. Хэлээд, сануулаад л байж байдаг даа.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Бидний хувьд торгох гэхээсээ илүү хүүхдүүддээ анхааруулга, сануулга өгөх, эцэг эх, асран хамгаалагчид нь мэдэгдэх л арга хэмжээ авдаг. Амлалт бичиг авах л арга хэмжээ авна шүү дээ. Ер нь торгуулийн хэмжээг нэмэх хэрэгтэй байх. Тэгж байж хуулийн хэрэгжилтэд нөлөөлөх байх.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– Утаат тамхи гэхээсээ илүү би яг тэр электрон тамхи л асуудал болж байна. Одоо 5 дугаар ангийн хүүхэд хүртэл кармандаа хийчихсэн явж байна. 3,4 ангийханд ч байна. Электрон тамхийг худалдан авах боломжтой байгаа нь тэднийг хэрэглэж болно гэсэн эрх чөлөөг олгоод байна. Сургуулийн орчин багш нарын зүгээс хориглож байгаа нь ямарч үр дүнгүй байна. Гадагшаа гараад л хэрэглэж байна. Худалдан борлуулахад тавьж буй хориглолтыг сайн хийж өгөх хэрэгтэй байна. Цахилгаан тамхины асуудлыг утаат тамхитай адил хуульд оруулж өгөх шаардлагатай байна. Электрон тамхийг CU, GS бол замбараагүй зарж байна. Өөр нэг асуудал бол хэрэглэсэн цахилгаан тамхийг хэрхэн хаях асуудал байна. Хаа сайгүй хаячихсан байгааг бага

насны хүүхдүүд олж аваад сорж үзэх, сонирхох тохиолдолд гарч байна. Цахилгаан тамхины хор хөнөөлийн талаарх сургалт, сурталчилгааг сайн хийх хэрэгтэй байна. Тамхи татах асуудал ганцхан эрэгтэй хүний асуудал биш болсон. Электрон тамхийг охидууд их татаж байна. Телевизээр ярилцлага өгч байгаа олны танил болон инфлэнсэрүүд, олон дагагчтай хүмүүс электрон тамхи хүзүүндээ зүүчихсэн зураг их оруулдаг нь далд хэлбэрийн сурталчилгаа болж, гоё ганган харагдаж хүүхдүүдийг уруу татахад нөлөөлж байна. Тамхины хяналтын тухай хуулийг үнэхээр чангатгах хэрэгтэй байна. Түүнээс хяналтаа чангаруулах хэрэгтэй байна.

4) ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 24 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН

"Тамхины хяналтын тухай хууль"-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– Утаат тамхины зөрчил 2,3 жилийн өмнө нилээд байсан. Өсвөрийн сэргийлэгч бүлгэмтэйгээ хамтарч ажиллаад сургууль дээр утаат тамхи татах зөрчил бол байхгүй. Хүүхдүүдийн утаат тамхины хэрэглээ бага болсон, утаат тамхитай хүүхэд байхгүй дээ. Сургуулийн орчмоор дамжин өнгөрч байгаа болон сургуулийн хашаанд хүмүүс татаж байгаа харагддаг. Энэ тохиолдолд хэрхэн торгох, хэрхэх нь тодорхой бус байдаг болохоор хэрэгждэггүй. Торгууль ногдуулах систем нь болж өгөхгүй байсан.

Таны бодлоор "утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– Сургуулийн хажуугийн дэлгүүрүүд нууцаар, ширхэглэж зардаг. Ил өлгөхгүйгээр нууцаар лангуун дороосоо гаргаж ирж зардаг. Дэлгүүр, ТҮЦ-үүд орлогоо бодоод хүүхдүүдэд зардаг. Манай ойрхон бөмбөгөр худалдааны төв байдаг болохоор хүүхдүүд тэндээс бас авчихдаг.

Таны бодлоор "утаат тамхийг ширхэглэн худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– 10 жилийн хүүхдүүд чинь ширхгээр л авна. Тэд нар өөрсдийнхөө эдийн засагт тохируулж байна 2-т ээж аавдаа баригдахдаа ширхэглээд авчихдаг учраас мэдэгдэхгүй. Ээж аав нарт бол мэдээлэл тогтмол өгч байгаа.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, тодруулбал, "21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– 3 жилийн өмнө бол утаат тамхи худалдах тохиолдолд их байсан. Одоо бол утаат тамхийг хүүхдүүд өрөөсөө хэрэглэхээ болиод нөгөө электрон тамхи руугаа орчихлоо л гэж хараад байгаа. Өөрөөр хэлбэл короногийн өмнө их байсан.

"21 нас хүрээгүй хүнээр утаат тамхи худалдуулах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Хотын төв болохоор арай өөр байгаад байна. Ер нь бас насанд хүрсэн хүмүүс л сууж л байгаа харагддаг юм. Би саяхан хорооныхоо цагдаатай энэ хавийнхаа дэлгүүрүүдээр явсан юм. Нөгөө электрон тамхины асуудлаар тэгэхэд бол дандаа л насанд хүрсэн хүмүүс байсан тэгээд бид нар зардаггүй гээд л.

Таны бодлоор "ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Тэгэхлээр 500 метр дотор бол худлаа байна. Бүх газар л 500 метр дотор байгаад байна бүгд л зарж байна шүү дээ. Одоо ингээд л 500 метр явахгүй 200 метр яваад л бөмбөгөр худалдааны төвд л гэхэд худалдаж байна.

Таны бодлоор "утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Нэг үеэ бодвол хүмүүс чинь соёлтой болчихлоо шүү дээ. Тамхи татах цэгтэй болчихсон. Багш нарын хувьд сургууль дээр татаж болохгүй гэдэг тул сургууль дээр утаат тамхи татах асуудал бол байхгүй. Харин сургуулийн хашаагаар дамжиж өнгөрч байгаа хүмүүс тамхи татаж явах тохиолдол бол байдаг. Тэр тохиолдолд сургуулийн ойр орчмоор тамхи татаж болохгүй гэж эхлээд хэлдэг байсан одоо ч хэлэхээ больж байна.

Тамхины хяналтын тухай хуульд "хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина" гэж заасан байдаг. Сая дурдсан байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Тавьж байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– ТББ, олон нийтийн байгууллагатай хамтардаг ажилдаг. Харин сургууль дээр Өсвөрийн сэргийлэгч бүлгэм ажилладаг. Тэр хүүхдүүд бие биедээ хяналт тавих, нийгмийн ажилтанд мэдээлэл өгөх зэргээр ажилладаг.

Хуульд "Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу

хэрэгжүүлнэ" гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Хорооны хөдөлгөөнт эргүүлүүдтэй л хамтарч ажилладаг. Маш сайн мэдээлэлтэй байж, хяналт тавьдаг. Хүүхдүүдэд архи, тамхи зардаг дэлгүүрүүдийг их сайн мэддэг. Тэд нар хорооны Засаг дарга болон нийгмийн ажилтанд мэдээллээ өгч ажилладаг юм билээ. Хөдөлгөөнт эргүүлүүд мөн гэр бүлийн хүчирхийллийг сайн илрүүлдэг.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Арай л өндөр юм шиг санагдаад байдаг. 20.000 байвал л болно.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Энэ хэрэгжихгүй л байна л даа. Хэрэгжих механизм нь арай өөр байгаад байна. Жишээ нь одоо манай сургуулийн үүдэнд нэг хүн тамхи татаад зогсож байвал би сануулна, торгодог гэж л хэлнэ. Зарим нь эргээд биднийг загана. Тэгээд л нөгөө цагдааг нь дуудах гэсээр байтал нөгөө хүн нь яваад өгнө. Тэгээд л ийм болж байгаа байхгүй юу. Тэгээд чи хүн торгодог чи хэн юм гээд л. Жишээ нь 00-д нэг хүүхэд тамхи татсан байлаа гэж бодоход цагдаа ирэх болчихоод байгаа байхгүй юу. За би чамайг ингэнэ ээж аавыг нь дуудаад хүүхдийг цагдаа руу шилжүүлж байгаа байхгүй юу. Тэгэхээр цагдаа нар чинь ачаалалтай. Тэгтэл би энд нэг тамхи татсан хүүхдийг торгуулах гээд л нөгөөдхийг чинь дуудаад л ирэхгүй шүү дээ ирэхгүй. Угаасаа тэр өрөөсөө хөрсөн дээр бууж өгөхгүй байгаа байхгүй юу. Хяналтын тогтолцоог бол сайжруулж, тухайн байгууллагынх нь яг тэр хүн хариуцана аа гээд л тодорхой болгох хэрэгтэй байна.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг 500,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Байгууллагын хувьд цагдаа нар л шалгах байх даа. Бар, ресторануудын хувьд өдөр ажилладаггүй болохоор гайгүй байдаг байх. Харин биллиардад цахилгаан тамхийг их татдаг юм билээ.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг 500,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Тамхийг нууж худалддаг, татдаг болохоор хурааж авч байгаагүй.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– Эцэг эхчүүдийн хүүхдүүдийнхээ утаат болон цахилгаан тамхины хэрэглээнд тавих хараа хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Боловсролын нь дээшлүүлэх хэрэгтэй байна. Хүүхдээ эрхлүүлээд цахилгаан тамхийг нь өөгшүүлдэг эцэг эх байна. Тоохгүй байх гэхээр бусад хүүхдүүдэд нөлөө үзүүлэх гээд байдаг тул анхаарахгүй орхиж болохгүй байна. Цахилгаан тамхи татсан хүүхдүүдээр өөрсдөөр нь бусад хүүхдүүдэд сургалт оруулсан нь их үр дүнтэй санагдсан.

Цахилгаан тамхийг сонирхож 5-аас дээш ангийхан, 9-өөс дээш ангийхан бүр орчихсон байна. Цахилгаан тамхийг ангидаа болон ОО өрөөнд татаад байгаа учраас сургуулиа камержуулсанаас хойш арай гайгүй болж байна. Цахилгаан тамхи гоё үнэр, амттай болохоор хүүхдүүд их сонирхолтой татаад байна.

Одоо 10 жилийн хүүхдүүд цахилгаан тамхи, цэнэглэгчийг нь бие биедээ дамлаж зарах асуудал их болж байна. Цахилгаан тамхийг оруулж ирэхгүй байхад анхаарч өгөөч. Хичнээн үнэтэй байсан ч хүүхдүүд яаж ийгээд л авчихана. Ээж аавынхаа хоол авч идээрэй гэсэн мөнгийг цуглуулж байгаад л авчихаж байна.

Манай сургууль цахилгаан тамхи илрүүлэх зорилгоор хүүхдүүдээ ирэхэд нь металл илрүүлэгчээр шалгаж үзсэн. Гэтэл эцэг эхчүүд хүүхдийн эрх зөрчиж байна, боловсролын яаманд мэдэгдэнэ гээд бөөн хэл ам болсон. Сургууль бол шоронгийн байгууллага юмуу гэх мэтчилэн загнасан. Дохиолол дугарсан хүүхдүүдээ шалгаж үзэхэд хүүхдүүдээс цахилгаан тамхи илрээгүй.

Цахилгаан тамхийг чөлөөтэй зарж байгаа, эцэг эхчүүд авч өгөөд байна, ах эгч нарыхааныг авч ирээд байгаа болохоор үнэхээр дийлдэхгүй байна.

5) ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 28 ДУГААР СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН

"Тамхины хяналтын тухай хууль"-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– Миний хувьд бол үнэхээр сайн хэрэгжиж чадахгүй байгаа гэж үзэж байгаа. Яагаад гэхээр сургууль орчмын бүсэд 500 метрт утаат тамхи худалдан борлуулахыг хориглосон ч гэсэн тэр нь хэрэгждэггүй. Жишээ нь манай School police хийж байгаа томчууд маань сургуулиас 500 метрийн дотор тамхи татаад байгаа харагддаг. Энд тамхи татаж болохгүй шүү гээд амаар ингээд хэлдэг. Бидний хувьд хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд наачихсан байдаг ч гэсэн хүмүүс очоод уншдаггүй байхгүй юу. Тэгэхээр манай иргэд маань олон нийт маань ерөөсөө энэ тамхины тухай хуулийг 100% сайн мэддэггүй, мэдээлэлгүй байдаг гэж би боддог. Яагаад гэхээр нөгөө нэг одоо тамхины тухай зар сурталчилгаа явуулахыг хориглочихсон байдаг юм байна лээ шүү дээ хязгаарлачихсан. Тэгэхээр хууль ингэж шинэчлэгдлээ, 500 метрт тамхи татахыг хориглоно гэх мэтээр олон нийтийн сүлжээнд цацдаггүй байх гэж би бодоод байгаа юм. Би сайн мэдэхгүй байна. Бид албан бичгээр сургууль орчмын бүсэд тамхи худалдан борлуулахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих гээд ирдэг л дээ? Сургууль орчмын бүсийг цаашдаа хуулийг шинэчилбэл сургуулийг тамхигүй бүс болгох хэрэгтэй. Тамхигүй бүс гэвэл бүх тамхинууд орчихно.

Ер нь ямар зөрчил ихэвчлэн гардаг вэ? Яагаад?

– Хүүхдүүдийн тамхи татаж байгаа харагддаггүй. Хүүхдүүд хувьд нууцаар татдаг хүний нүднээс холуур булан тохой, байрны орц, доод талын подвал гээд гэх мэтчилэн. Утаат тамхины хэрэглээний хувьд яалт ч үгүй хязгаарлагдмал. Тэд нар чинь нөгөө нэг насанд хүрээгүй учраас, ялангуяа нөгөө хяналт сайтай байдаг учраас сургууль орчмын бүсэд бол сурагчдыг камержуулчихсан байдаг учраас бол хяналт сайтай гэж байгаа юм.

Хэрэгжихгүй байгаа зохицуулалтын хувьд, миний бодлоор манай ахлах ангийн хүүхдүүдэд утаат тамхи хэрэглэдэг зарим нэг хүүхдүүд байдаг, судалгаагаар ч гэсэн гарч байдаг. За тэгээд л одоо тамхи чинь угаасаа аймаар үнэртдэг шүү дээ, аягүй үнэртдэг учраас хажуугаар өнгөрөхөд сэнх гээд л үнэртэх юм бол би ярилцаад л үзэхээр түцээс авсан, жижиг борлуулдаг цэгүүдээс авсан байдаг юм. Тэгэхээр манай ААН-үүд л худалдаад байна шүү дээ. Тиймээс тэд нарт л маш сайн ойлголтыг өгч дүрэмт хувцас өмссөн хүүхдүүдэд буюу насанд хүрээгүй нь тодорхой буюу 21 нас хүрээгүй, 18 нас хүрээгүй илт тодорхой байвал зарахгүй байх хэрэгтэй байна. Ашгийн төлөө ч гэлээ хүүхэд, насанд хүрээгүй болбол чамд өгөхгүй, зарахгүй баймаар байна. Тэгэхээр бид нарын хувьд хичээлийн жил эхлэнгүүт л ойр орчмынхоо ААН, дэлгүүр, мэхлаг, түцүүдэд тамхины хяналтын тухай хуулиа хэрэгжүүлж, сурагчдад бүх төрлийн тамхи худалдан борлуулахгүй байна уу гэсэн тиймэрхүү албан бичиг хүргүүлдэг. Тэрийг тогтмол өгдөг, Сургуулийн орчинд бол сургуулийн захиргаа болон багш ажилчид хяналт тавих хүний нөөцийн боломж бол байдаг. Угаасаа ч хэрэгжүүлж байгаа манай сургуулиуд бол бүгдээрээ хэрэгжүүлж байгаа. Олон төрлийн тамхинаас урьдчилан сэргийлдэг. Гэхдээ хүүхдүүд маань нууцаар авч татаад байгаа.

Таны бодлоор “утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– Гар дээрээс ширхгээр зараад байдаг байдал бол харагддаггүй юм. Харин нөгөө түц, мэхлагууд, CU, GS их зардаг. Бас 8 нэрийн барааны дэлгүүр, байрнуудын доод талын дэлгүүрүүд, байрны дэлгүүрүүд, байрны голд байдаг дэлгүүрүүдэд зарагдаад байдаг.

Таны бодлоор “утаат тамхийг ширхэглэн худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– Тэгэхлээр хүүхдүүд татаад байна гэдэг чинь тэгээд л зарж байгаа газар нь өгөөд л байна гэсэн үг байхгүй юу. Бид өр нь үе үе сургуулийн ойр орчмын гадаад, дотоод эрсдэлийн үнэлгээг хийхдээ ойр орчмын дэлгүүр, баар ресторантай урьдчилан сэргийлэх үнэлгээ хийгээд явж байхад ширхэглэж зарж байгаа дэлгүүрүүд маш их байдаг. Тэгээд аль болох л та нар болохгүй шүү энэ чинь хуультай юм байна лээ шүү гээд л хэлдэг. Яг үнэндээ үйлдэл дээр нь л харахгүй бол зарж байгаа нь ч тэр, авч байгаа нь ч тэр хэлэхгүй.

Таны бодлоор “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Тамхины цэг гэж байдаг штэй. Их сургууль, ААН-үүдийн гадаа байдаг шүү дээ. Жишээ нь манай сургуулийн ойрхон буудал байдаг. Тэр буудлын гадаа хүмүүс маш их тамхи татаж байдаг. Тэгэхээр хувийн болон төрийн байгууллагуудад 500 метрт тамхи татахыг хориглох тухай шаардлага хүргүүлэх гэхээр хот зохион байгуулалт буюу сургууль орчимдоо баар, ресторан, буудал нь холилчихсон байгаа учраас зохицуулалт хийхэд аягүй хэцүү. Бид нарын хувьд улирал эхлэх бүрт шаардлага, албан бичиг хүргүүлээд л энэ асуудлыг хязгаарлаж өгөөч гэж байнга сануулж байдаг. Гадаа тамхи татаж байгаа хүмүүсийн хувьд гараад л хэлдэг.

Таны бодлоор “утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Одоо манай сургуулийн баруун талд зам дагуу маш олон буудал баар ресторан, дэлгүүр байдаг гадна талд нь хогийн сав нь битүү тамхины иш харагддаг. Байрнууд ч ялгаагүй замын цаана байдаг. Бидний хувьд байрны эрэгүүл хийдэг. Эрэгтэй багш нараараа хуваарь гаргаад. Яагаад гэхээр бид нар бүх талын хяналт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүх талынхаа ажлыг хийхдээ судалгаа хийгээд, эрэгүүл хийдэг. Тэгэхээр ахлах ангийн хүүхдүүд болон тамхидалт маш их байдаг. Байрных нь гадаа суугаад л тамхи татаад байх жишээний.

Мөн тоглоомийн саад, байрнууд хажуудаа тамхины цэгтэй байна. Утаат тамхины хувьд сургуулийн орчинд сурагчдын хувьд харьцангуй бага өр нь маш бага байдаг. Яагаад гэхээр тэр чинь аюултай үнэртдэг учраас.

Тамхины хяналтын тухай хуульд "хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина" гэж заасан байдаг. Сая дурдсан байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– Надтай бол хамтарч ажиллаж байсан тохиолдол байхгүй. Миний хувьд бол хүүхэд хөгжил хамгаалыг хариуцдаг тэгээд хүүхэд хамгаалалд бүх хүүхдийн бүх талын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлынхаа хүрээнд сургуулийн дотно болон гадна орчны эрсдэлийн үнэлгээ хийдэг.

Хуульд "Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ" гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Хороо дүүргийн хувьд хамтарсан багаараа л хүүхдийн эрсдэл, гэр бүлийн орчин ч юм уу сургуулийн орчны дээрлэлт, эрсдэл хүчирхийлэл дээр хамтарч ажилладаг. Тамхины хувьд одоогоор нэг их хамтарч ажиллаагүй л байна.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Одоо би жишээ нь маш их одоо ойр орчмын хүмүүст сургуулийн 500 метр дотор тамхи татаж болохгүй гээд л хэлээд л тэгээд л торгуультай шүү л гэж хэлдэг. Тэгээд торгуулийг нь хэн хэрхэн авах юм, хаана хэнд хандахаа мэдэхгүй байгаад байгаа байхгүй юу тэ? Тамхи татаж буй зургийг нь авах юм уу, баталгаа нотолгоо нь юу байх юм. Жишээ нь 500 нэгжээр торгоно гээд зохицуулчихсан хааш нь мэдээлэх талаар зохицуулалт байхгүй, шийдвэрлэлт нь байхгүй тийм ээ хэн торгох юм? Одоо зөрчлийнхөө хуулиар бол цагдаа л байх. За тийм Зөрчлийн тухай хуулиараа цагдаад мэдэгдлээ гэхэд нөгөө цагдаа нь ирэх хүртэл нөгөө хүнийг нь байх эсэх. Цагдаа бол заавал нотлох хэрэгтэй гэдэг тэгэхээр тэр хүний зургийг авахаар чинь одоо хууль бус болчихож байгаа шүү дээ. Ингээд хуулиуд өр нь хоорондоо аягүй маш зөрчилтэй. Тамхины хяналтын хуулийн хэрэгжилтийг сайжруулаа гэвэл хяналт тавих эрх бүхий хүнийг томилох хэрэгтэй.

Бид нар сургууль орчмын бүсийг л тамхигүй бүс болгоход үнэхээр 500 метрт үнэхээр тамхигүй байлгахыг хүсэж байвал сургуулийн нийгмийн ажилтан, жижүүр нарт зургийг нь авах эрх өгөх юм бол эргээд байгууллагад арга хэмжээ авах боломжтой болно. Торуулахгүйн тулд, үйл ажиллагаагаа хэвийн явуулахын тулд арга хэмжээ авна шүү дээ. Хэрэв надад эрхийг нь өгчих юм бол энд тамхи татаж байна, энэ байгууллагын үйлчлүүлэгч нь гэх мэтээр баталгаажуулах боломжтой. Ерөнхийд нь нэг тийм маш тодорхой болчихвол боломж байгаад байгаа байхгүй юу. Хуульд тодорхойгүй юмнууд зөндөө байдаг. Одоо хориглоно л гээд байдаг хориглочихлоо л гээд байдаг яах гээд байгаа юм?

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хүнийг 500,000 төгрөгөөр8 хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Ер нь тийм тохиолдол байхгүй. Би өнгөрсөн жил School police хийж байгаа нэг аавд шаардлага тавьсан юм. Тэгсэн ч юугаа мэддэг юм гээд эсэргүүцэл илэрхийлсэн.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– 1) Тамхины тухай хуулийн зохицуулалтуудад нэг бүрчлэн хариуцлагын тогтолцоо хэн хариуцлага хүлээлгэхийг нь ойлгомжтой тодорхой болгох. Мэдээж цагдаагийн байгууллага гэхдээ тэрэнд нь хэн хяналт тавих юм? Иргэн бүр хэрхэн оролцох боломжтой гэдгийг тодорхойлж өгөх.

2) Сургуулийн орчинд утаат тамхи татах боломжгүй харин электрон тамхи бол маш их байна. Хэдийгээр нөгөө нэг янз янзын жимсний үнэртэй ч гэсэн тэр чинь ингээд ууршаад алга болчихдог учраас хурдан гарна. Өнөөдрийн байдлаар бага ангиас эхлээд ахлахыг нь хүртэл хэрэглэж байгаа тохиолдол харагдаж байна. Бага гэдэг нь 5 дугаар ангийн хүүхдүүд шүү дээ. Тэд нар чинь сонирхоод сонирхлын журмаараа л байгаад байна. Тэдэнд гэр бүлийн болон нийгмийн орчин нөлөөлж байна. Хүн болгон энгэртээ зүүгээд л, гоё зүүлт шиг л яваад байгаа шүү дээ. Сургуулийн орчинд бол дүрэмт хувцас өмсөж байгаа хүүхдүүд нууцаар л даа тэр чинь тэгээд ил бол татахгүй. Тэгэхээр энэ тамхины тухай хуульдаа электрон тамхийг оруулаад өгөөч ээ энэ чинь бас ууршаад утаа гарч л байгаа. Хэдийгээр яамны сайдын 140 дүгээр тушаал нь гарсан ч гэсэн сургууль орчны бүсэд хориглолоо гэсэн ч гэсэн зохицуулалт нь маш бага.

Тийм бид нар чинь тэгээд л электрон тамхийг яалт ч үгүй үйлдэл дээр нь хурааж аваад л буцаагаад эцэг эхэд нь хүлээлгэж өгөх л арга хэмжээ авч байгаа. Өөр арга хэмжээ юу ч байхгүй. Тамхины хяналтын хуульдаа оруулж зохицуулалт хийж өгөх шаардлагатай байна. Ер нь сургууль орчмын бүсийг тэр чигт нь тамхигүй бүс л болгох хэрэгтэй.

3) Бүх төрлийн тамхины хор уршгийг маш сайн таниулах ёстой юм болов уу? Мөн хүүхдүүдийн эцэг эхчүүдэд мэдүүлэх ёстой юм болов уу яа? Яг үнэндээ эцэг эхчүүд өөрсдөө хүүхдүүддээ авч өгөөд байхгүй юу. Утаат тамхийг нь би мэдэхгүй байна харин электрон тамхийг бол хүүхдээ дийлэхгүй өрөөсөө авч өгч байгаа тохиолдол ганц нэг гарч байсан.

4) Манай сургууль “эрүүл амьдралын төлөө электрон тамхинаас татгалзъя” гэсэн аян өрнүүлж гэр бүлийн орчны электрон болон утаатай тамхи хэрэглээний судалгааг цахимаар хийж үзэхэд 6-12 дугаар ангийн 1500 орчим хүүхдийг хамруулахад бараг 50 хувь гэр бүлийн орчинд дам тамхидалтад өртдөг гэж гарсан. Тэгэхээр одоо томчуудын одоо тамхины хэрэглээ маш их байна лээ. Бидний хувьд жижүүр анги болон өсвөрийн сэргийлэгчид эрэгтэй 00 өрөөгөөр хяналт шалгалт хааяа хийдэг. Энэ тохиолдолд электрон тамхи л хааяа нэг гарч ирэхээр нь эцэг, эхтэй нь уулзаж, хүлээлгэж өгөөд зөвлөмж өгдөг.

5) Хүүхдүүд сургууль орчимд хяналт сайн байдаг боловч сургуулийн хашаанаас гараад л замбараагүй болчихож байна. Эцэг эхийн хараа хяналт сул байгаа учраас гэр хүртлээ анхаарал үнэхээр сул байна. Өнгөрсөн жилээс эхлээд бид нар электрон тамхинаас урьдчилан сэргийлэх янз янзын арга аргууд хэрэглэсэн. Жишээ нь хүүхэд өөрсдөөр нь контент, бичлэг хийлгэх зэргээр урьдчилан сэргийлэлт маягаар нэгэндээ нөлөөллийн ажлуудыг бас хийлгүүлсэн.

6) Хүүхдүүдийн дунд цахилгаан тамхийг онлайнаар их зарах байдал ихэссэн байна. Facebook группууд хямд бас хүргэлттэйгээр нууцаар зардаг сүлжээ бий болсон байна.

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧДААС АВСАН ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

1) ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧ – ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 5 ДУГААР ХОРОО

“Тамхины хяналтын тухай хууль”-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– Анх хууль батлагдсаны дараа хэрэгжилт сайн байсан. Харин одоо зарим талаар хэрэгжилт буурсан. Тухайлбал, тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүд дээр хууль хэрэгжиж байгаа. Харин сургуулийн орчим болон ТҮЦ-үүд хууль зөрчин тамхи нууцаар зардаг нь үнэн. Тэгээд бид нар арга хэмжээг нь аваад явдаг. Бараг 70% нь зөвшөөрөлгүй явуулж байгаа гэж ойлгож болно шүү.

Ер нь ямар зөрчил ихэвчлэн гардаг вэ? Яагаад?

– 1) Тамхийг ширхгээр зарах тохиолдол их байна. Ширхгээр нь зардаг дэлгүүр ч байна, ТҮЦ ч байна.

2) Тусгай зөвшөөрөлгүй газрууд тамхи худалдаалах.

Тамхины хяналтын тухай хуулийн зүйл, заалтуудаас амьдралд бүүхгүй, хэрэглээгддэггүй зохицуулалт Таныхаар байна уу?

– Тамхи худалдаалах зөвшөөрөлтэй дэлгүүрүүд цөөн тул зөвшөөрөлгүй газруудад нууцаар худалдаалах үзэгдэл их байдаг. Тамхины хяналтын тухай хуульд тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүдийн хяналт сайн байгаа ч ЕБС-ийн 500 метрийн зайд худалдахгүй гэсэн заалт хүндрэл үүсгэж байна.

Таны бодлоор “утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– Зөвшөөрөгдсөн цэг нь Улаанбаатар хотод 30% байдаг гэж үзвэл манайд бараг 100% зөвшөөрөл байхгүй. Бүгд л нууцаар зардаг, хадгалдаг. Жишээ нь ТҮЦ-д зөвшөөрөл гаргахаа больчихсон. Угаасаа ТҮЦ-д тусгай зөвшөөрөл байхгүй, үйл ажиллагааны зөвшөөрөл гэж байхгүй. Тийм учраас бүгд тамхи нууцаар зараад байдаг юм уу даа. Яагаад нууцаар зараад байгаа юм гэж асуухаар тэд амь зуудаг гол орлого гэдэг юм.

Таны бодлоор “утаат тамхийг ширхэглэн худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– За тэгээд саяын хүмүүс чинь тамхийг ширхэглэн зарж байна. Мэдээж нөгөө л амьжиргаа, мөнгө, ашгаас л болж зарж байна.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, тодруулбал, “21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Энэ бас хэцүү асуудал. Тогтооход хэцүү. Зарим хүмүүс энэ газар хүүхдүүдэд тамхи зараад манай хүүхэд авсан байна гэсэн гомдол гаргахаар арга хэмжээ авч болж байгаа юм. Яагаад гэвэл авсан хүн нь байж байдаг тодорхой.

“21 нас хүрээгүй хүнээр утаат тамхи худалдуулах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Тамхи зарж байгаа үйлдэл нь өөрөө нууцаар явагдаж байгаа болохоор хүүхэд зарж байгааг тогтооход бас л хэцүү дээ.

Таны бодлоор “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Сургуулийн орчим 500 метрийн радиуст тамхи худалдаалахыг хориглодог. Энэ заалт хэрэгжихэд хүндрэлтэй. Манай хорооны нутаг дэвсгэрийн хэмжээ хаашаа хаашаага 2 км ч хүрэхгүй, эгтэл манай хороонд 4, 5 сургууль байдаг, тэгээд зөвшөөрөлтэй дэлгүүр бараг байхгүй. Дэлгүүрүүд бүгд нууцаар зарж байна. Биднийг очиход тамхи байхгүй, харин гэнэдүүлээд ч юм уу, шалгаад үзвэл тамхи байж байдаг. Жишээ нь, хойд талын өрөөнд тамхи байгаа тохиолдолд тамхийг зарсан гэж үзэхэд бас хэцүү. Хадгалж байгаа тамхийг нь бид нар аваад хуулийн дагуу арга хэмжээ авъя гэхэд бас өөр. Баримт нь тамхин дээр угаасаа гарахгүй учраас зарсан гэж нотлох боломжгүй. Тэр 500 метрээ жишээ нь 100 метр болговол илүү хэрэгжих боломжтой.

Таны бодлоор “утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Гудамжинд тамхи татаж байгаа хүн зөндөө байна. Хориглосон газар тамхи татсан гэдгээр нь би арга хэмжээ авч байсан. 50 мянган төгрөгөөр торгодог. Бид нар торгоход атериалжуулах процесс нь хүндрэлтэй байдаг. Энийг материалжуулахгүйгээр шууд таблетаараа буюу цахимаар торгох гэхээр нөгөө хүн нь хүлээн зөвшөөрөх үү, үгүй юу. Энэ заалтаас гадна тамхи татчихаад ишийг нь хаясан зөрчил их байдаг.

Яагаад хориглосон газар тамхи татаад байна вэ гэвэл, хүмүүсийн өөрийнх нь ухамсрын асуудал, цаг завгүйн асуудал байна. Дээр нь утаат тамхийг татахыг зөвшөөрсөн цэг гэж бараг байдаггүй. Тийм учраас цаг заваа гаргаад зөвшөөрөгдсөн цэг хайгаад явна гэдэг хэцүү. 5 дугаар хороонд гэхэд тамхины цэг Тэнгис кино театр, Теди төв, манай хэлтсийн хойно гээд 3-хан газар байгаа. Тэгэхээр тамхины цэгийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Тамхины хяналтын тухай хуульд “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина” гэж заасан байдаг. Сая дурдсан байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– Бараг байхгүй шүү. Манай цагдаагийн байгууллага л ажилладаг.

Хуульд “Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Засаг дарга нар бараг Тамхины хяналтын тухай хуулиар хяналт тавиад яваад байхгүй. Хогоо л хогны асуудал ярьж байдаг, нийтийн эргүүл гэж байхгүй. Ердийн эргүүлүүд зүгээр хог хаана байгааг нь хэлж өгдөг. Одоо Засаг дарга нарын одоо хийдэг ажил нь ганцхан хогийн гэрээ болчихоод байна шүү дээ. Энэ дээр Засаг дарга нь өөрөө ороод хамтарсан багаараа хяналт тавья гээд санаачилга гаргаад явж байгаагүй.

Хяналт тавихад хуулийн хүрээнд тулгамдсан асуудал байдаг уу?

– Зөрчил шалган шийдвэрлэх процесс нь цагдаагийн албан хаагчийн ажлын ачааллыг их болгодог. Бид өөрсдөө тамхи хурааж авсан тэмдэглэл үйлдэнэ, өөрсдөө материалжуулна гээд нэг өдөр, маргааш нь өөрсдөө аваад шалгаад тамхийг нь устгуулахаар бол дүүрэг рүү өгнө, хадгалсан гэж үзвэл тамхийг нь буцаагаад эзэнд нь өгнө гээд дахиад нэг өдөр зарцуулна. Тэрийг чинь Цагдаагийн сан, Зөрчлийн сан гээд 2 санд шивж оруулна, газар дээр нь шивнэ гэхээр заримдаа сүлжээгүй болчдог. Сүлжээгүй болчихсон болхоор хэлтэс рүү очоод шивнэ. Тийм учраас цагдаагийн албан хаагчид чинь ачаалал өгнө гэсэн үг л дээ. Зөрчлийг нотлох асуудал нь тулгамдсан асуудал болоод байна. Хяналт тавихад хүмүүс зөрчлөө өөрсдөө гаргаж өгөхгүй шүү дээ. Гэтэл бидэнд тамхи зарж байгааг нотлох нотолго, жишээ нь камерын бичлэг байхгүй. Дэлгүүр, ТҮЦ дээр хадгалж байгаа тамхийг хураад авахад хэцүү. Тэд нар түр тавьчихсан, одоо аваад явна гэвэл бид баахан хайрцагтай тамхийг хураахад бас хэцүү. Хуульд тамхийг хадгалах нөхцөлийг, тэдэн ширхэгээс дээш хадгалсан гэж тусгаж өгвөл бид хадгалсан гээд арга хэмжээ авах боломжтой болно. Одоогийн байдлаар бид нар хадгалсан тамхийг хурааж аваад буцаагаад өгөхөд цагдаагийн байгууллага дарамталсан гээд нэр хүндгүй болоод байна.

УЕП-аас цагдаагийн байгууллага руу нэг тоот явуулсан байдаг. Албан бичигт ААН-ийг Зөрчлийн тухай хуулийн 6.3-т заасан “Тамхины хяналтын тухай хууль зөрчсөн” гэх үндэслэлээр 500 нэгжтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгохгүй, харин 10.4-т заасан “Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих” гэсэн үндэслэлээр хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох гэсэн зөвлөмж ирсэн. Энэ чиглэл ирсний дараа бид нар яг яах нь мэдэгдэхгүй нэг хэсэг хүмүүсээ торгож чадахгүй, бас ажлаа алдсан. Үүнийг дагуу хууль бус нөгөө тамхийг чинь 500 нэгжээр торгохоо бараг больчихсон. Тэгэхээр бид нар нөгөө тамхийг нь хурааж аваад буцаах болж байгаа юм.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Жишээ нь Ялалтын талбай дээр тамхи татаад зогсож байгаа иргэнийг би “та энд тамхи татаж болохгүй” гэхэд “яахаараа болдоггүй юм, би хогийн цэгний хажууд татаж байна” гэдэг. Хогийн цэг чинь тамхины цэг биш байхгүй юу. Хүмүүс хогийн цэгийн хажууд татахаар тамхины цэг гэж ойлгоод байдаг. Ийм

тохиолдолд би арга хэмжээг нь авахад нэг иргэн надад гомдол гаргаж байсан. Харин түүх дээр нөгөө хүн маань унаж байсан. Иргэдийн зүгээс үүнийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдлууд гардаг.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– ААН-үүдийн хувьд тамхины цэгээ дотроо байрлуулдаг, эсхүл гадаанаа шон дээр нэг юм өлгөчихөөд тэрийгээ тамхины цэг гээд байдаг. Ийм тохиолдолд арга хэмжээ авах хэцүү байдаг. Уул нь бол тамхины цэгийн стандартыг тодорхой болгох нь зөв болов уу. Ер нь бол ААН дээр нэг их арга хэмжээ аваад байх зөрчил байдаггүй. Манайх төвийн хороо болохоор харьцангуй гайгүй. Бар, караоке гэхэд дотроо тамхины цэгтэй. Харин хойшоогоо гэр хороололд тийм юм байхгүй шүү дээ. Стандарттай холбоотой өөр нэг нийтлэг асуудал бол дотор тамхи татах цэг гээд өрөө бэлдээд тавьсан ч өрөөнийх нь агаар сорогч ажиллахгүй байдаг. Энд бас тамхи татах болохгүй шүү дээ.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хүнийг 500,000 төгрөгөөр хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Тохиромжтой гэж бодож байна. Бид нар хууль хэрэгжүүлдэг. Цагдаагийн хороод зөрчил гарсан бол торгодог, тэрийгээ нотолж чаддаг. Хүндрэлтэй асуудал бол олсон орлогыг нотлох юм. Тэд дан ганц тамхиа зараад байдаггүй, бусад бараагаа бас зардаг. Тэгэхээр нөгөө хүний дансыг нь, байгууллагын дансыг нь шалгаад үзээд ч нотлож чадахгүй. Хэрэв тамхин дээр мөнгөний баримт гардаг бол нотлох боломжтой. Эсхүл зарим хүмүүс тооцоо хийхдээ “тамхи” гээд шилжүүлчихдэг, тэрийг нь бид нар тамхи зарсан байна, энэ тамхинаас олсон орлого байна гээд түүнийг нь улсын орлого болгож тушаа гэдэг болохоос биш энэ зөрчлийг нотлогдоход хэцүү байдаг.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– Цахилгаан тамхины асуудал их хүнд байна. Тамхи чинь өөрөө дотроо олон төрөл шүү дээ. Тэр олон төрлийг нь авч зохицуулаад тусгай зөвшөөрөл дээрээ заагаад, утаат амхины нэгэн адил авч үзээд хуульдаа оруулчих юм бол тусгай зөвшөөрөл шаардаад явчихна. Цахилгаан тамхийг хуульчилж оруулаагүй учраас бид нар цахилгаан тамхинд арга хэмжээ авахад үндэслэл байхгүй байгаа юм.

2) ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧ – СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН 1-Р ХЭЛТЭС

“Тамхины хяналтын тухай хууль”-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– Манай СБД-ийн цагдаагийн газрын 1 дүгээр хэлтэс нийт СБД-ийн 1-ээс 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэгтэй тэмцэх нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдал хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тамхины хяналтын тухай хуулийн биеэлэлтийг Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан цагдаагийн байгууллагаас шалган шийдвэрлэх харьяалал дээр хяналт тавьдаг чиг үүргийн хүрээнд хяналт тавьж ажилладаг. Манай дээр эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ) гэж эргүүл хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэдэг хороон цагдаа болон хэсгийн байцаагчид бүсээрээ эргүүлд гардаг, хяналт шалгалт хийдэг. Гүйцэтгэж байх явцад хориглосон газарт тамхи зарж борлуулсан бол зөрчил бичиж, зөрчлийг нь ЭБАТ гомдол мэдээллийг бүртгэн авч прокурорын хяналт доор зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулдаг. Дийлэнхдээ автобусны буудлын ойр орчим, ТҮЦ, байрны дор байрладаг хүнсний дэлгүүрүүд, ААН-үүд зохих зөвшөөрөлгүйгээр тамхи зарж борлуулж байдаг. Энэ асуудал л их гардаг.

Ер нь ямар зөрчил ихэвчлэн гардаг вэ? Яагаад?

– Дийлэнхдээ тамхи зөвшөөрөлгүй худалдан борлуулах зөрчил гардаг. Тухайлбал “Багшийн дээд”-ийн орчинд, байрнуудын доор байдаг дэлгүүрээдэд үгээмэл зарж борлуулдаг.

Тамхины хяналтын тухай хуулийн зүйл, заалтуудаас амьдралд буухгүй, хэрэглэгддэггүй зохицуулалт Таныхаар байна уу?

– Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх чиг үүргийнхээ хүрээнд хорооны хэсгийн байцаагчаараа мэдэгдэл, шаардлага, зөвлөмжийг удаа дараа өгдөг: Танайх тусгай зөвшөөрөлгүй байж тамхи, согтууруулах ундааны зүйл зарж болохгүй, танайх сургуулийн ойр орчмоос 500 метрийн зайнд зарж болохгүй гэх мэт. Гэвч иргэд ашиг хонжоо олох зорилгоор энэ үйлдлээ гаргасаар байна. Мөн иргэдийн амьдралын боломж бололцооноос хамаарч байна гэж бодож байна.

Таны бодлоор “утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– Зөвшөөрөлгүй газар тамхи зарж байгаа чинь дандаа иргэд зарж байна. Гудамж, талбайд өндөр настай хүн суугаад тамхи зараад байна. Дараа нь автобусны буудал дээр, ТҮЦ зарж байна. ТҮЦ-ийн үйл ажиллагаа

явуулдаг хүмүүсийн амьдралын түвшин ямар байх билээ, тэгээд мөнгө арай ахиу олох бүтээгдэхүүнээ зараад байна.

Таны бодлоор “утаат тамхийг ширхэглэн худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– Мэдээж саяын хэлсэн хүмүүс чинь амжиргаагаа, ашгаа бодоод тамхийг ширхгээр нь зарж байна.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, модруулбал, “21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах, түүгээр утаат тамхи худалдуулах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Цагдаагийн албан хаагч хяналтын камер шүүж үзэхэд тухайн хүн нь 21 насанд хүрч үү хүрээгүй юу гэдгийг нь шууд тогтоох боломжгүй болоод байна. Цагдаагийн алба хаагч хувцастай хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэж байхад насанд хүрээгүй хүнд болон зарж байсан, эсхүл худалдаж авсан тамхиа нуудаг ч юм уу, ямарваа ил тод зөрчил байдаггүй. Мөн албан хаагчид ТҮЦ, хүнсний дэлгүүр дээр байнга хяналт тавиад байх боломжгүй. Харин гудамж, талбай дээр 21 насанд хүрээгүй хүн тамхи татаад байна гэдэг чинь тамхи бас худалдаж аваад л байна гэсэн үг.

Саяхан МУИС-ийн тэр дотуур байрнаас манай дээр албан бичиг ирсэн: зарим ААН шөнө, оройн цагаас амраахгүй байна, гэмт хэрэг зөрчлийн шинжтэй үйлүүд гарах юм байна гэсэн. Түүний мөрөөр цагдаагийн байгууллагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч эхэлсэн. СБД-ийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэр дээр, МУИС-ийн ойр орчим байрлах ТҮЦ-үүд борлуулах зөрчлүүд гардаг.

Таны бодлоор “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

Сургуулиас 500 метрийн дотор тамхи зарах зөрчил гардаг гэж түрүүн ярьсан. Бид зохих арга хэмжээг аваад явдаг. Яагаад ийм зөрчил гараад байна вэ гэвэл иргэдийн ашиг олох гэсэн сонирхол, дээр нь иргэдийн амьдралын боломж бололцооноос хамаарч байгаа болов уу. Энэ хэмжээг буулгаж хуульд өөрчлөлт оруулмаар санагддаг.

Таны бодлоор “утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Тамхи татахыг хориглосон газар татах зөрчил гарч байна.

Тамхины хяналтын тухай хуульд “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина” гэж заасан байдаг. Сая дурдсан байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсанаас хойш цагдаагийн байгууллагатай хамт явж шалгаж байгаа зүйл байхгүй. Манайх хуучин мэргэжлийн хяналтын байгууллага гэж байхад хамт үзлэг шалгалтууд хийдэг байсан.

Хуульд “Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Иргэд нийтээрээ гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг ганцхан цагдаагийн байгууллагынх гэж хардаг боловч энэ чинь бүх шатны байгууллагууд хяналт хийж болно шүү дээ. Одоо нийслэл дээр гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх зөвлөл гэж байдаг. Тэрэн шиг дүүргийн ЗДТГ-ын дэргэд ч юм уу, Иргэдийн хурлын дэргэд ч юм уу, шат шатандаа гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулдаг зөвлөл ажиллуудаг баймаар байна.

Хяналт тавихад хуулийн хүрээнд тулгамдсан асуудал байдаг уу?

– За яг энэ асуудлыг хуулиар нарийн зохицуулаад өгчих хэрэгтэй юм шиг санагдаад байгаа. Миний бодлоор бизнес эрхлэгчээ дэмжих зорилготойгоор ТҮЦ-үүдэд зөвшөөрлийг олговол яадаг юм. ТҮЦ гэдэг чинь иргэнд зөвшөөрлийг өгөөд, стандарт дүрмийг нь нарийн тогтоож өгөөд, хэрэгжилт дээр нь хяналтаа тавьчих хэрэгтэй. Хууль, стандар, дүрмээ дагаж мөрдөөд, хэрэв зөрчсөн бол цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ дагуу арга хэмжээг нь авч явбал зүйтэй санагдаж байна.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Зөрчлийн тухай хууль 2017 оны 7 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Энэ хуулийг батлахаас өмнө нэлээн судалгаа дүн шинжилгээ хийсэн байх. Хариуцлагын арга хэмжээнүүдийг нь нэлээн судалгаан дээр тулгуурлаж гаргасан зүйл байх. Харин мөнгөн дүнг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэйгээ уялдуулж гаргамаар юм уу.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хүнийг 500,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Зөрчлийн шалган шийдвэрлэх тухай хуулийн мөн чанар нь зөрчил үйлдсэн эд зүйл, зөрчил үйлдэхэд ашигласан хэрэгслийг хураана гэдэг. Цагдаагийн байгууллага хуулийн дагуу хурааж аваад, Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор баталсан журмаар шийдвэрлэж байгаа. Ингэж хурааж байгаа гэдэг чинь бол дахиж энэ төрлийн зөрчил үйлдэгдэхгүй л гэж гэдгээс урьдчилан сэргийлж байгаа нэг хэлбэр юм.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– Одоо хууль дээр шинэ тутам гарч ирж байгаа нөгөө Вип-ийг тамхины нэр төрөл дээр нэмээд өгмөөр байна. Вип-ийг чинь одоо хүүхэд, залуучууд, 10 жилийн сурагч, оюутан гэхгүй бүгд л кино театр гээд хаа хамаагүй сороод явж байна. Тэр одоо бөх шиг ч үнэртэй, гаа шиг ч үнэртэй байна. Одоо Вип-ийг Монгол Улсын хил гаалиар оруулж ирэхэд хориг тавьдаг ч юм уу, ямар нэгэн байдлаар тодорхой хуульчлах хэрэгтэй байна. Одоо бараг утаа тамхинаас илүү энэ вилийг их татдаг болжээ гэж харж байгаа. Электрон тамхи буюу вилийг Монгол Улсын гаалиар оруулж ирэхдээ электрон бараа гэж оруулж ирдэг. Гаалийн бүрдүүлэлт дээр код өгөөд гаалийн улсын байцаагч энийг электрон барааны нэхэмжлэх дээр оруулж ирж байна. Тэгэхээр электрон тамхи гэдгийг Монгол Улсын гаалийн код дээр утаа тамхи гэдгийг Тамхин хяналтын тухай хуульд өөрчилж, электрон тамхийг утаат тамхитай адил болгочихвол гаалиас эхлээд хяналтаа тавиад явах боломжтой. Цаашлаад вилийг хуулийг дагуу утаат тамхи шиг сургуулийн орчим 500 метрт зарахгүй, 21 нас хүрээгүй хүн зарахгүй гэсэн үг.

3) ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧ – БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН 2-Р ХЭЛТЭС

“Тамхины хяналтын тухай хууль”-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– Тамхины хяналтын тухай хууль дунд зэрэг хэрэгжиж байгаа, бүрэн хэрэгжихгүй байгаа.

Ер нь ямар зөрчил ихэвчлэн гардаг вэ? Яагаад?

– Хамгийн их зөрчил нь ихэвчлэн сургуулийн орчинд гардаг. Хуулийн заалтуудаас хамгийн их хэрэгжихгүй байгаа нь сургуулийн орчинд буюу 500 метрт тамхи худалдаалахгүй байх гэдэг заалтыг хамгийн их зөрчиж байна.

Тамхины хяналтын тухай хуулийн зүйл, заалтуудаас амьдралд буухгүй, хэрэглэгддэггүй зохицуулалт Таныхаар байна уу?

– Утаат тамхийг зарахыг хориглосон газруудад зарахгүй байх гэдэг хуулийн заалт ер нь муу хэрэгжиж байна. Энд хяналт тавихад маш хүндрэлтэй байгаа. Сургуулийн ойр орчим утаат тамхийг нууж зарах зөрчил их гарч байдаг.

Таны бодлоор “утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– Сая хэлсэн, нөгөө сургуулийн орчинд, 500 метрийн зайд ихэвчлэн хүнсний дэлгүүр, ТҮЦ тамхи зараад байна. Эд нар дээр дандаа тамхийг нууцаар зарж байгаад баригдаж, торгуулийн арга хэмжээ авагдаж байдаг. Тэгээд дэлгүүрүүд юу гэж яриада байна вэ гэвэл: бид тамхи зарахгүй бол орлогогүй байна, тийм болохоор бид торгуулаад ч хамаагүй тамхиа нуугаад ч хамаагүй зарахаас өөр аргагүй байна.

Таны бодлоор “утаат тамхийг ширхэглэн худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– Сүүлийн үед тамхийг ширхэглэж зарна гэдэг тохиолдол ерөнхийдөө маш бага болсон. Одоо амьдрал арай гайгүй болчихоод байгаа юм уу? Яагаад байгаа юм? Хүмүүс тамхийг ерөнхийдөө хайрцагаар нь л ихэвчлэн зардаг, авдаг болсон. байна. Бид ийм зөрчил их бага илрүүлсэн. Гол нь тамхийг лангуун доороо нууж зарах асуудал их байна.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, тодруулбал, “21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах, түүгээр утаат тамхи худалдуулах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Насанд хүрээгүй хүүхдэд тамхи зарах тохиолдол гардаг, гэхдээ тийм элбэг гараад байдаггүй. Ийм зөрчил гарвал түүн дээр арга хэмжээ авагдаад явдаг. Гэхдээ нөгөө сургуулийн бүсэд тамхи худалдахтай харьцуулбал, харьцангуй бага гардаг.

Таны бодлоор “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Сургуулийн орчинд, 500 метрийн зайнд тамхи худалдахыг хорилосон цэгүүдэд л, тийм бүсэд байршиж байгаа хүнсний дэлгүүр, ТҮЦ л тамхийг нууж зарж байна. Яагаад зараад байгаан гэхээр нөгөө л орлоготой холбоотой байдаг.

Таны бодлоор “утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газар тамхидахад хориглохсон байгаа шүү дээ. Хуулийн наад заалт хэрэгжихэд бас хэцүү. Тамхи татаж байгаа үйлдлийг нь яг газар дээр нь таарч байж л хуулийн хариуцлага хүлээлгэнэ. Тэгэхгүй бол хүмүүс тамхиа нуугдаж байгаад, булан тохойд очиж нуугдаж байгаад хаа сайгүй татаад байдаг. Насанд хүн хүн ч байдаг, насанд хүрээгүй хүүхэд ч байдаг тамхиа нуугдаж байгаад татдаг.

Тамхины хяналтын тухай хуульд “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина” гэж заасан байдаг. Сая дурдсан байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– Тэрийг бол ёстой мэдэхгүй байна. Надтай таарч байгаагүй.

Хуульд “Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Засаг дарга нар цагдаагийн албан хаагчтай хамт шалгалт хийгээд явдаг. Голдуу утаат тамхины шалгалтыг хар тамхи, мансууруулах бодисын шалгалттай хамт хийгээд явдаг. Хүүхдүүд, насанд хүрэгчид хаана янз бүрийг тамхийг татаж болзошгүй газруудаар шалгадаг. Жишээ нь, орцны дээвэр, хонгил, подвалд зэрэг газруудад улиралд нэг удаа шалгалт явагддаг.

Хяналт тавихад хуулийн хүрээнд тулгамдсан асуудал байдаг үү?

– Сүүлийн үед прокуроруудын зүгээс яг Тамхины хяналтын тухай хуульд заасан санкцаар шийтгэл оногдуулах нь хамаагүй бага болчихсон. Хуучин бол тэр 6.3-аар иргэнийг 300 мянгаар, ААН-ийг 3 сая төгрөгөөр торгодог, тамхийг нь хураадаг, хууль бусаар олсон орлого нь хураадаг улсын орлого болгодог байсан. Гэвч сүүлийн үед Зөрчлийн тухай хуулийн зөвхөн зөвшөөрөлгүй худалдаа, үйлчилгээ эрхэлсэн гэдэг зүйл, заалтаар хамааруулж үзээд, тамхи хураахгүй, харьцангуй бага хэмжээний торгууль ногдуулж байгаа.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Хариуцлага нэлээн өндөр байлгаж байж л энэ бүхнийг зохицуулахгүй бол, хариуцлага нь бага байхаар л хүмүүс тоохгүй байна шүү дээ.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хүнийг 500,000 төгрөгөөр хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Ерөнхийдөө хуулийн хэрэгжилт яагаад ингээд муу байгаад байна вэ гэвэл, хуулийн хариуцлага тооцох санц бага байгаагаар холбоотой. Дээр нь прокуроороос Зөрчлийн тухай хуулийн тамхийны хяналтын хууль тогтоомжийн биш зөршөөрөлгүй худалдаа, үйлчилгээ эрхэлсэн гэдгээр хариуцлага тооцоод байна. Уул нь эд зүйл хураах нь хамгийн эхэнд байх ёстой байхгүй юу.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– Электрон тамхийг зохицуулахгүй бол замбаагүй хэрэглэдэг болоод байна. Электрон тамхийг зах замбараагүй зарагдаж байна. Бүх дэлгүүрээд зарж байна. Ялангуяа 10 жилийн хүүхдүүд аягүй их хэрэглэдэг болчихсон байна. Хүүхдүүд өр нь бүгдээрээ л вип кармандаад л явж байна шүү дээ. Тэгэхээр хуульд энийг оруулж, хатуу хариуцлага тавьж зохицуулахгүй бол замбараагүй хэрэглэж байна.

Хууль хэрэгжихгүй байгаа нэг шалтгаан бол хуулийн хариуцлага бага байгаагаар холбоотой. Худалдаа хийж байгаа хүмүүс бид нар ингэж ашгаа олж байна гэж хандаад байна. Хүмүүс тамхи авахаар орж ирэхдээ нэмээд нэг ундаа, нэг талх аваад гардаг юм. Тэгэхгүй болохоор наад дэлгүүр чинь тамхи зардаггүй юм гээд орж ирэхгүй. Тамхи зардаг нэг дэлгүүрээсээ, нэг газраасаа л ундаа, талхаа авчихдаг юм. Тийм болохоор бид нар зарахаас өөр аргагүй гэдэг тайлбарыг маш их хэлдэг.

4) ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧ – БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН ХЭЛТЭС

“Тамхины хяналтын тухай хууль”-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт 50%-тай гэж үзэж байна, 100% хэрэгжихгүй байгаа. 1-рт, 2022 оноос Нийслэлийн ЗД-ын зарим төрлийн худалдаа, аж ахуйн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтгүйгээр эрхлэх шийдвэр гарсан. Тэрэнтэй холбоотойгоор ААН рүү шууд орж шалгалт хийхээ больсон. Тухайн ААН дээр

ямар нэгэн гэмт хэрэг, зөрчил гарсан тохиолдолд шууд орж шалгаж байгаа болохоос биш эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаад шалгахад больсон.

2-рт, цагдаагийн албан хаагчид их ачаалалтай ажиллаж байгаа. Хүний нөөц хүрэлцэхгүй байна. Тиймээс жишээлбэл, гудамжинд тамхи татаж байгаа хүнийг хараад “Энд автобусны буудал дээр тамхи татаж болохгүй” гэж хэлээд зогсоох боломжгүй болсон. Өмнө нь ийм хяналт тавьдаг байсан, одоо байхгүй болсон.

Ер нь ямар зөрчил ихэвчлэн гардаг вэ? Яагаад?

– Жишээлбэл, ТҮЦ ажиллуулж байгаа хүмүүс амьдралаа залгуулах гэж тамхи ширхгээр нь, эсхүл нууцаар зарах тохиолдол байдаг. Та бидний мэдэхгүйгээр их хэмжээгээр борлуулж байгаа ч байж магадгүй. Одоо албан ёсны зөвшөөрөлтэй CU, GS2” гэх мэт сүлжээ дэлгүүрүүд байна. Гэхдээ эдгээр дэлгүүрүүд дээр ч хяналт сайн тавигдаж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Тамхины хяналтын тухай хуулийн зүйл, заалтуудаас амьдралд буухгүй, хэрэглэгддэггүй зохицуулалт Таныхаар байна уу?

– Зөрчлийн тухай хууль болон Тамхины хяналтын тухай хуулийн заалтууд дээр тодруулга хийх хэрэгтэй байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 6.3-т заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт утаат тамхийг импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах талаар тодорхой зохицуулалт байгаа. Гэхдээ энэ импортлох, экспортлох дээр үнэхээр хяналт тавьж чадаж байна уу гэдэг асуудал байна. Би үүнийг сайн мэдэхгүй байна.

Таны бодлоор “утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– Жишээлбэл, хэдэн жилийн өмнө сургуулийн орчим 500 метрийн радиуст тамхи худалдаалахыг хориглосон. Гэхдээ сургуулиуд шинээр баригдахад өмнө нь зөвшөөрөлтэй байсан дэлгүүрүүд үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байдаг. Сургууль баригдсан гэж үндэслэн тухайн ААН-ийн зөвшөөрлийг цуцалж байгаа тохиолдол гараагүй. Энэ нь хуулийн уялдаа холбоогүйн нэг илрэл гэж харж байна.

Таны бодлоор “утаат тамхийг ширхэглэн худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– Энийг нөгөө амьдралаа болгох гэж байгаа нэг эмээ, өвөө нар л ерөнхийдөө зарж байна уу даа. Сүүлийн үед ширхгээр зарахгүй байх шиг байна. Хайрцаг хайрцаар нь тавьчихаад л худалдааны төвүүдийн гадаа, том том захууд, үйлчилгээний төвүүдийн үүдэнд ч зарж байдаг. Хүн ихээр цугладаг газруудад, автобусны буудлууд дээр, ТҮЦ-үүдэд зарж байна.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, тодруулбал, “21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах, түүгээр утаат тамхи худалдуулах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Одоо энэ хүний царайг хараад энэ хүүхэд байна аа гэж мэдээд байсан. Одоогийн энэ Z үеийнхэн бол 1-рт арай овортой харагдаад байна, 2-рт их өндөр залуучууд байгаа болохоор тэднийг 21 нас хүрээгүй гэж таниж чадахааргүй болчиход байна. Худалдагч архи, пиво, тамхи худалдахдаа тухайн хүнээ 21 насанд хүрээгүй байна гэж таньж чадахгүй байна.

Худалдагч бүр өөрсдөө архи, пиво, тамхи авна гээд ороод ирж байгаа тохиолдолд тухайн хүнээсээ Е-Монголиа-р насaa батал гээд шаардлага тавьбал нэг тал руугаа цэгцрэх байх.

Таны бодлоор “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Түрүүн би хэлсэн дээ, сургуулийн орчим 500 метрийн радиуст тамхи худалдаалахыг хулиар хориглосон. өмнө нь зөвшөөрөл авсан байсан ААН-ийн орчинд шинэ сургууль баригдахад ашиглалтанд ороход нөгөө ААН-ийн зөвшөөрөл үйлчилсэн хэвээрээ л байна.

Таны бодлоор “утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Утаа тамхины хувьд байгаа. Гэхдээ орчин үеийн хүмүүсийн ухамсар нь өөрчлөгдсөн байна. Хаана татах вэ, ямар цэг дээр очиж татах вэ, ил задгай татах асуудал хэдэн жилийн өмнөхтэй харьцуулахад цөөрсөн байна гэж харж байгаа. Тэгэхдээ мэр царай харагдсаар л байгаа, огт таслан зогсоочхож байгаа юм байхгүй л дээ.

Тамхины хяналтын тухай хуульд “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина” гэж заасан байдаг. Сая дурдсан байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– Байхгүй. Цагдаагийн байгууллагаас өөр хяналт тавьдаг байгууллага байдаг юм уу? Дээр үед бол Мэргэжлийн хяналт гээд нэг байгууллага байсан, тэрийг чинь татан буулгаад хаячихсан. Одоо Тамхины хяналтын тухай хуульд ганцхан цагдаагийн байгууллага л хяналт тавьж байгаа шүү. Өөр ТББ-ууд хяналт тавьдаг зүйл байхгүй.

Хуульд “Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу

хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Засаг дарга нар бол захирамж гаргаж, нэг цаасан дээр юм бичихээс биш, өөрийн биеэр хяналт хийдэг юм уу. Тэд нар чинь өрөөдөө л ажиллаж байдаг шүү дээ.

Хяналт тавихад хуулийн хүрээнд тулгамдсан асуудал байдаг үү?

– ААН тамхи нууцаар зарчихсан, насанд хүрээгүй хүүхдэд тамхи зарчихсан, сургуулийн бүсэд тамхи зарчихсан гээд бид нар тухайн зөрчлөө шалгаад, дэлгүүр дээр нь очиж бараагаа хураана, хураагаад дүүрэг дээрээ аваачиж өгч устгуулна. Устгуулахын тулд бид тоотгоо бичинэ, шилжүүлнэ гээд бас ажиллагаатай байдаг. Тэгээд тэр чинь хэдэн мянган ширхэг бүүрээр нь, хайрцаг бүрээр нь, баглаа бүрээр нь тоолоод, дараа нь дүүргийн үйлдвэр үйлчилгээний хэлтэст нь аваачиж тоо ширхгээр нь тушаана, тушаасныхаа дараа бид материалдаа хавсаргаад прокурорт хүргүүлдэг юм. Тэгээд прокурор нь хууль зүйн заалтыг нь шалгаад “зөв арга хэмжээ авсан байна” гээд журмын дагуу цаашаа явдаг. Тэгэхээр нэгхэн зөрчил шалгаж шийдвэрлэх бүрт материалжуулаад дуусгахад бараг 30, 40 бичгийн цаас, өчнөөн төчнөөн үйл ажиллагаа явагдана, энэ бүхэн хэчнээн цаг суух уу гээд зөндөөн юм болдог. Өөрөөр бол процесс ихтэй, цаг их авдаг юм.

Гэтэл ганцхан торгуулийн хуудас бичээд л албадан төлүүлэх, торгуулиа төрийн сандаа тушаалгаад явах юм бол илүү шуурхай болно. Жишээ нь замын цагдаа шиг шууд торгочихмоор байгаа юм. Тэгээд тэр хүн нь 14 хоногийн дараа торгуулиа төлөхгүй бол мөнгөн дүн нь нэмэгдээд явна. Харин хэв журмын албан хаагчид тэгэж торгож болохгүй.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Энэ 50 нэгжээр торгож байгаа нь торгуулах чадвартай улсууд байна, чадваргүй улсууд гэж бас байна. Бид бол хуулийн дагуу торгоод л явна.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Хуулийн этгээд дээр бол заавал бид “торгууль цэг мн” шиг юмаар торгохгүй, заавал торгуулийн хуудсаар торгож байж материалд хавсаргаад. Тэр хүн торгуулаад хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд албадан гаргуулах, хүлээн зөвшөөрсөн тохиолдолд торгуулийг нь төрийн санд тушаагаад квитанцыг нь хавсаргаж прокурорт хүргүүлдэг. Энэ процесс нь их удаан байгаа юм. Бид хуулиа мөрдөөд л явна.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хүнийг 500,000 төгрөгөөр 8 хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Энэ эд хөрөнгийг нь хурааж байгаа тохиолдол одоо ховор болчихсон. Олсон орлогыг нь, мөнгө төгрөгийг нь хурааж байгаа тохиолдол бараг байхгүй болсон.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилттэй ганцхан цагдаагийн байгууллага тэмцээд барахгүй байх гэж бодож байна. Тэр ТББ-ууд нь хяналт тавих ч юм уу. Жишээ нь, “school police” хийхэд ажлаас нь чөлөөлдөөд хийдэг шиг адилхан сургуулийн бүсэд магадгүй урамшуулалтайгаар тамхины хяналтыг тавьдаг арга хэмжээ авдаг ч юм уу. Яг энэ хуулиар нь алба хаагч нар томилж, дагнасан хяналт тавьбал хэрэгжилт нь сайн явагдана шүү. Эсхүл тамхины хуулиар нээгдсэн байдлаар хэсэгчилсэн арга хэмжээ 7 хоногт нэг удаа явуулбал, жишээ нь 7 хоног болгон удаа бүх ААН-үүдийг, бүх ТҮЦ-үүдийг шалгадаг нээгдсэн арга хэмжээ явуулаад байвал ажмаар зөрчил багасана гэсэн үг.

5) ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧ – ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН 1-Р ХЭЛТЭС

“Тамхины хяналтын тухай хууль”-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– Тамхины хяналтын тухай хууль нутаг дэвсгэрүүдэд харилцан адилгүй хэрэгжиж байна. Жишээлбэл, манай Хануул дүүргийн нутаг дэвсгэр дээр сургууль, цэцэрлэг, эмнэлгийн орчин, автобусны буудлын орчин зэрэг газруудад харилцан адилгүй үйлчилж байдаг. Тамхины хяналтын тухай хууль дээр тамхи татахын хориглосон 8 цэгийг заагаад өгсөн байдаг. Гэтэл олон нийтийн газар, цэцэрлэгт хүрээлэн зэрэг газруудад хэрэгжихгүй байна.

Ер нь ямар зөрчил ихэвчлэн гардаг вэ? Яагаад?

– Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйл дээр Тамхины хяналтын тухай хуулийн зөрчлийг тусгасан байдаг. Харин Зөрчлийн тухай хуулийн 5.1.1 дээр гудамж талбайд тамхины иш хаях, нус цэрээ хаях гэсэн зөрчлүүд байгаа. Хүмүүс 1-рт хориглосон газар тамхи татаж байна, 2-рт хориглосон газарт тамхиа татаад, ишийг нь хаяж байна. Яагаад ийм зөрчил гараад байна вэ гэвэл, тамхи татах зориулалтын цэгүүд байхгүй байна. Ийм цэгийг сум, дүүргийн Засаг дарга нар, ААН, байгууллагууд байгуулах үүрэгтэй, гэтэл энэ бас хэрэгжихгүй байна.

Мөн сургуультай ойр ТҮЦ, хүнсний дэлгүүрүүд зөвшөөрөлгүйгээр тамхийг худалдан борлуулж байна. Одоо ийм тодорхой төрлийн зөрчлүүд ерөнхийдөө бол ихэвчлэн үйлдэгдэж байна. Яагаад гэвэл тамхины эрэлт их байна. Тамхи татаж байгаа хүмүүс их учраас одоо ТҮЦ-үүд маш ихээр тамхийг ширхэглэн зарж борлуулж байна. Дэлгүүрүүд болохоороо нөгөө тусгай зөвшөөрөлгүйгээр бас иш зарж борлуулж байгаа нь эрэлт их байна гэсэн үг.

Тамхины хяналтын тухай хуулийн зүйл, заалтуудаас амьдралд буухгүй, хэрэглэгддэггүй зохицуулалт Таныхаар байна уу?

– Тамхины хяналтын тухай хуульд татхыг хориглосон 8 цэгийг заагаад өгсөн. Гэхдээ шаардлагатай цэгүүдийг бас оруулж өгөөгүй гэж үзэж байна. Хүмүүс хүүхдээ салхилуулахдаа цэцэрлэгт хүрээлэнд, хүүхдийн тоглоомын талбайд тамхи татаж байна. Мөн гудамж, олон нийтийн талбай гэх газруудыг хуульд нэмж оруулмаар санагддаг.

Таны бодлоор "утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– Дэлгүүрүүд зөвшөөрөлгүй зарж байна. Тэгэхээр тэнд эрэлт ихтэй байна гэсэн үг. Эрэлт ихтэй учраас тухайн газрууд нь тамхи зараад, зөрчил үйлдэгдээд байна, зөрчил үйлдэгдсэн тохиолдолд манай дээр хариуцлага тооцоод явж байна. Олон тохиолдол байдаг.

Таны бодлоор "утаат тамхийг ширхэглэн худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– Ширхэглэн худалдах асуудал бол ерөнхийдөө ТҮЦ-үүд дээр, нөгөө автобусны буудал дээр байдаг. Ширхэглэн худалдах гэдэг нь нөгөө төлбөрийн боломжоос шалтгаалж байна, бүтэн хайрцагар нь авах боломжгүй тохиолдолд ширхгээр худалдаж авч байна.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, тодруулбал, "21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах, түүгээр утаат тамхи худалдуулах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Дэлгүүр бүр хяналтгүй зараад байдаггүй. 1-рт, 21 насанд хүрээгүй хүүхдүүд тамхи авахдаа том хүнээр дамжуулж тамхи авч байна. Тэд хэрэв өөрт нь зарахгүй байгаа бол гудамжинд таарсан хүнээсээ гуйгаад, мөнгө төгрөгийг нь өгөөд дамжуулж авч байна. 2-рт, хуурамч бичиг баримтаар, оноо худлаа хэлж авч байна, ахынхаа ч юм уу үнэмлэхийн зургийг харуулж байгаад тамхи худалдаж аваад байна.

Зарим тохиолдолд дэлгүүр өөрсдөө хяналтаа тавихгүй бичиг баримтыг нь шалгахгүйгээр зарж байгаа тохиолдол ерөнхийдөө гарч байна.

"21 нас хүрээгүй хүнээр" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Одоогоор манай дээр бол тийм зөрчил гарсан тохиолдол байхгүй байна. Нөгөө архи зардаг дэлгүүрүүдэд бас тамхи зарж байгаа. Архи борлуулахад мөн 21-ээс дээш нас гээд заагаад өгчихсөн байдаг учраас тэр дэлгүүрт насанд насанд хүрсэн хүмүүс суудаг тул энэ төрлийн зөрчил гараагүй байна.

Таны бодлоор "ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулсан, худалдаа, үйлчилгээ явуулсан тохиолдол ер нь гардаг. Тухайн 500 метрийн дотор тамхи зарж байгаа ганц ч дэлгүүр байхгүй байхад нөгөө эрэлт нь их байгаа байна. Тэгэхээр тухайн газар нууцаар худалдаж эхэлнэ. Нэг дэлгүүр зараад эхлэхэд тухайн орчинд тамхи авах магадлал нь ихсэж байгаа учраас нөгөө орлого ихтэй, эрэлт ихтэй байгаа учраас л ийм зөрчил гараад байна. Орлогоо бодоод л зөрчил хийгээд байна гэсэн үг байна шүү дээ.

Таны бодлоор "утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Зөрчлийн ихэнх хувь нь тохиолдолд гудамж, талбайд гарч байна. Өөрөөр бол, утаат тамхийг хориглосон газар татаж байна. Гудамж, талбайд татсан тамхиныхаа ишийг хогийн саванд биш, гудамж, талбайд хаяж байна. Энэ зөрчлүүд нь ерөнхийдөө бол манай гудамж, талбайн зөрчлийн ихэнх хувийг эзэлж байгаа юм. Тэгээд энэ чинь эргээд нөгөө тамхи татах зориулалтын цэгтэйгээ холбоотой байгаад байна,

Тамхины хяналтын тухай хуульд "хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина" гэж заасан байдаг. Сая дурдсан байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– Надад хэрэглэгчийн эрхийг хамгаалах, ТББ-аас Тамхины хяналтын тухай хуулийн тогтоомжид хяналт тавьсан тохиолдол ерөөсөө таарсан юм алга. Энэ тухайн хяналт тавьж байгаа талаар бол мэдээлэл ерөөсөө байхгүй байна.

Хуульд "Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ" гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг үү?

– Дүүрэг, хорооны Засаг дарга нартай хамтарч Тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжилтийг хангах зорилгоор төлөвлөгөөт шалгалтуудыг хийдэг. Ерөнхийдөө хуулийн хэрэгжилтийг хангах гээд арга хэмжээ зохион байгуулаад явдаг.

Хяналт тавихад хуулийн хүрээнд тулгамдсан асуудал байдаг уу?

– Сая миний хэлсэнчлэн тодорхой цэгүүдийг хуульдаа тусгаж өгөөгүй учраас хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад бас хүндрэл бэрхшээлтэй талууд гарч байна. Тамхины хяналтын тухай хуульд тамхи татахыг хориглосон цэгүүдийг заагаад өгчихсөн байдаг. Энэ 8 цэгт хамгийн их зөрчил гарах болзошгүй газруудыг нэмэх шаардлагатай л гэж үзэж байна. Тухайлбал, гудамж талбайд алхаад явж байхад л урд нь тамхи татаад явж байгаа чинь арын хүмүүс дам тамхидалтанд өртөөж байна гэсэн үг.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Хэрвээ ААН нь тамхи татах цэг байгуулаагүй тохиолдолд 500 нэгжээр хуулийн этгээдийг торгох нь их хүндрэл учруулахгүйгээр рга хэмжээ авч байгаа гэж бодож байна. Харин ч багадсан санки гэж үзэж байна, энэ хэмжээг нэмчихвэл нөгөө ААН-үүд маань илүү хариуцлагатай байх боломжийг хангах юм уу даа.

Зөрчлийн тухай хуулиар "Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд өшиглөсөн эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хүнийг 500,000 төгрөгөөр хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож" хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэхэд иргэн гээд байхгүй, хуулийн этгээд, ААН байгууллагуудад илүү хамаатай, илүү холбогдоод явчихдаг. Харин худалдах нь иргэнтэй илүү холбогддог. Хуульд энэ хоёрыг салгаж зохицуулмаар санагддаг. Экспортлох, импортлох, үйлдвэрлэх нь худалдах, хэрэглэхээс илүү өргөн хүрээтэй гэж бодож байна. Эдгээр үйл ажиллагаанд тавигдах шаардлага бас арай өөр агуулгатай баймаар юм.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– Сум, дүүрэг, хорооны Засаг дарга нар Тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд хяналт тавих үүргээ биелүүлснээр, энэ хууль Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд сайн хэрэгжих боломжийг бүртгүүлж өгөөсэй гэж боддог юм. ААН, байгууллагууд гадаанаа тамхи татах зориулалтын цэгийг байрлуулаад, бас сум, дүүргийн Засаг дарга нар тамхины цэг байгуулах газрыг нь зааж өгөөд, тухайн цэг дээр хяналт тавьдаг баймаар байна. Тэгээд цагдаагийн байгууллага зөрчил үйлдээд байгаа газрууд болон иргэдэд нь хариуцлага тооцдог гээд хамтарсан, хамтын үйл ажиллагаагаар Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт сайжрах юм болов уу.

Б) ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧ – ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

"Тамхины хяналтын тухай хууль"-ийг хэр зэрэг хэрэгжиж байна гэж Та бодож байна вэ? Яагаад?

– Хуулийн зөрчил байнга гардаг, тэдгээр зөрчлийг цагдаагийн байгууллагаас Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан харьяаллын дагуу Зөрчлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсгүүдэд заасан үйлдлүүдийг шалган шийдвэрлэдэг.

Ер нь ямар зөрчил ихэвчлэн гардаг вэ? Яагаад?

– Ихэвчлэн тусгай зөвшөөрөлгүйгээр худалдаалах, тамхийг ширхэглэн худалдах, зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхи худалдах зэрэг зөрчлүүд гардаг. Дээрх зөрчлүүд гарч байгаа шалтгаан нь иргэдийн хуулийн мэдлэг дутмаг, мөн амьдралын түвшин бага байгаатай холбоотой. Гудамжинд тамхи ширхгээр зараад сууж байгаа эмээ нар байна шүү дээ. Хуулийг хэрэгжүүлэхийн тулд тэдгээрийн тамхийг хурааж аваад, 300,000 төгрөгөөр торгоно гэдэг бас хүндрэлтэй л асуудал байдаг.

Тамхины хяналтын тухай хуулийн зүйл, заалтуудаас амьдралд буухгүй, хэрэглэгддэггүй зохицуулалт Таныхаар байна уу?

– Бүгд хэрэгжээд явах боломжтой гэж боддог.

Таны бодлоор "утаат тамхийг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт худалдах" тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.12)

– Зөрчил их гардаг. Дээр хариулсантай мөн адил иргэдийн хуулийн мэдлэг дутмаг, мөн амьдралын түвшинтэй холбоотой.

Таны бодлоор “утаат тамхийг ширхэглэн худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.8)

– Мэдээж нийтлэг гардаг зөрчлүүдийн нэг. Мөн л адил иргэдийн хуулийн мэдлэг дутмаг, амьдралын түвшинтэй холбоотой. Зарим нь тамхиа зарж, талхны мөнгөө олж байгаа бол, зарим нь хайрцаг тамхи авах боломжгүйдээ л ширхгээр авч байгаа.

Таны бодлоор хүүхэд, залуучуудад, модруулбал, “21 нас хүрээгүй хүнд утаат тамхи худалдах, түүгээр утаат тамхи худалдуулах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Ийм зөрчил харьцангуй буурсан гэж боддог. Нэг үеэ бодвол иргэд маань тамхи худалдаалахдаа хүүхдийн бичиг баримт шалгадаг болсон. Дээрх зөрчил гарч байгаа нь хүний ухамсартай л холбоотой.

“21 нас хүрээгүй хүнээр” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.7)

– Мөн л гардаг зөрчил. Ихэвчлэн гэрийнхээ ажиллуулдаг дэлгүүрт суугаад худалдаа хийж байгаа хүүхэд, залуучууд байдаг. Мөн л эцэг, эхийн, иргэдийн хуулийн мэдлэг дутмаг байгаатай л холбоотой.

Таны бодлоор “ЕБС-ийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор утаат тамхи худалдах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§6.7.14)

– Ийм зөрчил нь иргэдийн хуулийн мэдлэг, ухамсартай холбоотой.

Таны бодлоор “утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татах” тохиолдол хэр зэрэг гардаг вэ? Яагаад? (§9.1)

– Нийтлэг гардаг зөрчил. Гэхдээ одоо иргэд гудамж, талбайд тамхи татаад явах нь багассан. Энэ нь иргэдийн ухамсар, биеэ авч явах соёл сайжирч байгаатай холбоотой гэж бодож байна.

Тамхины хяналтын тухай хуульд “хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон бусад ТББ тамхины хяналтын тухай хуулийн биелэлтэд олон нийтийн хяналт тавина” гэж заасан байдаг. Сая дүрдсэн байгууллагуудаас ийм хяналт тавьсан тохиолдолтой та таарч байв уу? Таарч байсан бол ямар байгууллага вэ? (§11.3)

– Ийм тохиолдолтой таарч байгаагүй.

Хуульд “Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Хуулийн энэ заалтад заасан төрийн зүгээс тавих хяналтын талаар юу гэж бодож байна вэ? Жишээлбэл, хорооны, дүүргийн зүгээс хяналт тавьдаг уу?

– Миний бодлоор Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт, тамхигүй эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд цагдаагийн байгууллага л түлхүү хяналт тавьж ажилладаг. Тамхины импорт, экспорт зэрэгт холбогдох байгууллагууд хяналт тавьдаг. Дүүрэг, хорооноос оролцоо бага гэж боддог.

Хяналт тавихад хуулийн хүрээнд тулгамдсан асуудал байдаг уу?

– Шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнүүд. Жишээ нь электрон, халаадаг, шиша, зажилдаг тамхи зэргийг хуульд тусгаагүй тул хяналт тавьж болдоггүй хүндрэлтэй.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи татахыг хориглосон газарт утаат тамхи татсан, эсхүл татах боломж олгосон хүнийг 50,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.1)

– Эдгээр хариуцлагууд нь энэ цаг хугацаанд тохиромжтой. Хойшдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулбал зөв санагддаг.

Зөрчлийн тухай хуулиар “Утаат тамхи худалдах, хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд өшиглөсөн эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хүнийг 500,000 төгрөгөөр хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгож” хариуцлага тооцох нь Таны бодлоор хэр зэрэг тохиромжтой вэ? Тохиромжгүй бол яах ёстой вэ? (§6.3.2)

– Одоогийн байдлаар энэ хариуцлагын хэмжээ нь тохиромжтой гэж бодож байна. Харин хоошид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулж өөрчлөх боломжтой.

НЭЭЛТТЭЙ АСУУЛТ

– Электрон, халаадаг, шиша зэрэг тамхинууд хуулиар зохицуулагдаагүй болохоор эдгээрийг иргэдээс хүссэн хэмжээгээрээ оруулж, хүссэн газраа татаж байгаа нь дутагдалтай байна.



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Одсүрэнгийн НОМИНЧИМЭГ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн өрдөн
Утас: 29-27-14 Факс: 32-70-16
E-mail: nominchimeg@parliament.mn
http://www.parliament.mn

2025.08.13 № УИХ-03/9558
танай _____-ны № _____-г

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Д.ГАНЗОРИГ,
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР
Б.ЖАРГАЛСАЙХАН НАР ТАНАА

Хуулийн төсөлд санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасны дагуу санал авахаар хүргүүлж байна.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, холбогдох тайланг хавсаргав.

Хавсралт 39 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

О.НОМИНЧИМЭГ




000175

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН НЭГТГЭЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 09 дүгээр сарын 15

Нэг. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд өгсөн санал:

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хурлын D.PARLIAMENT.MN цахим сүлжээнд байршуулсан бөгөөд 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн байдлаар нийт 466 санал ирүүлсэн байна. Нийт ирүүлсэн саналаас хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой 283 санал, 2 дугаар зүйлтэй холбоотой 183 санал ирүүлснийг агуулгаар нь нэгтгэж, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх лавлагаа, мэдээллийг бэлтгэн, нэгдүгээр хавсралтад хавсаргав.



Хоёр. Хуулийн төслийн хэлэлцүүлгийн үеэр гаргасан санал:

Хуулийн төслийг боловсруулах явцад олон улсын хэлэлцүүлэг, зөвлөгөөн 1 удаа, холбогдох төрийн байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг 2 удаа тус тус зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэг, зөвлөгөөнд нийт 440 гаруй хүн оролцсон болно. Хэлэлцүүлэг, зөвлөгөөнөөс гарсан нийт саналыг агуулгаар нь нэгтгэж, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх дараах лавлагаа, мэдээллийг бэлтгэн, хоёрдугаар хавсралтад хавсаргав.

Гурав. Байгууллагуудаас ирүүлсэн санал:

Хуулийн төсөл боловсруулах явцад нийт 15 байгууллагаас ирсэн саналыг нэгтгэж, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх дараах лавлагаа, мэдээллийг бэлтгэн, гуравдугаар хавсралтад тус тус хавсаргав.

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД
D.PARLIAMENT.MN ЦАХИМ ХАЯГААР ИРҮҮЛСЭН ОЛОН НИЙТИЙН САНАЛЫГ ТУСГАСАН ЭСЭХ
ТАЛААРХ ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хурлын D.PARLIAMENT.MN цахим сүлжээнд байршуулсан бөгөөд 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн байдлаар нийт 466 санал ирүүлсэн байна. Нийт ирүүлсэн саналаас хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой 283 санал, 2 дугаар зүйлтэй холбоотой 183 санал байна. Нийт ирүүлсэн саналыг агуулгаар нь нэгтгэж, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх дараах лавлагаа, мэдээллийг бэлтгэлээ.

Д/д	Хуулийн төслийн холбогдох заалт	Иргэдээс ирүүлсэн санал, сэтгэгдэл	Хуулийн төсөлд тусгасан эсэх	Үндэслэл, тайлбар
Төслийн 1 дүгээр зүйлд тусгасан дараах зүйл, хэсэг, заалттай холбоотой нийт 274 саналыг нэгтгэн тусгасан.				
1.	6.7.16.энэ хуулийн 3.1.1.а, 3.1.1.б, 3.1.1.в-д заасан бүх төрлийн тамхи, цэнэглэх шингэнд үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх; /192 санал, сэтгэгдэл/	1.Янжуур тамхийг дэмжсэн, нэг талыг барьсан хууль мэт ойлгогдож байна. • Хуулийн төсөл нь электрон тамхи, түүний амт үнэрийг хориглож байгаа ч янжуур тамхинд хориг тавиагүй, улмаар хууль нэг талыг барьсан, янжуур тамхины компаний захиалгатай мэт харагдаж байна. • Янжуур тамхи нь дам тамхидалт, уушгины өвчлөл, цэртэй ханиалга, шарласан шүд, заваан үнэр зэргээс шалтгаалан илүү хортой гэж үзэж байна. • Хуулийн төсөлд лобби орсон, ард түмнээ хамгаалах биш хордуулах хууль болсон байна.	Хүлээж авах боломжгүй.	Хуулийн төсөлд бүх төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүнийг тусгаж өгсөн бөгөөд аль 1 талыг барьсан зүйл байхгүй болно. Хуулийн төслийн 3.1.1-т тодорхойлолтыг тусгасан. Дэлхийн улс орнууд хүүхэд, залуучуудын дундах электрон тамхины хэрэглээг хязгаарлах зорилгоор электрон тамхийг бүрэн хориглох, эсхүл түүний амт, үнэрийг хязгаарлах бодлогыг хэрэгжүүлж байна. 2024 оны байдлаар 30 гаруй улс электрон тамхийг бүрэн болон худалдах, импортлохыг хориглосон бол 20 улс амт, үнэрийг хориглосон.

	2. Хүний эрх, сонголтыг зөрчсөн хууль гэж үзэж байна. - Насанд хүрсэн хүний сонголтын эрх чөлөөг хязгаарласан, ялангуяа амт, үнэртэй бүтээгдэхүүн хэрэглэх эрхийг хаасан гэж үзэж байна. - Хэрэглэгчдэд сонголт үлдээх, зөвхөн насанд хүрээгүй хүнд борлуулахыг хориглох нь зүйтэй. - Хэт туйлширсан хууль, "янжуураа л тат гэж тулгасан хууль" гэсэн хандлагатай байна.	Хүлээж авах боломжгүй.	Тамхины хяналтын тухай хууль нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилготой юм. Мөн нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор төрөөс аливаа хязгаарлалт, хориг тогтоох боломжтой бөгөөд энэ нь олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Түүнчлэн тус хуулийн төслөөр аль нэг тамхин бүтээгдэхүүнд давуу байдал олгоогүй бөгөөд бүх тамхин бүтээгдэхүүнд адил үйлчлэх хуулийн зохицуулалтыг тусгасан болно.
	3. Амт, үнэр нь өсвөр үе, эмэгтэйчүүдийг татах хүчин зүйл гэдэгтэй санал нэг байв. - Гаатай, жимстэй, хагалдаг капсултай амт нь өсвөр үе, эмэгтэйчүүдэд таалагддаг, хэрэглээг нэмэгдүүлдэг. - Иймд амт, үнэр, хагалдаг капсултай тамхийг хориглох нь зүйтэй гэсэн дэмжсэн санал. - Амт үнэр нь хэрэглэгчдэд "аюулгүй мэт ойлголт төрүүлдэг" нь хэрэглээг нэмэгдүүлдэг.	Дэмжсэн санал.	

	4.Электрон тамхи бол илүү цэвэр, соёлтой хэрэглээ гэж үзэж байна. • Янжуураас гар хуруу шарлах, үнэр шингэх, цэртэй ханиалга зэрэг сөрөг нөлөө ихтэй. • Электрон тамхи нь үнэр багатай, амт сонголттой, бохирдол багатай, хүмүүс өөрсдөө тамхинаас гарах шилжилтийн шат гэж харж байна. • Цэвэрхэн хэрэглээ, орчны бохирдлыг бууруулахад ч зэрэг гэж үзэж байна.	Хүлээж авах боломжгүй.	ДЭМБ болон бусад олон улсын судалгаагаар бүх төрлийн тамхин бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй нь тогтоогдсон. Мөн тус хуулийн төсөлд бүх тамхин бүтээгдэхүүнд адил үйлчлэхээр хуулийн зохицуулалтыг тусгасан болно.
	5. Амт, үнэрийг хоригловол далд худалдаа, хууль бус сүлжээ нэмэгдэнэ гэж болгоомжилсон. • Хэт хориг тавибал хууль бус борлуулалт, татваргүй бүтээгдэхүүн, далд зах зээл нэмэгдэх эрсдэлтэй. Иймд хууль нь уян хатан, бодит нөхцөл байдалтай нийцсэн байх ёстой гэсэн саналууд давамгайлсан. • Хэт нэг талт бодлого нь нийгмийн эсэргүүцэл, хэрэгжилтэд хүндрэл үүсгэнэ.	Хүлээж авах боломжгүй.	Электрон тамхины амт үнэрийг хориглосноор хууль бус худалдаанд төрийн холбогдох байгууллагууд хяналт тавьж, хариуцлага тооцох эрх зүйн орчин байгаа болно. Дэлхийн улс орнууд хүүхэд, залуучуудын дундах электрон тамхины хэрэглээг хязгаарлах зорилгоор электрон тамхийг бүрэн хориглох, эсхүл түүний амт, үнэрийг хязгаарлах бодлогыг хэрэгжүүлж байна. 2024 оны байдлаар 30 гаруй улс электрон тамхийг бүрэн болон худалдах, импортлохыг хориглосон бол 20 улс амт, үнэрийг хориглосон.

		6. Судалгаа, нотолгоо шаардаж байна. • Электрон тамхи яг ямар хэмжээнд хортой болох, ямар бодис, нөлөөлөлтэй болох талаар бодит судалгаа, нотолгоог олон нийтэд ил тод тавих хэрэгтэй. • “Хамгийн хортой нь аль нь вэ?”, “Янжуурт 4000 хорт бодис байхад электрон тамхи хор багатай гэж үздэг” гэж үзсэн сэтгэгдэл их байна.	-	Электрон тамхины хор нөлөөний талаарх олон улсын судалгаа, нотолгоо нь олон нийтийн сүлжээнд нээлттэй байдаг. Дээрх судалгаануудын үр дүнгээр электрон тамхины дараах төрлийн хор нөлөөг тогтоосон байдаг. Үүнд: - Уушги ба амьсгалын тогтолцооны нөлөө - Зүрх судасны тогтолцооны нөлөө - Генетик ба эсийн түвшний нөлөө - Химийн найрлага ба хорт бодисууд
2.	6.7.17.тамхины хайрцаг, сав, баглаа боодол нь өнгө, дүрслэл, хэлбэр дизайны, материал, гүйцэтгэл болон бусад гадаад шинж чанараараа хүний анхаарал, сонирхлыг татахуйц, эсхүл бусад эд зүйлстэй андуурагдахаар байх. /33 санал, сэтгэгдэл/	Хэт нэг талыг барьсан, логикгүй, амьдралд нийцэхгүй зохицуулалт оруулсан байна. Янжуур тамхи нь электрон тамхинаас илүү хортой бөгөөд ушгины өвчлөл, хорт хавдар, дам тамхидалт зэргийг дурдаж, хэрэглээг бууруулахын тулд татварыг нэмэх шаардлагатай. Электрон тамхи нь соёлтой, хор багатай хэрэглээ бөгөөд хэрвээ хортой гэж үзэж байгаа бол шинжлэх ухааны үндэслэлээр батлах шаардлагатай. Тамхин бүтээгдэхүүний сав, баглаа боодол нь хүний анхаарал татахааргүй, эрүүл мэндэд хортой гэсэн ойлголтыг өгдөг байх хэрэгтэй. Ялангуяа хүүхдийн сонирхлыг татахаас сэргийлж, андуурагдахааргүй, энгийн савлагаа хэрэгтэй.	Хүлээж авах боломжгүй. Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төслийн зорилго нь хүүхэд, залуучуудын тамхины хэрэглээг бууруулах зорилготой бөгөөд ДЭМБ-ын ТХСК-ын зөвлөмжид тамхин бүтээгдэхүүний сав, баглаа, бодлыг хүний анхаарал татахааргүй энгийн сав, баглаатай болгохыг зөвлөдөг. Бүх төрлийн тамхин бүтээгдэхүүн хүний биед хор нөлөөтэй олон улсын судалгаагаар нотлогдсон. Хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд тамхин бүтээгдэхүүний ОАТ-ын хэмжээг үе шаттай нэмэхээр тусгасан. Электрон тамхины хор нөлөөний талаарх дараах чиглэлийн ОУ-ын судалгаанууд байдаг. Үүнд: Уушги ба амьсгалын тогтолцооны нөлөө, зүрх судасны тогтолцооны нөлөө, генетик ба эсийн түвшний нөлөө, химийн найрлага ба хорт бодисуудын нөлөө.
		Хүүхдийн хэрэглээ нэмэгдэхээс сэргийлэх нь чухал бөгөөд анхаарал татахуйц савлагаа нь хүүхдүүдэд сэдэл төрүүлж болзошгүй тул ийм	Хуулийн төсөлд тусгасан.	-

3.	6.8.3.тамхийг худалдахдаа далд байршуулж, хэрэглэгч бүтээгдэхүүнийг сурталчилгааны шинж чанар агуулаагүй жагсаалтаас сонгон худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх; /52 санал, сэтгэгдэл/	терлийн сурталчилгааг хориглох хэрэгтэй. 1.Далд худалдаалах нь үр нөлөөгүй, буруу зохицуулалт гэж үзэж байна. • “Далд хэлбэрээр зарах” зохицуулалтыг утгагүй, хэрэгжих боломжгүй, улмаар хор уршигтай гэж үзэж байна. • “Нуух тусам сонирхол татдаг”, “ил тод байх нь зөв”, “ил зарж, хяналт тавих нь илүү үр дүнтэй” гэсэн байр суурь зонхилж байна. • Хэрэглэгчийн сонголт хийх эрхийг хязгаарлаж байна гэж үзсэн.	Хүлээж авах боломжгүй.	Тамхин бүтээгдэхүүнийг дэлгүүр, худалдааны төвийн кассын дэргэд шилэн хоргонд ил байршуулан худалдаалж байгаа нь хүүхэд, залуучууд тамхин бүтээгдэхүүн худалдан авах сэдлийг төрүүлж байдаг. Иймд олон улсад “борлуулалтын цэг дэх ил байршуулалтыг хориглох - point-of-sale display ban” бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд 2024 оны байдлаар тамхийг ил байршуулж худалдаалахыг бүрэн хориглосон 39 улс, зарим хязгаарлалт тогтоосон 45 улс байна.
		2.Далд худалдаа нь хууль бус, хяналтгүй зах зээлийг дэмжих эрсдэлтэй • Одоо ч дэлгүүрүүд далд байдлаар тамхи зарсаар байгаа бөгөөд энэ нь зөвшөөрөлгүй цэгүүд, татваргүй наймаа, чанарын баталгаагүй бүтээгдэхүүн нэмэгдэх нөхцөл болж байна. • Далд байдал нь баримтгүй, өндөр үнэтэй, хяналтгүй наймааг дэмждэг. • “Далд хэлбэр нь эдийн засгийн зохицуулалт биш, харин далд эдийн засгийг дэмжсэн үйлдэл”.	Хүлээж авах боломжгүй.	
		3.Зохицуулалт хэрэгжихгүй, эсрэг үр дагавартай байх эрсдэлтэй • Хууль ёсоор зөвшөөрөлтэй цэгүүд багасах ч далд худалдаа улам нэмэгдэж, тамхидалтын насжилт улам залуужих эрсдэлтэй.	Хүлээж авах боломжгүй.	Тамхины хяналтыг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгож, хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор хуулийн 5 дугаар зүйлийг өөрчлөн найруулсан. Өөрөөр хэлбэл, тус хууль батлагдсанаар хуулийн хэрэгжилтийн хяналт, хариуцлага сайжрах нөхцөл бүрдэнэ.

	• “Хууль батлах тусам хэрэгжилт муу, бодит байдалд нийцэхгүй”, “хууль бус цэгүүд бүр гаарах нь” гэсэн шүүмжлэл байв.			
	• “Худалдан авагч нь насанд хүрсэн эсэхийг л шалгах байхад хангалттай”. • Ил тод зарах боловч 21 наснаас дээш худалдан авагчийг бүртгэх, шалгах хяналт хэрэгжүүлэх нь зөв.	Хүлээж авах боломжгүй.	Тамхин бүтээгдэхүүнийг дэлгүүр, худалдааны төвийн кассын дэргэд шилэн хоргонд ил байршуулан худалдаалж байгаа нь хүүхэд, залуучууд тамхин бүтээгдэхүүн худалдан авах сэдлийг төрүүлж байдаг. Иймд олон улсад “борлуулалтын цэг дэх ил байршуулалтыг хориглох - point-of-sale display ban” бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд 2024 оны байдлаар тамхийг ил байршуулж худалдаалахыг бүрэн хориглосон 39 улс, зарим хязгаарлалт тогтоосон 45 улс байна.	
	5. Цаад ашиг сонирхлыг хардсан байр суурь илэрхийлжээ. • Зохицуулалт нь тодорхой компани, монополь зах зээлийг хамгаалж байгаа, бусад өрсөлдөгчийг шахах зорилготой байна. • Дэлхийн зарим улс орнуудад тамхины компаниуд ижил зохицуулалтыг “лоббидож” оруулсан гэж дурджээ.	Хүлээж авах боломжгүй.	Тус хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 110 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, түүнд дэмжлэг үзүүлэх төрийн холбогдох байгууллагуудын албан тушаалтнууд хамтран боловсруулсан. Өөрөөр хэлбэл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг УИХ-ын дарга томилсон болно. Түүнчлэн хуулийн төсөлд аль нэг тамхин бүтээгдэхүүнд давуу байдал олгоогүй бөгөөд бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнд адил үйлчлэх зохицуулалтыг тусгасан болно.	
	6. Татварын бодлоготой холбоотой шүүмжлэл • Татварыг нэмэх нь зөв ч, хурц өсөлт, тодорхойгүй зарцуулалт, иргэдийн амьдралд хүндрэл учруулах байдал шүүмжлэл хүлээж байна. • “Татвараа нэмэхээс илүү хэрэгтэй зүйл хий”, “төсвийн зарцуулалтыг ил тод болго” гэх зэрэг санал байв.	Хүлээж авах боломжгүй.	Олон улсын туршлагаас үзэхэд, тамхины хэрэглээг бууруулахад татварын бодлого хамгийн чухал нөлөөтэй нь практикт нотлогдсон бөгөөд дэлхийн улс орнууд татвараа үе шаттай нэмэгдүүлэх замаар тамхины хэрэглээг бууруулах бодлого баримтлан ажиллаж байна. Манай улсын хувьд тамхин бүтээгдэхүүний үнэ бусад орнуудтай харьцуулахад харьцангуй хямд буюу талхнаас хямд үнээр худалдаалагдаж байна.	

			Иймд хуулийн төсөлд тамхины татварыг 2025-2030 хүртэл үе шатай нэмэгдүүлэх замаар татварыг хэмжээг 70 хувьд хүргэх зохицуулалтыг тусгасан.		Иймд хуулийн төсөлд тамхины татварыг 2025-2030 хүртэл үе шатай нэмэгдүүлэх замаар татварыг хэмжээг 70 хувьд хүргэх зохицуулалтыг тусгасан.
		7.Архидан согтууралт, согтууруулах ундааг адилхан зохицуулах хэрэгтэй	Хүлээж авах боломжгүй.		Уг хуулийн төсөл нь Тамхины хяналтын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл юм. Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн үзэл баримтлал хүүхэд, залуучуудын тамхины хэрэглээг бууруулахад чиглэгдсэн болно. Иймд Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль уг хуулийн төсөлд хамааралгүй болно.
		- Зарим иргэд архи, пиво ч мөн адил хор хөнөөлтэй тул дан ганц тамхийг хориглох нь шударга бус гэж үзсэн. “Архи, пивыг ч далд байршуулах уу?”, “нэгэн ижил бодлого хэрэгтэй” гэсэн санал гарсан.			
4.	6.8.5.энэ хуулийн 6.8.4-т заасан жагсаалт нь зөвхөн мэдээлэл өгөх зорилготой байх бөгөөд бүтээгдэхүүнийг брэнд, лого оруулж сурталчлах хэлбэрээр хэрэглэгчид үзүүлэхийг хориглоно. /1 санал, сэтгэгдэл/	Нэр нь өөрөө лого байхаар яаж ч яалгах юм.	Хүлээж авах боломжгүй.		Тамхин бүтээгдэхүүнийг далд байршуулж, зөвхөн 21-ээс дээш насанд хүрсэн хүний хүсэлтээр нэр, үнийн мэдээллийг тусгасан жагсаалт санал болгон түүнээс сонгон худалдан авах зохицуулалтыг тусгасан. Ингэснээр өсвөр үе, залуучуудын анхаарлыг татах, тамхины хэрэглээг өдөөх эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм.
5.	9.1.9.эмнэлэг, сувилал, тэдгээрийн гаднах орчин, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орц, шат, цахилгаан шат, хүүхдийн тоглоомын талбай, гудамж, цэцэрлэгт хүрээлэн, спортын байгууламж. /1 санал, сэтгэгдэл/	Цэгээ сайн байгуулж өгөх хэрэгтэй. Ер нь хэдэн хувийн компани л автобусны буудлуудаар цэг байгуулсан харагддаг	Хуулийн төсөлд тусгасан.		Тамхи татах цэгийн тоог хуулиар зохицуулах боломжгүй. Тус санал нь хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэж байгаа болно.

6. 9.1.1.Тамхи татдаг хүнийг тамхинаас гаргах, хорт никотины хамаарал, хорт зуршлаасаа салах үйл явцыг дэмжих, хөнгөвчлөх зорилготой эмчилгээ, эм бэлдмэл зэргийг багтаасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ. Тусламж үйлчилгээ нь дараах төрөлтэй байна: 9.1.1.1.сэтгэлзүйн эмчилгээ; 9.1.1.2.никотин орлуулах эмчилгээ; 9.1.1.3.эмийн эмчилгээ; 9.1.1.4.тусгай утасны зөвлөгөө, мэдээллийн тусламж үйлчилгээ гэж тусгасан.	1.Тамхинаас гаргах нь зөв боловч дэмжлэг хэрэгтэй • Тамхинаас шууд гарах хүнд, олон хүн донтсон байдаг тул сэтгэл зүйн болон эмчилгээний дэмжлэг шаардлагатай гэж үзэж байна. • “Тамхидуулаад дараа нь эмчилнэ гэж юу гэсэн үг вэ?”, “сэтгэл зүйн эмчилгээ хийлгэхгүйгээр гарахад хүндрэлтэй” гэх мэт санаа гарсан. • Нийгмийн даатгалын хүрээнд тамхинаас гарах эмчилгээ, дэмжлэгийг хамруулах шаардлагатай.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төслийн 9.1 дүгээр зүйл-д Тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээ 9.1.1.Тамхи татдаг хүнийг тамхинаас гаргах, никотины хамаарал, хорт зуршлаасаа салах үйл явцыг дэмжих, хөнгөвчлөх зорилготой эмчилгээ, эм бэлдмэл зэргийг багтаасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ. Тусламж үйлчилгээ нь дараах төрөлтэй байна: /12 санал, сэтгэгдэл/
2.Утаат тамхины хор хөнөөлийг онцолжээ • Утаат тамхинд өртсөн олон хүн дам тамхидалтаар нас барж, эрүүл мэндээр хохирч байгаа тул цаашид хэрэглээг бууруулах нь чухал гэж үзжээ. • Янжуурт буцааж оруулах бус, харин эрсдэл багатай хэрэглээ рүү шилжих бодлого хэрэгтэй гэж үзэж байна.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төслийн зорилго бүх төрлийн тамхины хэрэглээг бууруулахад чиглэсэн тул саналыг агуулгаараа тусгагдсан.	
3.Урьдчилан сэргийлэлт, боловсрол чухал • Өсвөр үеийнхэнд тамхины хор хөнөөлийн тухай мэдлэг олгох хичээл сургуулийн хөтөлбөрт оруулах хэрэгтэй. • Гэм хорыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр таниулах, сургалт семинар	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төслийн 5.2-т Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ: 5.2.1.ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хөтөлбөрт тамхины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтын агуулга боловсруулж, багтаах, дагах ЗГТСТХНӨТХ-ийн 19.3.7-д ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хүүхэд, залуучуудыг тамхинаас урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа гэж тус тус тусгасан.	

	зохион байгуулахыг санал болгожээ.	санал	
	4.Хууль, бодлого нь итгэл төрүүлэхгүй, лобби, мөнгө угаалт гэж хардах хандлага байна. - Зарим иргэн энэ төрлийн бодлого, хууль, хөтөлбөрүүдийг "ковид багц" шиг мөнгө угаалт болчих вий гэж хардаж байна. "Эцэст нь үр дүнгүй, төслүүд замхардаг", "түргэн тусламж шиг л удаан, найдваргүй ирдэг" гэх шүүмжлэл байв.	Хүлээж авах боломжгүй.	Тус хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 110 дугаар захимаржаар байгуулагдсан ажлын хэсэг, түүнд дэмжлэг үзүүлэх төрийн холбогдох байгууллагуудын албан тушаалтнууд хамтран боловсруулсан. Өөрөөр хэлбэл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг УИХ-ын дарга томилсон болно. Түүнчлэн хуулийн төсөлд аль нэг тамхин бүтээгдэхүүнд давуу байдал олгоогүй бөгөөд бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнд адил үйлчлэх зохицуулалтыг тусгасан болно.
	5.Дэмжиж буй байр суурь Тамхинаас гарах, эрсдэл багатай хэрэглээг дэмжих, нийгмийн мэдлэгийг нэмэгдүүлэх санаачилгуудыг зарим иргэд дэмжиж байгаагаа илэрхийлсэн байна.	Дэмжсэн санал.	
7. 9¹.2.Энэ хуулийн 9¹.1-д заасан тусламж үйлчилгээ нь үр нөлөөтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй, холбогдох стандартын шаардлага хангасан байх ба тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан үзүүлнэ. /1 санал, сэтгэгдэл/	Уг нь тэгдэг бол сайн л байна. Гэхдээ эрүүл мэндийн даатгал насаараа төлчихөөд хүссэн үйлчилгээгээ одоог хүртэл авж чадахгүй байна.	Дэмжсэн санал.	Дагах ЭМДТХНӨОТХ-ийн төслийн 1 дүгээр зүйлд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн "9.1.16-д тамхинаас гарах эмчилгээний эм, бүтээгдэхүүн.", 2 дугаар зүйлд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3.1.7-д "хөнгөвчлөх" гэсний дараа "тамхинаас гарах эмчилгээний эм, бүтээгдэхүүн" гэж тус тус нэмэлт оруулсан.
Төслийн 2 дугаар зүйлд тусгасан дараах зүйл, хэсэг, заалттай холбоотой нийт 174 санал ирсэн бөгөөд агуулгаар нь нэгтгэн тусгалаа.			

8.	3.1.1. "тамхин бүтээгдэхүүн" (цаашид "тамхи" гэх) гэж тамхины навч, ургамлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн болон нийлэг аргаар гаргаж авсан никотин, түүний уламжлал дагавар бодис, бохь, химийн бодис агуулсан, амт, үнэр оруулагч нэмсэн, эсхүл нэмээгүй, татах, үнэрлэх, сорох, зажлах, аманд уусгах, биед наах, эсхүл бусад аргаар, дагалдах хэрэгсэл бүхий төхөөрөмжийг ашиглаж болон ашиглахгүйгээр хэрэглэх зориулалттай, хууль тогтоомжид заасны дагуу эмийн бүртгэлд	1.Хуулийн төсөл нэг талыг барьсан, янжуур тамхийг дэмжсэн өнгө аястай байна. - Хуулийн зарим зохицуулалт нь электрон тамхийг зохицуулалтаас гадуур үлдээж, харин утаат янжуур тамхинд илүү таатай орчин бүрдүүлж байгаа мэт ойлгогдож байна. - Татвар, хязгаарлалтын хувьд электрон тамхи өндөр татвартай, янжуур бага татвартай байгаа нь эрүүл бус бүтээгдэхүүнийг дэмжиж буй мэт сэтгэгдэл төрүүлж байна. - Иргэд "энэ хууль уламжлалт утаат тамхийг хамгаалсан хууль болчих вий" гэх болгоомжлол илэрхийлжээ.	Хүлээж авах боломжгүй.	Хуулийн төслөөр "тамхин бүтээгдэхүүн"-ний тодорхойлолтыг өргөтгөн шинэчилж, зөвхөн уламжлалт тамхи бус, орчин үед хэрэглээ нь нэмэгдэж буй электрон, халаадаг болон усан тамхи, никотин агуулсан шингэн, үнэрлэх, сорох, зажлах, биед наах зэргээр хэрэглэх бүх төрлийн бүтээгдэхүүн, тэдгээрийн дагалдах хэрэгслийг хамруулан хуульчилж тусгасан. Ингэснээр шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнийг хууль тогтоомжийн хяналт, зохицуулалтад бүрэн хамруулах, хэрэгжилтийг сайжруулах, өсвөр үеийг эрсдэлт хэрэглээнээс хамгаалах, практик хэрэгцээ шаардлагад нийцсэн чухал зохицуулалт болно гэж үзсэн.
----	--	--	------------------------	---

бүртгэгдсэн тамхинаас гаргах эмээс бусад дараах бүтээгдэхүүнийг хэлнэ: /24 санал, сэтгэгдэл/	2.Тамхины тодорхойлолтыг олон улсын конвенцын дагуу шинэчлэх шаардлагатай - Одоогийн хуульд заасан "тамхины тодорхойлолт" нь ДЭМБ-ын Тамхины эсрэг конвенцын тодорхойлолттой зөрчилдөж байна. - Конвенцын дагуу "тамхин бүтээгдэхүүн" гэдэг нь тамхины навчаар хийсэн, сорох, зажлах, үнэрлэх зориулалттай бүх бүтээгдэхүүнийг хамарсан ойлголт тул электрон тамхи, никотины орлуулалт зэрэг нь тусдаа ангилалд орох шаардлагатай гэж үзжээ.	Хүлээж авах боломжгүй.	Монгол Улсын нэгдэн орсон "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем" /БТКУС/-ийн тухай Олон улсын конвенц (1983), түүний хавсралт "Уялдуулсан системийн жагсаалт"-ын бүлэг 24, 84, 96 (2022 оны хувилбар)-д заасан тайлбар болон ангилалд үндэслэн хуулийн нэр томъёог боловсруулсан болно. Дэлхийн гаалийн байгууллагаас боловсруулсан тус конвенцыг 198 улс нэгдэн орж мөрдөж байгаа бөгөөд олон улсын барааны худалдааны 98 гаруй хувь нь хэрэгжүүлж байна.
	3.Электрон тамхийг тусад нь зохицуулах, шинжлэх ухааны үндэслэлтэй хандах хэрэгтэй. - Электрон тамхи, шиша зэргийг нэг ангилалд хамааруулах нь шинжлэх ухааны үндэслэлгүй, ойлгомжгүй зохицуулалт болох эрсдэлтэй. - Электрон тамхи бол "тамхи" бус, харин өөр төрлийн никотин дамжуулагч төхөөрөмж учраас ялгах ёстой гэж үзжээ. - Электрон тамхийг буруу ангилж, эрсдэл багатай хэрэглээг хориглох нь өргөн хэрэглэгчтэй шинэ бүтээгдэхүүнийг шууд	Хүлээж авах боломжгүй.	

	хавсайдуулах, технологийн дэвшлийг хязгаарлах болно. 4.Хууль санаачлагчдад итгэх итгэл хоёрдмол байна. • Зарим иргэд хуулийн төслийг эрүүл мэндийн бодлогын хүрээнд маш чухал алхам хэмээн дэмжиж буйгаа илэрхийлж байна. • Нөгөө хэсэг нь энэ хууль тодорхой ашиг сонирхолт бүлэглэл, тамхины бизнес эрхлэгчдийн лоббид автсан байж магадгүй хэмээн эргэлзэж, хардсан байр суурьтай байна. • “Хуулиа бүрэн уншаагүй хүмүүсийн comment, худал мэдээлэл их байна”, “электрон тамхи үйлдвэрлэгчдийн гар хөл байж магадгүй” гэх шүүмжлэл байна.		Тус хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 110 дугаар захимаржаар байгуулагдсан ажлын хэсэг, түүнд дэмжлэг үзүүлэх төрийн холбогдох байгууллагуудын албан тушаалтнууд хамтран боловсруулсан. Өөрөөр хэлбэл, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг УИХ-ын дарга томилсон болно. Түүнчлэн хуулийн төсөлд аль нэг тамхин бүтээгдэхүүнд давуу байдал олгоогүй бөгөөд бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнд адил үйлчлэх зохицуулалтыг тусгасан болно.
	5.Хүүхэд, өсвөр үеийг хамгаалах зохицуулалтыг чангатгах санал давамгайлж байна. • Хуулийн төсөлд 21 нас хүрээгүй иргэдэд худалдаалахыг хориглох, зөрчил гаргасан тохиолдолд тусгай зөвшөөрөл хураах, дахин олгохгүй байх гэх мэт хатуу хариуцлага, хяналтыг тусгах санал их байна. • Ялангуяа цахим тамхины хэрэглээ өсвөр насныхан дунд ихэсч байгаа тул илүү нарийвчилсан, үр нөлөөтэй урьдчилан сэргийлэх механизм шаардлагатай гэж үзжээ.	Хуулийн төсөлд зарим саналыг тусгасан.	

		6.Татварын бодлогыг олон улсын жишигт нийцүүлж, тэнцвэртэй хандах шаардлагатай • Иргэд тамхины бүх төрлийн бүтээгдэхүүнд татварыг нэмэхийг дэмжиж байгаа ч, хэт нэг талын татварын өсөлт нь шийдэл биш, шударга бус өрсөлдөөнийг бий болгодог гэж шүүмжилжээ. • Янжуур тамхи хамгийн хямд үнээр зарагддаг нь хэрэглээг улам дэмжиж байгааг татварын бодлогоор зохицуулах санал дэвшүүлсэн.	Хуулийн төсөлд тусгасан.	ДЭМБ-ын загварчлалд үндэслэн тооцсон. (TaXSiM)
		7.Тамхинаас сэргийлэх болон гаргах арга хэмжээ үр дүнтэй, урт хугацааны бодлого байх ёстой. • Бүх төрлийн тамхины хортой байдлыг олон нийтэд ойлгуулах, хичээл болгон оруулах, ухуулга, сурталчилгаа явуулах зэрэг урьдчилан боловсролын бодлого чухал гэдэгт санал нэгдэж байна.	Хуулийн төсөлд тусгасан.	
9.	3.1.1.в.никотин, никотин давс, амт, үнэр оруулагч болон бусад химийн бодис агуулсан, эсхүл агуулаагүй шингэнийг цахилгаан хэрэгслээр ууршуулан татах, эсхүл түүнтэй адилтгах аргаар хэрэглэх зориулалттай электрон тамхи, түүний цэнэглэгч шингэн, эд анги, дагалдах хэрэгслийг, /4 санал, сэтгэгдэл/	Үнэр амтаа бүгдийг нь хориглоод байвал эргээд хэрэглэгчид бүгд хамгийн хор нөлөө ихтэй янжуур тамхиа л хэрэглэнэ шүү дээ. Электрон тамхи хэрэглээд янжуураас татгалзаж чадсан хүмүүс зөндөө байдаг. Тус хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн 3.1.1.в никотин, никотин	Хүлээж авах боломжгүй.	ДЭМБ болон бусад олон улсын судалгаагаар бүх төрлийн тамхин бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй нь тогтоогдсон. Мөн тус хуулийн төсөлд янжуур тамхи болон электрон тамхины амт, үнэрийг хориглосон. Өөрөөр хэлбэл, 21 насанд хүрсэн иргэн аль төрлийн тамхин бүтээгдэхүүн хэрэглэх нь тухайн иргэний сонголт болно.

		давс, амт, үнэр оруулагч болон бусад химийн бодис агуулсан, эсхүл агуулаагүй шингэнийг цахилгаан хэрэгслээр ууршуулан татах, эсхүл түүнтэй адилтгах аргаар хэрэглэх зориулалттай электрон тамхи, түүний цэнэглэгч шингэн, эд анги, дагалдах хэрэгсэл гэсэн заалтыг хасах буюу ЭЛЕКТРОН ТАМХИГҮЙ УЛС ОРОН БОЛОХ.	давс, амт, үнэр оруулагч болон бусад химийн бодис агуулсан, эсхүл агуулаагүй шингэнийг цахилгаан хэрэгслээр ууршуулан татах, эсхүл түүнтэй адилтгах аргаар хэрэглэх зориулалттай электрон тамхи, түүний цэнэглэгч шингэн, эд анги, дагалдах хэрэгсэл гэсэн заалтыг хасах буюу ЭЛЕКТРОН ТАМХИГҮЙ УЛС ОРОН БОЛОХ.	
10.	3.1.11. "тамхи зөвшөөрөгдсөн цэг" гэж энэ хуулийн 3.1.1.д-д зааснаас бусад тамхийг энэ хуулийн 3.1.3-т заасан дам тамхидалт болгохгүйгээр татах зориулалтаар тусгайлан бэлтгэсэн талбай, агааржуулалтын тоног төхөөрөмжөөр тоноглож тусгаарласан ерөөг. /2 санал, сэтгэгдэл/	Дам тамхидалтад өртөхгүй бүтээгдэхүүнийг ялгаж салгах.	Хуулийн төсөлд тусгасан.	
		Тийм газар олон байгуулах хэрэгтэй.	Хуулийн төсөлд тусгасан.	Тамхи татах цэгийн тоог хуулиар зохицуулах боломжгүй. Тус санал нь хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэж байгаа болно.
11.	5 дугаар зүйл. Тамхины хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн "утаат", 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтын, 9 дүгээр зүйлийн 9.1.5, 9.1.6 дахь заалтын "утаат" гэснийг тус тус хүчингүй болсонд тооцсугай. /2 санал, сэтгэгдэл/	Улаанбаатарчууд өвөл нүүрсний хорт утаандаа хорддог нэмээд янжуур тамхиныхаа хорт утаа нь холилдоод л бүүр л заваардаг биздээ. Ёоо тэр үнэр бол ярилтгүй шууд л дотор муухай оргиж толгой өвддөгшдээ.	-	Тамхины хяналтын тухай хуульд зөвхөн "утаат тамхи" гэх тодорхойлолт байсан бөгөөд энэхүү тодорхойлолтод шинэ болон шинээр гарч ирж буй тамхин бүтээгдэхүүн хамаардаггүй байсан. Иймд хуулийн төсөлд тамхин бүтээгдэхүүний тодорхойлолтыг өргөн хүрээнд тодорхойлох зорилгоор "утаат" гэдэг үгийг хассан болно.
		Утаат тамхи бол хүмүүсийн уушгийг хордуулж, хорт хавдрыг нэмэгдүүлж байхад яагаад дэмжсэн төсөл боловсруулсан юм бэ.	Хүлээж авах боломжгүй.	

12.	5.1.1.тамхины хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх талаарх улсын нэгдсэн бодлогыг боловсруулах, Засгийн газраар батлуулах, хэрэгжилтэд хянат тавих; /2 санал, сэтгэгдэл/	Янжуур тамхинаас илүү электрон тамхи нь илүү боловсон хэрэглээ гэж үзэж байна. Тамхи татсан хүний хажуугаар гархад хүртэл ямар ихүүн муухай үнэр байдаг.	-	Бүх төрлийн тамхин бүтээгдэхүүн хүний эрүүл мэндэд хортой бөгөөд хуулийн төслийн зорилго нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилготой болно.
13.	5.2.1.ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хөтөлбөрт тамхины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтын агуулга боловсруулж, багтаах; /1 санал, сэтгэгдэл/	Зарим талаараа энэ нь өөрөө сурталчилгаа болдог сул тал байдаг. Багш найз маань сурагчиддаа ийм сургалт оруулсаны дараа хүүхдүүд сонирхож үзсэн тохиолдол тэр өдрөө гарч байсан. Хор уршигтай гэж тайлбарлахаасаа илүү маркетинг хийчихдэг юм шиг байгаа юм.	-	-
14.	5.2.2.бүх шатны сургууль, сургалтын байгууллагад энэ хуулийн 6.7.14, 9.1.8-д заасан хориглосон заалтын хэрэгжилтийг хянах, зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэх, сургуулийн орчинд бүх төрлийн тамхи хэрэглэхийг хориглох, хэрэгжилтэд хяналт тавих; /3 санал, сэтгэгдэл/	Сургуулийн 500 метрт тамхи худалдаа хийх нь хориотой хэдий ч нууж зарсаар 2015 оноос хойш өнөөдөр хүртэл зарсаар байгааг хэнч үүнийг ярихгүй байгаа бас энэ хуулиар сайжраагүй байна яаж дээрдэж байгаа вэ тэд далд хэлбэрээр зарсаар байх орчинг бүрдүүлж өгч байгаагаас ялгаагүй Сургуулийн бүсэд янжуур тамхи илээр зардаг тэгэхээр хууль хэрэгжихгүй байх шиг ээ. Сургуулийн бүсэд янжуур тамхи зарсаар байгаа шүү.	Хуулийн төсөлд тусгасан.	-
15.	5.4.1.энэ хуулийн 4.1.1-д заасан тамхины татварын талаар баримтлах бодлого болон татвараас бий болсон орлогыг хүн амын эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг тогтвортой санхүүжүүлэх зарчмыг баримтлан, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх:	1. Ил тод байдал, хариуцлагын асуудал - Тамхины татвараар төвлөрсөн орлого яг юунд, хэрхэн зарцуулагдаж байгааг олон нийтэд тодорхой мэдээлэхгүй байна. “Эрүүл мэндийн салбарт зарцуулна” гэсэн боловч бодит тайлан, үр дүн харагддаггүй.	Хуулийн төсөлд тусгасан.	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт боловсруулсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус саналыг тусгасан болно.

/60 санал, сэтгэгдэл/	• Хяналт, үнэлгээний хараат бус тогтолцоо байхгүй тул итгэл төрөхгүй байна.		• Иргэдийн амьдралд үзүүлэх эдийн засгийн дарамт • Иргэдийн орлого багатай үед татвар нэмэх нь шууд дарамт болдог. • Тамхины үнэ нэмэгдсэн ч хэрэглээ буурахгүй, хямд, хууль бус бүтээгдэхүүн рүү шилжих эрсдэлтэй. • Амьдралын өртөг өндөр, бараа бүтээгдэхүүний үнэ өсөх шалтгаан болж байна.	Хүлээж авах боломжгүй.	Тамхины үнэ болон тамхины хэрэглээ урвуу хамааралтай байдаг. Олон улсын туршлагаас үзэхэд, тамхины хэрэглээг бууруулахад татварын бодлого хамгийн чухал нөлөөтэй нь практикт нотлогдсон бөгөөд дэлхийн улс орнууд татвараа үе шаттай нэмэгдүүлэх замаар тамхины хэрэглээг бууруулах бодлого баримтлан ажиглаж байна. Манай улсын хувьд тамхин бүтээгдэхүүний үнэ бусад орнуудтай харьцуулахад харьцангуй хямд буюу талхнаас хямд үнээр худалдаалагдаж байна. Иймд хуулийн төсөлд тамхины татварыг 2025-2030 хүртэл үе шаттай нэмэгдүүлэх замаар татварыг хэмжээг 70-н хувьд хүргэх зохицуулалтыг тусгасан.
	• Тамхины хэрэглээг бууруулах, хүн амын эрүүл мэндийг дэмжих бодлогын үр нөлөө татвараас харагдахгүй байна. • Зорилтот арга хэмжээ, сургалт, сөрөг сурталчилгаа зэрэг бодитой арга хэмжээ орхигдож байна. • Зөвхөн татвар нэмэх замаар асуудал шийдэх оролдлого нь хэт нэг талыг барьсан.	Хүлээж авах боломжгүй.		Одоогоор тамхинаас гаргах эмчилгээний эм, бүтээгдэхүүнийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлдэггүй болно. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт боловсруулсан Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд	
	4. Давхардсан, оновчгүй санхүүжилт • Эрүүл мэндийн салбар аль хэдийн улсын төсөв, даатгалаар санхүүждэг. • Тамхины татвараар дахин хөрөнгө босгох нь давхардал, үр			-	

		ашиггүй зарцуулалт дагуулах эрсдэлтэй. • “Тогтвортой санхүүжилт” нэрийн дор зорилтот бус зарцуулалт хийгдэж болзошгүй.		нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, тамхинаас гаргах эмчилгээний эм, бүтээгдэхүүнийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих боломжийг бүрдүүлж, тамхинаас гаргах үйл явцад иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, улмаар хүн амын эрүүл мэндийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
		5.Хуурамч бүтээгдэхүүн, хууль бус зах зээлийн эрсдэл • Татвар нэмэгдэх тусам хямд, хуурамч тамхи зах зээлд нэмэгдэнэ. • Энэ нь хүний эрүүл мэндэд илүү хор хохирол учруулж болзошгүй. • Иймд татвартай зэрэгцэн хяналт шалгалт, хууль бус зах зээлийн эсрэг арга хэмжээ авах ёстой.	-	Тамхины хяналтыг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгож, хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор хуулийн 5 дугаар зүйлийг өөрчлөн найруулсан. Түүнчлэн Монгол Улсын хэмжээнд хууль бус аливаа худалдаанд хяналт тавих чиг үүргийг төрийн холбогдох байгууллагууд хуульд заасан чиг үүргийн дагуу хэрэгжүүлдэг.
16.	5.4.2.тамхины импорт, экспорт, үйлдвэрлэл, худалдаанд гааль, татварын бодлогыг хэрэгжүүлэх замаар хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх; /50 санал, сэтгэгдэл/	1.Хэт хатуу татварын бодлого нь сөрөг үр дагавартай • Татвар, гааль, хяналт хэтэрхий чангарснаар: • Хууль бус, хямд үнэтэй, хортой бүтээгдэхүүн зах зээлд нэмэгдэнэ. • Импортлогч, үйлдвэрлэгч, жижиг дэлгүүр, ТҮЦ-үүдийн ачаалал, эрсдэл нэмэгдэнэ. • Илүү өндөр үнэ нь хэрэглээг зогсоох бус, хууль бус сувгаар хэрэгжих нөхцөл болдог.	-	
		2.Ил тод байдал, хяналт, үр ашигт эргэлзэж байна • Татварын орлогын зарцуулалт тодорхой бус, тайлагнал, үр дүнгийн үнэлгээ байхгүй.	-	

	• “Хяналт тавина” гэх боловч авлигын эрсдэл өндөр, бодит үр нөлөө харагддаггүй. • Иргэд “төлсөн татвар маань хаашаа орж байна вэ?” гэдгийг мэдэхгүй, итгэхгүй байна.		
• Энгийн иргэдийн орлого хүрэлцэхгүй байхад татвар нэмэгдсэнээр шууд дарамт учирч байна. • Татвар нэмэгдлээ гээд хүмүүс тамхинаасаа гарахгүй, харин илүү хортой, хямд тамхинд шилжинэ. • Үнэ нэмэгдэх тусам хэрэглээ хяналтаас гарах эрсдэлтэй.	3.Татвар нэмэгдсэнээр иргэд хохирно	Хүлээж авах боломжгүй.	Тамхины үнэ болон тамхины хэрэглээ урвуу хамааралтай байдаг. Олон улсын туршлагаас үзэхэд, тамхины хэрэглээг бууруулахад татварын бодлого хамгийн чухал нөлөөтэй нь практикт нотлогдсон бөгөөд дэлхийн улс орнууд татвараа үе шаттай нэмэгдүүлэх замаар тамхины хэрэглээг бууруулах бодлого баримтлан ажиллаж байна. Манай улсын хувьд тамхин бүтээгдэхүүний үнэ бусад орнуудтай харьцуулахад харьцангуй хямд буюу талхнаас хямд үнээр худалдаалагдаж байна. Иймд хуулийн төсөлд тамхины татварыг 2025-2030 хүртэл үе шаттай нэмэгдүүлэх замаар татварыг хэмжээг 70-н хувьд хүргэх зохицуулалтыг тусгасан.
• Татварын орлогыг эрүүл мэндийн боловсрол, сэргийлэх ажилд ил тод, зорилтот байдлаар зарцуулах хэрэгтэй. • Сурталчилгаа, хорт зуршлаас гарахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд хэрэгтэй. • Татвар нэмэх бус хэрэглээг бууруулах шинэлэг, үр дүнтэй бодлого шаардаж байна.	4.Зөвхөн татвар нэмэхээс илүү цогц бодлого шаардлагатай	Хүлээж авах боломжгүй.	Хуулийн төсөлд тамхины хэрэглээг бууруулахад чиглэгдсэн дараах асуулга бүхий зохицуулалтыг тусгасан. Үүнд: - Татварыг үе шаттай нэмэх; - Янжуур болон электрон тамхины амт, үнэрийг хориглох; - ЕБС-ийн сурагчдад зохиулсан урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх; - Тамхинаас гарах эм, эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх; - Засгийн газрын тусгай санд төвлөрсөн тамхины ОАТ-аас төвлөрсөн хөрөнгөөс хүүхэд, залуучуудад зориулсан төсөл, арга хэмжээнд зарцуулах гэх мэт зохицуулалтыг тусгасан. Өөрөөр хэлбэл, тамхины хэрэглээг бууруулах үр дүнтэй, шинэлэг олон зохицуулалтыг тусгасан болно.

17.	5.6.1.харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд тамхины хяналтын хэрэгжилтийг зохион байгуулах; /1 санал, сэтгэгдэл/	Хяналт тавьж чадаагүйг бид бүгд мэднэ. Бүгд далд хэлбэрлүү шилжсэн хууль санаачилж батлаад тэрийг биелүүлдэггүй хуулийн этгээд болон тэрийг мэдсээр байж арга хэмжээ авдаггүй төрийн алба хаагч ямар арга хэмжээ авхуулах вэ?	-	Тамхины хяналтыг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох замаар хуулийн хэрэгжилтийг үр нөлөөтэй болгох зорилгоор хуулийн 5 дугаар зүйлийг өөрчлөн найруулсан. Өөрөөр хэлбэл, тус санал агуулгаараа тусгагдсан болно.	
18.	5.6.3.энэ хуулийн 9.1.1, 9.1.2, 9.1.3, 9.1.4, 9.1.7, 9.1.8, 9.1.9-д заасан хориглосон газраас бусад гадаад орчин дахь нийтийн эдэлбэр газарт байгуулах тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийн байршил, төсвийг шийдвэрлэх; /1 санал, сэтгэгдэл/	Эмнэлгийн орчинд тодорхой тамхины цэг байгуулахыг зөвшөөрөх хэрэгтэй байна. Хориглосноор тамхины цэг байгуулж болдоггүй. Тамхины цэггүй болохоор хүмүүс хаа сайгүй тамхи татаж замбараагүй байдаг гэсэн саналыг өгье.	Хүлээж авах боломжгүй.	Хуулийн үзэл баримтлалтай нийцээгүй тул тус саналыг тусгах боломжгүй.	
19.	5.6.4.тамхи худалдаалах зөвшөөрөл олгох цэгийн тоо байршлыг тогтоохдоо энэ хуульд заасан зарчим, хязгаарлалтыг хангах, тамхи худалдаалах зөвшөөрөлтэй цэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих; /1 санал, сэтгэгдэл/	Нууцаар зөндөө л зарж байгаа.	-	Тамхины хяналтад тавих төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох замаар хуулийн хэрэгжилтийг үр нөлөөтэй болгох зорилгоор хуулийн 5 дугаар зүйлийг өөрчлөн найруулсан. Өөрөөр хэлбэл, тус санал агуулгаараа тусгагдсан болно.	
20.	5.6.5.орон нутгийн хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах.	Орон нутагт хууль илүү үйлчилдэг ш дээ.	-		

21.	/1 санал, сэтгэгдэл/ 6.4.1. зурагт анхааруулга нь тамхины дотор, гадна хайрцаг, сав, баглаа боодол, татах төхөөрөмж, эд анги, дагалдах хэрэгсэл тус бүрийн нүүрэн талын гадаргууны талбайн 70-аас багагүй хувийг эзэлсэн байх;	Зүгээр л мөнгө босгох арга л даа. Хяналт шалгалтаа хийнэ гээд байдаг. Хийсэн юм байгаа юм уу?	-	Тамхины хяналтын суурь конвенцид заасан шаардлагад нийцүүлэн тус заалтыг оруулсан болно. Зурагт анхааруулгыг 70 ба түүнээс дээш хувь хүртэл байхаар зохицуулсан 34 улс байдаг. Тамхины хяналтад тавих төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох замаар хуулийн хэрэгжилтийг үр нөлөөтэй болгох зорилгоор хуулийн 5 дугаар зүйлийг өөрчлөн найруулсан. Өөрөөр хэлбэл, тус санал агуулгаараа тусгагдсан болно.
22.	/4 санал, сэтгэгдэл/ "6.7.2. энэ хуулийн 3.1.1.а, 3.1.1.б-д заасан тамхийг нэг хайрцагт 20 ширхгээс цөөн тоогоор, эсхүл дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг 200 граммаас багаар савлах, энэ хуулийн 3.1.1.в-д заасан электрон тамхины шингэний хэмжээг 2 миллилитрээс, 10 цэнэглэгчийг миллилитрээс ихээр савлах, электрон тамхины шингэн дэх никотины агууламж 20 миллиграмм/миллилитрээс их байх;" /14 санал, сэтгэгдэл/	1. Янжуур тамхинд агуулагдах никотин, хорт бодисын агууламж илүү өндөр • Янжуур тамхинд агуулагдах никотины хэмжээ 13–20 мг, мөн давирхай, бохь зэрэг олон хорт бодис агуулдаг. Энэ нь уушги, умайн хүзүү, хоолойн хорт хавдрын гол шалтгаан болдог. • Янжуур тамхи нь электрон тамхинаас илүү хор хөнөөлтэй байхад зохицуулалт сул байгааг шүүмжилж байна. 2. Электрон тамхи харьцангуй бага никотинтой • Электрон тамхины шингэнд ихэвчлэн 1–5 мг никотин агуулагддаг. • Сонголт ихтэй, илүү хэмнэлттэй, бохь давирхайгүй, зарим талаар илүү "цэвэр" хэрэглээ гэж үздэг. • 1 мл шингэнд 2 мг-аас хэтрэхгүй байх заалт нь үндэслэл муутай, хэт хатуу байна гэж дүгнэжээ.	Хүлээж авах боломжгүй.	Европын Холбооны Тамхины Бүтээгдэхүүний Талаарх Удирдамж (TRP) нь электрон тамхины шингэний савны багтаамжийг 2 мл, цэнэглэгчийн багтаамжийг 10 мл-ээр хязгаарласан. Энэ нь хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангах, никотины хэт хэрэглээг багасгах зорилготой. Зорилго: Никотины хэрэглээг нэг удаадаа хязгаарлах, хордлогын эрсдлийг бууруулах, удаан хугацаагаар тамхи татахыг хязгаарлах. Хүүхдийн аюулгүй байдал: Цэнэглэгч багтаамж бага байх нь хүүхдийн санамсаргүйгээр уух эрсдлийг бууруулдаг. PD 2014/40/EU: Энэхүү хязгаарлалтыг хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангах, никотины тунг илүү сайн хянах зорилгоор тогтоосон.

		3.Хууль тогтоомжийн тэгш бус хандлага буюу янжуур тамхийг дэмжсэн мэт байна. • Хуульд зөвхөн электрон тамхинд хатуу хязгаар тавьж, янжуурын хортой агууламжийг үл хайхрах нь шударга бус. • Энэ нь “янжуур тамхийг дэмжсэн бодлого” мэт ойлгогдож, хэрэглэгчдийн бухимдлыг төрүүлж байна. • Хуулийн санаачлагчдыг тамхины компаниудын нөлөөнд автсан мэт гэж шүүмжилжээ.	Хүлээж авах боломжгүй.	
		4.Шударга, шинжлэх ухаанч бодлого шаардлагатай • Аль ч төрлийн тамхинд хяналт тавихдаа шударга, адил тэгш хандлагатай, үндэслэл сайтай зохицуулалт хэрэгтэй. • Никотины дээд хэмжээг нийтлэг жишгээр тогтоох, хоёр талын хэрэглээг хоёуланг нь судалсан судалгаанд үндэслэх ёстой. • Иргэд шинжлэх ухаанд суурилсан, тэнцвэртэй бодлого хэрэгжүүлэхийг шаардаж байна.	Хуулийн төсөлд тусгасан.	
23.	“9.1.8.цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, хүүхдийн асрамжийн газар, хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх газар,” /4 санал, сэтгэгдэл/	Сургуулийн гаднах орчин, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орц, цахилгаан шат, хүүхдийн тоглоомын талбайг хасдаг нь яаж байгаа юм бэ дам тамхидалтыг улам сэдэрэх юм хийх юм.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8 дахь хэсэгт заасан хориглосон бүсийг хуулийн төслийн 9.1.8, 9.1.9-д дараах байдлаар өргөжүүлэн зохицуулсан болно. Үүнд: 9.1.8.цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, өмнөлөг, сувилал, тэдгээрийн гаднах орчин, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орц, шат, цахилгаан шат, хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн.

			9.1.8.цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, хүүхдийн асрамжийн газар, хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх газар;
			9.1.9.эмнэлэг, сувидал, тэдгээрийн гаднах орчин, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орц, шат, цахилгаан шат, хүүхдийн тоглоомын талбай, гудамж, цэцэрлэгт хүрээлэн, спортын байгууламж.
	Хориг тавих шаардлагатай.	Хуулийн төсөлд тусгасан.	-
	Тамхи тамхин бүтээгдэхүүнийг татах, худалдан борлуулахыг хориглох шаардлагатай.	Хуулийн төсөлд тусгасан.	-
	Сургууль дотор цахилгаан тамхины нэгжлэг тогтмол хийх.	-	Хуулиар зохицуулах харилцаа биш хэдий ч агуулгаараа хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэж байгаа болно.

---000---

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧДООС ГАРСАН САНАЛЫГ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТУСГАСАН ЭСЭХ ТАЛААРХ ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛЭГ

Хуулийн төслийг боловсруулах явцад олон улсын хэлэлцүүлэг, зөвлөгөөн 1 удаа, холбогдох төрийн байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг 2 удаа тус тус зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэг, зөвлөгөөнд нийт 440 гаруй хүн оролцсон болно. Нийт хэлэлцүүлэг, зөвлөгөөнөөс гарсан саналыг агуулгаар нь нэгтгэж, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх дараах лавлагаа, мэдээллийг бэлтгэлээ.

Д/д	Санал	Хуулийн төсөлд тусгасан байдал	Тайлбар
Нэг: "Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал" хэлэлцүүлэг, зөвлөгөөнөөс гарсан санал /2025.01.27, 28-ны өдөрүүдэд Төрийн ордонд зохион байгуулсан бөгөөд олон улсын байгууллага болон төрийн байгууллагын төлөөлөл зэрэг 100 гаруй хүн оролцсон./			
1.	Татварыг нэмэгдүүлэх, олон нийтэд зөрөг нөлөөлөл үзүүлж ажиллах, эрх зүйн хүрээнд дэвшилттэй зохицуулалтуудыг тусгах.	Хуулийн төсөлд тусгасан.	Дагах ОАТТХНӨОТХ-ийн төсөлд татварыг 2030 он хүртэл үе шаттай нэмэгдүүлэхээр тусгасан.
2.	Ногоон байгууламж, спортоор хичээллэх боломж, тоглоомын талбай зэргийг өргөжүүлэх нь энэ зорилттой шууд хамааралтай байгаа гэдгийг хөндөж, онцгой албан татварын орлогыг үүнд зарцуулах.	Хуулийн төсөлд тусгасан.	Дагах ЗПТСТХНӨОТХ-ийн төслийн 19.3.8-д хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг эрүүл, идэвхитэй өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийтийн зориулалттай спортын байгууламж шинээр барих, өргөтгөх, засварлах, аймаг нийслэлээс спортын дугуйлангийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлэх хөтөлбөрийг санхүүжүүлэх гэж тусгасан.
3.	Тамхинд ногдуулж байгаа онцгой албан татварын хэмжээ бусад улс орнуудтай харьцуулахад бага байгаа тул зохих арга хэмжээг хугацаа алдалгүй авах.	Хуулийн төсөлд тусгасан.	Дагах ОАТТХНӨОТХ-ийн төсөлд 2025-2030 хүртэл үе шаттай нэмэгдүүлэх замаар татварыг хэмжээг 70 хувьд хүргэх зохицуулалтыг тусгасан.
4.	Шууд болон дам сурталчилгаанд хяналт тавьж, нийгэмд нөлөө ихтэй хүмүүс, урлагийн бүтээлийг зөргөөр ашиглах.	Хуулийн төсөлд тусгасан.	Тамхины хяналтыг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох замаар хуулийн хэрэгжилтийг үр нөлөөтэй болгох зорилгоор хуулийн 5 дугаар зүйлийг өөрчлөн найруулсан. Өөрөөр хэлбэл, тус санал агуулгаараа тусгагдсан болно.
5.	Тамхины хэрэглээг бууруулахад нэгдүгээрт, татварын бодлого чухал, хоёрдугаарт, хүүхдүүдийн боловсрол чухал бөгөөд сургуулийн өмнөх, бага анги, дунд, том ангийн хүүхдүүдэд зориулсан сургалтыг хөтөлбөр боловсруулах. Мөн тамхины онцгой албан татварын 2 хувь нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад хангалтгүй байх тул энэхүү хувь хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарах.	Хуулийн төсөлд тусгасан.	Дагах ОАТТХНӨОТХ-ийн төсөлд татварыг 2030 он хүртэл үе шаттай нэмэгдүүлэхээр тусгасан. Хуулийн төслийн 5.2-т Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ: 5.2.1. ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хөтөлбөрт тамхины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтын агуулга боловсруулж, багтаах гэж тусгасан.

6.	Электрон тамхийг сургуулийн орчинд хориглож байгаа хэдий ч бусад олон нийтийн орчин, гэр бүлийн орчинд хүүхдүүд электрон тамхийг хэрэглэж байгаа тул нэгдсэн журмаар хориглох	-	Гэр бүлийн орчинд тамхины хэрэглээг хуулиар хориглох боломжгүй болно. Хэдийгээр гэр бүлийн орчинд хориглоогүй ч хуулийн төслийн 5.7.Тамхины хяналтын талаар иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ: 5.7.1.энэ хуулийн хэрэгжилтийг гэр бүл, ажлын байрны орчинд хангах; талаар тусгасан болно.
7.	Тамхины онцгой албан татвараас Эрүүл мэндийг дэмжих санд жилд дундажаар 10 орчим тэрбум төгрөг орж байгаа. Хэрэв энэ хэмжээг нэмбэл нийгмийн эрүүл мэндийг хамгаалах олон зүйл хийх боломжтой байх тул энэ хэмжээг нэмэх.	Хуулийн төсөлд тусгасан.	Дагах ОАТТХНӨОТХ-ийн төсөлд 2025-2030 хүртэл үе шаттай нэмэгдүүлэх замаар татварыг хэмжээг 70 хувьд хүргэх зохицуулалтыг тусгасан.
8.	Нэгдүгээрт, электрон тамхинд онцгой албан татвар ногдуулах, хоёрдугаарт, 21-ээс доош насны хүүхдэд электрон тамхи татахыг хориглох, гуравдугаарт, лабораторуудын хүчин чадлыг сайжруулах, эцэст нь цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Хуулийн төсөлд тусгасан.	Электрон тамхинд онцгой албан татвар ногдуулах зохицуулалтыг дагах хуулийн төсөлд тусгасан. Мөн хуулийн төсөлд электрон тамхийг тамхин бүтээгдэхүүнд тооцсоноор 21-ээс доош насны хүнд тамхи худалдахгүй зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.
9.	Монгол Улсын тамхины үнэ бусад улсуудтай харьцуулахад хэт хямд байх тул тамхины татвар тооцох олон улын 2 төрлийн аргыг судлан үзэж татвараа тогтооход анхаарах.	Хуулийн төсөлд тусгасан.	ДЭМБ-ын загварчлалд үндэслэн тооцсон. (TaXSiM)
10.	Монгол Улсын хувьд нэн тэргүүнд электрон тамхи буюу бусад төрлийн тамхийг тамхины нэгэн адил авч үзэж татвар ногдуулах, дотоод орчинд татуулахгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төсөлд тамхи, тамхин бүтээгдэхүүний тодорхойлолтыг шинэчлэн өргөн хүрээнд тодорхойлж, бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнийг тусгасан болно. 3.1.1."тамхин бүтээгдэхүүн" (цаашид "тамхи" гэх) гэж тамхины навч, ургамлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн болон нийлэг аргаар гаргаж авсан никотин, түүний уламжлал дагавар бодис, бохь, химийн бодис агуулсан, амт, үнэр оруулагч нэмсэн, эсхүл нэмээгүй, татах, үнэрлэх, сорох, зажлах, аманд уусгах, биед наах, эсхүл бусад аргаар, дагалдах хэрэгсэл бүхий төхөөрөмжийг ашиглаж болон ашиглахгүйгээр хэрэглэх зориулалттай, хууль тогтоомжид заасны дагуу эмийн бүртгэлд бүртгэгдсэн тамхинаас гаргах эмээс бусад дараах бүтээгдэхүүнийг хэлнэ-
11.	Монгол Улс Тамхины хяналтын суурь конвенцын MPower зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажилласан бөгөөд эдгээр зөвлөмжүүдээс татварын хувь хэмжээг нэмэх асуудал л өдийг хүртэл шийдэгдэхгүй байгааг анхаарах.	Хуулийн төсөлд тусгасан.	Дагах ОАТТХНӨОТХ-ийн төсөлд 2025-2030 хүртэл үе шаттай нэмэгдүүлэх замаар татварыг хэмжээг 70 хувьд хүргэх зохицуулалтыг тусгасан.
12.	Тамхины татварын бодлогыг авч хэрэгжүүлэхийн тулд хамгийн гол нь хэрэглээг	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төслийн үзэл баримтлал нь тамхины хэрэглээг бууруулах зорилготой болно.

	бууруулах гэдэг зорилттойгоо уялдуулж зохицуулах.		
13.	Монгол Улсад мөрдөгдөж буй одоогийн татварын суурь тарифыг хамгийн багадаа 7-8 дахин нэмэгдүүлж байж олон улсын зөвлөмж буюу татварын хэмжээг 70 хувьд хүргэх.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төсөлд тамхины татварыг 2025-2030 хүртэл үе шаттай нэмэгдүүлэх замаар татварыг хэмжээг 70-н хувьд хүргэх зохицуулалтыг тусгасан.
14.	Улсын хилээр нэвтэрч байгаа тамхи, тамхин бүтээгдэхүүн дээр асуудал гардаг бөгөөд учир нь тамхи болон түүнтэй адилтгах хэрэгсэл, бүтээгдэхүүний нэр томьёоны тодорхойлолт хуулиар тодорхой заагдаагүй байдаг тул энэ тал дээр ажиллах.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төсөлд тамхи, тамхин бүтээгдэхүүний тодорхойлолтыг шинэчлэн өргөн хүрээнд тодорхойлж, бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнийг тусгасан болно. 3.1.1. "тамхин бүтээгдэхүүн" (цаашид "тамхи" гэх) гэж тамхины навч, ургамлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн түүхий эд болгон үйлдвэрлэсэн болон нийлэг аргаар гаргаж авсан никотин, түүний уламжлал дагаар бодис, бохь, химийн бодис агуулсан, амт, үнэр оруулагч нэмсэн, эсхүл нэмээгүй, татах, үнэрлэх, сорох, заглах, аманд уусгах, биед наах, эсхүл бусад аргаар, дагалдах хэрэгсэл бүхий төхөөрөмжийг ашиглаж болон ашиглахгүйгээр хэрэглэх зориулалттай, хууль тогтоомжид заасны дагуу эмийн бүртгэлд бүртгэгдсэн тамхинаас гаргах эмээс бусад дараах бүтээгдэхүүнийг хэлнэ
15.	Электрон тамхинаас гадна электрон тамхитай ижил төстэй бүтээгдэхүүн ихээр орж ирж байгаа бөгөөд зөвхөн никотины агууламжийг үндэслэн татвар ногдуулах нь өрөөсгөл асуудал тул үүнийг хуулийн төсөл боловсруулахдаа анхаарах.	Хуулийн төсөлд тусгасан.	
Хоёр. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгээс гарсан санал /2025.05.05-ны өдөр зохион байгуулсан бөгөөд ЭМЯ, НЭМГ, НЭМҮТ, СЭМҮТ, ЭХЭМҮТ, ХСҮТ, ХӨСҮТ, АШУҮИС-ийн удирдлага, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд зэрэг 100 гаруй хүн оролцсон./			
16.	Онцгой бүсэд тамхи худалдаалахыг хязгаарлах, олон нийтэд ил тод борлуулахыг багасгах.	Хуулийн төсөлд тусгасан.	Тамхин бүтээгдэхүүнийг ил байршуулж худалдаалахыг хориглосон зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Хуулийн төслийн 6.8.3-д тамхийг худалдахдаа далд байршуулж, хэрэглэгч бүтээгдэхүүнийг сурталчилгааны шинж чанар агуулаагүй жагсаалтаас сонгон худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх гэж тусгасан.
17.	Тамхины үнийг өсгөж, хэрэглээг хязгаарлах бодлого хэрэгжүүлэх.	Хуулийн төсөлд тусгасан.	Дагах ОАТТХНӨОТХ-ийн төсөлд 2025-2030 хүртэл үе шаттай нэмэгдүүлэх замаар татварыг хэмжээг 70 хувьд хүргэх зохицуулалтыг тусгасан.
18.	Хүүхдийг насанд хүрэхийг хүлээлгүйгээр, ямар ч хэлбэрийн тамхи (электрон болон уламжлалт)-ны худалдаа, хэрэглээг бүрэн хориглох.	-	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.7-д "21 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулах"-ыг хориглох зохицуулалттай.
19.	Бүх эмнэлэг дотор болон гадаах орчинд тамхины хэрэглээг бүрэн хориглох.	Хуулийн төсөлд тусгасан.	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Тамхины хяналтын тухай хуулийн 9.1.8-д заасны дагуу эмнэлгийн гадаад, дотоод орчинд тамхи татахыг хориглодог.
20.	Тамхины хэрэглээ, борлуулалтыг төрийн байгууллагуудын дотор болон гадаах орчны бүсэд хориглох.	-	Төрийн байгууллагуудын дотоод орчинд тамхи татахыг хязгаарлах, хориглох зохицуулалтыг дотоод журмаараа зохицуулдаг.
21.	Тамхины татварыг үе шаттай нэмэхээр төлөвлөж байгаа нь хэрэглэгчдийн авах чадварт шууд нөлөөлөхгүй гэж үзэж болох ч татварын	Хуулийн төсөлд тусгасан.	Дагах ОАТТХНӨОТХ-ийн төсөлд 2025-2030 хүртэл үе шаттай нэмэгдүүлэх замаар татварыг хэмжээг 70 хувьд хүргэх зохицуулалтыг тусгасан.

	хэмжээг илүү олцом, өндөрөөр нэмэгдүүлэхийг санал болгож байна.		
22.	Электрон тамхины бүх төрлийн үнэр, амт оруулагч бодисыг бүрэн хориглох шаардлагатай.	Хуулийн төсөлд тусгасан.	6.7.16.энэ хуулийн 3.1.1.а, 3.1.1.б, 3.1.1.в-д заасан бүх төрлийн тамхи, цэнэглэх шингэнд үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байхыг хориглосон.
23.	Электрон тамхины хэрэглээг олон нийтийн дотоод орчинд (байгууллага, сургууль, эмнэлэг зэрэг) бүрэн хориглох хэрэгтэй.	Хуулийн төсөлд тусгасан.	Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй ТХТХ-ийн 9.1.6-д аж ахуйн нэгж, байгууллагын угаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгээс бусад ажлын байрын дотоод орчин-д тамхи татахыг хориглосон байдаг.
24.	Бүх төрлийн тамхинд ижил татвар тогтоохын оронд никотины агууламжаас хамааруулан татварын хэмжээг ялгавартай тогтоох санал байна.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төсөлд Гаалийн албан татварын хувь хэмжээг адил тогтоож8 харин ОАТ-ын хувь, хэмжээг тамхин бүтээгдэхүүний төрлөөс шалтгаалан ялгаатай тогтоосон болно.
25.	Хэрэв тамхины үйлдвэрлэлд технологи сайжирч, савлагаа өөрчлөгдөх тохиолдолд татварын шинэ нөхцөл байдалд уялдуулан өөрчлөлт оруулах боломжтой байх.	-	-
26.	Амт, үнэртэй бүтээгдэхүүнд онцгой албан татвар ногдуулах.	-	Хуулийн төсөлд тамхин бүтээгдэхүүний амт, үнэрийг бүрэн хориглосон болно.
27.	УИХ-ын гишүүн О.Номинчимэг тууштай, шийдвэртэй байр суурьтай байж, хуулийн шинэчлэлийг амжилттай батлуулаасай гэж хүсэж байна. Эрүүл мэндийн салбарын бид бүхэн дэмжих болно.	Дэмжсэн санал	-
28.	Эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, шаардлагатай нөөцийг хангах.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төслийн 5.2-т Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ: 5.2.1.ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хөтөлбөрт тамхины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтын агуулга боловсруулж, багтаах, дагах ЗГТСТХНӨОТХ-ийн 19.3.7-д ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хүүхэд, залуучуудыг тамхинаас урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа гэж тус тус тусгасан.
29.	Эрүүл мэндийн боловсролыг анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээний салшгүй хэсэг болгон хуульчлах.	-	Хуулийн төсөл нь нэмэлт, өөрчлөлтийн төсөл бөгөөд хэрэв тухай хуулийн 50-иас дээш хувийг хөндвөл шинэчилсэн найруулгын төсөл болж өргөжихөөр байгаа тул тус саналыг тусгаагүй болно.
30.	Дотоодын болон импортын тамхинд ногдуулах татварын хэмжээний ялгааг арилгаж, ижил татварын бодлого хэрэгжүүлэх.	Хуулийн төсөлд тусгасан.	Дагах УИХ-ын "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолын төсөлд татварын хэмжээг ижил байхаар тусгасан.
31.	Тамхинаас гаргах бүх бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, тухайлбал, тамхины	Хуулийн төсөлд тусгасан.	Дагах ЭМДТХНӨОТХ-ийн төсөлд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын "хөнгөвчлөх" гэсний

	наалт, бохь болон бусад эмийн хангамжийг нэмэгдүүлэх шаардлага маш их байна.		дараа " , тамхинаас гаргах эмчилгээний эм, бүтээгдэхүүн" гэж нэмж тусгасан.
32.	Тамхины донтолтыг багасгах, хүмүүсийг тамхинаас гаргах эмчилгээний хөтөлбөрүүдийг өргөжүүлэх, хөнгөлөлттэй эмийн жагсаалтад оруулах нь чухал.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төслийн 91.3-т Энэ хуулийн 91.1-т заасан тусламж үйлчилгээг төрөөс дэмжих, бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх бөгөөд тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сан болон хөнгөлөлттэй эмийн жагсаалтад хамруулах замаар санхүүжүүлнэ. Үүнтэй холбогдсон харилцааг холбогдох хуулиар нарийвчлан зохицуулна гэж тусгасан.
33.	Сургуулийн орчинд хуулийн хэрэгжилтийг сайжруулж, иргэдийн эрх, үүргийн талаар илүү ойлгомжтой болгох.	Хуулийн төсөлд тусгасан.	Тамхины хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төр, иргэн, хуулийн этгээдийн хүлээх нийтлэг үүргийг өргөжүүлэн, тодорхой томъёолсон болно. Өөрөөр хэлбэл, тус санал агуулгаараа тусгагдсан болно.
34.	Тамхи татах цэгийн байрлалыг илүү нарийвчлалтай, агааржуулалттай байх шаардлагыг хуулиар тогтоох.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төслийн 3.1.11-т "тамхи татах зөвшөөрөгдсөн цэг" гэж энэ хуулийн 3.1.1-д зааснаас бусад тамхийг энэ хуулийн 3.1.3-т заасан дам тамхидалт бий болгохгүйгээр татах зориулалтаар тусгайлан бэлтгэсэн талбай, агааржуулалтын тоног төхөөрөмжөөр тоноглож тусгаарласан өрөөг гэж тодорхойлсон.
35.	Хичээлийн хөтөлбөрт тамхины хортой нөлөө, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг үр дагаварыг тогтмол сурталчлах, сургалтын үйл ажиллагаанд энэ асуудлыг оруулах.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төслийн 5.2-т Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ: 5.2.1.ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хөтөлбөрт тамхины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтын агуулга боловсруулж, багтаах гэж тусгасан.
36.	Электрон тамхийг бүхэлд нь хориглох, мөн энэ талаар сургалт, мэдээлэл олгох.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төсөлд электрон тамхийг бүрэн хориглох зохицуулалтыг тусгаагүй хэдий ч электрон тамхинд ОАТ ногдуулах, амт, үнэрийг хориглох зэрэг зохицуулалтыг тусгасан болно.
37.	Торгуулийн хэмжээ өндөр байх нь асуудал үүсгэж болзошгүй. Торгуулийн хэмжээг зохистой түвшинд тогтоож, зөрчил гаргасан этгээдэд тохирох шийтгэл ногдуулах.	Хуулийн төсөлд тусгасан.	Датах ЗТХНӨОТХ-ийн төслийн 2 дугаар зүйлд тусгасан.
38.	Тамхи нь хавдрын эрсдлийг нэмэгдүүлдэг нь олон удаа батлагдсан зүйл. Тиймээс тамхинаас гарах боломжийг нэмэгдүүлэх нь чухал. Гэхдээ тамхи татах сэдлийг нэмэгдүүлдэг хамгийн гол хүчин зүйл нь тамхины цэгүүд байдаг. Тамхины цэгүүд нь хүмүүсийг тамхи татахад түлхэц болдог бөгөөд түүнийг бууруулах, бүр хуулиар хаах шаардлагатай гэж үзэж байна.	-	Тамхи татах цэгүүдийг бүрэн хориглох нь өнөөгийн нөхцөл байдалд тохиромжгүй зохицуулалт тул хуулийн төсөлд тусгаагүй болно.
39.	Татварыг нэмэх нь асуудлыг шийдвэрлэх хамгийн үр өгөөжтэй арга тул үе шаттайгаар, нилээд нэмж байгааг дэмжиж байна.	Дэмжсэн санал	-

Гурав. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгээс гарсан санал /2025.05.14-ний өдөр зохион байгуулсан бөгөөд ЕБС-ийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, багш зэрэг 240 гаруй хүн оролцсон./			
40.	Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.14-т заасан "ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдах;" заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах.	Хуулийн төсөлд тусгасан.	Тамхины хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төр, иргэн, хуулийн этгээдийн хүлээх нийтлэг үүргийг өргөжүүлэн, тодорхой томъёолсон болно. Өөрөөр хэлбэл, тус санал агуулгаараа тусгагдсан болно.
41.	Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.7-д заасан "21 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулах;" заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах.	Хуулийн төсөлд тусгасан.	Тамхины хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төр, иргэн, хуулийн этгээдийн хүлээх нийтлэг үүргийг өргөжүүлэн, тодорхой томъёолсон болно. Өөрөөр хэлбэл, тус санал агуулгаараа тусгагдсан болно.
42.	Электрон тамхины амт, үнэрийг бүрэн хориглох.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төслийн 6.7.16-д энэ хуулийн 3.1.1.а, 3.1.1.б, 3.1.1.в-д заасан бүх төрлийн тамхи, цэнэглэх шингэнд үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байхыг хориглосон.
43.	Тамхины хэрэглээний талаарх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төслийн 5.2-т Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ: 5.2.1.ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хөтөлбөрт тамхины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтын агуулга боловсруулж, багтаах гэж тусгасан.
44.	Тамхин бүтээгдэхүүнийг лангууны хажууд ил байршуулахыг хориглох.	Хуулийн төсөлд тусгасан.	Тамхин бүтээгдэхүүнийг ил байршуулж худалдаалахыг хориглосон зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Хуулийн төслийн 6.8.3-д тамхийг худалдахдаа далд байршуулж, хэрэглэгч бүтээгдэхүүнийг сурталчилгааны шинж чанар агуулаагүй жагсаалтаас сонгон худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх гэж тусгасан.
45.	Тамхин бүтээгдэхүүний зар сурталчилгааг бүрэн хориглох.	-	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Тамхины хяналтын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан байдаг.
46.	Хүүхэд, залуучуудын тамхины хэрэглээг бууруулахад тэдний сэтгэл зүйн асуудал хөндөгддөг учраас сэтгэлзүйн боловсрол олгоход анхаарах.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төслийн 5.2-т Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ: 5.2.1.ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хөтөлбөрт тамхины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтын агуулга боловсруулж, багтаах гэж тусгасан.
47.	Тамхины хэрэглээг гэр бүлийн орчинд урьдчилсан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх.	-	-
48.	Сургуулийн орчинд тамхи татсан хүүхдэд хариуцлага тооцох боломжгүй байдаг тул хүүхдэд хариуцлага тооцох боломжтой болгох.	-	Тус санал нь Тамхины хяналтын тухай хуулиар зохицуулах боломжгүй харилцаа болно.
49.	Тамхины хэрэглээг бууруулахын тулд хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа идэвхтэй өнгөрүүлэх орчинг бүрдүүлэх.	Хуулийн төсөлд тусгасан.	Дагах ЗПГСТХНӨОТХ-ийн төслийн 19.3.8-д хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг эрүүл, идэвхитэй өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийтийн зориулалттай спортын байгууламж шинээр барих, өргөтгөх, засварлах, аймаг нийслэлээс спортын дугуйлангийн

				хүртэмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлэх хөтөлбөрийг санхүүжүүлэх гэж тусгасан.
50.	Сургуулийн орчинд хатуу хориг тавих талаар нарийвчилсан журам оруулах, тэмдэг тэмдэглэгээ чухал байна. Үүнийг хуульчилж өгөх.	-		Тус харилцааг журмаар зохицуулах боломжтой.
51.	Тамхины татвараар сан бүрдүүлж, урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах.	Хуулийн төсөлд тусгасан.		Дагах ТГТСТХНӨОТХ-ийн төслийн 19.3.7-д ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хүүхэд, залуучуудыг тамхинаас урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа гэж тусгасан.
52.	Зөрчлийн торгууль, хариуцлагыг чангатгах, давтан гаргасан тохиолдолд зөвшөөрлийг хүчингүй болгох.	Хуулийн төсөлд тусгасан.		Хуулийн төсөлтэй хамт боловсруулсан Зөрчлийн тухай хуулийн төсөлд торгуулийн хэмжээг нэмж тусгасан болно.
53.	Олон нийтийн ТВ, бусад олон нийтийн сувгийг ашиглаж иргэдийг соён гэгээрүүлэх.	-		Тус саналыг хуулиар зохицуулах шаардлагагүй болно.
54.	Электрон тамхи нь шингэн агуулах сав, баттерей хэсгээс бүрддэг бөгөөд баттерей ямар хортойг бид мэдэж байгаа. Тиймээс салангид байх уу, нэг байх уу гэдгийг хуулиндаа тусгаж өгөх.	Хуулийн төсөлд тусгасан.		Хуулийн төслийн 3.1.1.6-д цахилгаан халаагч болон бусад арга, хэрэгслээр асаахгүйгээр сорж татах зориулалттай бүх төрлийн халаадаг тамхи болон түүний хэрэгсэл, тэдгээрийн эд анги, дагалдах хэрэгслийг гэж тусгасан.
55.	Хүүхдийн донтолын цаад шалтгаан нь эцэг эх, гэр бүл байдаг. Иймд хуулийн төслийг насанд хүрэгчид рүү илүү чиглэх нь зүйтэй болов уу.	Хуулийн төсөлд тусгасан.		-
56.	Олон нийтийн газар, албан байгууллагад тамхи татах цэгийн стандарт гэдгийг тогтоож өгмөөр байна.	Хуулийн төсөлд тусгасан.		Хуулийн төслийн 3.1.11-т "тамхи татах зөвшөөрөгдсөн цэг" гэж энэ хуулийн 3.1.1-д-д зааснаас бусад тамхийг энэ хуулийн 3.1.3-т заасан дам тамхидалт бий болгохгүйгээр татах зориулалтаар тусгайлан бэлтгэсэн талбай, агааржуулалтын тоног төхөөрөмжөөр тоноглож тусгаарласан өрөөг гэж тодорхойлсон.
57.	Хуулийн хэрэгжилтийг анхаарч, байгууллага хоорондын уялдаа холбоог анхаарах шаардлагатай.	Хуулийн төсөлд тусгасан.		Хуулийн төслийн 5 дугаар зүйл-д Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар салбар хоорондын хамтын ажиллагаа, төр, иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоог илүү тодорхой тусгасан.
58.	Электрон тамхийг хуулиар бүрэн хориглох.	Хүлээж авах боломжгүй.		Электрон тамхийг бүрэн хориглох нь янжуур болон бусад тамхин бүтээгдэхүүнд давуу байдал үүсгэх эрсдэлтэй тул тус саналыг тусгаагүй болно.
59.	Хуулийн хэрэгжилтийн хяналт, хариуцлагыг сайжруулах.	Хуулийн төсөлд тусгасан.		Тамхины хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төр, иргэн, хуулийн этгээдийн хүлээх нийтлэг үүргийг өргөжүүлэн, тодорхой томъёолсон болно. Өөрөөр хэлбэл, тус санал агуулгаараа тусгагдсан болно.
60.	Бүх төрлийн тамхины татварыг нэмэгдүүлэх.	Хуулийн төсөлд тусгасан.		Дагах ОАТТХНӨОТХ-ийн төсөлд 2025-2030 хүртэл үе шаттай нэмэгдүүлэх замаар татварыг хэмжээг 70 хувьд хүргэх зохицуулалтыг тусгасан.

			Дагах УИХ-ын "Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолын төсөлд татварын хэмжээг ижил байхаар тусгасан.
61.	Тамхины хор нөлөөний талаар сургалтын хөтөлбөрт тусгах асуудлыг хуульчлах.	Хуулийн төсөлд тусгасан.	Хуулийн төслийн 5.2-т Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ: 5.2.1.ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн хөтөлбөрт тамхины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтын агуулга боловсруулж, багтаах гэж тусгасан.
62.	Тамхины хэрэглээтэй холбоотой сурагч, эцэг эхийн үүрэг, хариуцлагыг хуульчлах.	Хуулийн төсөлд тусгасан.	Тамхины хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төр, иргэн, хуулийн этгээдийн хүлээх нийтлэг үүргийг өргөжүүлэн, тодорхой томъёолсон болно. Өөрөөр хэлбэл, сурагч, эцэг, эх нь иргэн гэх тодорхойлолтод хамаарах тул тус санал агуулгаараа тусгагдсан болно.
63.	Хуулийн төслийг бүхэлд нь дэмжсэн.	Дэмжсэн санал	-

—оОо—

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД АЛБАН БИЧГЭЭР ИРҮҮЛСЭН
САНАЛЫГ ТУСГАСАН ЭСЭХ ТАЛААРХ ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ**

Хуулийн төсөл боловсруулах явцад нийт 15 байгууллагаас ирсэн саналыг нэгтгэж, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх дараах лавлагаа, мэдээллийг бэлтгэлээ.

Д/д	Санал	Хуулийн төсөлд тусгасан байдал	Тайлбар
Нэг.Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын 2025.02.14-ний өдрийн 02/156 дугаар албан бичгээр ирүүлсэн санал			
1.	6.4. Тамхи нь эрүүл мэндийн хор нөлөөний тухай анхааруулгатай байх бөгөөд анхааруулга нь дараахь шаардлагыг хангасан байна: 6.4.1. зурагт анхааруулга нь бүх төрлийн тамхин бүтээгдэхүүн, электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийн хайрцаг, сав, баглаа боодлын нүүрэн талын болон ар талын гадаргуугийн талбайн 70-аас багагүй хувийг эзэлсэн байх. 6.4.2. бичигт анхааруулга нь том хэмжээтэй, тод харагдахуйц, гаргацтай байна. 6.4.1. заалт нь энэхүү хуулийн 6.5.1 болон 6.5.2 дахь заалтад тусгасан шаардлагуудыг хэрэгжүүлсний дараа хүчин төгөлдөр болно. 6.5. Эрүүл мэндийн хор нөлөөний тухай анхааруулгын загваруудыг эрх бүхий төрийн байгууллага батална. 6.5.1. Тамхины эрүүл мэндийн хор нөлөөний тухай зурагт болон бичигт анхааруулгыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн төв байгууллага батална. 6.5.2. Тамхин бүтээгдэхүүний эрүүл мэндэд учруулах хор нөлөөний зурагт болон бичигт анхааруулгыг байрлуулах техникийн шаардлагыг стандартчлал, техникийн	Хуулийн төсөлд тусгасан байдал Хуулийн төсөлд тусгасан.	1. Хуулийн төсөлд зурагт анхааруулгын хэмжээг 70 хувьд хүргэх дараах зохицуулалтыг тусгасан. <u>6.4.1. зурагт анхааруулга нь тамхины дотор, гадна хайрцаг, сав, баглаа боодол, татах төхөөрөмж, эд анги, дагалдах хэрэгсэл тус бүрийн нүүрэн талын гадаргууны талбайн 70-аас багагүй хувийг эзэлсэн байх;</u>
2.	6.5. Эрүүл мэндийн хор нөлөөний тухай анхааруулгын загваруудыг эрх бүхий төрийн байгууллага батална. 6.5.1. Тамхины эрүүл мэндийн хор нөлөөний тухай зурагт болон бичигт анхааруулгыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн төв байгууллага батална. 6.5.2. Тамхин бүтээгдэхүүний эрүүл мэндэд учруулах хор нөлөөний зурагт болон бичигт анхааруулгыг байрлуулах техникийн шаардлагыг стандартчлал, техникийн	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т "Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэх, худалдах, импортлох, экспортлох тамхинд агуулагдах бохь, никотин, бусад хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгт тавих стандартыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Стандартчиллын Үндэсний зөвлөл батална." гэж заасан. Өөрөөр хэлбэл, тамхины эрүүл мэндийн хор нөлөөний тухай зурагт болон бичигт анхааруулгад тавих шаардлагыг стандартчилан Стандартчиллын Үндэсний зөвлөлөөс баталж байгаа болно.

	зохицуулалт хариуцсан төрийн байгууллага батална.		
Хоёр.Цагдаагийн ерөнхий газрын 2025.02.24-ний өдрийн 01/279 дугаар албан бичгээр ирүүлсэн санал			
3.	Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын "үйлдвэрлэсэн" гэсний дараа “, эсхүл электрон тамхи, түүний дагалдах хэрэгсэл,” гэж мөн заалтад тайлбар хэсгийг доор дурдсан агуулгатайгаар тус тус нэмэх; “Тайлбар: “Электрон тамхи” гэж шингэнийг халааж, азрозоль үүсгэдэг электрон төхөөрөмжийг ойлгоно.”	Хуулийн төсөлд тусгасан	Хуулийн төсөлд "тамхин бүтээгдэхүүн"-ний тодорхойлолтыг өргөтгөн шинэчилж, зөвхөн уламжлалт тамхи бус, орчин үед хэрэглээ нь нэмэгдэж буй электрон, халаадаг болон усан тамхи, никотин агуулсан шингэн, үнэрлэх, сорох, захлах, биед наах зэргээр хэрэглэх бүх төрлийн бүтээгдэхүүн, тэдгээрийн дагалдах хэрэгслийг хамруулан хуульчилж тусгасан. Ингэснээр шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнийг хууль тогтоомжийн хяналт, зохицуулалтад бүрэн хамруулах, хэрэгжилтийг сайжруулах, өсвөр үеийг эрсдэлт хэрэглээнээс хамгаалах, практик хэрэгцээ шаардлагад нийцсэн чухал зохицуулалт болно гэж үзсэн.
4.	Хуулийн мөн зүйлийн 3.1.2 дахь заалтын “дүнсэн” гэсний дараа “, электрон тамхи” гэж нэмэх.	Хуулийн төсөлд тусгасан	
Гурав.Алтангадас ХХК-аас цахим шуудангаар ирүүлсэн санал			
5.	Санал болгож буй нэмэлт,өөрчлөлтийн төслийн эдийн засаг, нийгэм болон хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг нарийн судалж, нотлох баримтад суурилсан, шударга хуулийн зохицуулалт боловсруулах;	Хуулийн төсөлд тусгасан	Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх бүрэлдэхүүнд Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахад оролцдог төрийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан ажиллаж байна. Мөн олон улсын болон дотоодын эрдэмтэн, судлаачдын судлагаа, тайлан, зөвлөмжийг тухай бүр судалсны үндсэн дээр хуулийн төслийг боловсруулсан болно. Түүнчлэн хуулийн төсөлтэй холбогдуулан Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэсэн.
6.	Бүх сонирхогч талуудын, тухайлбал салбарын төлөөлөл, нийтийн эрүүл мэндийн мэргэжилтэн, жижиглэнгийн худалдаачид болон хэрэглэгчдийн саналыг цуглуулж, тэдгээрийг харгалзан үзэж, тэнцвэртэй, хүртээмжтэй хуулийн зохицуулалт боловсруулах;	Хуулийн төсөлд тусгасан	Хуулийн төсөл боловсруулах хүрээнд олон улсын 1, дотоодын буюу Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахад оролцдог төрийн байгууллагуудын төлөөллийг оролцуулсан 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийн хуулийн төсөлдөө тусган ажиллаж байна. Түүнчлэн 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн байдлаар нийт иргэд, олон нийтээс ирүүлсэн 488 санал, мөн тамхины худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж, холбогдох төрийн бус байгууллагуудаас нийт 14 албан бичгээр санал ирүүлсэн бөгөөд эдгээр саналыг судлан үзэж, шаардлагатай зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан болно.

7.	Тамхины салбар дахь бизнесийн оролцогчидтой нээлттэй яриа хэлэлцээ, хамтын ажиллагааны замаар урт хугацааны, тогтвортой зохицуулалтын төлөвлөгөөг баталж, ил тод байдал, харилцан ойлголцлыг дэмжин ажиллахыг хүсье.	Хамтран ажиллах санал	Тус саналыг холбогдох төрийн байгууллагад уламжлах болно.
Дөрөв.Буучхуу ХХК-ийн 2025.5.27-ны өдрийн ПА 17/05 албан бичгээр ирүүлсэн санал			
8.	Үнэр, амт оруулагчийг нэг мөр ангилахад төвөгтэй байдаг. Мөн үнэр, амт оруулагчийг бүтээгдэхүүний орц уу, эсхүл бүтээгдэхүүнийг тодорхойлогч амт (characterizing flavour) уу гэдгийг ялгаж салгах хэрэгтэй.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Үнэр, амт оруулагч бодис нь найрлага боловч, хэрэв тод мэдэгдэхүйц амт үүсгэвэл тухайн бүтээгдэхүүн “characterizing flavour” гэж зохицуулалтын тусгай ангилалд оруулдаг. • Найрлага = техникийн ангилал; бүх үнэр, амт оруулагч энд орно. • Тодорхойлогч амт = хууль эрхзүйн/зохицуулалтын ангилал; зөвхөн тодорхой, мэдэгдэхүйц амт/үнэр бий болгосон тохиолдолд хэрэглэнэ. Бодлогод үзүүлэх ач холбогдол • Электрон тамхинд агуулагдах бүх үнэр, амт оруулагч бодисыг найрлага болгон бүртгэх ёстой. • Хэрэв эдгээр бодис нь тодорхойлогч амтыг бий болговол, зохицуулагч байгууллагууд илүү хатуу хориг, хязгаарлалт тавьж болно (жишээ нь: ментол, жимс, чихэр гэх мэт). Электрон тамхины шингэн (“e-liquid”, “vape juice”) нь дараах үндсэн найрлагатай: • Никотин (заавал биш) • Уусгагч бодис (пропилен гликол, ургамлын глицерин) • Үнэр, амт оруулагч бодисууд (хүнсний зориулалтын амт оруулагч химийн нэгдлүүд) Найрлага гэж үзэх нь: • Бүтээгдэхүүнд зориуд нэмсэн бүх бодисыг найрлага гэж тодорхойлдог.

			• АНУ-ын Хүнс, Эмийн Захиргаа (FDA) бүх үнэр, амт оруулагчийг электрон тамхины найрлагад заавал бүртгэхийг шаарддаг / U.S. Food and Drug Administration (FDA). <i>Premarket Tobacco Product Applications and Ingredient Reporting Requirements</i>. 2020/. • Европын Холбооны Тамхины Бүтээгдэхүүний удирдамж (2014/40/EU)-д “найрлага” гэдгийг <i>тамхины бүтээгдэхүүн</i> эсвэл <i>түүнтэй холбоотой бүтээгдэхүүнд орсон аливаа бодис, бүрэлдэхүүн хэсэг, үүнд үнэр, амт оруулагч орно</i> гэж тодорхойлсон байдаг /European Union. <i>Directive 2014/40/EU of the European Parliament and of the Council</i>. Official Journal of the European Union, 2014/.
			Тодорхойлогч амт (Characterizing flavour) гэж үзэх нь: • Тодорхойлогч амт гэдэг нь <i>тамхины өөрийнхөөс бусад тод мэдээгдэхүйц үнэр эсвэл амтныг хэлдэг</i> (жишээ нь: ментол, жимс, чихэр, ваниль) /European Union. <i>Directive 2014/40/EU of the European Parliament and of the Council</i>. Official Journal of the European Union, 2014/. • ДЭМБ-ын Тамхины Хяналтын Суурь Конвенц (FCTC) нь залуусын сонирхлыг нэмэгдүүлдэг тул тодорхойлогч амтыг хориглохыг зөвлөдөг /World Health Organization (WHO). <i>WHO Report on the Global Tobacco Epidemic: Addressing New and Emerging Products</i>. Geneva: WHO, 2021/
9.	Бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнд бүх төрлийн үнэр, амт оруулагч нэмэхийг хориглоно гэдэг бол гадаадаас тамхи хууль бусаар, тэр дундаа хуурамч тамхи бөөн бөөнөөрөө орж ирэхэд шууд хүргэнэ. Хууль бус үйлдвэрлэгчид техникийн нормыг мөрдөхгүй, хортой орлуулагч бодис ашигладаг. Энэ нь хэрэглэгчийн эрүүл мэндэд учрах эрсдэлийг эрс нэмэгдүүлнэ.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Тус хуулийн төслийн үзэл баримтлал нь хүүхэд, залуучуудын тамхины хэрэглээг бууруулж, нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдэж байгаа тул хуулийн төслийн гол зохицуулалтуудын нэг нь гаанаас бусад тамхины амт, үнэрийг хориглох зохицуулалт юм. 1.Дэлхийн улс орнууд хүүхэд, залуучуудын дундах электрон тамхины хэрэглээг хязгаарлах зорилгоор электрон тамхийг бүрэн хориглох, эсхүл түүний амт, үнэрийг хязгаарлах бодлогыг хэрэгжүүлж байна.

10.	Тамхин бүтээгдэхүүнд үнэр, амт оруулахыг хориглож байгаа санаа нь зөв боловч техникийн талаас ч, хууль зүйн талаас ч хэцүү саадтай учирна. Иймд дараах арга хэмжээг авбал илүү тохиромжтой. Үүнд: 1.Бүтээгдэхүүний амт оруулагч нэмэлтүүдийг ангилах яв цав шалгуур боловсруулж, хоёрдмол утгаар тайлбарлах боломжгүй болгох. 2.Тамхин бүтээгдэхүүнийг насанд хүрээгүй хүмүүс хэрэглэхээс сэргийлж, жишээ нь, сав, баглаа боодол дээр чихэр, амттан, хүүхэлдэйн киноны дүрс, зураг ашиглахыг хориглох, амтын тайлбарыг сурталчлах зорилгоор бус бодитоор бичих, тухайн бүтээгдэхүүн хуульд нийцсэн эсэхийг гэрчилгээгээр баталгаажуулах, хуульд харшилсан бүтээгдэхүүнийг зах зээлд гарсны дараа хуульд албадан нийцүүлэх зэргээр хяналтыг чангатгах.	2024 оны байдлаар 30 гаруй улс электрон тамхийг бүрэн болон худалдах, импортлохыг хориглосон бол 20 улс амт, үнэрийг хориглосон. Бүрэн хориглосон: https://cloud.parliament.mn/index.php/s/5HyjAk8Wwmypsp2 Амт, үнэр хориглосон: https://cloud.parliament.mn/index.php/s/xmEpKEMp8i8MqJN 2.Электрон тамхи нь эрүүл мэндэд олон сөрөг нөлөө үзүүлж байгаа нь судалгаагаар нотлогдож байгаа бөгөөд сүүлийн үеийн судалгаанаас дурдвал. Уушги ба амьсгалын тогтолцооны нөлөө - European Respiratory Society-ийн судалгаагаар электрон тамхи нь уушгины эсийн гэмтэл, ДНХ-ийн эвдрэл, үрэвсэл үүсгэж, амьсгалын замын өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг болохыг тогтоожээ. Эх сурвалж: https://publications.ersnet.org/content/eri/57/1/1901815?utm - Manchester Metropolitan University-ийн судалгаагаар 20-иод насны залуусын дунд хийсэн туршилтаар электрон тамхи татдаг хүмүүсийн уушгины багтаамж, дасгалын гүйцэтгэл нь тамхи татдаг хүмүүстэй ижил түвшинд буурсан байжээ. Эх сурвалж: https://www.theguardian.com/society/article/2024/sep/08/vaping-damages-young-peoples-lungs-as-much-as-smoking-study-suggests?utm Зүрх судасны тогтолцооны нөлөө: - Судасны үйл ажиллагааны доройтол: 2024 оны судалгаагаар электрон тамхи нь судасны үйл ажиллагаанд шууд сөрөг
-----	--	--

		нөлөө үзүүлдэг бөгөөд никотингүй вэйп ч гэсэн судасны цусны урсгалыг бууруулж, хүчилтөрөгчийн хангалтыг багасгадаг болохыг тогтоожээ. Эх сурвалж: https://edition.cnn.com/2024/11/25/health/vaping-vascular-health-oxygen-levels/index.html?utm • Америкийн Физиологийн Нийгэмлэгийн судалгаагаар хулганад 16-60 долоо хоногийн турш электрон тамхины утаанд өртөхөд судасны агшилт нэмэгдэж, судасны тэлэлтийн чадвар буурч, системийн даралт ихсэх, зүрхний булчингийн томрол зэрэг өөрчлөлтүүд илэрсэн байна. Никотины агууламж өндөр байх тусам эдгээр сөрөг нөлөөлөл илүү хүчтэй илэрч байжээ. Эх сурвалж: https://journals.physiology.org/doi/prev/20210219-aop/abs/10.1152/ajpheart.00997.2020?utm Генетик ба эсийн түвшний нөлөө • European Respiratory Society-ийн судалгаагаар электрон тамхи нь ДНХ-ийн гэмтэл, эсийн үхэл, дархлааны генийг дарангуйлж, уушгины эсийн үйл ажиллагааг алдагдуулдаг болохыг тогтоожээ. Эх сурвалж: https://publications.ersnet.org/content/eri/57/1/1901815?utm Химийн найрлага ба хорт бодисууд • Хорт бодисуудын үүсэл: Ирландын Хааны Мэс заслын Коллежийн судалгаагаар электрон тамхины амт оруулагч бодисуудыг халаах үед 127 төрлийн “хурц хордлоготой”, 153 “эрүүл мэндэд аюултай”, 225 “цочроогч” химийн нэгдлүүд үүсдэг болохыг тогтоожээ.
--	--	---

			Эх сурвалж: https://www.rcsi.com/impact/details/2024/05/flavoured-vapes-may-produce-many-harmful-chemicals-when-e-liquids-are-heated-new-research?utm
11.	Хуулийн төслийн 5.1.4-т "импортлох тамхины хэмжээ, нэр төрлийн талаар энэ хуульд заасан тамхины хэрэглээг бууруулах зарчимтай уялдуулан нэгдсэн бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих," гэх заалт нь чөлөөт зах зээлийн зарчмыг үгүйсгэж, Эрүүл мэндийн яаманд УИХ-аас давсан эрх мэдэл олгож байна. Ямар шалгуураар импортлох тамхины хэмжээ, төрлийг тогтоох вэ? Энэ заалт энэ хэвээр батлагдлаа гэж бодвол ЭМЯ бага хэмжээний квот тогтооход тэр нь дороо дүүрчихнэ. Тэгэхээр гадаадын зах зээлээс хуурамч тамхин бүтээгдэхүүн бөөнөөрөө орж ирнэ гэсэн үг Хуурамч бүтээгдэхүүн хүн амын эрүүл мэндэд жинхэнэ бүтээгдэхүүнээс илүү их хор хохирол учруулна. Түүнчлэн квот тогтоох тухай энэхүү заалт Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн XI:1 зүйлийг /Тоо, хэмжээний хязгаарлалтыг арилгах тухай/ зөрчих бөгөөд мөн хэлэлцээрийн XX зүйлд заасан эрүүл мэндийн үндэслэлээр амлалт, үүргээс чөлөөлөгдөх тохиолдолд хамаарагүй юм.	Хуулийн төсөлд тусгасан	Хуулийн төслийн холбогдох заалтад найруулгын засвар оруулж хууль тогтоомжид нийцүүлсэн болно.
12.	Хуулийн төслийн 5.7.3-т "тамхи үйлдвэрлэгч, импортлогчоос бүх төрлийн хандив, тусламж, тэтгэлэг хүлээж авахаас татгалзах," гэж тусгажээ. Хэнээс хандив, тусламж авч болохыг иргэндээ тулган хүлээлгэнэ гэдэг бол Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн байж болшгүй заалт. Ийм хориглолт төрийн албан хаагчдад бол болно. Угаасаа ч хуульчилсан байгаа.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж Тамхины хяналтын тухай хуулийн 5.2.3- т "тамхи үйлдвэрлэгчээс төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг хүлээж авахаас татгалзах." гэж заасан байдаг. Харин хуулийн төсөлд Тамхины хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулсан бөгөөд зарим заалтыг хэвээр үлдээсэн өөрөөр хэлбэл, тус заалт нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй заалт болно.
13.	Хуулийн төслийн 6.4.1-т "зурагт анхааруулга нь тамхины дотор, гадна хайрцаг, сав, баглаа боодол, татах төхөөрөмж, эд анги, дагалдах хэрэгсэл тус бүрийн нүүрэн талын гадаргууны талбайн 70-аас	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг ТХСК, түүний Сав баглаа боодол, шошгожуулалтын удирдамж болон олон улсын туршлага, жишигт нийцүүлэн "зурагт анхааруулга нь тамхины дотор, гадна хайрцаг, сав, баглаа боодол, татах төхөөрөмж, эд

	багагүй хувийг эзэлсэн байх,” гэж тусгажээ. Европын тамхин бүтээгдэхүүний захирамж /DIRECTIVE 2014/40/EU/-д зааснаар утаат тамхин бүтээгдэхүүний сав баглаа боодлын нүүрэн болон ар талын 65%-д “Тамхи татах нь Таны амь насыг хөнөөнө” гэсэн бичвэр бүхий эрүүл мэндийн анхааруулга тавихыг шаарддаг /уг захирамжийн 9 дүгээр зүйл/. Харин утаагүй бүтээгдэхүүний хувьд нэгж хайрцаг болон гаднах савалгаан дээр түүний 30%-ийг эзэлсэн дараах бичвэр байхыг шаарддаг. “Энэхүү тамхин бүтээгдэхүүн нь Таны эрүүл мэндэд хортой бөгөөд донтуулах үйлчилгээтэй /уг захирамжийн 12/1/ дугаар зүйл./ Иймд ЕХ-ны жишээг дагаж, утаагүй бүтээгдэхүүний гаднах савалгаан дээр “Энэхүү тамхин бүтээгдэхүүн нь Таны эрүүл мэндэд хортой бөгөөд донтуулах үйлчилгээтэй.” гэсэн бичвэр нэгж хайрцаг болон гаднах савалгааны гадаргуугийн 30%-ийг хамарсан байна гэж хуульд тусгуулах саналтай байна.	анги, дагалдах хэрэгсэл тус бүрийн нүүрэн талын гадаргууны талбайн 70-аас багагүй хувийг эзэлсэн байх” гэж өөрчилсөн. Энэхүү зохицуулалт нь бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнд хамаарах бөгөөд дэлхийн улс орнууд зурагт анхааруулгын хэмжээг 90 хувь хүртэл хуульчлан тогтоосон байдаг. Зурагт анхааруулгыг 70 ба түүнээс дээш хувь хүртэл байхаар зохицуулсан 34 улс байна. Зурагт анхааруулгын хэмжээг хуулиар зохицуулсан улс орнууд: https://cloud.parliament.mn/index.php/s/G9Qzbnc3EAj8Q4t WHO FCTC Article 11 болон түүний Guidelines нь сав, шошго дээр фотографик/пиктограмм health warnings-ийг санал болгож, хэмжээ (олон улсын зөвлөмж: 50%–80% PPA буюу гол дүрсийн талбай), rotation (өөрчлөх), хэлний шаардлага, мөн сурталчилгааг хориглох заалтыг онцолсон. Mongolia одоогоор саванд front+back 65% pictorial warning шаарддаг. (WHO FCTC, Tobacco Control Laws) Зурагт анхааруулгын үндсэн зорилго нь хэрэглэгчдэд эрүүл мэндийн эрсдэлийг мэдээлэх, бүтээгдэхүүнд сонирхох сонирхлыг бууруулах, ялангуяа өсвөр насныхны хэрэглээг бууруулах ач холбогдолтой. Электрон тамхинд зурагт анхааруулга шаардлагатай талаар нотолгоо: 1. Зөвхөн текстэн анхааруулга (жишээ нь: “Никотин донтуулдаг”) нь эрүүл мэндийн эрсдэлийг мэдээлэхдээ зурагт анхааруулгаас сул нөлөөтэй байдаг ба электрон тамхины хорт бодисын талаарх зурагт анхааруулгыг харсан залуучууд эрсдэлийг илүү өндөр гэж ойлгосон бөгөөд зөвхөн текстэн анхааруулга харсан хүмүүсээс илүү электрон тамхи хэрэглэх хүсэл бага байсан үр дүн гарсан. Hammond D. <i>Warnings on e-cigarettes: are they effective?</i> Tobacco Control, 2019. 2. Уушги, зүрхний өвчний зурагтай анхааруулга харсан өсвөр насныхан электрон тамхийг илүү хор хөнөөлтэй, нийгмийн
--	---	--

			хувьд бага хүлээн зөвшөөрөгдсөн гэж үнэлсэн. Зурагт анхааруулга нь сониуч зан болон хэрэглэх сонирхлыг бууруулсан Noar SM, et al. <i>Pictorial warnings and e-cigarette risk perceptions among youth</i>. Nicotine & Tobacco Research, 2020 3. Никотины донтолт болон тархинд үзүүлэх нөлөөг харуулсан зурагт анхааруулга нь залуучуудад электрон тамхи нь никотины хамааралд хүргэж болзошгүйг илүү сайн ойлгуулсан. Зурагт анхааруулга харсан оролцогчид электрон тамхи нь "тамхинаас илүү аюулгүй хувилбар биш" гэдэгтэй илүү санал нийлсэн Wittenberg E, et al. <i>E-cigarette warnings and perceptions of addiction</i>. Health Communication, 2020. 4. Электрон тамхины утаанд агуулагдах формальдегид болон бусад хорт бодисын талаарх зурагт анхааруулга нь зөвхөн нэрийг дурдсан текстээс илүүтэй эрсдэлийн ойлголтыг нэмэгдүүлсэн. ays D, et al. <i>Toxicant exposure messaging for e-cigarettes</i>. Tobacco Regulatory Science, 2015. 5. Электрон тамхи хэрэглэгчдийг хорт бодис, маш нарийн ширхэгт тоосонцорт өртүүлдэг бөгөөд энэ нь уушги болон зүрх судасны өвчин үүсгэх эрсдэлтэйг баталсан. Эрсдэлийг мэдэлэхэд зурагт анхааруулгыг хэрэглэхийг зөвлөсөн National Academies of Sciences, Engineering, and Medicine. <i>Public Health Consequences of E-Cigarettes</i>. Washington, DC: NASEM, 2018. 6. Тамхины бүх төрлийн бүтээгдэхүүн дээр зурагт анхааруулга нь текстэн анхааруулгаас давуу нөлөөтэй байсныг харуулсан. Noar SM, et al. <i>Pictorial cigarette pack warnings: a meta-analysis of experimental studies</i>. Tobacco Control, 2016. Үүнд: - Анхаарал татах ба эргэн санах чадварыг нэмэгдүүлсэн, - Эрүүл мэндийн эрсдэлийн талаарх мэдлэгийг бэхжүүлсэн, - Татгалзах эрмэлзлийг нэмэгдүүлсэн - Бүтээгдэхүүний сонирхлыг бууруулсан.
14.	Хуулийн төслийн 9.1.8-д "цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, хүүхдийн	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Тус хуулийн төслийн үзэл баримтлал нь хүүхэд, залуучуудын тамхины хэрэглээг бууруулж, нийгмийн эрүүл мэндийг

	асрамжийн газар, хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх газар,” гэж тусгажээ.	Одоо мөрдөж байгаа Тамхины хяналтын тухай хуулиар ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдахыг хориглосон. Энэ бол уг хуулийн хамгийн тааруу хэрэгжсэн заалт. Албан бус судалгаагаар 2023 онд Улаанбаатар хотод тамхи худалдаалах зөвшөөрөлтэй цэг 1341 байхад 500 метрийн зайтай байх хуулийн заалтыг зөрчиж тамхи нууцаар зардаг 1019 цэг байна гэж гарсан. Хууль бус худалдааны цэгийн тоо нийт 2360 цэгийн 43%-ийг эзэлж байна.	хамгаалахад чиглэгдэж байгаа тул тус заалтыг хөндөх нь ухарсан алхам болно гэж үзсэн.
	Чухамдаа 500 метрийн зай тогтоосноос болж ТҮЦ-үүд олширсон билээ.Энэ хэрэгждэггүй заалтыг бүр өргөтгөн, цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, хүүхдийн асрамжийн газар, хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх газрыг нэмж, нөхцөл байдлыг улам дордуулж байна. Хүүхэд асрах газрууд одоо нийтийн орон сууцны барилга болгонд бий болсон. Үүнтэй холбогдуулан 500 метр гэсэн заалтыг 250 метр болгож бууруулах нь зүйтэй гэсэн саналтай байна. Оронд нь энэ Хуулийн төсөлд заасны дагуу тамхин бүтээгдэхүүнийг хүүхдэд үзүүлэхгүй байхын тулд ил байршуулахыг хориглох нь зөв.		Түүнчлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтыг хэрэгжихгүй байгаа гэх шалтгаанаар хүчингүй болгох нь нэг талаар хууль дээдлэх зарчмыг үгүйсгэж, цаашид буруу жишиг тогтох нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзсэн.
	Мөн насанд хүрээгүй хүмүүс рүү чиглэсэн сав, баглаа боодол, сурталчилгааны материал (жишээ нь, барааны тэмдэг эсвэл чихэр, амттан, хүүхэлдэйн киноны дүрс) ашиглахыг хориглох саналтай байна.		Иймд ажлын хэсгээс хуулийн хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн арга хэмжээг авах нь илүү оновчтой шийдэл гэж үзсэн болно.
15.	Хуулийн төслийн 3.1.1.б-д "цахилгаан халаагч болон бусад арга, хэрэгслээр асаахгүйгээр сорж татах зориулалттай бүх төрлийн халаадаг тамхи болон түүний хэрэгсэл, тэдгээрийн эд анги, дагалдах хэрэгслийг," гэсэн заалтаар янжуураас тусад нь буюу	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Тамхины хяналтын тухай хуулийн үйлчлэлд бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнийг хамруулах зорилгоор тамхин бүтээгдэхүүний тодорхойлолтыг өргөн хүрээнд тодорхойлсон бөгөөд энэ нь аль нэг тамхи нь хор багатай, ихтэй гэх ойлголттой хамааралгүй болно.

	“цахилгаан халаагч болон бусад арга, хэрэгслээр асаахгүйгээр сорж татах зохиулалттай бүх төрлийн халаадаг тамхи” хэмээн тодорхойлсон байна. Тэгэхээр бүтээгдэхүүний шинж чанар, зориулалт, тамхины агуулагдах хэмжээ нь янжуураас өөр юм бол онцгой албан татварын хувь хэмжээ нь ч өөр байх учиртай.		Өөрөөр хэлбэл, бүх төрлийн тамхин бүтээгдэхүүн хүний эрүүл мэндэд хортой учраас аль нэг тамхин бүтээгдэхүүнд давуу байдал олгохгүй байх зарчмыг баримтлан ОАТ-ын хэмжээг ижил хэмжээнд тогтоосон болно.
16.	Иймд дэлхийд зонхилж буй туршлагыг харгалзан халаадаг тамхинд онцгой албан татвар ногдуулахдаа түүний нийтийн эрүүл мэндэд учруулах эрсдэлтэй дүйцүүлэн хувь хэмжээг тогтоох, өөрөөр хэлбэл, янжуураас бага хувь хэмжээ тогтоохыг хичээнгүйлэн хүсч байна.	-	Тус саналыг үндэслэлтэй эсэхийг тодруулахаар холбогдох төрийн байгууллагад албан бичиг хүргүүлсэн бөгөөд одоогоор хариу ирүүлээгүй байна.
Тав.Улаанбаатар хотын тамхины бөөний худалдаа эрхлэгчдээс 2025.5.26-ны өдөр ирүүлсэн санал			
17.	Иймд хэрэв Монгол Улс үүрэг авсан гаалийн татварын хувь, хэмжээнээс давсан татвар ногдуулах юм бол ДХБ-ын бусад гишүүн улсын зүгээс гомдол гаргах эрсдэл бий болно.	Хуулийн төсөлд тусгасан	Ажлын хэсэг иргэд, байгууллагаас ирсэн саналыг үндэслэн Тамхины хяналтын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгахаар ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, шилжилтийн үеийн зохицуулалтыг тус хуулийн төсөлд тусгана.
	Тамхин бүтээгдэхүүнд амт оруулахыг хориглосон ч хэрэглэгчдийн дур сонирхол шууд өөрчлөгдөхгүй учир, тэдний хэрэгцээг хангах зорилгоор Хятад болон ОХУ зэрэг улсаас хууль бусаар амт оруулсан тамхи нэвтрэх эрсдэл маш өндөр байна. Ийнхүү хууль бус бүтээгдэхүүн түгээмэл болбол бид амт оруулсан тамхи сонирхдог үйлчлүүлэгчдээ алдаж, улмаар орлого багасах эрсдэлтэй байна.		Түүнчлэн тамхин бүтээгдэхүүний амт, үнэрийг хоригтосноор хууль бус бүтээгдэхүүн худалдаалах эрсдэл үүсэхээс сэргийлж

	Бөөний худалдаачдын хувьд амт оруулсан тамхи гол бүтээгдэхүүнд тооцогддог тул уг төрлийн тамхийг хориглох нь бидэн шиг жижиг аж ахуйн нэгжүүд зах зээлийн өрсөлдөөнөөс шахагдаж гарах, шударга бус байдалд өртөх магадлалтай байна.		Монгол Улсад үйлдвэрлэсэн болон импортлосон, чөлөөт бүс, татваргүй барааны дэлгүүрт оруулсан бүх төрлийн тамхин бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, борлуулалтын үе шат бүрээр эцсийн хэрэглэгч хүртэл олон улсын стандартад нийцсэн дахин даутагдашгүй, цахим өгөгдөл бүхий код ашиглан цахим төлбөрийн баримт, гаалийн мэдүүлэгт үндэслэн татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх зохицуулалтыг тусгасан.
18.	Бидэнд байгаа амт оруулсан тамхины нөөц Монгол Улсад хууль ёсоор худалдаалагдах боломжгүй болж, устгалд орох магадлалтай. Харамсалтай нь энэ талаар хамгаалах заалт, шилжилтийн буюу хөнгөлөлтийн хугацаа хуулийн төсөлд тусгагдаагүй байна. Үүний үр дүнд бид хууль ёсоор үйл ажиллагаа явуулж байсан хэдий ч үлэмж хэмжээний хохирол амсах эрсдэлтэй гэж харж байна.		Тус зохицуулалтыг тусгаснаар тухайн тамхин бүтээгдэхүүн хаана үйлдвэрлэгдээд хаанаас ирээд хаана борлуулагдаж байгааг хянах боломжтой болох бөгөөд өөрөөр хэлбэл, хууль бус бүтээгдэхүүний худалдаанд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.
19.	Тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлэх талаар хуулийн төсөлд тусгасан нь бас нэгэн ноцтой эрсдэлийг дагуулахаар байна. Бүтээгдэхүүний үнэ нэмэгдвэл хэрэглэгчдийн сонголт хямд үнэтэй, хууль бусаар оруулж ирсэн гарал үүсэл тодорхойгүй тамхи руу чиглэх болно. Одоог хүртэл тамхины хууль ёсны үнийг харьцангуй тогтвортой барьж ирсний хүчинд хууль бус тамхины зах зээлээс ангид байж чадсан. Гэтэл энэхүү хуулийн төсөлд заасанчлан татварыг огцом нэмэгдүүлбэл, хууль бус далд борлуулалт нэмэгдэж бидний орлого огцом буурах аюултай байна.		Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд дээрх зохицуулалт байдаг бөгөөд тус зохицуулалтын хүрээнд бүх төрлийн согтууруулах ундаанд хяналт тавьж ажиллаж байгаа тул тамхин бүтээгдэхүүнд мөн адил хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байгаа болно.
Зургаа.Монголын хижиглэн худалдаа эрхлэгчийн холбоо ТББ-аас 2025.01.28-ны өдөр ирүүлсэн санал			
20.	Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, олон гажуудал сөрөг үр дагаврыг бий болгож байгаа ялангуяа 6.7.14.ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдахыг хориглосон заалт нь бодит амьдрал дээр хэрэгжихгүй авлигыг өөгшүүлэх, эсрэгээрээ тамхины борлуулалтыг дэмжсэн /далд хэлбэрээр тамхи худалдаалах нь нэмэгдсэн/, янз бүрийн тамхийг орлуулах бүтээгдэхүүний хэрэглээг дэмжсэн /электрон тамхи гэх мэт/, татварын орчинд сөргөөр нөлөөлөх гажуудлыг бий болгож байгааг худалдаа эрхлэгчид олон баримтаар нотолж, энэхүү заалтад өөрчлөлт оруулах шаардлагыг хүчтэй	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Тус хуулийн төслийн үзэл баримтлал нь хүүхэд, залуучуудын тамхины хэрэглээг бууруулж, нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдэж байгаа тул тус заалтыг хөндөх нь ухарсан алхам болно гэж үзсэн. Түүнчлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтыг хэрэгжихгүй байгаа гэх шалтгаанаар хүчингүй болгох нь нэг талаар хууль дээдлэх зарчмыг үгүйсгэж, цаашид буруу жишиг тогтох нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзсэн. Иймд ажлын хэсгээс хуулийн хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн арга хэмжээг авах нь илүү оновчтой шийдэл гэж үзсэн болно.

	илэрхийлсээр ирлээ.		
	Энэ хүрээнд зарим улс орны тамхины хуулийн туршлагаас ч нилээдгүй судалж үзсэн бөгөөд тухайлбал Япон, Нидерланд, Солонгос, Орос болон бусад улс орны тамхины хуулинд ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн байгууллагаас 500 метрийн зайн хэмжээг /зарим улс оронд хамгийн ихдээ 200 метрийн хязгаарлалт л байна/ зааж хориглосон бус тогтоож хуульчилсан улс байхгүй байгааг ажлын хэсэг онцгой анхаарч худалдаа эрхлэгч бидэндэнхүү заалттай холбоотой үндэслэлтэй тайлбарыг албан ёсоор өгөхийг ажлын хэсгээс хүсэж байна.		
21.	"Хууль тогтоомжийн тухай хууль"-ийн 8.1.5. эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах; 8.1.6.хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах гэсэн зүйл заалтуудыг үндэслэн Тамхины хяналтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн ажлын хэсгээс зохион байгуулж байгаа аливаа хэлэлцүүлэг, уулзалтад тус холбооны болон худалдаа эрхлэгчдийн төлөөллийг оролцуулах, хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд оруулах санал, санаачлагыг дэмжин хамтран ажиллахыг хүсье.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Хуулийн төсөл боловсруулах хүрээнд олон улсын 1, дотоодын буюу Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахад оролцдог төрийн байгууллагуудын төлөөллийг оролцуулсан 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийн хуулийн төсөлдөө тусган ажиллаж байна. Түүнчлэн 2025 оны 09 дүгээр сард тамхи үйлдвэрлэгч, импортлогч компанийн төлөөлөл болон холбогдох төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөж байна.
Долоо.Монголын жижиглэн худалдаа эрхлэгчийн холбоо ТББ-аас 2025.5.26-ны өдөр ирүүлсэн санал			
22.	Хэрэв тамхины онцгой албан татварыг огцом нэмэгдүүлбэл, манай дэлгүүрээс тамхи худалдан авах хүн эрс багасах болно. Тамхи худалдан авдаг үйлчлүүлэгчид ихэвчлэн бусад бараа бүтээгдэхүүн ч мөн хамтад нь авдаг тул тамхины борлуулалт буурахын зэрэгцээ дэлгүүрийн нийт орлого ч дагаад багасна. Бодит байдал дээр тамхины үнэ өссөн ч бидний ашиг нэмэгдэхгүй, эсэргээрээ хохирол амсах магадлалтай байна.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Улс орон бүр нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор өөрийн улсын онцлогт тохирсон хууль тогтоомжийг баталдаг. Монгол Улс ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцид нэгдэн орсон бөгөөд олон улсын өмнө хүлээсэн үүрэг байдаг. Монгол Улс 2020 оноос хойш тамхин бүтээгдэхүүний онцгой албан татварын хувь хэмжээг нэмээгүй бөгөөд ДЭМБ-аас хийсэн судалгаагаар Монгол Улсын дотоодын зах зээлд жижиглэн худалдаалж буй тамхин бүтээгдэхүүний борлуулалтын үнийн дүнд эзлэх татварын хувь хэмжээ 25-35 орчим хувь байгаа нь

			хөгжиж буй улсуудын түвшнээс доогуур байгаа бөгөөд ДЭМБ-аас энэ харьцааг 75 хувьд хүргэхийг зөвлөдөг. Иймд ажлын хэсэг тамхин бүтээгдэхүүний онцгой албан татварыг үе шаттай нэмэгдүүлэхээр хуулийн төсөлд тусгасан болно. Өөрөөр хэлбэл, онцгой албан татварыг огцом нэмэхгүй бөгөөд 2026-2030 он хүртэл үе шаттай нэмэгдүүлж 70 хувьд хүргэхээр төлөвлөж байна. Түүнчлэн тамхины үнэ болон хэрэглээ урвуу хамааралтай байдаг бөгөөд ялангуяа хүүхэд, залуучуудад илүү нөлөөлдөг нь олон судалгаагаар нотлогдсон. Иймд нийтийн эрүүл мэнд, тэр дундаа хүүхэд, залуучуудын тамхины хэрэглээг бууруулахад тус зохицуулалтын зорилго чиглэгдэж байгааг дурдах нь зүйтэй. Ажлын хэсэг иргэд, байгууллагаас ирсэн саналыг үндэслэн Тамхины хяналтын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгахаар ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, шилжилтийн үеийн зохицуулалтыг тус хуулийн төсөлд тусгана.
23.	Манай дэлгүүрт борлуулагддаг тамхины тодорхой хувийг амт, үнэр оруулсан тамхи эзэлдэг. Хэрэв амт оруулсан тамхийг бүхэлд нь хориглох юм бол бид байнгын үйлчлүүлэгчдээ алдаж, орлого ч мөн мэдэгдэхүйц буурна. Түүнчлэн, хуулийг нэн даруй мөрдөх нөхцөлтэй баталбал, манай дэлгүүрийн одоогийн нөөц бүхэлдээ устгалд орох аюулд хүрч, эдийн засгийн хувьд томоохон хохирол амсах болно.	Хуулийн төсөлд тусгасан	
24.	Тамхи ил байршуулахыг хориглох тухай заалт ч бас том асуудал үүсгэнэ. Хуулийн өөрчлөлтөд зориулж зориулалтын хаалттай тавиур, шүүгээ худалдан авах шаардлага тулгарна. Тамхины төрөл маш олон тул энгийн шүүгээ хангалтгүй, харин тусгай хийц бүхий тавиурууд хэрэг болох бөгөөд нэг бүр нь дор хаяж 300,000 төгрөгийн өртөгтэй байдаг. Энэ нь бидний хувьд маш их санхүүгийн дарамт болно. Мөн үйлчлүүлэгчдэд тамхи гаргаж өгөх бүртээ тусгайлан хайж, олоход ихээхэн хугацаа шаардлагатай. Хаалттай тавиураас тамхи авч өгөхийн тулд хараа хяналт сул болсноор хулгай, гэмт хэргийн эрсдэл ч нэмэгдэх аюултай.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Манай улсад тамхи болон шинэ төрлийн тамхин бүтээгдэхүүнийг дэлгүүр, худалдааны төвийн кассын дэргэд шилэн хоргонд ил байршуулан худалдаалж байгааг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж "борлуулалтын цэг дэх ил байршуулалтыг хориглох - point-of-sale display ban" зохицуулалтыг тусгалаа. Өөрөөр хэлбэл, хуульд эдгээр бүтээгдэхүүнийг далд байршуулж, зөвхөн 21-ээс дээш насанд хүрсэн хүний хүсэлтээр нэр, үнийн мэдээллийг тусгасан жагсаалт санал болгон түүнээс сонгон худалдан авах зохицуулалтыг тусгалаа. Мөн далд байршуулах гэдгийг холбогдох заалтын доор тайлбар оруулж өглөө. Ингэснээр өсвөр үе, залуучуудын анхаарлыг татах, тамхины хэрэглээг өдөөх эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм. 2024 оны байдлаар тамхийг ил байршуулж худалдаалахыг бүрэн хориглосон 39 улс, зарим хязгаарлалт тогтоосон 45 улс байна.

			Ил байршуулахыг бүрэн хориглосон 39 улс: Буркина Фасо, Беларус, Бенин, Кабо Верде, Колумб, Коста Рико, Конго, Кот Дивуар, Эсватини, Этиоп, Гамби, Гайана, Ирак, Ирланд, Казахстан, Косово, Кени, Киргизстан, Лаос, Молдав, Мексик, Непал, Шинэ Зеланд, Пакистан, Панам, ОХУ, Сенегал, Словени, Суринам, Өмнөд Африк, Тайланд, Тринидад ба Тобаго, Туркменистан, Того, Туркс ба Кайкос, Уганда, Уругвай, Узбекистан, Венесуэл. Зарим хязгаарлалт тогтоосон 45 улс: Антигуа ба Барбуда, Австрали, Армен, Барбадос, Бурунди, Болив, Бразил, Бермуда, Канад, Камбож, Денмарк, Эквадор, Англи, Эстони, Эль Сальвадор, Эритрей, Фижи, Финланд, Гүрж, Гондурас, Исланд, Израйл, Иордан, Латви, Ливан, Макао, Макао, Малайз, Мальта, Маврики, Малдив, Нидерланд, Норвеги, Нигери, Хойд Ирланд, Шотланд, Сейшелийн арлууд, Сьерра Леон, Сингапур, Тайвань, Турк, Зүүн Тимор, Украин, Арабын Нэгдсэн Эмират улс, Вьетнам, Уэльс.
Найм.Монголын жижиглэн худалдаа эрхлэгчдийн холбоо ТББ-аас 2025.6.12-ны өдөр ирүүлсэн санал			
25.	Тус хуулийн 6.7.14 -т ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдахгүй байх заалтын радиусын хэмжээг бууруулах санал, санаачилгыг хуулийн нэмэлт өөрчлөлтийг боловсруулж буй ажлын хэсэгт хүргүүлж байгаа боловч хэлэлцүүлж буй төслийн энэхүү заалтанд ямар нэгэн өөрчлөлтийг тусгаагүй байна. Иймд тамхи борлуулахыг хязгаарласан тойргийн хэмжээг бодит байдалд нийцүүлэн 150 метр хүртэл бууруулж, хууль ёсны худалдаа, борлуулалтыг дэмжихийг нийт худалдаачид санал болгож байгааг уламжилъя.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Тус хуулийн төслийн үзэл баримтлал нь хүүхэд, залуучуудын тамхины хэрэглээг бууруулж, нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдэж байгаа тул тус заалтыг хөндөх нь ухарсан алхам болно гэж үзсэн. Түүнчлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтыг хэрэгжихгүй байгаа гэх шалтгаанаар хүчингүй болгох нь нэг талаар хууль дээдлэх зарчмыг үгүйсгэж, цаашид буруу жишиг тогтох нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзсэн. Иймд ажлын хэсгээс хуулийн хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн арга хэмжээг авах нь илүү оновчтой шийдэл гэж үзсэн болно.
26.	Тус хуулийн төслийн 6.7.16 дахь заалт нь худалдаа, борлуулалтын үйл ажиллагаанд төдийгүй нийгэм, эдийн засгийн зарим сөрөг үр дагаврыг бий болгох нөхцлийг бүрдүүлэхээр тусгагдсан нь хэрэглэгчийн худалдан	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	2024 оны байдлаар 30 гаруй улс электрон тамхийг бүрэн болон худалдах, импортлохыг хориглосон бол 20 улс амт, үнэрийг хориглосон.

	авалт хийх, сонгох эрхийг хязгаарлаж тамхины далд худалдаа, бизнесийг өөгшүүлэх боломжийг бүрдүүлэх нөхцлийг бий болгосон гэж үзэж байна. Хуулийн төслийн 6.7.16-д заасан бүх төрлийн тамхи, цэнэглэх шингэнд үнэр амт оруулах бодис, бэлдмэл нэмэхийг хориглосон заалтыг дахин нягтлан үзэж, бодит нөхцөл, эдийн засгийн нөлөөллийн судалгаанд тулгуурлан зохицуулалт хийх нь зүйтэй.	Бүрэн хориглосон: https://cloud.parliament.mn/index.php/s/5HvjAk8VWwmtypsp2 Амт, үнэр хориглосон: https://cloud.parliament.mn/index.php/s/xmErKEMpi8IMqJN 2.Электрон тамхи нь эрүүл мэндэд олон сөрөг нөлөө үзүүлж байгаа нь судалгаагаар нотлогдож байгаа бөгөөд сүүлийн үеийн судалгаанаас дурдвал. Уушги ба амьсгалын тогтолцооны нөлөө • European Respiratory Society-ийн судалгаагаар электрон тамхи нь уушгины эсийн гэмтэл, ДНХ-ийн эвдрэл, үрэвсэл үүсгэж, амьсгалын замын өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг болохыг тогтоожээ. Эх сурвалж: https://publications.ersnet.org/content/eri/57/1/1901815?utm • Manchester Metropolitan University-ийн судалгаагаар 20-иод насны залуусын дунд хийсэн туршилтаар электрон тамхи татдаг хүмүүсийн уушгины багтаамж, дасгалын гүйцэтгэл нь тамхи татдаг хүмүүстэй ижил түвшинд буурсан байжээ. Эх сурвалж: https://www.theguardian.com/society/article/2024/sep/08/vaping-damages-young-peoples-lungs-as-much-as-smoking-study-suggests?utm Зүрх судасны тогтолцооны нөлөө: • Судасны үйл ажиллагааны доройтол: 2024 оны судалгаагаар электрон тамхи нь судасны үйл ажиллагаанд шууд сөрөг нөлөө үзүүлдэг бөгөөд никотингүй вэйп ч гэсэн судасны цусны урсгалыг бууруулж, хүчилтөрөгчийн хангалтыг багасгадаг болохыг тогтоожээ.
--	--	--

	Эх сурвалж: https://edition.cnn.com/2024/11/25/health/vaping-vascular-health-oxygen-levels/index.html?utm Америкийн Физиологийн Нийгэмлэгийн судалгаагаар хулганад 16-60 долоо хоногийн турш электрон тамхины утаанд өртөхөд судасны агшилт нэмэгдэж, судасны тэлэлтийн чадвар буурч, системийн даралт ихсэх, зүрхний булчингийн томрол зэрэг өөрчлөлтүүд илэрсэн байна. Никотины агууламж өндөр байх тусам эдгээр сөрөг нөлөөлөл илүү хүчтэй илэрч байжээ. Эх сурвалж: https://journals.physiology.org/doi/prev/20210219-aop/abs/10.1152/ajpheart.00997.2020?utm
	Генетик ба эсийн түвшний нөлөө European Respiratory Society-ийн судалгаагаар электрон тамхи нь ДНХ-ийн гэмтэл, эсийн үхэл, дархлааны генийг дарангуйлж, уушгины эсийн үйл ажиллагааг алдагдуулдаг болохыг тогтоожээ. Эх сурвалж: https://publications.ersnet.org/content/eri/57/1/1901815?utm
	Химийн найрлага ба хорт бодисууд Хорт бодисуудын үүсэл: Ирландын Хааны Мэс заслын Коллежийн судалгаагаар электрон тамхины амт оруулагч бодисуудыг халаах үед 127 төрлийн "хурц хордлоготой", 153 "эрүүл мэндэд аюултай", 225 "цочроогч" химийн нэгдлүүд үүсдэг болохыг тогтоожээ. Эх сурвалж: https://www.rcsi.com/impact/details/2024/05/flavoured-vapes-may-produce-many-harmful-chemicals-when-e-liquids-are-heated-new-research?utm

Ес.Баянхонгор аймагас ирүүлсэн санал /ЭМЯ-нд хүргүүлсэн санал/		
27.	Хуулийн 9.2-т заасан "Аж ахуйн нэгж, байгууллага хуульд заасан тамхины хяналтын үйл ажиллагаатай холбогдсон зохицуулалтыг байгууллагынхаа хөдөлмөрийн дотоод журамд тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина" гэснийг "Аж ахуйн нэгж, байгууллага хуульд заасан тамхины хяналтын үйл ажиллагаатай холбогдсон зохицуулалтыг байгууллагынхаа хөдөлмөрийн дотоод журамд тусгаж, тамхины хэрэглээ, дам тамхидалтын улмаас хүний эрүүл мэнд, эдийн засаг, байгаль орчинд учруулах сөрөг үр дагаврын талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийж хэрэгжилтэд нь хяналт тавьна" гэж өөрчлөх.	Хуулийн төсөлд тус заалтыг хөндөөгүй тул тус саналыг хүлээн авах боломжгүй. Учир нь хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлж хуулийн төслийг боловсруулсан болно.
28.	Хуулийн 9.3-т заасан "Аж ахуйн нэгж, байгууллагын орох хаалга, хүлээлгийн танхим, хонгил, бие засах газар болон бусад шаардлагатай газарт тамхи татахыг хориглосон анхааруулах тэмдэг байрлуулна" гэснийг "Аж ахуйн нэгж, байгууллагын орох, гарха хаалга, хүлээлгийн танхим, хонгил, бие засах газар болон бусад шаардлагатай газарт тамхи татахыг хориглосон анхааруулах тэмдэг заавал байрлуулна" гэж өөрчлөх.	Хуулийн төсөлд тус заалтыг хөндөөгүй тул тус саналыг хүлээн авах боломжгүй. Учир нь хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлж хуулийн төслийг боловсруулсан болно.
29.	Хуулийн 11.1-т "Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ" гэснийг "Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий холбогдох байгууллага, цагдаа болон эрүүл мэндийн байгууллага хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ" гэж өөрчлөх.	Хуулийн төсөлд тус заалтыг хөндөөгүй тул тус саналыг хүлээн авах боломжгүй. Учир нь хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлж хуулийн төслийг боловсруулсан болно.
Арав.Монголын Байгаль орчныг хамгаалах оюутан залуучуудын холбоо ТББ-аас 2025.6.10-ны өдөр ирүүлсэн санал		

30.	Хуулийн төслийн 3 дугаар зүйлээс 2 дахь заалт буюу хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтыг өөрчлөн найруулж байгаа заалтыг хасаж, хуулийн төслийн 5 дугаар зүйлд Тамхины хяналтын тухай хуулийн 3.1.11 дэх заалтыг хүчингүй болгосонд тооцохоор нэмэх.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Тамхины хяналтын тухай хуулийн 5.2.5-д “энэ хуулийн 9.1.5, 9.1.6-д заасан газарт угаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг 300м ² -аас доошгүй талбай бүхий барилга байгууламжид нэгээс илүүгүй байхаар тухайн аж ахуйн нэгж, байгууллага байгуулах.” гэж заасан.
31.	Хуулийн төслийн 3 дугаар зүйлд Тамхины хяналтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтыг “9.1.5 нийтийн хоол, худалдаа, баар цэнгээний газар,” гэж өөрчлөн найруулахаар нэмэх.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Хуулийн төслийн тус зохицуулалт нь дээрх зохицуулалттай уялдаж байгаа тул хасах боломжгүй болно. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Тамхины хяналтын тухай хуулийн 5.2.5-д “энэ хуулийн 9.1.5, 9.1.6-д заасан газарт угаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг 300м ² -аас доошгүй талбай бүхий барилга байгууламжид нэгээс илүүгүй байхаар тухайн аж ахуйн нэгж, байгууллага байгуулах.” гэж заасан.
32.	Хуулийн төслийн 3 дугаар зүйлд Тамхины хяналтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтыг “9.1.6 аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны дотоод орчин,” гэж найруулахаар нэмэх.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Мөн хуулийн 9.1.5-д “нийтийн хоол, худалдаа, баар, цэнгээний газрын угаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгээс бусад орчин,” гэж заасан. Өөрөөр хэлбэл, дээрх зохицуулалт нь хоорондоо уялдаатай зохицуулалт тул тус саналыг хүлээн авах боломжгүй. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Тамхины хяналтын тухай хуулийн 5.2.5-д “энэ хуулийн 9.1.5, 9.1.6-д заасан газарт угаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг 300м ² -аас доошгүй талбай бүхий барилга байгууламжид нэгээс илүүгүй байхаар тухайн аж ахуйн нэгж, байгууллага байгуулах.” гэж заасан.
33.	Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу өөрчлөн найруулалтаар оруулж байгаа “Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар салбар хоорондын хамтын ажиллагаа, төр, иргэн, хуулийн 9.1.5, 9.1.6-д заасан газарт тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг 300м ² -аас доошгүй талбай бүхий барилга байгууламжид нэгээс илүүгүй байхаар тухайн хуулийн	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Мөн хуулийн 9.1.6-д “аж ахуйн нэгж, байгууллагын угаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгээс бусад ажлын байрын дотоод орчин,” гэж заасан. Өөрөөр хэлбэл, дээрх зохицуулалт нь хоорондоо уялдаатай зохицуулалт тул тус саналыг хүлээн авах боломжгүй. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Тамхины хяналтын тухай хуулийн 5.2.5-т “энэ хуулийн 9.1.5, 9.1.6-д заасан газарт угаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг 300м ² -аас доошгүй талбай бүхий барилга байгууламжид нэгээс илүүгүй байхаар тухайн аж ахуйн нэгж, байгууллага байгуулах.” гэж, 9.1.5-д “нийтийн хоол, худалдаа, баар, цэнгээний газрын угаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгээс бусад орчин,” гэж, 9.1.6-д “аж ахуйн нэгж, байгууллагын

	этгээд байгуулах" гэсэн 5.7.4 дэх заалтыг хуулийн төслөөс хасах.		утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгээс бусад ажлын байрын дотоод орчин," гэж тус тус заасан. Харин хуулийн төсөлд Тамхины хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулж байгаа тул тус заалтын дугаарлалтыг өөрчилсөн болно. Түүнчлэн Тамхины хяналтын тухай хуулийн 9.1.5, 9.1.6 дахь заалтууд нь хуулийн төсөлд хөндөгдөөгүй заалт тул тус заалтуудтай хамаарал бүхий 5.7.4 дэх заалтыг хасах боломжгүй болно.
Арван нэг. Улсын Гуравдугаар төв эмнэлэг /ЭМЯ-нд хүргүүлсэн санал/			
34.	6.7.16. Энэ хуулийн 3.1.1.а, 3.1.1.б, 3.1.1.в-д заасан бүх төрлийн тамхи цэнэглэх шингэнд үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх... гэсэн дээр "Үнэр амт оруулах бодисыг нэмэхгүй байх. Өсвөр насны хүүхдийн сонирхолыг татах, амт үнэр нь тааламжтай бус байх хэрэгтэй." гэсэн санал.	Хуулийн төсөлд тусгасан	Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Тамхины хяналтын тухай хуулийн 6.7-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд дараахь зүйлийг хориглоно." гэж заасан бөгөөд хуулийн төсөлд тусгасан "6.7.16.энэ хуулийн 3.1.1.а, 3.1.1.б, 3.1.1.в-д заасан тамхи, цэнэглэх шингэн, энэ хуулийн 3.1.2-т татах төхөөрөмж, түүний эд анги, дагалдах хэрэгсэлд тамхинаас өөр төрлийн үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байх," гэдэг нь хориглосон утгыг илэрхийлж байгаа болно. Түүнчлэн "амт, үнэр нь тааламжтай бус" гэх агуулгыг оруулбал яг ямар амт, үнэрийг тааламжтай бус гэж үзэх вэ? гэх асуулт гарч, түүнийг мөн тодорхойлох шаардлага үүсэх тул тус саналыг хүлээн авах боломжгүй болно.
35.	6.7.17. Тамхины хайрцаг, сав баглаа боодол нь өнгө, дүрслэл, хэлбэр дизайны, материал, гүйцэтгэл болон бусад гадаад шинж чанараараа хүний анхаарал, сонирхлыг татахуйц, эсхүл бусад эд зүйлстэй андуурагдахаар байх..." гэсэн дээр "Сав баглаа боодлыг энгийн харахад хүний сонирхол, авах хүсэл төрүүлэхгүй байх хэрэгтэй." гэсэн санал.	Хуулийн төсөлд тусгасан	Хуулийн төслийн 6.4.1-т "зурагт анхааруулга нь тамхины дотор, гадна хайрцаг, сав, баглаа боодол, татах төхөөрөмж, эд анги, дагалдах хэрэгсэл тус бүрийн нүүрэн талын гадаргууны талбайн 70-иас багагүй хувийг эзэлсэн байх," гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, тамхины бүтээгдэхүүний 70-аас дээш хувийг эрүүл мэндийн зурагт анхааруулга эзлэх тул тус санал агуулгаараа туссан гэж үзэж байна.
36.	"Тамхи татах зөвшөөрөгдсөн цэг" гэж энэ хуулийн 3.1.1-д зааснаас бусад тамхийг энэ хуулийн 3.1.3-т заасан дам тамхидалт бий болгохгүйгээр татах зориулалтаар тусгайлан бэлтгэсэн талбай, агааржуулалтын тоног төхөөрөмжөөр тоноглож тусгаарласан өрөөг"..." гэсэн дээр "Тамхи татах цэг" үүнийг илүү сайжруулж, тамхины утааг шууд гадагш зайлуулах төхөөрөмжтэй, шүүлтүүр бүхий агаар цэвэршүүлэгчтэй, дотроо тамхины хүний эрүүл	Хуулийн төсөлд тусгасан	Тус санал нь хуулийн төсөлд агуулгаараа туссан бөгөөд хуулийн төслийн 5.6.3- "энэ хуулийн 9.1.1, 9.1.2, 9.1.3, 9.1.4, 9.1.7, 9.1.8-д заасан хориглосон газраас бусад нийтийн эдэлбэр газарт байгуулах тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийн байршил, төсвийг шийдвэрлэх," гэж тусгасан.

	мэндэд үзүүлэх хор хөнөөлийн талаарх санамж байршуулсан байх.” гэсэн санал.		
37.	5.6.2.Тамхины эсрэг сургалт, сурталчилгаа, тамхигүй орчин бий болгох чиглэлд төлөвлөгөө гарган ажиллах сургалт сурталчилгаа системтэй явуулах... гэсэн дээр “Эрүүл мэнд, боловсрол, хэвлэл мэдээллийн салбар хамтран тамхины хор уршгийг таниулах нөлөөллийн олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгаа тогтмол үр дүнтэй зохион байгуулах.” гэсэн санал.	Хуулийн төсөлд тусгасан	Хуулийн төсөлд дараах хэсэг, заалтыг тусгасан бөгөөд тус санал нь агуулгаараа тусгагдсан гэж үзэж байна. Үүнд: 1.4.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт 2025 оны .. сарын ..-ны өдрийн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусгагдсан тамхи болон тамхин бүтээгдэхүүний хор уршгийн талаарх агуулгыг батгаан шинэчлэх, бүх шатны сургуулийн дотоод журмыг хуульд нийцүүлэн тамхи, тамхин бүтээгдэхүүнийг хориглох заалт тусгах, хууль, дотоод журмын талаарх суралцагчдад таниулан сурталчилж, хэрэгжилтийг хангах; 5.2.1.ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт тамхины хор уршиг, насанд хүрээгүй иргэнийг тамхинд орохоос урьдчилан сэргийлэх агуулга тусгах; Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.14-т “ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдах,”-ыг хориглосон заалт байдаг. Иймд тус саналыг хуулийн төсөлд тусгах боломжгүй болно.
38.	5.6.4.Тамхи худалдаалах зөвшөөрөл олгох цэгийн тоо байршлыг тогтоохдоо энэ хуульд заасан зарчим, хязгаарлалтыг хангах, тамхи худалдаалах зөвшөөрөлтэй цэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих... гэсэн дээр “ Сургуулийн эргэн тойрны 500м-т тамхи худалдаалах цэгийн тоонд хязгаарлалт хийх, насанд хүрээгүй хүүхдэд тамхи худалдсан аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцулж өндөр дүнгээр торгох.” гэсэн санал.	Хуулийн төсөлд тусгах боломгүй	
39.	5.6.5.Орон нутгийн хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах... гэсэн дээр “Орон нутгийн хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллаж тогтмол үзлэг хяналт хийх, зөрчилд хариуцлагыг чангатгах.” гэсэн санал.	Хуулийн төсөлд тусгасан	Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр “Хуулийн хэрэгжилтийг хангах хяналтын тогтолцоо сул, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо хангалтгүй, хариуцлага тооцох механизм бүрхэг байгаа нь хэрэгжилтийг үр дүнгүй болгож байна. Үүрэг, хариуцлагын хуваарилалт тодорхойгүй, хяналт хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын ажиллагаа сул байгаагаас үүдэн бүх ачаалал Цагдаагийн байгууллагад төвлөрч, тэдний ажиллах чадавх, үр нөлөөнд сөргөөр нөлөөлж байна.” гэж дүгнэсэн.
			Иймээс хуулийн төслийн 5 дугаар зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулж тамхины хяналтын бодлого, зохицуулалтыг эрүүл

			мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад төвлөрүүлэн, салбар хоорондын уялдаа холбоог хангах зохицуулалтыг тусгаласан.
			Мөн тамхины хяналтыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэн, хуулийн этгээд, үйлдвэрлэгч, импортлогчийн оролцоо, үүргийг нарийвчлан тодорхойлж, давхардлыг арилган, хамтын ажиллагааг сайжруулах зохицуулалтыг тусгасан.
40.	5.8.2.Энэ хууль болон эрх бүхий байгууллагаас баталсан тамхины найрлага, тамхины хайрцаг, сав, баглаа боодолд тавигдах стандартыг хангах.” гэсэн санал.	Хуулийн төсөлд тусгах боломгүй	Түүнчлэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хамт боловсруулсан. Өөрөөр хэлбэл, тус санал агуулгаараа хуулийн төсөлд тусгагдсан болно.
41.	5.8.4 НЭМЭХ НЬ... гэсэн дээр “Тамхитай холбоотой бүх төрлийн сурталчилгааг хориглох.” гэсэн санал.	Хуулийн төсөлд тусгах боломгүй	Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Тамхины хяналтын тухай хуулийн 5.8.2-т “Энэ хууль болон эрх бүхий байгууллагаас баталсан тамхины найрлага, тамхины хайрцаг, сав, баглаа боодолд тавигдах стандартыг хангах.” гэсэн санал.” гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, тус санал нь дээрх заалттай агуулгын хувьд давхардаж байна.
42.	91.9. Тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, Тамхи татдаг хүнийг тамхинаас гаргах, никотины хамаарал, хорт зуршлаасаа салах үйл явцыг дэмжих, хөнгөвчлөх зорилготой зөвлөгөө, эмчилгээ, сэтгэлзүйн дэмжлэг, эм бэлдмэл зэргийг багтаасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ. Тусламж үйлчилгээ нь дараах төрөлтэй байна: 91.1.1 сэтгэлзүйн эмчилгээ, 91.1.2. никотин орлуулах эмчилгээ, 91.1.3. эмийн эмчилгээ, 91.1.4. тусгай утасны зөвлөгөө, мэдээллийн тусламж үйлчилгээ... гэсэн дээр “Тамхины хамаарлаас гаргах эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, 91.1. Тамхи татдаг хүнийг тамхинаас гаргах, никотины хамаарал, хорт зуршлаасаа салах үйл явцыг дэмжих, хөнгөвчлөх зорилготой зөвлөгөө, эмчилгээ, сэтгэлзүйн дэмжлэг, эм бэлдмэл зэргийг багтаасан эрүүл мэнийн цогц тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байгууллага “Тамхинаас гарах зөвлөгөө өгөх кабинет” -аар үзүүлнэ. Эрүүл мэндийн тусламж	Хуулийн төсөлд тусгасан	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд дараах нэмэлт оруулсан. 91.1. Тамхи татдаг хүнийг тамхинаас гаргах, никотины хамаарал, хорт зуршлаасаа салах үйл явцыг дэмжих, хөнгөвчлөх зорилготой зөвлөгөө, эмчилгээ, сэтгэлзүйн дэмжлэг, эм бэлдмэл зэргийг багтаасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ. Тусламж үйлчилгээ нь дараах төрөлтэй байна: 91.1.1. сэтгэлзүйн эмчилгээ; 91.1.2. никотин орлуулах эмчилгээ; 91.1.3. эмийн эмчилгээ; 91.1.4. тусгай утасны зөвлөгөө, мэдээллийн тусламж үйлчилгээ.

	үйлчилгээ нь дараах төрөлтэй байна: 9 ^{1.1.1} . Тандалт үнэлгээ хийх (Тамхи таталтын байдал, давтамж, хугацааг тодорхойлох, Никотины хамаарлын зэргийг тодорхойлох (жишээн нь: Fagerstrom-ийн асуумж)), 9 ^{1.1.2} . 5A/5R загварын зөвлөгөө, 9 ^{1.1.3} . Сэтгэлзүйн эмчилгээ, 9 ^{1.1.4} . Никотин орлуулах эмчилгээ, 9 ^{1.1.5} . эмийн эмчилгээ, 9 ^{1.1.6} . тусгай утасны зөвлөгөө, мэдээллийн тусламж үйлчилгээ (Тамхигүй утас г.м)" гэсэн санал.		
43.	9 ^{1.1.8} .Цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, хүүхдийн асрамжийн газар, хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх газар... гэсэн дээр Цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, хүүхдийн асрамжийн газар, хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх газар, эмнэлэг, сувилал, тэдгээрийн гадна орчин, нийтийн зориулалтын орон сууцны байшингийн орц, шат, цахилгаан шат, хүүхдийн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, дэлгүүр, үйлчилгээний төв." гэсэн санал.	Хуулийн төсөлд тусгасан	Хуулийн төслийн 2 дугаар зүйлд дараах нэмэлт оруулсан. Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар 6.7.10 дахь заалтын "сугалаа гаргах" гэсний дараа " , үнэгүй тараах, бэлэглэх, хөнгөлөлт үзүүлэх, эд зүйлсээр арилжаалах" гэж, 7 ² дугаар зүйлийн 7 ^{2.2.11} дэх заалтын "эрүүл ахуйн" гэсний дараа "болон энэ хуульд заасан бусад" гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.8 дахь заалтын "дотуур байр," гэсний дараа "хүүхдийн асрамжийн газар, хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх газар," гэж мөн заалтын "цэцэрлэгт хүрээлэн," гэсний дараа "гудамж, спортын байгууламж." гэж тус тус нэмсүгэй.
Арван хоёр.Эрүүл мэндийн боловсролыг хөгжүүлэх багш, судлаачдын холбооноос 2025.6.10-ны өдөр ирүүлсэн санал			
44.	Хуулийн төслийн 3 дугаар зүйлээс 2 дахь заалт буюу хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтыг өөрчлөн найруулж байгаа заалтыг хасаж, хуулийн төслийн 5 дугаар зүйлд Тамхины хяналтын тухай хуулийн 3.1.11 дэх заалтыг хүчингүй болгосонд тооцохоор нэмэх.	-	Монголын Байгаль орчныг хамгаалах оюутан залуучуудын холбоо ТББ-аас 2025.6.10-ны өдөр ирүүлсэн саналтай давхацсан
45.	Хуулийн төслийн 3 дугаар зүйлд Тамхины хяналтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтыг "9.1.5 нийтийн хоол, худалдаа, баар цэнгээний газар," гэж өөрчлөн найруулахаар нэмэх.	-	
46.	Хуулийн төслийн 3 дугаар зүйлд Тамхины хяналтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтыг "9.1.6 аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны дотоод орчин," гэж найруулахаар нэмэх.	-	
47.	Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу өөрчлөн найруулалтаар оруулж байгаа " Тамхины хяналтыг хэрэгжүүлэх талаар салбар хоорондын хамтын ажиллагаа, төр, иргэн, хуулийн 9.1.5, 9.1.6-д заасан газарт тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг 300м²-аас доошгүй талбай бүхий барилга	-	

	байгууламжид нэгээс илүүгүй байхаар тухайн хуулийн этгээд байгуулах." Гэсэн 5.7.4 дэх заалтыг хуулийн төслөөс хасах.			
Арван гурав.Улаанбаатар хотын Худалдааны танхимаас 2025.6.13-ны өдөр ирүүлсэн санал				
48.	Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд янжуур, навчин тамхи, халаадаг тамхин бүтээгдэхүүнд хэт өндөр татвар ногдуулахаар заасныг эргэн харах. Тухайлбал, 2026 онд татварын хувь хэмжээ хоёр дахинаас ч илүү хэмжээгээр нэмэгдэхээр тусгагдсан байна. Ийнхүү гэнэтийн өндөр татвар тогтоох нь хууль бус наймаа газар авахад хүргэх аюултай байдгийг олон улсын олон жишээ харуулж байна. Энэ нь улсын төсвийн орлого, нийтийн эрүүл мэнд төдийгүй эдийн засагт бүхэлд нь хохирол учруулж болзошгүй.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Улс орон бүр нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор өөрийн улсын онцлогт тохирсон хууль тогтоомжийг баталдаг. Монгол Улс ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцид нэгдэн орсон бөгөөд олон улсын өмнө хүлээсэн үүрэг байдаг. Монгол Улс 2020 оноос хойш тамхин бүтээгдэхүүний онцгой албан татварын хувь хэмжээг нэмээгүй бөгөөд ДЭМБ-аас хийсэн судалгаагаар Монгол Улсын дотоодын зах зээлд жижиглэн худалдаалж буй тамхин бүтээгдэхүүний борлуулалтын үнийн дүнд эзлэх татварын хувь хэмжээ 25-35 орчим хувь байгаа нь хөгжиж буй улсуудын түвшнээс доогуур байгаа бөгөөд ДЭМБ-аас энэ харьцааг 75 хувьд хүргэхийг зөвлөдөг.	Улс орон бүр нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор өөрийн улсын онцлогт тохирсон хууль тогтоомжийг баталдаг. Монгол Улс ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцид нэгдэн орсон бөгөөд олон улсын өмнө хүлээсэн үүрэг байдаг. Монгол Улс 2020 оноос хойш тамхин бүтээгдэхүүний онцгой албан татварын хувь хэмжээг нэмээгүй бөгөөд ДЭМБ-аас хийсэн судалгаагаар Монгол Улсын дотоодын зах зээлд жижиглэн худалдаалж буй тамхин бүтээгдэхүүний борлуулалтын үнийн дүнд эзлэх татварын хувь хэмжээ 25-35 орчим хувь байгаа нь хөгжиж буй улсуудын түвшнээс доогуур байгаа бөгөөд ДЭМБ-аас энэ харьцааг 75 хувьд хүргэхийг зөвлөдөг.
49.	"Бүх төрлийн тамхи, цэнэглэх шингэнд үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байхыг хориглох" заалтыг өөрчлөх. Бүх төрлийн тамхинд үнэр, амт оруулагч нэмэхийг хориглох нь хэт нэг талыг барьсан санал гэж үзэж байна. Амт оруулагч болон бусад орц нь янжуур төдийгүй тамхи болон никотин агуулсан бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд зайлшгүй агууламжид нь орж байдаг орцнууд юм. Эдгээрийг бүхэлд нь хориглох нь тус бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бүхэлд нь хориглосонтой адил болох	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Түүнчлэн тамхины үнэ болон хэрэглээ урвуу хамааралтай байдаг бөгөөд ялангуяа хүүхэд, залуучуудад илүү нөлөөлдөг нь олон судалгаагаар нотлогдсон. Иймд нийтийн эрүүл мэнд, тэр дундаа хүүхэд, залуучуудын тамхины хэрэглээг бууруулахад тус зохицуулалтын зорилго чиглэгдэж байгааг дурдах нь зүйтэй.	Иймд ажлын хэсэг тамхин бүтээгдэхүүний онцгой албан татварыг үе шаттай нэмэгдүүлэхээр хуулийн төсөлд тусгасан болно. өөрөөр хэлбэл, онцгой албан татварыг огцом нэмэхгүй бөгөөд 2026-2030 он хүртэл үе шаттай нэмэгдүүлж 70 хувьд хүргэхээр төлөвлөж байна.

		хориглох, эсхүл түүний амт, үнэрийг хязгаарлах бодлогыг хэрэгжүүлж байна. 2024 оны байдлаар 30 гаруй улс электрон тамхийг бүрэн болон худалдах, импортлохыг хориглосон бол 20 улс амт, үнэрийг хориглосон. Бүрэн хориглосон: https://cloud.parliament.mn/index.php/s/5HvAk8VWwmyrps2 Амт, үнэр хориглосон: https://cloud.parliament.mn/index.php/s/xmErKEMpi8IMqJN 2.Электрон тамхи нь эрүүл мэндэд олон сөрөг нөлөө үзүүлж байгаа нь судалгаагаар нотлогдож байгаа бөгөөд сүүлийн үеийн судалгаанаас дурдвал. Уушги ба амьсгалын тогтолцооны нөлөө - European Respiratory Society-ийн судалгаагаар электрон тамхи нь уушгины эсийн гэмтэл, ДНХ-ийн эвдрэл, үрэвсэл үүсгэж, амьсгалын замын өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг болохыг тогтоожээ. Эх сурвалж: https://publications.ersnet.org/content/eri/57/1/1901815?utm - Manchester Metropolitan University-ийн судалгаагаар 20-мод насны залуусын дунд хийсэн туршилтаар электрон тамхи татдаг хүмүүсийн уушгины багтаамж, дасгалын гүйцэтгэл нь тамхи татдаг хүмүүстэй ижил түвшинд буурсан байжээ. Эх сурвалж: https://www.theguardian.com/society/article/2024/sep/08/vaping-damages-young-peoples-lungs-as-much-as-smoking-study-suggests?utm
--	--	--

		Зүрх судасны тогтолцооны нөлөө: • Судасны үйл ажиллагааны доройтол: 2024 оны судалгаагаар электрон тамхи нь судасны үйл ажиллагаанд шууд сөрөг нөлөө үзүүлдэг бөгөөд никотингүй вэйп ч гэсэн судасны цусны урсгалыг бууруулж, хүчилтөрөгчийн хангалтыг багасгадаг болохыг тогтоожээ. Эх сурвалж: https://edition.cnn.com/2024/11/25/health/vaping-vascular-health-oxygen-levels/index.html?utm • Америкийн Физиологийн Нийгэмлэгийн судалгаагаар хулганад 16-60 долоо хоногийн турш электрон тамхины утаанд өртөхөд судасны агшилт нэмэгдэж, судасны тэлэлтийн чадвар буурч, системийн даралт ихсэх, зүрхний булчингийн томрол зэрэг өөрчлөлтүүд илэрсэн байна. Никотины агууламж өндөр байх тусам эдгээр сөрөг нөлөөлөл илүү хүчтэй илэрч байжээ. Эх сурвалж: https://journals.physiology.org/doi/prev/20210219-aop/abs/10.1152/aipheart.00997.2020?utm
		Генетик ба эсийн түвшний нөлөө • European Respiratory Society-ийн судалгаагаар электрон тамхи нь ДНХ-ийн гэмтэл, эсийн үхэл, дархлааны генийг дарангуйлж, уушгины эсийн үйл ажиллагааг алдагдуулдаг болохыг тогтоожээ. Эх сурвалж: https://publications.ersnet.org/content/eri/57/1/1901815?utm
		Химийн найрлага ба хорт бодисууд

			Хорт бодисуудын үүсэл: Ирландын Хааны Мэс заслын Коллежийн судалгаагаар электрон тамхины амт оруулагч бодисуудыг халаах үед 127 төрлийн "хурц хордлоготой", 153 "эрүүл мэндэд аюултай", 225 "цочроогч" химийн нэгдлүүд үүсдэг болохыг тогтоожээ. Эх сурвалж: https://www.rcsi.com/impact/details/2024/05/flavoured-vapes-may-produce-many-harmful-chemicals-when-e-liquids-are-heated-new-research?utm	
50.	Эрүүл мэндийн яаманд "5.1.4. импортлох тамхины хэмжээ, нэр төрлийн талаар энэ хуульд заасан тамхины хэрэглээг бууруулах зарчимтай уялдуулан нэгдсэн бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих" үүрэг хүлээлгэсэн заалт. Тамхин бүтээгдэхүүний импортын квот тогтоох тухай энэхүү заалт Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн XI: 1 зүйлийг зөрчих бөгөөд мөн хэлэлцээрийн XX зүйлд заасан эрүүл мэндийн үндэслэлээр үүрэг амлалтаас чөлөөлөгдөх тохиолдолд хамаарахгүй юм. Мөн хилийн чанадаас хууль бус, тэр дундаа хуурамч тамхин бүтээгдэхүүн их хэмжээгээр орж ирэхэд хүргэнэ. Хууль бус үйлдвэрлэгчид техникийн нормыг мөрдөхгүй, хортой орлуулагч бодис ашигладаг. Энэ нь хэрэглэгчийн эрүүл мэндэд учрах эрсдэлийг эрс нэмэгдүүлнэ.	Хуулийн төсөлд тусгасан	Хуулийн төслийн холбогдох заалтад найруулгын засвар оруулж хууль тогтоомжид нийцүүлсэн болно.	
51.	Дээрх гурван заалт бүхэлдээ одоогийн хууль ёсны янжуурын зах зээлд сөрөг нөлөөлж хууль бус бүтээгдэхүүнд дотоодын зах зээлийг алдах эрсдлийг бий болгож болзошгүйгээс гадна улсын төсөвт төвлөрөх ёстой гаалийн хураамж болон дараах татварын орлогыг бууруулж болзошгүй гэж үзэж байна. Үүнд: - Онцгой албан татвар - НӨАТ - Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (тамхи үйлдвэрлэгч, импортлогч компаниуд, мөн	Хуулийн төсөлд тусгасан	Хууль бус бүтээгдэхүүн худалдаалах эрсдэл үүсэхээс сэргийлж Монгол Улсад үйлдвэрлэсэн болон импортлсон, чөлөөт бус, татваргүй барааны дэлгүүрт оруулсан бүх төрлийн тамхин бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, борлуулалтын үе шат бүрээр эцсийн хэрэглэгч хүртэл олон улсын стандартад нийцсэн дахин даутагдашгүй, цахим өгөгдөл бүхий код ашиглан цахим төлбөрийн баримт, гаалийн мэдүүлэгт үндэслэн татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх зохицуулалтыг тусгасан.	

	холбогдох агуулах, тээвэр логистик зэрэг бизнесийн орлого огцом буурах учраас) Хувь хүний орлогын албан татвар (тамхины болон түүнтэй холбоотой салбарт ажиллагсад цомхотголд орж, цалин урамшуулал авах боломжоо алдана. Цомхотголд шууд болон шууд бусаар бараг 3000 иргэн өртөх магадлалтай)		Тус зохицуулалтыг тусгаснаар тухайн тамхин бүтээгдэхүүн хаана үйлдвэрлэгдээд хаанаас ирээд хаана борлуулагдаж байгааг хянах боломжтой болох бөгөөд өөрөөр хэлбэл, хууль бус бүтээгдэхүүний худалдаанд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаг согтуурахтай тэмцэх тухай хуульд дээрх зохицуулалт байдаг бөгөөд тус зохицуулалтын хүрээнд бүх төрлийн согтууруулах ундаанд хяналт тавьж ажиллаж байгаа тул тамхин бүтээгдэхүүнд мөн адил хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байгаа болно.	
Арван дөрөв. ПРЕМИУМ НЭКСУС ХК, НОМИН ХОЛДИНГ ХХК болон ДИЖИТАЛ КОНЦЕПТ ХХК-иас ирүүлсэн санал				
52.	Тамхины хяналтын тухай хуулийн 6.7.14-т "ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдах"-ыг хориглож заасныг хасах	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Тус хуулийн төслийн үзэл баримтлал нь хүүхэд, залуучуудын тамхины хэрэглээг бууруулж, нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдэж байгаа тул тус заалтыг хөндөх нь ухарсан алхам болно гэж үзсэн. Түүнчлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтыг хэрэгжихгүй байгаа гэх шалтгаанаар хүчингүй болгох нь нэг талаар хууль дээдлэх зарчмыг үгүйсгэж, цаашид буруу жишиг тогтох нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзсэн. Иймд ажлын хэсгээс хуулийн хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн арга хэмжээг авах нь илүү оновчтой шийдэл гэж үзсэн болно.	
53.	2024 оноос 2030 он хүртэл үе шаттайгаар тамхи, тамхин бүтээгдэхүүнд ногдох онцгой албан татварыг нэмэх нь зүйтэй, гэхдээ одоо олон нийтэд танилцуулсан хуулийн төсөлд тусгаснаар 225%-аар нэмэх биш харин 60%-ийн өсөлттэйгөөр, Мөн Олон Улсын жишгийг дагаж хор хөнөөл багатай бүтээгдэхүүнд бага татвар ногдуулах, өртөг өндөр дүнгээр үйлдвэрлэгдэж байгаа бүтээгдэхүүнийг хязгаарлахгүй гэдэг үүднээс электрон тамхинд янгуур тамхинаас 65%-аар бага татвар ногдох.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Улс орон бүр нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор өөрийн улсын онцлогт тохирсон хууль тогтоомжийг баталдаг. Монгол Улс ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцид нэгдэн орсон бөгөөд олон улсын өмнө хүлээсэн үүрэг байдаг. Монгол Улс 2020 оноос хойш тамхин бүтээгдэхүүний онцгой албан татварын хувь хэмжээг нэмээгүй бөгөөд ДЭМБ-аас хийсэн судалгаагаар Монгол Улсын дотоодын зах зээлд жижиглэн худалдаалж буй тамхин бүтээгдэхүүний борлуулалтын үнийн дүнд эзлэх татварын хувь хэмжээ 25-35 орчим хувь байгаа нь хөгжиж буй улсуудын түвшнээс доогуур байгаа бөгөөд ДЭМБ-аас энэ харьцааг 75 хувьд хүргэхийг зөвлөдөг.	

			Иймд ажлын хэсэг тамхин бүтээгдэхүүний онцгой албан татварыг үе шаттай нэмэгдүүлэхээр хуулийн төсөлд тусгасан болно. өөрөөр хэлбэл, онцгой албан татварыг огцом нэмэхгүй бөгөөд 2026-2030 он хүртэл үе шаттай нэмэгдүүлж 70 хувьд хүргэхээр төлөвлөж байна. Түүнчлэн тамхины үнэ болон хэрэглээ урвуу хамааралтай байдаг бөгөөд ялангуяа хүүхэд, залуучуудад илүү нөлөөлдөг нь олон судалгаагаар нотлогдсон. Иймд нийтийн эрүүл мэнд, тэр дундаа хүүхэд, залуучуудын тамхины хэрэглээг бууруулахад тус зохицуулалтын зорилго чиглэгдэж байгааг дурдах нь зүйтэй.
54.	Тамхины асуудал зохицуулсан эрх зүйн хэм хэмжээг нэгтгэж, нэг эх сурвалжид төвлөрүүлэх санал	Хуулийн төсөлд хамааралгүй санал	Тус саналыг холбогдох төрийн байгууллагад уламжлах болно.
Арван тав. “Филип Моррис Казакстан” ХХК-иас 2025 оны 9 дүгээр сарын 05-ны өдөр цахим шуудангаар ирүүлсэн санал			
55.	Дагалдах хэрэгсэл нь нэг удаагийн бүтээгдэхүүн биш учраас тэдгээрт онцгой албан татвар ногдуулахаар хуулийн төсөлд тусгасан байгааг хасах саналтай байна.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Хуулийн төсөлд бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнийг Тамхины хяналтын тухай хуулийн үйлчлэлд хамруулахаар тамхин бүтээгдэхүүний тодорхойлолтод тусгасан. Иймд зарим төрлийн тамхин бүтээгдэхүүн нь түүний дагалдах хэрэгслийн хамт нэг бүтээгдэхүүн болж хэрэглэгддэг тул тамхин бүтээгдэхүүний нэг хэсэг гэж үзэж ОАТ ногдуулсан болно. Мөн тус зохицуулалт нь нэг удаагийн бүтээгдэхүүнийг хязгаарлаж, байгаль орчныг хамгаалах олон улсын жишигтэй нийцэж байгаа болно.
56.	Хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэх үүднээс янжуурын албан татварыг хэт их нэмэхгүй байх нь зүйтэй.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	ДЭМБ-аас тамхины жижиглэнгийн үнийн хамгийн багадаа 75%-ийг бүх төрлийн татвар (онцгой, гаалийн, НӨАТ г.м) бүрдүүлэх ёстой гэж зөвлөдөг. Монгол Улсын хувьд тамхин бүтээгдэхүүний дундаж үнэ 3850 төгрөг байгаа бөгөөд үүнийн 40 орчим хувийг татвар эзэлж байгаа нь дэлхийн хамгийн хямд тамхитай улсын жагсаалтад багтах, улмаар тамхины хэрэглээг дэмжих нөхцөлийг бүрдүүлж байгаа тул бүх төрлийн тамхин бүтээгдэхүүний татварыг үе шаттай нэмэгдүүлэхээр хуулийн төсөлд тусгасан болно.
57.	Халаадаг тамхин бүтээгдэхүүний онцлог шинж чанарыг харгалзан уг бүтээгдэхүүний онцгой албан татварыг янжуураас өөр хувь хэмжээгээр ногдуулах саналтай байна.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Тамхины хяналтын тухай хуулийн үйлчлэлд бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнийг хамруулах зорилгоор тамхин бүтээгдэхүүний тодорхойлолтыг өргөн хүрээнд тодорхойлсон бөгөөд энэ нь аль нэг тамхи нь хор багатай, ихтэй гэх ойлголттой хамааралгүй болно.

			Өөрөөр хэлбэл, бүх төрлийн тамхин бүтээгдэхүүн хүний эрүүл мэндэд хортой учраас аль нэг тамхин бүтээгдэхүүнд давуу байдал олгохгүй байх зарчмыг баримтлан ОАТ-ын хэмжээг ижил хэмжээнд тогтоосон болно.
58.	Ууталсан никотин-д онцгой албан татвар ногдуулах саналтай байна.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Тамхины хяналтын тухай хуулийн үйлчлэлд бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнийг хамруулах зорилгоор тамхин бүтээгдэхүүний тодорхойлолтыг өргөн хүрээнд тодорхойлсон бөгөөд энэ нь аль нэг тамхи нь хор багатай, ихтэй гэх ойлголттой хамааралгүй болно. Өөрөөр хэлбэл, бүх төрлийн тамхин бүтээгдэхүүн хүний эрүүл мэндэд хортой учраас аль нэг тамхин бүтээгдэхүүнд давуу байдал олгохгүй байх зарчмыг баримтлан ОАТ-ын хэмжээг ижил хэмжээнд тогтоосон болно.
59.	Бүх төрлийн тамхи, цэнэглэх шингэнд үнэр, амт оруулах бодис, бэлдмэл нэмсэн байхыг хориглосон заалтыг хасах саналтай байна.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Тус хуулийн төслийн үзэл баримтлал нь хүүхэд, залуучуудын тамхины хэрэглээг бууруулж, нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдэж байгаа тул хуулийн төслийн гол зохицуулалтуудын нэг нь гаанаас бусад тамхины амт, үнэрийг хориглох зохицуулалт юм. 1.Дэлхийн улс орнууд хүүхэд, залуучуудын дундах электрон тамхины хэрэглээг хязгаарлах зорилгоор электрон тамхийг бүрэн хориглох, эсхүл түүний амт, үнэрийг хязгаарлах бодлогыг хэрэгжүүлж байна. 2024 оны байдлаар 30 гаруй улс электрон тамхийг бүрэн болон худалдах, импортлохыг хориглосон бол 20 улс амт, үнэрийг хориглосон. Бүрэн хориглосон: https://cloud.parliament.mn/index.php/s/5HyjAk8Wwmypsp2 Амт, үнэр хориглосон: https://cloud.parliament.mn/index.php/s/xmEpKEMpi8IMqJN 2.Электрон тамхи нь эрүүл мэндэд олон сөрөг нөлөө үзүүлж байгаа нь судалгаагаар нотлогдож байгаа бөгөөд сүүлийн үеийн судалгаанаас дурдвал.

		Уушги ба амьсгалын тогтолцооны нөлөө - European Respiratory Society-ийн судалгаагаар электрон тамхи нь уушгины эсийн гэмтэл, ДНХ-ийн эвдрэл, үрэвсэл үүсгэж, амьсгалын замын өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг болохыг тогтоожээ. Эх сурвалж: https://publications.ersnet.org/content/erj/57/1/1901815?utm - Manchester Metropolitan University-ийн судалгаагаар 20-иод насны залуусын дунд хийсэн туршилтаар электрон тамхи татдаг хүмүүсийн уушгины багтаамж, дасгалын гүйцэтгэл нь тамхи татдаг хүмүүстэй ижил түвшинд буурсан байжээ. Эх сурвалж: https://www.theguardian.com/society/article/2024/sep/08/vaping-damages-young-peoples-lungs-as-much-as-smoking-study-suggests?utm Зүрх судасны тогтолцооны нөлөө: - Судасны үйл ажиллагааны доройтол: 2024 оны судалгаагаар электрон тамхи нь судасны үйл ажиллагаанд шууд сөрөг нөлөө үзүүлдэг бөгөөд никотингүй вэйп ч гэсэн судасны цусны урсгалыг бууруулж, хүчилтөрөгчийн хангалтыг багасгадаг болохыг тогтоожээ. Эх сурвалж: https://edition.cnn.com/2024/11/25/health/vaping-vascular-health-oxygen-levels/index.html?utm - Америкийн Физиологийн Нийгэмлэгийн судалгаагаар хулганад 16-60 долоо хоногийн турш электрон тамхины утаанд өртөхөд судасны агшилт нэмэгдэж, судасны тэлэлтийн чадвар буурч, системийн даралт ихсэх, зүрхний булчингийн томрол зэрэг өөрчлөлтүүд илэрсэн байна.
--	--	--

			Никотины агууламж өндөр байх тусам эдгээр сөрөг нөлөөлөл илүү хүчтэй илэрч байжээ. Эх сурвалж: https://journals.physiology.org/doi/prev/20210219-aop/abs/10.1152/ajpheart.00997.2020?utm Генетик ба эсийн түвшний нөлөө - European Respiratory Society-ийн судалгаагаар электрон тамхи нь ДНХ-ийн гэмтэл, эсийн үхэл, дархлааны генийг дарангуйлж, уушгины эсийн үйл ажиллагааг алдагдуулдаг болохыг тогтоожээ. Эх сурвалж: https://publications.ersnet.org/content/eri/57/1/1901815?utm Химийн найрлага ба хорт бодисууд - Хорт бодисуудын үүсэл: Ирландын Хааны Мэс заслын Коллежийн судалгаагаар электрон тамхины амт оруулагч бодисуудыг халаах үед 127 төрлийн “хурц хордлоготой”, 153 “эрүүл мэндэд аюултай”, 225 “цочроогч” химийн нэгдлүүд үүсдэг болохыг тогтоожээ.
60.	Тамхин бүтээгдэхүүний импортын квотыг тогтоох тухай заалтыг хасах саналтай байна.	Хуулийн төсөлд тусгасан	Хуулийн төслийн холбогдох заалтад найруулгын засвар оруулж хууль тогтоомжид нийцүүлсэн болно.
61.	Хуулийн төслийн 6.4.1-т заасан заалтыг “зурагт анхааруулга нь тамхины хайрцаг, сав, баглаа боодлын нүүрэн талын гадаргууны талбайн 70-аас багагүй хувийг эзэлсэн байх” гэж өөрчлөх саналтай байна.	Хуулийн төсөлд тусгасан	Хуулийн төсөлд “6.4.1.зурагт анхааруулга нь 3.1.1.а, 3.1.1.б, 3.1.1.в-д заасан тамхины хайрцаг, сав, баглаа боодлын нүүр болон ар талын талбайн хэсгийн гадаргуугийн талбайн 70-аас багагүй хувийг эзэлсэн байх,” гэж тусгасан.
62.	Хуулийн төслийн 6 дугаар зүйлд заасан дагаж мөрдөх хугацааг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс гэж өөрчлөх саналтай байна.	Хуулийн төсөлд тусгах боломжгүй	Дагаж мөрдөх хугацааг урт хугацаанд тавих нь олон талын сөрөг үр дагаврыг бий болгож хуулийн үйлчлэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байдаг тул тус саналыг хүлээн авах боломжгүй болно.